

**Боловсрол, шинжлэх ухааны яамны 2021 оны Хууль тогтоомж, тогтоол
шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан**

Шийд вэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	. Хэрэгжилтийн явц	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль						
1	1	Бага, дунд боловсролын тухай 2002-05-03 Дугаар 2002.06.01	13.8. Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоог боловсролын, нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.	- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенцод нэгдэн орсон улс бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн амьдарч байгаа орон нутагтаа боловсрол эзэмших эрхийг эдлүүлэх үүргийг хүлээсэн. Манай улсын хувьд ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ноогдох хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоог тогтоох нь конвенцын заалтыг зөрчсөн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхсан үйлдэл болох учраас БСШУС-ын сайдын А/292 тоот тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-аар зохицуулсан. Журамд “Дэмжлэгийн баг” /сургууль дундын байж болно/-ийг сургуулийн захирлын тушаалаар байгуулж, ажиллах хүний тоо нь тухайн сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, орон нутгийн онцлог, мэргэжилтний нөөц, сургалтын орчин, хүүхдийн болон эцэг эх, асран хамгаалагчийн саналыг үндэслэн ажиллах мөн нэг ангид 1-2 хүүхэд сурахаар сургууль дээрээ зохицуулалт хийхээр тусгасан.	100%	Хяналтаас хасуулах
2	2	Сургуулийн өмнөх боловсролын тухай 2008-05-23 Дугаар 2008.05.23	8.15. Сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байгууллагын нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог боловсролын нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.	- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенцод нэгдэн орсон улс бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн амьдарч байгаа орон нутагтаа боловсрол эзэмших эрхийг эдлүүлэх үүргийг хүлээсэн. Манай улсын хувьд сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ноогдох хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоог тогтоох нь конвенцын заалтыг зөрчсөн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхсан үйлдэл болох учир Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/177 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам”-ыг батлуулж зохицуулсан. Уг журмыг хэрэгжүүлэх зөвлөмжид ердийн бүлэгт 1-2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулж болно. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/118 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.8.-д “Цэцэрлэг нь хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургах тохиолдолд хүүхдийн хөгжлийн бэрхшээлд тохирсон ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог,	100%	Хяналтаас хасуулах

				хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой хэрэгжүүлнэ” гэдгийг зөвлөмжид тусган ажиллаж байна.		
3	3	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02	19.1.9. Төрийн захиргааны төв байгууллага жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг Жендерийн үндэсний хороонд дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх.	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Салбар зөвлөлийг шинэчлэн батлах тухай” 2021 оны А/459 дүгээр тушаалаар салбар зөвлөлийг шинэчлэн байгуулсан. - Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, салбарын жендерийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээ тайлан болон 2022 оны төлөвлөгөөг БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 2/102 тоот албан бичгээр Жендерийн үндэсний хороонд хүргүүлсэн. - Салбар зөвлөлийн 2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	
4	4	Инновацийн тухай 2012-05-22 Дугаар 2012.07.05	17.1.12. Үндэсний инновацийн шагналын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.	- “Үндэсний инновацийн шагнал олгох журам”-ыг баталсан. Журмын зохицуулалтаар 2 жилд нэг удаа, “Шилдэг инновацийн бүтээгдэхүүн”, “Үйлчилгээний салбарын шилдэг инноваци” гэсэн 2 төрөлд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд үндэсний инновацийн шагналыг олгохоор журамласан. Тус журмын дагуу 2018 онд Шилдэг инновацийн бүтээгдэхүүний шагналыг Гарааны ветбиотек ХХК-ийн малын эктопаразитууд болон хачиг шимэгчлэхээс урьдчилан сэргийлэх, эмчлэх зориулалтай бэлдмэл “Делтамон Пу-рон”, Үйлчилгээний салбарын шилдэг инновацийн шагналыг Айтүүлс ХХК-ний “Дата төвийн бүтээгдэхүүн, үйлчилгээ” тус тус хүртэж байсан бол 2020 онд Баргилтех ХХК-ийн “Эко барьцалдуулагч” бүтээгдэхүүнд “Шилдэг инновацийн бүтээгдэхүүн”, Ворлд плас дижитал ХХК-ийн “Ворлд плас аппликэйшн” бүтээгдэхүүнд “Үйлчилгээний салбарын шилдэг инноваци”-ийн шагналыг олгосон.	100%	хяналтаас хасуулах
	5		6.1.13. Паркийн нутаг дэвсгэрт олгосон газар, төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, нутаг дэвсгэрт үйлчлэх хөнгөлөлт, урамшуулал, тэдгээрийн хэлбэр, хэмжээг тогтоох, паркийн үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам баталж мөрдүүлэх. (6.1.Засгийн газар инновацийн үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа шинжилгээ, инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх дэд бүтэц, орчныг бүрдүүлэх, импортыг орлох, экспортод чиглэсэн өндөр технологи, инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах санхүүгийн олон талт эх үүсвэрээр хангах, инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулах тухай” 19 дүгээр тогтоолоор инноваци, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг үүрэг бүхий шинжлэх ухааны паркийн захиргааг байгуулсан. Тус захиргааны бүтэц, дүрэм, үйл ажиллагаатай холбоотой дүрэм журам (5)-ыг батлан мөрдөж байна. Шинжлэх ухааны парк байгуулах ТЭЗҮС-ыг хийлгэсэн. Шинжлэх ухааны паркийг байгуулах байршлыг тогтоох судалгааг хийж, МУ-ын 5 байршил(хамгийн боломжит байршил УБ Аэросити/-д байгуулах боломжтой гэсэн судалгааны үр дүн, дүгнэлт гаргасан.	100%	хяналтаас хасуулах
	6		13.4. Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн	- Засгийн газрын 2020 оны 95 дугаар тогтоолоор “Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл”-ийг батлуулсан. Уг тэргүүлэх чиглэл нь	100%	Хяналтаас хасах

			төслийг өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж өмнөх тэргүүлэх чиглэлийн хугацаа дуусахаас 12 сарын өмнө Засгийн газраар хэлэлцүүлнэ.	хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг тул 5 жилийн хугацаатайгаар батлагдсан болно. Хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Дэлхийн банкны санхүүжилттэйгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газартай хамтран хэрэгжүүлж байгаа "Ухаалаг засаг" төслийн 16 инновацийн дэд төслийг "Инновацийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх заавар"-ын дагуу сонгон шалгаруулж, нийт 1,2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгох/инновацийн тэргүүлэх чиглэлийн төсөл/-оор хамтын шийдвэрийг хэрэгжүүллээ.		
5	7	Боловсролын тухай 2013-02-07 Дугаар 2013.03.07	39.12. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/216 дугаар тушаалаар "Төсвийн хэмнэлт, өөрийн нэмэлт орлогыг тайлагнах, зарцуулах, нягтлан бодох бүртгэлд тусгах журам"-ыг батлан хэрэгжүүлж байна.	100%	Хяналтаас хасах
6	8	Хүүхэд харах үйлчилгээний тухай 2015-07-02 Дугаар 2016.01.01	6.7.. Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, стандартыг Засгийн газар батална.	- "Хүүхэд харах үйлчилгээний тухай" хуулийн 6.7-д "Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, стандартыг Засгийн газар батална" гэж заасны дагуу энэхүү үйлчилгээний шаардлагыг тогтоосон "Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" MNS 6540:2015 стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан. Уг стандартаар "Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн Хүүхэд харах үйлчилгээний үндсэн шаардлага, Хүүхэд харагчид тавих шаардлага, Хүүхдийн хоол хүнсэнд тавих шаардлага, Үйлчилгээний байрны дотоод орчинд тавих шаардлага, Үйлчилгээний байрны гадаад орчинд тавих шаардлага, Хүүхдийн эрүүл мэнд, эерэг харилцааг дэмжсэн асран хамгаалалтад тавих шаардлагын нарийвчлан тогтоосноос гадна 9-р зүйлд Хүүхэд харах үйлчилгээнд хориглох зүйлийг тогтоож тусгасан байна.	100%	Хяналтаас хасуулах
	9		6.5.. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан нэг хүүхэд харагчид оногдох хүүхдийн тоо таваас илүүгүй байх бөгөөд хүүхдийн насны ялгааг харгалзан Засгийн газар тогтооно.	- Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхдийн насыг "Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 5.1-д "Хүүхэд харах үйлчилгээнд хоёр наснаас ерөнхий боловсролын сургуульд элсэх хүртэлх насны хүүхэд хамрагдана." гэж заасан. Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 06 сарын 26-ны өдрийн А/409 тоот тушаалаар баталсан "Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам"-ын 6.2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн хүүхэдтэй хамт үйлчилгээнд хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэгээс илүүгүй байна.", 6.3. "Хүүхэд харах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дагнан хамруулах тохиолдолд энэ чиглэлээр мэргэшсэн хүн хүүхэд харагчаар ажиллана. Нэг хүүхэд харагчид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо гурваас илүүгүй байна." гэж заасан.	100%	Хяналтаас хасуулах

7	10		10.1.. Хүүхэд харах үйлчилгээний бодлого, төлөвлөлт, санхүүжилт, удирдлага, мэдээлэл, хяналт-шинжилгээ, зохицуулалтыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа агентлаг, хэлтэс хариуцан хэрэгжүүлнэ. /Энэ хэсгийг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/	- Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх шалгуур, нөхцөл, бүрдүүлэх баримт бичиг, зөвшөөрөл олгох үйл ажиллагааны зохион байгуулалт, түүнд хяналт тавихад Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 06 сарын 26-ны өдрийн А/409 тоот тушаалаар батлагдсан “Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам” батлан мөрдөж байна. Хүүхэд харах үйлчилгээнд олгох санхүүгийн дэмжлэг хэмжээг тооцож төлөвлөх, түүнийг хуваарилах, олгох, зарцуулалтад нь хяналт тавихтай холбогдсон асуудлыг Засгийн газрын 2015 оны 513 дугаар тогтоолоор баталсан, “Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам” -д 2018 онд Засгийн газрын 74 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан өнөөг хүртэл мөрдөж байна.	100%	Хяналтаас хасуулах
	11	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016-02-05 Дугаар 2016.02.05	12.2.. Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	- Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран боловсруулаад байна. Энэхүү журам нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилж, орчуулах үйл ажиллагааны харилцааг зохицуулсан. Тухайлбал, энэ төрлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох байгууллага, хэлмэрч, орчуулгын үйлчилгээ болон хэлмэрч, орчуулагчид тавих шаардлагыг тус тус тодорхойлж, үйлчлүүлэгчийн талын эрх, үүрэг, санхүүжилт зэрэг асуудлыг тусгасан. Гэвч журмын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дараах 2 асуудлыг шийдвэрлэсний дараагаар батална гэж үзэж хүлээгдэж байна: 1.Монгол Улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолтод “Дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэсэн мэргэжлийг шинээр оруулах; 2. Энэ чиглэлийн үйлчилгээ эрхлэх иргэдийн хөдөлмөр эрхлэх асуудал нь ХНХЯ-ны чиг үүрэгт хамаарах тул хэлмэрч орчуулагчийн үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох.	70%	
	12		14.5.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, бүх шатны боловсрол олгох үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална.	- “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралтаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны А/116, А/304, А/197 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2018-2022) тус тус батлагдсан. Хөтөлбөр, төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд бүх шатны боловсрол олгохтой холбогдох 28 үйл ажиллагаа тусгагдсан бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг хангаж, тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд жил бүр хүргүүлэн ажиллаж байна.	100%	Хяналтаас хасах
	13		15.8.. Энэ хуулийн 15.6-д заасан сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална. (15.6.Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр,	- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолын 5 дугаар заалтаар “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын “4.1.2. бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагч эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрийн суралцагч”-д сургалтын төлбөрийн буцалгүй тусламж олгохоор болсон.	100%	Хяналтаас хасах

8			магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцна.)	Түүнчлэн тус тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журам”-ыг шинэчлэн баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй, бакалаврын боловсрол эзэмшиж буй /давхардсан тоогоор/ 1255 суралцагчид 1.8 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй 918 суралцагчид /давхардсан тоогоор/ 1.4 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийн санхүүжилтийн тооцоог Боловсролын зээлийн сангаас тус тус санхүүжүүлсэн байна.		
	14		15.2.. Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургахад шаардагдах хэрэглэгдэхүүний судалгаа хийж, түүний үр дүнд үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/184 дүгээр тушаалаар “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.	100%	
	15		15.3.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/309 дүгээр тушаалаар “Харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа олгох сургалтын жишиг хөтөлбөр”, “Харааны бэрхшээлтэй хүүхдэд хөдөлгөөн орон зайн баримжаа олгох хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийг тус тус баталсан. Эдгээр хөтөлбөр нь үндэсний хэмжээнд анх удаа батлагдаж байгаа бөгөөд ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа болон хөдөлгөөн орон зайн баримжаа олгох сургалтыг ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулах багшид арга зүйн удирдамж, дэмжлэг болж байна.	100%	
	16		15.9.. Энэ хуулийн 15.7-д заасан ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт, зардлын хэмжээ, олгох журмыг боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-д байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслийн жагсаалт”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/184 дүгээр тушаалаар баталсан “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”-ын хүрээнд цэцэрлэг сургуульд зайлшгүй нийлүүлэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн жагсаалтыг тус тус гаргасан.	100%	
	17	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016-04-14 Дугаар 2016.04.14	15.4.. Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувийг эцэг, эх, асран хамгаалагчаас, Нийгмийн халамжийн тухай хуулийн 20.2-т заасан хүүхдийн хоолны зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.	- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын нормативыг нэмэгдүүлэх чиглэлээр хүүхдийн хоолны 14 хоногийн үлгэрчилсэн цэс төлөвлөж, шим тэжээл, өртгийн тооцоог хийсэн. 24 цагийн, сувиллын болон тусгай цэцэрлэгийн хүүхдийн хоолны норматив зардал 6315 төгрөг, ердийн буюу 8-10 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийн хүүхэд хоногийн хоолны зөвлөмж хэмжээний 75 хувийг хангахуйц байдлаар дунджаар 1054 кал илчлэг бүхий хоолны өртөг 4740 төгрөг байх урьдчилсан тооцоо гарч байна. Ердийн цэцэрлэгийн хүүхдийн одоо мөрдөгдөж буй хоолны зардалд нэмэгдэх 2265 /48%/ төгрөгийг эцэг эх, асран хамгаалагчаас гаргуулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад байна.	70%	

9	18	Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-05-12 Дугаар 2017.05.12	8.4.2.. 8.4.Хог хаягдлын талаар боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.4.2. Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын сургалтын хөтөлбөрт хог хаягдлын талаархи боловсролын агуулгыг тусгах;	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Сургалтын хөтөлбөр батлах тухай” А/181 дүгээр тушаалаар “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр”-т хог хаягдлын талаарх агуулгыг тусган хэрэгжүүлж байна. Үүнд: Хог хаяхгүй байх, хог хаягдлаа зориулалтын саванд ялгаж хийж хэвших; Гол, усанд хог хийхгүй байхыг мэдэх; Цаас, усыг гамтай хэрэглэж хэвших. - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/220 дугаар тушаалаар баталсан дунд ангийн хими, газар зүй, дизайн технологийн сургалтын хөтөлбөрт дараах байдлаар тусган хэрэгжүүлж байна. Химийн сургалтын хөтөлбөр бохирдол, ус ахуйн хог хаягдлаар бохирдох шалтгааныг олж тайлбарлах, ахуйн нөхцөлд бохирдлоос сэргийлэх, түүнд оруулах хувь нэмрээ тодорхойлж чаддаг болох. Газар зүйн сургалтын хөтөлбөрт байгаль хамгаалах уламжлалт зан үйл, тусгай хамгаалалттай газар нутгийн талаар мэдээлэл цуглуулан боловсруулж, тархалтыг зурагт тэмдэглэн ач холбогдлыг дүгнэж, орон нутагтаа тулгарч буй байгаль орчны тулгамдсан асуудал хог хаягдлыг хэрхэн шийдвэрлэх талаар саналаа боловсруулах, -Дизайн технологийн сургалтын хөтөлбөрт хэрэглээнээс гарсан хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой баримт мэдээллийг судлах, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар хаягдал материалыг ашиглан хэрэгцээт зүйл бүтээх, технологи ажилбарын үед гарсан хог хаягдлыг ангилах дахин ашиглах боломжтойг ялгах, ажлын байрны эмх цэгц, аюулгүй байдлыг ханган ажиллах гэх мэт.	100%	
10	19	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай 2017-05-18 Дугаар 2017.05.18	8.2.. "Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. /8.1.1-д ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах/"	- Ерөнхий боловсролын сургуулийн “Сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчлэх”; “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд эх орныхоо түүх соёлыг судлах хичээлийг оруулах”; “Сургалтын хөтөлбөрт хүүхдийг хүнлэг, эх оронч, үндэсний ухамсар, бахархалтай, эх орноо хайрладаг, хүрээлэн байгаа орчноо хамгаалдаг, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндэлдэг, хариуцлагатай, амьдрах ухаантай, итгэл даах чадвартай иргэн болгон төлөвшүүлэх агуулгыг тусган хэрэгжүүлэх” хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүллээ: • Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан БСШУС-ын сайдын 2019 оны А/492 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлсэн. • Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангид судлах “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулан БСШУС-ын сайдын 2019 оны “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” А/390 дүгээр тушаалаар батлан үндэсний хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсэн. • Ерөнхий боловсролын сургуульд судлах Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж БСШУСЯ, ЭМЯ хамтран боловсруулж БСШУС-ын сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна.	100%	

				- Багш мэргэжлээр сургалт эрхэлдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилгоор хийгдэж буй ажлын хүрээнд багш бэлтгэх хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага боловсруулах, багш бэлтгэх сургалтын хөтөлбөр болон багшлах дадлагын шаардлагыг шинэчлэх, шинэ зууны Монгол багшийн загвар боловсруулах, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар судалгаа, дүгнэлт гаргах, сургалт, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах чиглэлээр БШУЯ, Эдийн засгийн хүндрэлтэй үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөлтэй гэрээ байгуулан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж байна. Үүнд: • Гадаад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн багш мэргэжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн судалгаа хийх; • Сургалтын хөтөлбөр судлалаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, хэлэлцүүлэг өрнүүлэх; • Чадварлаг багш хөтөлбөрийн дагуу багш мэргэжлийн стандартад тулгуурлан багш бэлтгэх хөтөлбөр болон багшлах дадлагын шаардлагуудыг шинэчлэх; МУБИС-ийг түшиглэн багш мэргэжлээр сургалт эрхэлдэг их, дээд сургуулиудтай хамтран ажиллах 4 дэд ажлын хэсэгтэй 2021 оны 5 дугаар сараас гэрээ байгуулан ажиллаж байна.		
11	20	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3.. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	- Төрийн албаны зөвлөлөөс 2021 онд 7 хоног бүрийн пүрэв гарагт салбар зөвлөлийн дарга, гишүүд нарийн бичгийн дарга нарт зохион байгуулж байгаа цахим сургалтад яамны албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулж ажилласан. - 2021 оны хагас, бүтэн жилд яамны албан хаагчдад дараах сургалтыг зохион байгуулаад байна. Үүнд: • “Төрийн албан хаагчийн ёс зүй” • “Төрийн албаны дипломат ёслол” • “Төрийн байгууллагад зан үйлийн менежментийг хэрэгжүүлэх нь” • “Худалдан авах ажиллагааны АЗ” • “Монгол хэлний найруулгын зүй” • “Монгол хэлний зөв бичих дүрэм” • “Хувийн болон байгууллагын стресс менежмент” • “Төрийн байгууллагад зан үйлийн менежментийг хэрэгжүүлэх нь” • “Эрүүл амьдралын хэв маяг, зөв зохистой хооллолт - Яам болон харьяа байгууллагын нийт албан хаагчдыг ковидоос урьдчилан сэргийлэх 1, 2, 3 тун вакцинд бүрэн хамруулсан. - Яамны албан хаагчдын 2021 онд ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх шийдвэрийн төслийг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны “Ээлжийн амралтын хуваарь батлах тухай” Б/45 дугаар тушаалаар батлуулж, албан хаагчдад амралтын мэдэгдлийг өгсөн. Яамны албан хаагчдад орон сууцны хөнгөлөлт үзүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан. Орон сууцны дэмжлэг хүссэн албан хаагчдын судалгааг гарган удирдлагад танилцуулсан.	100%	

				2022 оны төсвийн төсөлд яамны албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангахад шаардагдах зардлын саналыг боловсруулсан.		
12	21	Багшийн хөгжлийг дэмжих тухай 2018-06-27 Дугаар 2019.01.01	6.2.. Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.	- “Чадварлаг багш” хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, тэмдэглэл гаргасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн “Хөтөлбөр, төлөвлөгөө, баталж, хэрэгжилтийг хангах тухай” А/07 дугаар тушаалаар Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймаг, нийслэлийн БСУГ, Засаг даргын тамгын газрын нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусган төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд Английн Засгийн газрын дэмжлэгтэйгээр Глобал Греүф институттэй хамтран нийт төрийн өмчийн 669 ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежер болох 1000 сургалтын байгууллагын удирдах ажилтан, багшийг “Дэлхийн түвшний менежер” хөтөлбөрт 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 4 дүгээр сарын 27-ны хугацаанд 12 багц сэдвээр сургалт зохион байгуулж сертификатаа Английн Глобал Греүф институтээс хүлээн аваад байна. Чадварлаг багш хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ерөнхий боловсролын сургалтын байгууллагын удирдлагын арга барилд өөрчлөлт хийх чухал шалгуурыг онцлон үзэж, захирал, менежерүүдийн үнэ төлбөргүйгээр Английн их сургуулийн онлайн сургалтын 6 сарын эрх нээж, сургалтыг монголд хэрэгжүүлэх албан ёсны эрхтэй “Гүрэн” академитай хамтран зохион байгууллаа.	100%	
	22		7.5.. Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	- Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмын төслийг боловсруулсан. 2022 оны III улиралд багтаан батлуулж хэрэгжүүлнэ. - Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирлын 2021 оны 02 сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Дээд боловсролын багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих журам”-ыг боловсруулан батлуулсан.	70%	
	23		8.3.. Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2021 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 264 дүгээр тогтоолын “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 3.2.3, 4.2.4-д заасны дагуу багш мэргэжлээр суралцагчдад төрөөс дэмжлэг үзүүлж байна. 2021 онд төрийн өмчийн дээд боловсролын 6 сургалтын байгууллагад багш мэргэжлээр суралцаж байгаа 1443 оюутанд 1,2 тэрбум төгрөг тэтгэлэг олгосон байна. Үүнд: багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь олгодог бөгөөд 1229 оюутанд 981,7 сая төгрөг, элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь, хичээлийн жилийн эхний улиралд суралцагч 2.8-3.0 болон түүнээс дээш голч дүнтэй суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг 100 хувь олгодог бөгөөд 204 оюутанд 223,0 сая төгрөгийн тэтгэлэг тус тус олгосон байна.	100%	
	24		9.2.. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт, боловсролын сургалтын	- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/812 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын	100%	

		байгууллагын багшийн мэргэжлийн зэргийг суралцагчдын сурлагын амжилт, чанар, суралцагч, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамж, заах аргын чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдлыг харгалзан хугацаанаас өмнө нэмэгдүүлж болох бөгөөд холбогдох журмыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	байгууллагын багш, ажилтанд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/854 дүгээр тушаалаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, аргазүйч, эрхлэгчид мэргэжлийн зэрэг олгох, хасах журмыг баталсан. Ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагын багш, ажилтанд мэргэжлийн зэрэг олгоход а) сурлагын амжилт, б) мэргэжил, арга зүйн ур чадвар, с) багш, хамт олон, эцэг, эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж, д) хөгжүүлсэн байдал гэсэн 4 үндсэн шалгуурыг баримталж байна. Сургуулийн захиралд мэргэжлийн зэрэг олгоход мэргэжил, арга зүйн ур чадварын гэсэн шалгуурыг хасаж “удирдан зохион байгуулах” чадварыг харгалзан үздэг. Мэргэжлийн зэрэг олгоход тавих шалгуурыг хангасан багш, ажилтанд хугацаанаас нь өмнө мэргэжлийн зэрэг олгох зохицуулалтыг дээр дурдсан журмаар зохицуулсан. Журмыг хэрэгжилтийг хангаж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/29 дүгээр тушаалаар 123 багшид “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгож, мэргэжлийн үнэмлэх олголоо. Харин 2021-2022 оны хичээлийн жилд “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийн шалгуурыг хангасан 171 багш, ажилтны баримт бичгийг магадлан шалгаж дүгнэлт гаргах ажил хийгдэж байна.		
25	11.3.. Багшид ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	БШУ-ны сайдын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/198 дугаар тушаалаар “Салбарын цалин хөлсний асуудал хариуцсан хорооны бүрэлдэхүүнийг төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын төлөөлөл оролцсон 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Энэхүү хороо нь салбарын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшуулалтай уялдуулсан гүйцэтгэлд суурилсан цалин хөлс олгох аргачлал боловсруулахаар ажиллаж байна. - Салбарын цалин хөлсний хорооны гишүүдийг чадавхжуулах зорилгоор “Монгол улсын эрүүл мэнд, боловсролын салбарт гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцооны загвар боловсруулах” -аар Олон улсын Хөдөлмөрийн байгууллага болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарсан сургалтыг 6, 7, 11 сард онлайнаар / нэг удаа 30 хүн/ 3 удаа, техникийн хэлэлцүүлгийг 12 сарын 3-ны өдөр танхимаар зохион байгуулж /25 хүн/ ажиллалаа. ОУХБ-аас зохион байгуулсан ГСЦХ-тэй холбоотой судалгаанд салбарын цалин хөлсний асуудал хариуцсан хорооны гишүүд болон салбарын ажиллагсад нийт 461 хүнийг хамрууллаа. “Ажлын хэсэг байгуулах тухай” БШУ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/394 дүгээр тушаалаар байгуулагдсан “Боловсролын салбарын санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж батлуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах зорилгоор “Гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог бий болгох, холбогдох эрх зүйн баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулах, батлуулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулсан ба уг ажлын хэсэг нь 3 удаа хуралдаж, олон улсын болон Монгол дахь Америк сургууль болон “Шинэ эрин” олон улсын сургуулийн арга туршлагыг судалж, бичиг баримтын судалгаа, боловсруулалт хийж байна.	70%		

13	26	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай 2019-05-30 Дугаар 2019.05.30	10.1.1. Сургуулийн нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг инфляцийн түвшин болон суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан жил тутам шинэчлэн батлах;(10.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- Засгийн газрын 2021 оны "Үдийн хоолны норматив тогтоох тухай" 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургагчдын үдийн хоолны зардлын норматив хэмжээг 1500 төгрөг байхаар баталсан. 2021 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчид үдийн цайны үйлчилгээнээс үдийн хоолны үйлчилгээнд шилжээд байна.	100%	
	27		10.1.2.. Энэ хуулийн 10.1.1-д заасан зардал болон тухайн жилд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгаж, хэрэгжүүлэх; (10.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны үйлчилгээний зардалд 58.2 тэрбум төгрөгийг 2021 оны улсын төсөвт тусган зарцуулж байна.	100%	
	28		10.1.3.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжсэн үндэсний хөтөлбөр батлах. (10.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- Засгийн газрын 2020 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 207 дугаар тогтоолоор 4 зорилт, түүнийг хэрэгжүүлэх 22 арга хэмжээ бүхий "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжсэн үндэсний хөтөлбөр"-ийг баталсан.	100%	Хяналтаас хасах
	29		10.2.1.. Эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөрт зохистой хооллох шим тэжээлийн мэдлэг олгох агуулгыг тусган боловсруулж, хэрэгжүүлэх; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн "Сургалтын хөтөлбөр батлах тухай" А/467 дугаар тушаалаар эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг баталж 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар ангийн сурагчдад 6 чиглэлийг агуулгаар 7 хоногт 1 цагаар эрүүл мэндийн хичээл орж байна. Эрүүл мэндийн хичээлийн 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд 2. Хооллолт ба хөдөлгөөн 3. Сэтгэцийн эрүүл мэнд 4. Хорт зуршил 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд 6. Аюулгүй байдал, анхны тусламж гэсэн агуулгын хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн багш, судлаач, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулан НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн хичээлийг зааж буй багшид шаардлагатай нэмэлт мэдээлэл, аль болох шинэлэг мэдээ мэдээлэл, аргазүй шаардах сэдвүүдийг сонгож аргачилсан зөвлөмжийг боловсруулан, хэвлүүлж орон нутагт хүргүүлээд байна. Энэхүү зөвлөмж нь багшид хичээлээ үр дүнтэй заахад тулгуур болох бөгөөд хооллолт ба хөдөлгөөний агуулгыг 100 хувь, бусад 5 агуулгыг 60-80 хувийг зөвлөмж болгон өгч байна.	100%	

30	10.2.2.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, батлуулах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- Хуульд заасан стандартын хамрах хүрээг өргөжүүлэн "Сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага" болгож стандартын төслийг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлж байна. Өнөөдрийн байдлаар стандартын төсөлд шаардлагатай холбогдох хууль тогтоомжийн үнэлгээний тайлан, гадаад улс орнуудын стандарт, гарын авлагын орчуулга зэргийг хүлээн авсан бөгөөд стандартын төсөл боловсруулж буй багтай 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд стандартын төслийг 2 дугаар сард багтаан хүлээн авна.	70%	
31	10.2.3.. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан орон тооны бус Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Журам батлах тухай” 2021 оны 20 дугаар тушаалаар сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус “Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан. Энэхүү журам Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд 2021.02.10-ны өдрийн 5036 дугаарт бүртгэгдсэн бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэх өмчийн бүх хэлбэрийн сургууль мөрдөж ажиллана.	100%	
32	10.2.5.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журмыг мэргэжлийн хяналтын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын холбогдох газар хэлтэстэй хамтран “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналт”-ын журмын төслийг боловсруулсан. Журмын төслийг яамны цахим сайтаар болон аймаг, нийслэлийн Боловсролын газраас санал авч эцэслэн сайжруулж, Боловсрол, шинжлэх ухааны Сайд болон Эрүүл мэндийн Сайд нар танилцаж, гарын үсэг зурсан бөгөөд Шадар сайдад хүргүүлж гарын үсэг зуруулахаар ажиллаж байна. 2022 оны I улиралд багтаан батлуулж, мөрдүүлнэ.	70%	
33	10.2.6.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод	- “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журам”-ын төслийг боловсруулж, Аймаг, нийслэлийн	70%	

		хяналтын журмыг батлах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	Боловсролын газраар дамжуулан 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Журмын төслийг Хууль, эрхзүйн хэлтэс хянаж байна. Энэхүү журам батлагдсанаар суралцагчийн хоол, хүнсний чанар аюулгүй байдалд өдөр тутамд хяналт тавьж, хоол хүнсний хордлого, хордлогот халдвар гарахаас урьдчилан сэргийлж, хуулийн хэрэгжилтийг хангуулах нөхцөл бүрдэнэ.		
34		10.2.9.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, холбогдон гарах зардлыг төсвийн төсөлд тусгаж, хэрэгжүүлэх; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- 2021 онд улсын төсөв болон орон нутгийн төсөв, гадаадын буцалтгүй зээл тусламжаар 35 сургуулийн хоолны газрын засвар үйлчилгээ, 62 сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шийдвэрлэсэн бөгөөд 2022-2024 онд хэрэгжих олон улсын байгууллагын төслийн хүрээнд 55 сургуулийг иж бүрэн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах юм. Салбарын хөрөнгө оруулалтын зардлаас хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нэн шаардлагатай байгаа 99 сургуульд нийт 3.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрхийг шилжүүлсэн. Цаашид хөрөнгө оруулалт шаардлагатай улсын хэмжээнд хоолны газаргүй бөгөөд хоолны газрын өргөтгөл барихаар зураг төсөл боловсруулсан 6 сургууль, зориулалтын бус хоолны газартай 235 сургууль /аймаг, орон нутагт 166, нийслэлд 69/, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж шаардлагатай 250 /аймаг, орон нутагт 238, нийслэлд 12/ сургууль байна.	100%	
35		10.2.10.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	- Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийн сургуулийн хоолны газрын барилга байгууламж, тоног төхөөрөмж, хүний нөөцийн талаар тандалт судалгаанд 20 аймгийн 519 сургууль хамрагдсан байна. Эдгээрийн 21.3% нь гал тогоогүй, 50.1% нь хоолны газартай, 48.3% нь зориулалтын бус гал тогооттой, 21% нь агуулахгүй, 12.2% нь хооллох заалгүй байна. Тандалт судалгаанд хамрагдсан сургуулийн 71.1% нь хоол үйлдвэрлэлийн хэсэгт агааржуулалтын системтэй боловч 39.2% нь хэвийн бус ажиллагаатай байна. Сургуулиудын 11.5% нь үндсэн ажилтангүй, 32.2% нь 1 тогоочтой, 44.4% нь 2 тогоочтой, 16.6% нь 3 тогоочтой, 4.4% нь нь 4 тогоочтой, 2.4% нь 5 ба түүнээс дээш тогоочтой үйл ажиллагаа явуулж байна. Тогооч нарын 72.8% нь хүүхдийн хоолны чиглэлээр мэргэшсэн байна. Сургуулиудын 60.7% нь эмчтэй, 6.7% нь хоол зүйчтэй байна. Үдийн хоолны үйлчилгээг нийт сургуулийн 22.9% нь дотуур байрын гал тогоонд бэлтгэж байгаа бол 35.9% нь гал тогоог түрээслэн үдийн хоолны үйлчилгээг сурагчдад хүргэж байна.	100%	
36		10.2.12.. Энэ хуулийн 10.2.11-д заасан хандив, тусламжийг хүлээн	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Журам батлах тухай” 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/264 тоот тушаалаар сургуулийн хоол	100%	Хяналтаас хасах

			авах ажлыг зохион байгуулах журмыг батлах. (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтын байр болон түүнд ашиглах тоног төхөөрөмжийг худалдан авах, засвар үйлчилгээ хийхэд зориулсан "Хандив, тусламжийг хүлээн авах ажлыг зохион байгуулах журам"-ыг баталсан. Журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5466 дугаарт бүртгэсэн. Энэхүү журмаар сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын шаардлага хангасан зориулалтын байр, гал тогоотой болгох, засвар үйлчилгээ хийх, хоол үйлдвэрлэлийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангахад улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна хандивлагч болон тусламж үзүүлэгч талуудын дэмжлэг туслалцааг авах, түүний эрх зүйн орчин бүрдсэн.		
14	37	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	7.1.8.. Өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулах, сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны "Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай" А/43 дугаар тушаалыг гаргуулж, их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалт, дадлагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авсан. - Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл, мэндийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн "Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай" 78,А/149,А/164,А/14, А/391 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Тус хамтарсан тушаалын 5 дугаар заалтаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, их, дээд сургууль, коллежийн сургалтын төлбөр, хураамжийг эцэг, эх, асран хамгаалагчид санхүүгийн дарамт үүсгэхгүйгээр сар, улирлаар төлөх уян хатан зохицуулалт хийх арга хэмжээ авахыг өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагын удирдах ажилтан нарт үүрэг болгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/135 дугаар тушаалаар "Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, дараагийн төлбөрт шилжүүлэх түр журам"-ыг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү түр журмаар ерөнхий боловсролын сургууль нь сургалтын төлбөрийг эцэг эх, асран хамгаалагчийн санхүүгийн нөхцөл боломжид суурилан уян хатан нөхцөлөөр тооцон авах, теле хичээлээс гадна сурагчдад цахим хичээл, давтлага өгсөн тохиолдолд нэмэлт төлбөртэй авахгүй байх, сургалтын төлбөр төлөөгүй гэх шалтгаанаар цахим болон танхимын сургалтад хамрагдахыг хязгаарлахгүй байх зэрэг асуудлыг зохицуулсан.	100%	Хяналтаас хасах
	38		7.1.9.. Бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо,	- Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд 2019-2020 оны хичээлийн жилд танхимаар хичээллэх нийт өдрийн 47 хувь, 2020-2021 оны хичээлийн жилд 62.5-68.0 хувийг тус тус зайн, цахим хэлбэрээр гэр бүлийн орчинд суралцсан. Танхимын сургалт зайн, цахим хэлбэрт шилжсэн хугацаанд боловсрол, сургалтын үйл ажиллагаа тасралтгүй байдлыг дэмжих хүрээнд 5,756 теле хичээл, 104 интерактив хичээл, 2,775 цахим хичээл, 50 цахим контент, радио болон аудио 30 хичээлийг тус тус бэлтгэн тэгш, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор дохионы хэл, тува, казах хэлний орчуулгатайгаар	100%	Хяналтаас хасах

			түүнд тавих хяналтыг сайжруулах; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	телевиз, радиогоор дамжуулан хүргэх ажлыг телевизүүдийн холбоо, хувийн хэвшлийн болон олон улсын байгууллага (Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан)-тай хамтран зохион байгууллаа. Теле хичээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас үүрэн холбооны оператор компаниудтай хамтран www.econtent.edu.mn. вэб сайтад байршуулсан теле хичээл болон төгсөх ангийн сурагчдад зориулан www.help.eec.mn, www.eyesh.eec.mn цахим хуудсанд үнэ төлбөргүй /дата/ нэвтрэх боломжийг бүрдүүлсэн нь хүүхдүүдэд бодит дэмжлэг болсон. Цар тахлын үед төгсөх ангийн сурагчдын хичээл, сургалтад тусгайлан анхаарч, тэдэнд зориулсан онлайн сургалтын талбарыг үүсгэн цахим хичээлийг улсын хэмжээнд X-XII ангид хичээл зааж байгаа шилдэг 602 багш удирдаж, хот, хөдөөгийн сургуулийн ахлах ангийн 30.1 мянган сурагч онлайн хичээлд хамрагдсан. Энэхүү арга хэмжээ нь хөдөөгийн сургуульд сурч байгаа хүүхдэд өөрийн сургуулийн багшийн хичээлээс гадна бусад аймаг, нийслэлийн сургуулийн шилдэг багшийн хичээлд хамрагдах, бусдаас суралцах, хамтран хөгжих боломж олгоход чиглэсэн. Теле хичээлээс гадна сургуулиуд Google Drive, Google Form, Zoom, Moodle зэрэг программуудыг ашиглан цахим анги үүсгэн хичээл, сургалтаа зохион байгуулж, теле хичээлтэй холбоотой тайлбар, давтлага өгөх, сурагчдаас шалгалт, сорил авах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж, шинэ шинэ туршлагауд хуримтлуулж чадсан .		
15	39	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01	13.3.. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.	- Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд ажлын хэсэгт техникийн болон мэргэжлийн дэмжлэг“ үзүүлж, хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлын дэд хэсгийн төлөвлөгөөг боловсруулж, ҮХГ-аар баталгаажуулсан. Энэхүү төлөвлөгөөний дагуу 3 удаагийн хэлэлцүүлэгт оролцож Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрийн боловсролын салбарын нөхцөл байдлын шинжилгээг 7 алхамтай арга зүйн дагуу хийж гүйцэтгэлээ. Үүнд: • Боловсролын салбарын үндсэн үзүүлэлтүүдийн өнөөгийн байдлыг сүүлийн 5 жил буюу 2016-2020 онуудаар тодорхойлох; • Оролцогч тал буюу үр шим хүртэгч, үйлчилгээ үзүүлэгч, түншийг тодорхойлох; • Асуудал, хэрэгцээг тодорхойлох; • Асуудлын шалтгаан тодорхойлох; • Үр дагаврыг тодорхойлох; • Бодлого зохицуулалтын шинжилгээ; • Нөхцөл байдлын нэгтгэсэн шинжилгээ; • Улмаар боловсролын салбарт тулгамдсан 10 асуудлыг тодорхойлон учир шалтгааны холбоог шинжилж, хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулав. - Түүнчлэн тэдгээр асуудалтай холбоотой хэрэгцээний шинжилгээ хийлээ. Шинжилгээний үр дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Ажлын хэсэг болон ажлын дэд хэсэг байгуулах тухай” 2021	100%	

				оны 50 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Ажлын дэд хэсэгт танилцуулан хэлэлцүүлж санал авлаа. Санал, зөвлөмж дээр үндэслэн нөхцөл байдлын шинжилгээг сайжруулж эцэслэлээ. Дэд ажлын хэсгийн тайланг боловсруулж, Үндэсний хөгжлийн газарт илгээлээ.		
	40		21.5.. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ.	- Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах Засгийн газрын дэд ажлын хэсгийг ЗГХЭГ-ын даргын 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга ахлан ажиллаж байна. Энэ асуудлын хүрээнд боловсролын салбарын нөхцөл байдлын шинжилгээ, хийж ажлын дэд хэсгийн хуралдаанд танилцуулаад байна.	70%	
16	41	Кино урлагийг дэмжих тухай 2021-07-02 Дугаар 2022.01.01	14.3. Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулна. Хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг соёл, боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.		Үнэлэх боломжгүй, хугацаа болоогүй.	
17	42	Хөдөлмөрийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2021-07-02 Дугаар 2022.01.01	17.4. Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг БШУ-ы сайд, ХНХ-ын сайдын хамтарсан тушаалаар байгуулахаар ажиллаж байна. БШУЯ-нд мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын чиг үүргийг шилжүүлж буйтай холбоотойгоор бүтцийн өөрчлөлт хүлээгдэж байна.	Үнэлэх боломжгүй, хугацаа болоогүй.	
18	43	Соёлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2021-07-02 Дугаар 2022.01.01	11.5. Боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн заавал судлах уран бүтээлийн жагсаалт, түүнийг судлахтай холбогдсон журмыг боловсролын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	БСШУ-ны сайдын 2003 оны жагсаалт батлах тухай 81 дүгээр тушаалаар “Сургуулийн өмнөх боловсролын түвшинд эзэмшвэл зохих ардын аман зохиолын төрөл зүйл, шүлэг дууны жагсаалт, БСШУ-ны сайдын 2004 оны 89 дүгээр тушаалаар “Хүүхдэд уран сайхан гоо зүйн мэдлэг олгоход баримтлах, уран бүтээлийн жагсаалт”-ыг баталсан. Энэхүү жагсаалтуудад орсон агуулгыг дахин жагсаалтыг шинэчилж гаргаагүй байна. БСШУ-ны сайдын 2004 оны 89 дүгээр тушаалаар “Хүүхдэд уран сайхан гоо зүйн мэдлэг олгоход баримтлах, уран бүтээлийн жагсаалт”-ыг баталсан. Энэхүү жагсаалт нь Монголын уран зохиол, дэлхийн уран зохиол, ардын аман зохиол, уран зураг агуулгын хүрээнд жагсаалтыг гаргасан. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт тус агуулгыг шингээсэн тул дахин жагсаалтыг шинэчилж гаргаагүй байна. Соёлын тухай Хууль нь 2022.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн тул 11.5. дугаар заалтыг	Үнэлэх боломжгүй, хугацаа болоогүй.	

				2022 оны хийх ажлын төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байна. Тус төлөвлөгөөнд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн заавал судлах уран бүтээлийн судалгаа хийх, жагсаалт гаргах ажлыг тусгана.		
УИХ-ЫН ТОГТООЛ						
19	44	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2013-02-08 Дугаар 2013.02.08	1.2.. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг тусгай сургууль болон сэргээн засалтын бусад төрөлжсөн байгууллага эзэмшүүлэх ажлыг шинэчлэн зохион байгуулах;	- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад боловсролын үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлж байна. Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу сэргээн засалтын төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх тусгай сургуульд 2021 онд 1683 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдаж байна. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-ын дагуу 2021 онд ерөнхий боловсролын сургуульд 4525 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төсөлд цэцэрлэг, сургууль нь хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан хүүхдэд боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй, ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчийн саналыг үндэслэн боловсруулж, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай зөвшилцөн тухайн суралцагчийн танхимд хичээллэх хугацааг уян хатан тогтоож болно. Мөн “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад “...цэцэрлэгийн үндсэн сургалтад хамрагдах боломжгүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх “явуулын багшийн” болон “нүүдлийн бүлгийн” хувилбарт сургалт зохион байгуулах”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааг танхимын сургалтаас гадна зайн, цахим болон холимог хэлбэрээр зохион байгуулж болно.”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнээс хамааран боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль байж болно.” гэсэн заалтуудыг тусгаад байна.	100%	
	45	№19	1.3.. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах чиглэлээр мэргэших дохионы хэлний багш, арга зүйч, эмч, согог зүйч зэргийг бэлтгэх зорилгоор нийт 20-оос доошгүй хүнийг жил бүр гэрээгээр, сургалтын төрийн сангийн зардлаар гадаадад сургах арга хэмжээ авах.	- 2021 онд Орос Монголын засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу богино хугацааны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч цар тахлын улмаас хэрэгжээгүй. Нөхцөл байдалтай уялдуулан гадаадын мэргэжлийн байгууллагын багш, эрдэмтэн нарыг оролцуулан дараах сургалтуудыг цахимаар зохион байгуулсан. - ОХУ-ын Москва хотын Багшийн Их сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн эрхлэгч профессор Елена Владимировна, Япон улсын Хюго Боловсролын Их сургуулийн профессор Тorigoe Такаши нарыг урьж оролцуулан багш нарт хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд ажиллах арга зүйн сургалтыг 2021 онд зохион байгуулсан. Сургалтад ерөнхий боловсролын 29, 116 дугаар сургуулийн багш нарыг хамруулсан.	100%	

				- ЮНЕСКО-оос зохион байгуулсан "Тэгш хамруулан сургах боловсролын үнэлгээ, төлөвлөлт" сэдэвт 2021.03.01-05.01 хүртэлх хугацаанд явагдсан 2 сарын сургалтад БШУЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 6 мэргэжилтэн хамрагдлаа. 14 орны тэгш хамруулан сургах боловсрол хариуцсан мэргэжилтэн оролцсон тус сургалтаар эзэмшсэн тэгш хамран сургах боловсролын төлөвлөлт, бодлого зохицуулалтын тухай мэдлэг ойлголтыг орон нутгийн удирдлагуудад түгээх сургалтыг Хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулахаар бэлтгэж байна. 2021 онд тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах чиглэлээр Япон улсад докторын сургалтад 1 багш, магистрын сургалтад 1 ажилтан хамрагдан суралцаж байна. Мөн АХБ-ны санхүүжилттэй бэлтгэсэн "Нийгмийн сэргээн засалтын цогц арга зүй: Үндэсний сургагч багш бэлтгэх сургалт"-д 6 аймгийн 60 багш ажилтан хамрагдсан. Сургалтад олон улсын нэр хүндтэй багш нар 32 цагийн хичээл заасан.		
20	46	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015-12-03 Дугаар 108-2015-12-30	1.1. 1/Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас хасагдсан, хавсралтад заасан төсөл, арга хэмжээнээс нэг маягийн зураг төслөөр барьж болох, 320 хүртэлх суудалтай сургууль, цэцэрлэг, дотуур байрын барилгыг 2016 оны 1 дүгээр улиралд багтаан концессоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөвт тусган ажиллах;	- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан 2016 онд хэрэгжүүлэх ажлыг даалгасан тогтоол байсан. Улсын Их Хурлаар Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09 -ны өдөр баталсан. 2016 онд шинээр батлагдсан 5 төсөл, арга хэмжээнүүд нь тухайлсан зурагтай байсан бөгөөд бүгд хэрэгжиж дууссан.	100%	Хяналтаас хасах
21	47	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2016-09-09 Дугаар 2016 №47	1.в/. Уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулах, дэд бүтэц, мал аж ахуй, аялал жуулчлал, шинжлэх ухаан болон био технологийн салбаруудад хөрөнгө оруулалтыг татах; (1/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:)	- 2020 онд "Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор"-ын барилгын ажлыг эхлүүлсэн. 2021 онд улсын төсөвт уг барилгын ажлыг үргэлжлүүлэх хүрээнд 24.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусган батлуулж, ажлыг үргэлжлүүлж байна. Уг кластер нь Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ба нийт 4.8 га, 74.300кв.м ашиглалтын талбай бүхий олон улсын стандартад нийцсэн нээлттэй, салбар дундын нэгдсэн, төрөлжсөн, лабораториудаас гадна Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд, бусад их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын 3300 орчим эрдэмтэн судлаач, албан хаагчид ажиллах хүчин чадал бүхий шинжлэх ухаан, инноваци, технологи, танин мэдэхүйн төв байна. Биотехнологийн салбарын судалгааны 14 төслийг 622,969.0 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Эдгээр төслийн үр дүнд шинэ технологи 1, тоног төхөөрөмж 2, патент 9, стандарт 4, ашигтай загварын гэрчилгээ 1 гарч үйлдвэрлэлд нэвтэрсэн байна.	100%	

22	48	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-06-09 Дугаар 2017 №46	1.4.. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвөөр дамжуулан хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг 2017-2018 оны хичээлийн жилээс эхлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байгаа орчинд суурилуулах, зайн сургалтын тоног төхөөрөмж худалдан авах зардал, багшийн цалинг тооцож улсын төсөвт тусгах;	НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд зориулсан 27 интерактив хичээлийг жишиг байдлаар боловсруулан econtent.edu.mn сайтад байршууллаа. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр боловсролын салбарт хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах зорилгоор 21 аймагт “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” байгуулан нийт 669,0 сая төгрөгийн өртөг бүхий 6290 ширхэг /ном, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом, туслах хэрэгсэл нийлүүлсэн байна. Эдгээр танхимд ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, олон нийтийн оролцоо, хандлагыг өөрчлөх, багш хамтран ажиллах, эцэг эх асран хамгаалагчийг зөвлөгөө мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна. Дээрх танхим нь тухайн орон нутагтаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих жишиг танхим болсон. Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүртээмжтэй орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангахад зориулсан санхүүжилтийг тусгаж байна. Тухайлбал, 2022 онд нийт 5,2 тэр бум төгрөгийн санхүүжилт батлагдсан байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт” батлагдсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлж боловсролд хамруулах асуудлыг бүх шатны Нутгийн захиргааны байгууллага зохион байгуулах, танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хүүхдийг хувилбарт сургалтад хамруулах ажлыг цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төв зохион байгуулах талаар тусгасан. Энэхүү аргачлал батлагдсанаар боловсролын гадна байгаа 2000 гаруй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдэж байна.	100%	
	49		1.6.. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн оношлоход шаардагдах оношилгооны иж бүрэн тоног төхөөрөмж, тусгай хэрэгцээт сургуулийн зориулалтын тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын хүртээмжтэй материал, хэрэгсэл, сурагчдыг тээвэрлэх автобусаар хангах;	- 2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа харааны бэрхшээлтэй болон сонсголын бэрхшээлтэй хүүхдийн суралцах орчин, нөхцөлийг дэмжин сайжруулах талаар авах арга хэмжээний төсөл боловсруулж, хэрэгжүүлэн ажиллалаа. - Япон Улсын Жайка ОУБ-н санхүүжилтээр ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн багш, сурагчдыг 60 нэр төрлийн сурах бичгийг сонсдог хэлбэрээр суулгасан, 160ш цахим ном уншигч DAISY-E-PUB төхөөрөмжөөр бүрэн хангасан. -2020 онд нийт 25 сая төгрөгийн санхүүжилтээр 29-р сургуульд 25ш зурагт, 116-р сургуульд 2ш компьютерын монгол цахим брайл гар, 2ш монгол брайлийг дэмждэг Даксберри программ, 60 нэр төрлийн ном, сурах бичгийг сонсдог хэлбэрээр суулгасан 174ш цахим ном уншигч DAISY-E-PUB төхөөрөмжийг тус тус хүлээлгэн өгч, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд үгийн баялгийг нэмэгдүүлэх, хэл яриаг хөгжүүлэх, сургалт зохион байгуулахад нэн шаардлагатай хэрэглэгдэхүүн болох телевизээр хангагдаж, харааны бэрхшээлтэй сурагчид брайл болон сонсдог /DAISY-E-PUB/ хэлбэрийн сурах бичиг, /DAISY-E-PUB/ ном уншигч төхөөрөмжөөр хангагдлаа. 2020 онд ЕБС-ын 40 барилга, цэцэрлэгийн 54 барилга ашиглалтад оруулж, шилжих зориулалтын 130 барилгад нийт 268.5 тэрбум төгрөг зарцуулж байна.	100%	Хяналтаас хасах
	50		1.8.. Тусгай хэрэгцээт боловсролын байгууллагын багшлах боловсон хүчнийг бэлтгэх,	- Монгол Улсын Боловсролын их сургууль “Тусгай хэрэгцээт боловсролын багш”-ийг 2015 оноос эхлэн бакалаврын сургалтаар бэлтгэж эхэлсэн бөгөөд 2019 онд 9, 2020 онд 19, 2021 онд 16 оюутан тус тус төгссөн. Мөн “Тусгай	100%	Хяналтаас хасах

			давтан сургах болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгах;	хэрэгцээт боловсрол” 2 багц цагийн сонгон судлах хичээлийг МУБИС-ийн “Багш” мэргэжлээр сурч байгаа оюутнууд 2015 оноос судалж эхэлсэн өгсөн бөгөөд 2021 онд 320 оюутан энэ хичээлийг сонгон судалсан байна. Тусгай хэрэгцээт боловсролын багшийн ангийн оюутнууд “Дохионы хэлмэрч орчуулагч”-ийн анхан шатны мэдлэг чадвартай байх шаардлагын улмаас “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсрол”, “Дохионы хэл” хичээлийг нийт 5 багц цагаар судалж, дадлагын хичээлийг холбогдох төрийн бус байгууллага болон сонсголгүй иргэдтэй хамтран зохион байгуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, тэгш хамран сургах асуудлаар 2021 онд ердийн сургалттай сургуулийн 1500 орчим багшид цуврал сургалт зохион байгуулж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах анхан шатны мэргэжлийн онол, арга зүйг эзэмшсэн.		
23	51	Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-05 Дугаар 2018 №02	1.3/. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор нийслэлээс орон нутаг руу ажиллаж амьдрах иргэдийн санал санаачилгыг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх, аян өрнүүлэх, дагуул хотуудыг бий болгож шинжлэх ухаан, технологи, инноваци, аялал жуулчлал, аж үйлдвэр, худалдааны чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх, төрийн зарим байгууллага болон төрийн өмчит их, дээд сургуулийг хотоос гаргах, тэдгээрийг холбосон хурдны зам, метро байгуулах урьдчилсан тооцоо судалгаа хийж, нийслэл хотын зарим чиг үүргийг аймгийн зэрэглэлтэй болон дагуул хот руу шилжүүлэх зэрэг асуудлыг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан судалж, холбогдох шийдвэрийг гаргах;	- БШУ-ны сайдын тушаалаар орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр төрөлжүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургуулийг шинээр байгуулах ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг уул уурхай, технологийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталж үйл ажиллагааны төлөвлөгөө хийж байна.	100%	
	52		1.7/. Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, урьдчилан сэргийлэх хүрээнд улсын хэмжээнд сургуулийн өмнөх, ерөнхий болон мэргэжлийн боловсрол, дээд сургуулийн хичээлийн жил эхлэх, дуусах болон улирлын амралтын хуваарийг өөрчлөх асуудлыг судалж, 2018 онд багтаан шийдвэрлэж, хэрэгжүүлэх.	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/747 дугаар тушаалаар хичээлийн жилийн бүтцийг өөрчилж улирлын амралтын хугацааг 12-1 дүгээр сард болгож өөрчилсөн болно. - Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд сургуулийн өмнөх, болон ерөнхий боловсролын сургуулийн хичээл сургалтыг 3 улиралд шилжүүлэн өвлийн хүйтний улиралд оруулахгүй байхаар шийдвэрлэн хэрэгжиж байна.	100%	Хяналтаас хасах

24	53	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2019-05-30 Дугаар 2019 №53	1.1/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хоол зүйчийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн бэлтгэх, төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн эмчийг хөрвөх сургалтад хамруулан 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн хүний нөөц бүрэн бэлтгэгдэх хүртэлх хугацаанд сургуулийн хоол зүйчээр ажиллуулах ажлыг зохион байгуулах;	- Засгийн газрын “Төлөвлөгөө батлах тухай” 2021 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттай хамруулах ажлын төлөвлөгөөнд 2021 онд 60 хоолзүйчийг хөрвүүлэн бэлтгэхээр тусгагдсан. Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 36 дугаар тэмдэглэл, “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 237 тогтоолд аймаг, нийслэлийн боловсролын газарт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий хоолзүйч ажиллуулах асуудлыг шийдвэрлэхийг тусган баталсан. Боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудсаар дамжуулан эхний удаад ерөнхий боловсролын 52 сургуульд хоолзүйчээр хөрвөн ажиллах сонирхолтой 60 хүний материалыг хүлээж аваад байна. Хоолзүйчээр хөрвөх сонирхолтой цаашид сургууль ажиллах мэргэжилтэнд Японы Хүүхдийг Ивээх сантай хамтран сургалтын тэтгэлэг олгох болно.	100%	
	54		1.2/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасны дагуу өдрийн хоолны үйлчилгээнд бага ангийн суралцагчдыг 2021-2022 оны, дунд ангийн суралцагчдыг 2022-2023 оны, ахлах ангийн суралцагчдыг 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн хамруулах;	- Засгийн газрын 2021 оны “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчдын үдийн хоолны зардлын норматив хэмжээг 1500 төгрөг байхаар баталсан. 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчид үдийн цайны үйлчилгээнээс үдийн хоолны үйлчилгээнд шилжээд байна.	100%	
	55		1.3/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан ажилтны цалингийн зардлыг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн улсын төсвөөс санхүүжүүлэх;	- Хоолзүйч, тогооч зэрэг мэргэжлийн хүний нөөцийн хэрэгцээ шаардлага, цалин хөлсний тооцоо судалгааг хийж, БСШУС-ын Байнгын хороонд танилцуулсан. Мөн Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 8 дугаар сарын 11-ны өдрийн 237 дугаар тогтоолоор аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтэст хоолзүйч ажиллуулах орон тоо, цалингийн зардлыг шийдвэрлэсэн.	100%	
	56		1.4/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан байрын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжид шаардагдах зардлыг энэ тогтоолын 8 дахь дэд заалтад заасан төлөвлөгөөний дагуу тухайн жилийн төсвийн төсөлд тусган улсын төсвөөс санхүүжүүлэх;	- 2021 онд улсын төсөв болон орон нутгийн төсөв, гадаадын буцалтгүй зээл тусламжаар 35 сургуулийн хоолны газрын засвар үйлчилгээ, 161 сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шийдвэрлэсэн. 2022-2024 онд хэрэгжих олон улсын байгууллагын төслийн хүрээнд 55 сургуулийг иж бүрэн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангана.	100%	

25	57		1.5/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасан зардлын нормативыг инфляцийн түвшин болон суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан Монгол Улсын Засгийн газраас жил тутам шинэчлэн батлах;	- Засгийн газрын 2021 оны "Үдийн хоолны норматив тогтоох тухай" 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургагчдын үдийн хоолны зардлын норматив хэмжээг 1500 төгрөг байхаар баталсан. 2021 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчид үдийн цайны үйлчилгээнээс үдийн хоолны үйлчилгээнд шилжээд байна	100%	
	58		1.6/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.2.12-т заасан хандив, тусламжийг хүлээн авах ажлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Журам батлах тухай" 2021 оны А/264 дүгээр тушаалаар батлагдсан "Хандив, тусламжийг хүлээн авах ажлыг зохион байгуулах журам"-аар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хандив, хандивлагч байгууллага болон иргэн, тусламж хүлээн авах эрх зүйн орчин бүрдсэн.	100%	
	59		1.7/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байрын түрээсийн гэрээг харилцан тохиролцож дуусгавар болгох ажлыг энэ тогтоолын 8 дахь дэд заалтад заасан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;	- Засгийн газрын 2021 оны "Төлөвлөгөө батлах тухай" 18 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулиудыг үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг баталсан. Энэхүү төлөвлөгөөний дагуу хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын түрээсийн гэрээг 2021-2024 хүртэл үе шаттайгаар дуусгавар болохоор заасан.	100%	
	60		1.8/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар батлах.	- Засгийн газрын 2021 оны "Төлөвлөгөө батлах тухай" 18 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг баталсан.	100%	
25	61	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй	1.4/б/. эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе шаттайгаар зохион байгуулах;	- 2020 оны эхний хагас жилийн байдлаар мэргэжил дээшлүүлэх үндэсний сургалтыг танхимаар зохион байгуулах сургалт "COVID 19" цар тахалтай холбоотойгоор БСШУС-ын сайдын 2020 оны 04 сарын 17-ны А/194 дугаар тушаалын хүрээнд цахим хэлбэрээр сургалт зохион байгуулагдсан. Нийгмийн ажилтны сургалтыг "Судалгааны арга зүй, МХХТ" агуулгаар зохион байгуулсан. "Тэгш хамран сургах" агуулгыг Мэргэжил дээшлүүлэх үндэсний сургалтад бүх зорилтот бүлгээрээ олгодог. Иймээс "Тэгш хамран сургах" агуулгыг 2 дахь цахим сургалтаараа төлөвлөсөн ба тус агуулгыг	70%	

	62	холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62	1.5/б/. хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх зорилгыг бүх шатны боловсролын хичээлийн хөтөлбөрт тусгах;	2020 онд эхний ба 5 болон 10 дахь жилдээ ажиллаж буй 105 нийгмийн ажилтан судалсан. - Хүүхэд, залуучуудад хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг зохион байгуулж байна. Үүнд: - Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн Нийгэмшихүйн сургалтын чиглэлийн агуулгад “хүүхдийн ялгаатай байдлыг мэдэх, хүндэтгэлтэй хандах, өөрөөсөө дүү хүүхдэд болон найддаа туслах, тусламж хүсэх” зэрэг чадварыг эзэмшүүлэх ажлыг тоглоомын үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлж байна. - Иргэний ёс зүйн боловсрол хичээлээр хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрхийн соёлын мэдлэг, чадварыг суралцагчдад олгох, төлөвшүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. - “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд хууль эрх зүйн хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа их, дээд сургуулиуд нь дэргэдээ хууль зүйн клиник лабораторитой болж, салбарын хууль эрх зүйн тогтолцоо, өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлагын судалгааг хийж, үр дүнг олон нийтэд танилцуулж, бакалаврын түвшний оюутнуудад “Хууль зүйн клиник 1, 2”, сургалтыг явуулж “Хууль зүйн үйлдвэрлэлийн дадлага” -аар бататгаж байна. 2019 оныг БСШУС-ын яамнаас ёс зүйн боловсролын жил болгон зарласны хүрээнд их, дээд сургуулийн удирдлага, багш, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн төгсөх ангийн оюутнуудад “Мэргэжлийн ёс зүй, багшийн соёл” сургалтыг зохион байгуулсан бөгөөд хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг Төрийн өмчийн их, дээд сургуульд “Хүний эрх” хичээлийг мэргэжлийн суурь түвшинд 3 багц цагаар нийт оюутанд заавал судлуулж байна.	100%	Хяналтаас хасах
	63	Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай 2020-04-09 Дугаар 2020 №21	Дөрөв.4/. дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлж төр, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчийг цахимаар ажиллах нөхцөлийг хангах, боловсролын алсын зайн сургалтын үйлчилгээг үзүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах хяналт бүхий цахим худалдааг дэмжих, импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодод үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хангамжийг сайжруулах зэрэг арга хэмжээнд шаардлагатай үнэ, тарифын хөнгөлөлтийг үзүүлэх, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	- “Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг онлайн хэлбэрт шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” БСШУС-ын сайдын 2020 оны А/105 дугаар тушаал гарч, тус институтээс танхимд зохион байгуулагдах байсан үндсэн сургалтыг зайн сургалтаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Зайн сургалтын эхний шатыг БСШУСЯ-аас тендер зарлаж, Эй Плас интернэйшнл (A Plus international) компани шалгарч, зайн сургалтыг зохион байгуулсан. Зайн сургалтын эхний шатанд 1,5,10 дахь жилдээ ажиллаж буй нийт 5510 багш, удирдах болон бусад ажилтан хамрагдахаас 4787 хүн буюу 87% нь хамрагдсан. “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/43 дугаар тушаалыг үндэслэн гаргасан “Теле хичээл заах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай” Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын захирлын 2020 оны А/05 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, СӨББ, ЕБС, их дээд сургуулийн багш нар болон Монголын телевизүүдийн холбоотой хамтран Теле хичээлийг 2020 оны 02 дугаар сарын 03-аас зохион байгуулан ажиллаж байна. Монголын телевизүүдийн холбооны нийт 14 телевизийн 170 ажилтан болон СӨБ-ын 20 багш, ЕБС-ийн 314 багш, Тусгай хэрэгцээт боловсролын 28 багш, дохионы хэлний орчуулагч, хэлмэрч 20 багш нийт 710 хүн Теле хичээл бүтээх ажилд	100%	Хяналтаас хасах

				оролцож ажилласан байна. байна. Хэдийгээр теле хичээл нь онцгой байдлын нөхцөлд эрсдэлээс сэргийлсэн тохиромжтой арга боловч нөгөө талаас суралцагчдад хүрэх хүртээмж, хичээлийн чанар агуулга, тохиромжтой байдал зэрэг нь бодит байдал дээр хэрхэн хэрэгжсэн талаар олон хүнд эргэлзээ төрүүлж буй. Учир нь зайны сургалт (теле, цахим гэх мэт)-ын үр нөлөө, тохиромжтой байдалтай холбоотой үнэлгээний ажил ховор байдаг. Иймд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан (НҮБХС) болон БШУЯ хамтран “Онцгой байдлын үеийн теле хичээлийн үр дүн, тохиромжтой байдал”-ийг үнэлэх судалгааны ажлыг хийлгэсэн.		
27	64	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, бүх салбарын төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх;	1.1/. 1.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, бүх салбарын төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх;	- Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын байгууллагуудын санхүүжилтийн сар улирлын хуваарийг улсын төсвийн эх үүсвэр болон Сангийн сайдын өгсөн чиглэлийн хүрээнд нийцүүлэн боловсруулж батлуулсан. Цаашид төсвийн жилийн хугацаанд өр төлбөргүй ажиллах чиглэлийг багцын байгууллагуудад үүрэг болгох, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, цаг тухайд нь шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж ажиллаж байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөх хэрэгжүүлэх гэрээнд 2021 оны төсвийн хэрэгжилтийг Төсвийн хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу төсвийн зарчим, сахилга бат, 2021 оны төсвийн онцлогт нийцүүлэн зохион байгуулах зохицуулалтыг оруулж, хэрэгжилтийн удирдлагыг эхлүүлээд байна. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шилжин хэрэгжиж байгаа цэцэрлэгийн төсөвт өртөг 46,654.5 сая төгрөг, санхүүжих дүн 28,452.4 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. - 2021 онд хэрэгжүүлэх 22 төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр 17,266.3 мянган төгрөгийг шуурхай, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан баталгаажуулж санхүүжилтийг олгуулсан. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх цэцэрлэгийн төсөл арга хэмжээний нийт 34 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц 19 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулж барилгын ажил эхлүүлээд байна. - Аймаг, нийслэлд баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас олгодог зөвшөөрлийг зохих журмын дагуу шуурхай олгоход дэмжлэг үзүүлж ажилласан. Шинээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний барилга эхлүүлэх зөвшөөрөл болон гэрээ сунгах ажлыг 21 аймагтай цахимаар хуралдаж тухай бүр чиглэл зөвлөгөөг өгсөн. - Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, нийт 148 барилга 226,642.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж, орон нутгийн дансанд бүртгүүлсэн.	100%	Хяналтаас хасах
	65		1.2/. Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг	- Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлд УАГ-с өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн нарийн бичгийн даргаар “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн	100%	

		Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах;	нэгтгэсэн тайланд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх” төлөвлөгөөг батлуулан ажиллаа. Тухайн төлөвлөгөөгөөр хариуцах албан тушаалтан болон биелэлтийг гаргах хугацааг тодорхой зааж үүржүүлсэн бөгөөд хугацаанд нь Үндэсний аудитын газарт албан бичгээр хүргүүлсэн. ТНБД-н 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” харьяа байгууллагад Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг чиглэл өгсөн. Түүнчлэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн албан бичиг, ТНБД-ын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 2/2755 дугаар албан бичгээр тус тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг чиглэлийг харьяа байгууллагуудад өгч ажиллаа. Үндэсний аудитын газраас хэрэгжилтийг үнэлж тайлан ирүүлээд байна. Дээрх тайланд төлбөрийн актын биелэлт 96.4 хувь, албан шаардлагын биелэлт 81.6 хувь, зөвлөмжийн биелэлтийг 79.4 хувьтай байна гэж үнэлээд байна.		
66		1.4/. Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн дараа оны төсвийн төсөлд тусгах асуудлыг шийдвэрлэх;	- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдаагүй үлдсэн боловсрол, шинжлэх ухааны салбарт зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай 274 төсөл арга хэмжээний нийт төсөвт өртөг 911,103.0 сая төгрөгийн санал, шинээр хэрэгжүүлэх 510 төсөл арга хэмжээний нийт төсөвт өртөг 1,571,844.2 сая төгрөгийн төслийн саналыг нэгтгэн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн 2022 оны төсвийн саналд хүргүүлж батлуулахаар ажилласан. Үүнд: 2022 онд шилжин хэрэгжүүлэхээр санал өгсөн шилжихээр барилга байгууламж 252 ТАХ, их засвар 17 ТАХ, тоног төхөөрөмж 4 ТАХ, шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж 356 ТАХ, их засвар 117 ТАХ, тоног төхөөрөмж 26 ТАХ, ТЭЗҮ 12 ТАХ хэрэгжүүлэхээр төсвийн саналд тусгасан. 2022 оны батлагдсан улсын төсөвт нийт 429 ТАХ батлагдсан бөгөөд шилжих 256 ТАХ болж буурч, шинээр хэрэгжих 173 ТАХ-ээр хэрэгжихээр батлагдсан.	100%	Хяналтаас хасах
67		1.5/. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Тус ажлын хүрээнд БШУ-ны сайд, БХБ-ын сайд, БОАЖ-ын сайдын хамтарсан тушаалаар Ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг улсын хэмжээнд гадна нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байр болон сумдын инженерийн шугам сүлжээний судалгааг хийж гүйцэтгэн ариун цэврийн байгууламжийн технологийн шийдлийг судлан шийдэж нэг маягийн зураг төсөл, загвар зураг, техникийн тодорхойлолтыг боловсрууллаа. Төсөл, арга хэмжээг зохион байгуулах ЗГ-ын 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 125 дугаар тогтоол батлуулсан. ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж БШУ-ны сайдын 2021.05.21-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” А/188 дугаар тушаалаар нэгдүгээр ээлжид хэрэгжүүлэх 16 аймгийн 54 сумын 195 сургууль, цэцэрлэг, дотуур байрны төсөвт өртгийг баталсан. ЗГ-ын 2021 оны 125 дугаар тогтоол, БШУ-ны сайдын 2021 оны А/188 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог тус яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулан төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov цахим системээр худалдан авах ажиллагааг зарлаж, төлөвлөгөөний дагуу ажлыг эхлүүлж, төсөл арга хэмжээний 2021 оны 1 дүгээр ээлжийн /Архангай,	70%	

				Баян-Өлгий, Баян-Хонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Төв, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий, Увс, Ховд, Хөвсгөл аймгуудын 54 суманд 12 багц төсөл арга хэмжээний шалгарсан аж, ахуй нэгжүүдтэй барилга, угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн. Хөвсгөл, Хэнтий, Баян-Хонгор, арга хэмжээний тендер зарлагдаж, сонгон шалгаруулалт хийгдэж байна. 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэлийн мэдээллийг нэгтгэн 2021 онд багтаан санхүүжүүлэх санхүүжилтийн судалгааг гаргаж Эрдэнэт ТӨҮГ-т 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлэн ажилласан.		
28	68	Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай 2021-01-29 Дугаар 2021 №23	4. Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус үүрэг болгосугай.	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит хуралдааны 35 дугаар тэмдэглэлийн дагуу Боловсролын ерөнхий хууль болон дагалдан гарах хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Хуулийн төслүүдийг 2021 оны 06 сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. Хуулийн төслүүд 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар дэмжигдэн 2021 оны намрын чуулганаар хэлэлцээд байна.	100%	
29	69	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67	1.1.3/. цар тахлаас шалтгаалан ерөнхий боловсролын сургуулийн суурь хичээлүүдийг танхимаар судалж чадаагүй, сурч боловсрох эрх нь зөрчигдсөн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	КОВИД-19 цар тахлын улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг зайн, цахим хэлбэрээр зохион байгуулснаас үүдсэн хичээл, сурлагын хоцрогдлын нөхцөл байдлыг тодруулах зорилгоор “Суралцагчийн сурлагын хоцрогдлыг оношлох үнэлгээ”-г үндэсний хэмжээнд нийт суралцагчийн 10 хувийг хамруулан 2021 оны 9 дүгээр сард зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллалаа. Оношлох үнэлгээнд II-XII ангийн 62.8 мянган сурагч хамрагдаж, давхардсан тоогоор 64 хичээлийн агуулгаар 296,282 нэгж үнэлгээ хийж, сурагчдын хоцрогдож буй агуулга болон гүйцэтгэлд шинжилгээ хийж, үр дүнг холбогдол талуудад танилцуулсан. Энэхүү үнэлгээгээр сурагчдын гүйцэтгэл үндэсний хэмжээнд 2019 онд зохион байгуулсан чанарын үнэлгээний гүйцэтгэлтэй харьцуулахад хичээл бүрд буурсан үр дүн гарсан. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад чиглэсэн сургалт, зөвлөн туслах ажлыг сурагчдын улирлын амралтын үргэлжлэх хугацаанд зохион байгуулах чиглэлийг аймаг, нийслэлийн боловсролын газруудад өгөөд байна. Үнэлгээний үр дүнд үндэслэн авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулаад байна. Мөн “КОВИД-19 цар тахлын дараах боловсролын салбарын сэргэлтийг дэмжих техникийн туслалцаа” төслийн баримт бичгийн төслийг Японы Хүүхдийг ивээх сантай хамтран боловсруулж, Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл (GPE) олон улсын байгууллагад хүргүүлээд байна.	100%	
30	70	Монгол Улсын Их Хурлын 2021 оны	4. Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит хуралдааны 35 дугаар тэмдэглэлийн дагуу Боловсролын ерөнхий хууль болон дагалдан гарах хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн	100%	

		намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай 2021-07-08 Дугаар 2021 №75	хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус үүрэг болгосугай.	мэдүүлэхээр тогтсон. Хуулийн төслүүдийг 2021 оны 06 сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. Хуулийн төслүүд 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар дэмжигдэн 2021 оны намрын чуулганаар хэлэлцээд байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төсөл багтсан. Уг хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг Улсын Их Хурлын даргын 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 58 дугаар захирамжаар байгуулагдсан.		
УИХ-ын байнгын хорооны тогтоол						
31	71	Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай 2013-04-16 Дугаар 2013 №04/04 НББСШУБХ/Т БХ	1.4/. Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр суралцаж төгсөөд эх орондоо ирсэн мэргэжилтнүүдийг гэрээний дагуу захиалагч байгууллага дараалал харгалзахгүйгээр эхний ээлжинд ажлын байраар хангах, тухайн төгсөгчийг захиалагч байгууллагадаа ажиллах гэрээний хугацаа дуусахаас өмнө хууль бусаар ажлаас чөлөөлсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол хууль бусаар ажлаас чөлөөлсөн этгээдээр сургалтын төлбөрийг төлүүлэх зарчмыг мөрдөж ажиллах,	- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Боловсролын зээлийн сан” байгуулах талаар авах арга хэмжээний тухай” 111 дүгээр тогтоолоор Сургалтын зээлийн санг Боловсролын зээлийн сан болгон өөрчлөн зохион байгуулж, Боловсролын зээлийн сангийн дүрмийг баталсан.	100%	Хяналтаас хасах
	72		1.5/. Сургалтын төрийн сантай гэрээ байгуулан гадаадад суралцахаар явсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй иргэдийн мэдээллийг тухайн оронд суугаа Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд болон холбогдох бусад байгууллагатай хамтран эзэн, холбогдогчдыг тодруулж тогтоох, зээлийн өрөө барагдуулаагүй иргэдийн барьцаанд тавьсан үндсэн хөрөнгийг борлуулан зээлийг төлүүлэх,	- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Боловсролын зээлийн сан” байгуулах талаар авах арга хэмжээний тухай” 111 дүгээр тогтоолоор Сургалтын зээлийн санг Боловсролын зээлийн сан болгон өөрчлөн зохион байгуулж, Боловсролын зээлийн сангийн дүрмийг баталсан.	100%	Хяналтаас хасах
	73		1.6/. Инженер-технологийн чиглэлээр дэлхийд шатлалаараа 100-д багтдаг нэр хүндтэй их	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай” 78 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” 271	100%	Хяналтаас хасах

		сургуулиудад төрөлхийн гоц авьяастай, улс, тив, дэлхийн олимпиадуудад эхний гурван байрт орсон хүүхдүүдийг төрийн зардлаар сургахад тавих шалгуурыг хөнгөрүүлэхгүй байх, эдгээр авьяастай хүүхдүүдийг гадаад хэлний тусгайлсан бэлтгэлд хамруулж эдгээр сургуулиудад элсэх бэлтгэлийг хангах нөхцөлийг бүрдүүлж өгөх,	дүгээр тогтоолоор батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолоор тус тус Монгол Улсын иргэдийг өндөр боловсролтой, хөгжингүй орны боловсрол эзэмшүүлэх зорилгоор дэлхийн шилдэг их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын түвшинд сургаж байна. “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалтыг баталсан. Тус жагсаалтад инженер, технологийн чиглэлээр утасгүй холбоо, өгөгдлийн ухаан, системийн аюулгүй байдал, хиймэл оюун ухаан, химийн инженерчлэл ба боловсруулалт, байгаль орчныг хамгаалах технологи, электроник, механик инженер, нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи, хүнсний инженерчлэл, газрын тосны инженер, уул уурхайн ашиглалтын технологи, барилгын материалын үйлдвэрлэлийн технологи, хаягдал боловсруулах технологи, биотехнологи, био-инженерчлэл, нано инженерчлэл зэрэг мэргэжлүүд тус тус багтаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг олгох журам, Монгол Улсын ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журмыг Засгийн газрын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 275 дугаар тогтоолоор батлуулсан. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг нь ЭЕШ-ын оноогоор тухайн сум, хороондоо тэргүүлсэн тус бүр нэг суралцагчийн сонгож, тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт хамруулах, улмаар дэлхийн шилдэг 100 сургуульд бакалаврын түвшинд суралцуулах тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах гэсэн 2 үе шаттайгаар явагдана. Ингэснээр тэтгэлэгт цөөн тооны тэр дундаа гүнзгийрүүлсэн болон олон улсын хөтөлбөрийн сургалттай сургуулийн суралцагч хамрагддаг байдлыг арилгасан, нөгөө талаас орон нутгийг чадварлаг боловсон хүчнээр хангах асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэсэн. Мөн Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт олон улсын уралдаан, тэмцээнд эхний 3 байрт орсон суралцагчийг сургалтын бүрэн тэтгэлэг олгохоор тусгасан.		
74		1.7/. төрийн сангийн зээлийг мэргэжлийн ямар чиглэлээр олгох, зарцуулалт, эргэн төлөлтийн талаарх мэдээллийг ил тод нээлттэй болгон суралцахыг хүсэгчдэд мэдээлэл олгодог тусгай төв байгуулах,	- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Боловсролын зээлийн сан” байгуулах талаар авах арга хэмжээний тухай” 111 дүгээр тогтоолоор Сургалтын зээлийн санг Боловсролын зээлийн сан болгон өөрчлөн зохион байгуулж, Боловсролын зээлийн сангийн дүрмийг баталсан.	100%	Хяналтаас хасах
75		1.8/. Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадын их, дээд сургууль болон магистрантур, докторантурт суралцуулах хүний тоо, мэргэжлийн чиглэлийг холбогдох яамдаас гаргуулан авч	- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Боловсролын зээлийн сан” байгуулах талаар авах арга хэмжээний тухай” 111 дүгээр тогтоолоор Сургалтын зээлийн санг Боловсролын зээлийн сан болгон өөрчлөн зохион байгуулж, Боловсролын зээлийн сангийн дүрмийг баталсан.	100%	Хяналтаас хасах

			нийтэд мэдээлэх, захиалгын дагуу нийтэд нээлттэй шалгаруулан суралцуулах,			
32	76	Шинжлэх ухааны байгууллагуудыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай 2014-04-23 Дугаар 2014 №07 НББСШУБХ	5. Эрдэм шинжилгээний зориулалт бүхий дундын нээлттэй лаборатори байгуулах, холбогдох тоног төхөөрөмж импортлоход гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх.	- Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагаа зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд “Лабораторийн судалгаа хөгжлийн зөвлөх” 18/09, “Лабораторийн магадлан итгэмжлэлийн зөвлөх” 18/10 зөвлөх үйлчилгээний судалгаа хийгдэж зөвлөмж гаргасан. ЗГ-ын 2019 оны 448 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодисыг гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх ажлыг Гаалийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж байна. Тогтоол төслийн хавсралтад тусгагдсан түүхий эд, материал, урвалж бодисын жагсаалтад гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, лабораторийн оношлуур үйлдвэрлэл, биотехнологи, микробиологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, байгалийн эрдэст бэлдмэлийн үйлдвэрлэл, эм, эм бэлдмэлийн үйлдвэрлэл, малын эм, эм бэлдмэл, шимт тэжээл, туршилтын үйлдвэрлэл зэрэг 7 салбарын инновацийн төсөл хэрэгжүүлэгч 12 байгууллагын 68 инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай 188 нэр төрлийн түүхий эд, материал, урвалж бодис хамрагдсан. Эдгээр түүхий эд, материал, урвалж бодисыг гаалийн татвараас 5 хувь буюу 183.9 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараас 10 хувь буюу 381.7 сая төгрөгийг чөлөөлснөөр инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нийт 565.6 сая төгрөгийн татварын хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлсэн. Үндэсний хэмжээнд дундын ашиглалтын болон сүлжээ лабораториудын тооллогыг анх удаа зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний байгууллагуудын лабораторийн нэгдсэн тооллогод их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, төв болон мэргэжил, арга зүйн байгууллагын харьяа сургалт, судалгаа, шинжилгээ, хяналтын лабораториудыг хамруулсан. Судалгаагаар Монгол Улсын эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, хувийн болон үндэсний хүрээлэн төвүүдийн дэргэд судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 54 байгууллагын сургалт, судалгаа, шинжилгээ, хяналтын 311 лаборатори, үүнээс олон улсад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн 24 лаборатори байгааг тоолж, баталгаажуулав.	100%	Хяналтаас хасах
	77		9. Төр-шинжлэх ухаан-бизнесийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлж, төрийн аливаа бодлого, шийдвэрийн төсөл боловсруулахдаа холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын санал, дүгнэлт, зөвлөмжийг харгалзаж байх.	- Хууль, тогтоомжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт Хууль тогтоомжийн төсөл боловсруулах явцад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдээс санал авч, төсөл боловсруулахад харгалзан үзэхээр туссан. Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.3.2 дахь заалтад захиргааны хэм хэмжээний актын төслийн хэлэлцүүлгийг эрдэмтэн, судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд зохион байгуулахаар зохицуулсан ба хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	Хяналтаас хасах

				Энэ хүрээнд 2021 онд боловсруулсан Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөлд эрдэм шинжилгээний байгууллагын санал, дүгнэлтийг тусгасан. Мөн УУХҮЯ-аас ХХААХҮЯ, БШУЯ-тай хамтран “Үйлдвэрлэлийн салбарт технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам”-ын төслийг боловсруулж, 3 сайдын хамтарсан тушаалыг батлуулсан. Энэ журмын төсөл боловсруулах ажлын хэсэгт төр-хувийн хэвшлийн эрдэмтэн судлаач, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллийг оролцуулж, санал, дүгнэлтийг тусган батлуулсан.		
33	78	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2015-06-13 Дугаар 2015_11	2. Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3, 39 дүгээр зүйлийн 39.12, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 8 дугаар зүйлийн 8.6, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 7.10 дахь хэсэгт заасан журам, үлгэрчилсэн дүрэм, стандартыг боловсруулж, батлан мөрдөх	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Журам батлах тухай" А/803 дугаар тушаалаар "Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам"-ыг батлан хэрэгжүүлж байна. БСШУС-ын сайдын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/425 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-д хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг хөгжлийн ахицаар үнэлэхээр тусган баталсан Тус журмын 3.15-д Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ, Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна, 3.16-д Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ гэж тус тус тусгасан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг тэгш хамруулан сургах боловсролын бодлогын орчинд чухал баримт бичиг болсон. Боловсролын багц хууль батлагдсанаар журмуудыг шинэчлэн батлах ажлыг үе шаттай зохион байгуулна.	100%	Хяналтаас хасах
34	79	Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааг дэмжих зарим арга хэмжээний тухай 2017-02-16 Дугаар 2017 №17	1.1/. Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулж, 2017 оны 2-р улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах;	- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоолоор “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого” батлагдсан. - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/443 дугаар тушаалаар Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг бүрэн хангасан. Харин 2021 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд орсон өөрчлөлтийг үндэслэн Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолын 5, 10 дахь заалтаар дээрх бодлогын баримт бичгийг хүчингүй болгосон.	100%	Хяналтаас хасах
	80	НББСШУБХ	1.2/. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан	- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 343 дугаар тогтоолоор “Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.	100%	Хяналтаас хасах

		технологийн төсөл хэрэгжүүлэх журам”, шинжлэх ухаан, технологийн салбарт Засгийн газраас батлан мөрдүүлж буй журам, зааварт үүссэн шинэ нөхцөл байдал, мэргэжлийн байгууллагаас гаргасан саналыг харгалзан өөрчлөлт оруулж, салбарын үйл ажиллагааны зохицуулалтыг уян хатан, боловсронгуй болгох;	- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам” батлагдсанаар мөн холбогдох өөрчлөлтүүд орсон. 2021 оны байдлаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Судалгааны төсөл санхүүжүүлэх, хэрэгжүүлэх хугацааг сунгах тухай” А/108 дугаар тушаалаар Улсын захиалгат 2021 оноос эхлэн хэрэгжүүлэх 29 төсөлд 934,000,000.0 төгрөг, үргэлжлэн хэрэгжиж буй 54 төсөлд 1,634,126.0 төгрөгийн санхүүжилтийг батлан, хэрэгжиж байгаа төслийн үр дүнг хүлээн авах хугацааг тус тус 1 жилээр сунгах уян хатан зохицуулалтыг хийлээ. Мөн хөтөлбөрийн зорилтот төслийг сонгон шалгаруулж, БШУ-ны сайдын 2021 оны А/179 тоот тушаалаар 5 зорилтот төсөлд 568.8 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн.		
81		1.3/. Монгол Улсын Засгийн газрын “Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 27 дугаар тогтоол, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2015 оны 78 дугаар тогтоолын хэрэгжилтийг тус тус хянаж, шинжлэх ухааны байгууллагуудын бүтэц тогтолцоо, харьяаллыг өөрчилсөнтэй холбоотойгоор үүсч буй тулгамдсан асуудлуудыг 2017 онд багтаан судлан шийдвэрлэх, цаашид тогтолцоог оновчтой болгох;	- Монгол Улсын Засгийн газрын 2019 он “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 379 дугаар тогтоол батлагдсан. - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/104 дүгээр тушаалаар Засгийн газрын 2019 оны 379 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. Үүний зэрэгцээ Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоолоор ШУТС-г ажлын алба болгон 24 орон тоотой ажиллахаар, ШУТУЗ-ийг хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой өргөжүүлсэн, зарим хүрээлэн төвийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, ШУА-ийн харьяанд Тархи судлалын хүрээлэнг байгуулахаар шийдвэр гарсантай холбогдуулан дараах зохицуулалтыг хийлээ: ШУТС-ийн бүтэц, дүрмийн өөрчлөлтийн төслийг боловсруулсан. ШУТУЗ-ийг гэрээт шинжээч авч ажиллуулах, цалин хөлсийг тооцож олгохтой холбоотой шийдвэр бүхий БШУ-ны сайдын 2021 оны А/366 дугаар тушаалыг баталж, хэрэгжилтийг бүрэн хангалаа. ШУА-ийн харьяанд Тархи судлалын хүрээлэнг байгуулж, төсвийг 2022 оны төсөвт тусган батлуулсан. Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн, Ой мод судлалын хүрээлэнг ШУТИС-ийн харьяанд улсын төсвөөс санхүүжүүлэхээр зохицуулалтын арга хэмжээ авч, төсвийг 2022 оны улсын төсөвт тусган батлуулсан.	100%	Хяналтаас хасах
82		1.4/. Шинжлэх ухааны байгууллагуудын барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой хөрөнгийн маргааныг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, цаашид тухайн байгууллагуудын	- Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор өөрчлөгдөн зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний байгууллагуудын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг балансаас баланст, орон тоо, төсвийн хамт шилжүүлэн, чиг үүргийн дагуу ажиллуулах арга хэмжээг зохион байгуулсан. Тус тогтоолоор: 1.Палеонтологи, геологийн хүрээлэнг Палеонтологийн хүрээлэн, геологийн хүрээлэн; 2.Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнг Биологийн хүрээлэн, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн; 3.Түүх, археологийн хүрээлэнг Түүх угсаатны зүйн хүрээлэн, Археологийн хүрээлэн; 4.Физик,	100%	Хяналтаас хасах

		тогтвортой, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх;	технологийн хүрээлэнгийн информатикийн салбарыг МУИС-ийн Математикийн хүрээлэнтэй нэгтгэн Математик, тоон технологийн хүрээлэн болгож тус тус зохион байгуулалтын бүтцийг өөрчлөн шинэчилсэн. Энэхүү тогтоолоор шинээр зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний байгууллагуудын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг балансаас баланст, орон тоо, төсвийн хамт шилжүүлж, дүрмийг батлуулан чиг үүргийн дагуу ажиллуулах арга хэмжээг зохион байгуулсан. Хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоолоор ШУА-ийн харьяанд Тархи судлалын хүрээлэнг байгуулж, 15 орон тоотой, ШУТИС-ийн харьяанд Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнг шилжүүлж 48 орон тоотой, ШУТИС-ийн харьяанд Ой мод судлалын хүрээлэнг байгуулж 25 орон тоотой ажиллахаар баталж, төсвийг 2022 оны улсын төсөвт тусган дээрх эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүдийн хэвийн ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлээ.		
83		1.6/. Шинжлэх ухаан, технологийн салбарт ажиллагсдын цалин хөлс, нийгмийн баталгааг үе шаттай нэмэгдүүлэх, төсвийн байгууллагын цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулах замаар эрдэм шинжилгээний ажилтнуудын цалин хөлсийг төрийн өмчит их, дээд сургуулиудын багш, профессорын жишигт хүргэх, залуу эрдэмтэн судлаачдыг дэмжих бие даасан хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;	- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 276, 472 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээ шинэчлэн батлагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 162 дугаар тогтоолоор “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдсан хэдий ч ХБТТУХ-ийн өөрчлөлтийг үндэслэн 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон. ШУТИ-ийн салбарын санхүүжилтийн тогтолцоог тогтмол болон өрсөлдөөнт санхүүжилтийн зарчимд шилжүүлэх ажлын хүрээнд эрдэм шинжилгээний ажилтны өнөөгийн цалингийн шатлал, ангилал зэрэглэлийг тогтоох нөхцөлийг судалж, 2022 оны төсөвт багтаан цалингийн шатлалыг нэмэгдүүлэх саналыг боловсруулж, СЯ-д хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.	70%	
84		1.7/. Салбарын бодлого төлөвлөлтийг сайжруулах, салбар дундын уялдаа холбоог хангах, эдийн засгийн өсөлтөд шинжлэх ухааны үүрэг ролийг нэмэгдүүлэх, Шинжлэх ухаан технологийн Үндэсний зөвлөл болон яамдын дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, суурь судалгааны үр дүнг төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах арга механизмыг бүрдүүлэх;	- Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоолыг батлуулж, тогтоолын 1, 10 дахь заалтаар ШУТҮЗ-ийг хуульд тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангаж, мэргэжлийн гэрээт шинжээчдийг авч ажиллуулах боломжийг бүрдүүлсэн. ШУТҮЗ-ийн дүрмийн дагуу ШУТИ-ийн салбарын бодлого эрхзүйн орчин, салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд ШУТҮЗ-ийн салбар зөвлөлийн саналыг тусган ажлын уялдааг ханган ажиллаж байна. ШУТҮЗ-ийн үйл ажиллагаанд яамдын дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн төлөөлөл тогтмол оролцож, бодлого шийдвэр, салбарт хэрэгжиж буй томоохон төсөл хөтөлбөрт санал зөвлөмж, дүгнэлт шийдвэр гаргах эрхтэй оролцдог. Уг үйл ажиллагаа нь бүрэн тогтмолжсон болно.	100%	Хяналтаас хасах
85		1.9/. Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг хэвийн	- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 19 дүгээр тогтоолоор Монгол Улсад өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинжлэх ухааны	100%	Хяналтаас хасах

		явуулах, туршилт судалгаа хийх, үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэнд оруулах тусгайлсан дэд бүтэц, маркетинг, менежментийн тогтолцоог бүрдүүлэх;	паркийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэйгээр “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулагдсан. Захиргаа, аж ахуйн алба, Маркетинг, инновацийн алба, Лаборатори, техникийн алба, Технологи дамжуулах алба, Технологи инкубаторийн алба гэсэн нийт 5 албатайгаар байгуулагдсан. Захиалгат төсөл, гэрээт ажил болон гаднын байгууллагатай хамтарсан эрдэм шинжилгээний төсөл, судалгааны ажил гүйцэтгэх, маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох, инновацийн бүтээгдэхүүн гаргах, технологи дамжуулалтыг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагаа явуулахаар стратеги төлөвлөгөөнд тусгасан. Үүнээс гадна инновацийн дэд бүтцийн хувьд төрийн өмчийн сургууль, төр хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд байгуулагдсанаар авч үзвэл: УБ хотын хэмжээнд 17 технологи дамжуулах төв, 13 дундын оффис, 9 инкубатор төв, 32 бизнес хөгжлийг дэмжих төв, орон нутагт 30 бизнес хөгжлийг дэмжих төв байгуулагдан хөдөө аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээ, туршилт судалгааг хийж, зарим бүтээгдэхүүн үйлчилгээг эдийн засгийн эргэлтэд оруулж байна.		
86		1.10/. Шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй, нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлыг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчны хүрээнд шийдвэрлэх, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.	- 2019 оны 12 дугаар сарын 20-ны УИХ-ын нэгдсэн чуулганаар Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж баталсан. “Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. “Алсын хараа -2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024” хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүд батлагдсантай холбоотойгоор шинэчлэлийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулахаар УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийг буцаан татах шийдвэрийг гаргууллаа. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/381/А/274/А/313 дугаар хамтарсан тушаалаар “Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам”-ыг баталсан. Технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффист гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид татварын дэмжлэг үзүүлэх журмын төслийг боловсруулсан.	100%	
87		1.8/. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэх, биет бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор тусгай зориулалтын сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Монгол	- 2017 онд Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээг төрийн худалдан авалтаар дэмжих зорилгоор ЭМЯ, ХХААХҮЯ, ОБЕГ-тай хамтран инновацийн 18 нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдан авахаар холбогдох тушаал шийдвэр, хамтран ажиллах гэрээний үндсэн дээр дэмжлэг үзүүлсэн. Худалдан авах ажиллагааны хүрээнд ЭМ-ийн сайдын 2017 оны А/66 дугаар тушаалаар эм эмнэлгийн оношлуур, эмийн бэлдмэл, урвалж бодис болон хүнсний нэмэлт бэлдмэл зэрэг 16 нэр төрлийн	100%	

			эрдэмтдийн бүтээсэн, дотооддоо үйлдвэрлэх боломжтой инновацийн бүтээгдэхүүнийг улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг дэмжих;	бүтээгдэхүүн, ХХААХҮЯ-ны захиалгаар малын долооц, ОБЕГ-ын захиалгаар хортон шавж устгах бэлдмэл, нийт 400 сая төгрөгийн төрийн худалдан авалтаар дэмжих ажлыг зохион байгуулсан. - ШУА-ийн Биологийн хүрээлэн, ХӨСҮТ, МУИС-ийн эрдэмтдийн багийн хамтарсан Sars-Cov2 вирусийн халдварын эсрэг бие үүсэж, дархлаа тогтсон эсэхийг богино хугацаанд илрүүлэх оношлуурын цомгийг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг төрөөс 180 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлээ. - Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг үндэслэн Эрүүл мэндийн яамны захиалгаар Боловсрол, шинжлэх ухааны яамнаас <i>Р.Оюунгэрэл удирдагчтай</i> “Монгол Улсад бүртгэгдсэн шинэ коронавируст халдвар (COVID-19)-ын эмнэлзүйн судалгаа”, <i>Ч.Батмогтох удирдагчтай</i> “Монгол Улсад SARS-CoV-2 шинэ вируст халдварын геномын судалгаа”, <i>П.Нямдаваа удирдагчтай</i> “Монгол Улсад SARS-CoV-2 омгуудын геномын бүтцийг тодорхойлж, молекул эпидемиологийн онцлогийг тогтоон, манай орны нөхцөлд тохирсон тандалт, сэргийлэх аргачлал, зөвлөмж гаргах” судалгаа, <i>Ц.Оюунсүрэн удирдагчтай</i> “Хүний биед SARS-CoV-2 вирусийн халдварыг эсрэг бие үүсгэж дархлаа тогтсон эсэхийг богино хугацаанд илрүүлэх оношлуурын цомгийг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх бэлтгэл ажил хангах” судалгаа, <i>Г.Батбаатар удирдагчтай</i> “SARS-CoV-2-ыг шүлсэнд илрүүлэх шинэ ПГУ оношлуур бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх” эрдэм шинжилгээ, судалгааны 5 төсөлт ажилд нийт 821,521.0 мянган төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн.		
35	88	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017-06-09 Дугаар 2017 №24 НББСШУБХ	1.1/. Боловсролын багц хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, 2017 оны намрын чуулганы хугацаанд УИХ-д өргөн мэдүүлэх;	- Боловсролын ерөнхий хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах хуулиудын төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан. Хуулийн төслүүдийг 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихыг дэмжсэн тэмдэглэл гарсан. Нэмэлт судалгаа, шинжилгээ, боловсруулалт, Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон дагалдан гарах хуулийн төслийг сайжруулах ажил хийгдэж, 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барьсан.	100%	Хяналтаас хасах
	89		1.2/. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030 батлах тухай” болон “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолд заасан боловсролын салбарт хэрэгжүүлэх зорилтыг хангах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, шаардагдах	- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д боловсрол, шинжлэх ухааны салбарын чиглэлээр тусгах зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 1а/273 албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” батлагдсан. Тухайн бодлогын баримт бичигт тусгагдсан салбарын холбогдох үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	Монгол Улсын урт хугацааны хөтөлбөр “Алсын хараа 2050” батлагдсантай холбогдуулан Тогтвортой хөгжлийн үзэл

		хөрөнгийг тухайн жилийн улсын төсөвт тусган баталж, хэрэгжүүлэх;			баримтлал 2030 хүчингүй болсон. Хяналтаас хасах
90		1.3/. Салбарын хөрөнгө оруулалтын үр нөлөөг дээшлүүлж, ашиглах боломжгүй болсон сургууль, дотуур байр, цэцэрлэгийн барилгын судалгаа, бүртгэлийг нарийвчлан гаргаж, улс, орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэн барьж байгуулах ажлыг эхлүүлж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;	- Боловсрол, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, үр ашиг, нөлөөг дээшлүүлэх, ажлын хүрээнд аймаг, нийслэл 330 сум, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн хүчин чадал, насжилт, дэд бүтэц, сургууль цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоо зэрэг 32 асуумжаар судалгаа шинжилгээ хийсэн. Судалгаанд үндэслэн салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн газарзүйн мэдээллийн нэгдсэн систем дээр үндэслэн төлөвлөж хэрэгжилтийг хангаж байна.	100%	
91		1.4/. Тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харъяалалд хууль тогтоомжид заасны дагуу яаралтай шилжүүлэх, Боловсролын асуудал эрхэлсэн эрдэм, шинжилгээ, арга зүйн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, сургалт, арга зүйн сектортой болох, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудал эрхэлсэн орон тоог бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах талаар баримтлах бодлого боловсруулж, батлан мөрдүүлэх, энэхүү бодлогын хүрээнд тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгт ажиллаж байгаа багш ажилтны нийгмийн асуудал, ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийн	Бага, дунд боловсролын тухай 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан нийслэлийн ерөнхий боловсролын 25, 29, 55, 63, 70, 116 дугаар сургууль, 10, 186 дугаар цэцэрлэгийг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяанд шилжүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Мөн БСШУС-ын 2019 оны А/625 дугаар тушаалаар Боловсролын хүрээлэнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, арга зүйн сектор”-ийг шинээр байгуулсан. Энэ сектор нь эрдэм шинжилгээ, судалгаа хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх арга зүй боловсруулахаас гадна “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Төв нь нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, багш нарт дэмжлэг үзүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 208 дугаар тогтоолоор ердийн хэв шинжтэй цэцэрлэг, сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл олгохоор шийдвэрлэсэн. Уг тогтоолын дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш туслах багш нар цалингийн 10 хувийн нэмэгдэл авч байна. Харин тусгай сургууль, цэцэрлэг ажиллаж буй багш, ажилтан Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох, тусгай сургалтын байгууллагын зардал тооцох журам”-ын дагуу 10-30 хувийн нэмэгдэл авч байна.	100%	Хяналтаас хасах

		бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид нэмэгдэл хөлс олгох зэрэг асуудлыг судлан шийдвэрлэх;			
92		1.5/. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хоол, хүнсний хангамжийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, чанарыг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх, “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгох эрх зүйн орчныг бий болгон шаардагдах төсвийг 2018 оны Улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;	- 2021 оны Засгийн газрын 237 дугаар тогтоолоор үдийн цайны нормативыг 1500 төгрөг болгож 2021 оны 9 сарын 1-с 373 мянга гаруй хүүхэд хамрагдаж 5:9 зарчмаар хичээллэн үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна. 2022 оны төсөвт дунд ангийн (6-9) ангийн хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт 2022 оны 9 сарын 01-ний өдрөөс эхлэн хамруулахаар 121.0 тэрбум төгрөгийн зардлын тооцооллыг хийн төсвийн төсөлд тусган СЯ-нд хүргүүлсэн. 2022 оны Төсвийн тухай хууль 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлагдахад 6-9 ангийн сурагчдын үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацааг хойшлуулан 2023 оноос хэрэгжүүлэхээр болсон тул зөвхөн бага ангийн сурагчдын үдийн хоолны зардалд 80.5 тэрбум төгрөг батлагдаад байна.	100%	Хяналтаас хасах
93		1.6/. Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын төвийн ажлын байрны нөхцөлийг сайжруулах асуудлыг шийдвэрлэх, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгаа, арга зүйн мэргэжлийн чадавхыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах;	- Багшийн хөгжлийн ордонд 2017 онд Боловсролын хүрээлэн, Боловсролын зээлийн сан, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтыг байршуулсан. Тус ордны өрөө тасалгааны хүртээмж хүрэлцэхгүй тул Боловсролын үнэлгээний төвийг “Оюуны ундраа группийн байранд, Насан туршийн боловсролын үндэсний төвийг МУБИС-ийн ... дүгээр байранд тус тус өрөө түрээслэх замаар байршуулан ажиллаж байна. 2019-2020 онд Боловсролын үнэлгээний төвд ДБ, АХБ-ны 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр элсэлтийн ерөнхий шалгалтын материалыг засах төхөөрөмж нийлүүлсэн.	100%	Хяналтаас хасах
94		1.7/. Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын лаборатори Монгол тэмүүлэл, Шинэ эхлэл сургуулийг тус тус сурч боловсрох орчныг хангасан зориулалтын хичээлийн байртай болгох, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;	- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо олон улсын сургалттай "Монгол тэмүүлэл" сургууль/ төсөвт өртөг 7,000.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ 2020-2021 онд хэрэгжихээр батлагдсан. 2021 оны улсын төсөвт төсөвт өртөг нэмэгдэж 8,500.0 сая төгрөгөөр батлагдаж санхүүжих дүн 3,500.0 сая төгрөгөөр батлагдсан. Барилга угсралтын ажил 2021 оны эхний хагас жилийн байдлаар 80 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.	100%	Хяналтаас хасах
95		1.8/. Гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийг их, дээд сургуулиудын лицей сургууль, багшлах боловсон хүчнийг давтан сургах, мэргэшүүлэх бааз суурь болгох эрх зүйн орчныг бий болгох, дээрх сургуулиудын сургалтын хураамжийн тодорхой хэсгийг сургууль өөрийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор зарцуулах	- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Боловсролын тухай хуулийн дагуу тодорхой шаардлага хангаж, хөтөлбөрөө баталгаажуулсан ерөнхий боловсролын сургууль ахлах ангид гүнзгийрүүлсэн сургалт эрхлэх боломжийг нээлттэй байдлаар зохицуулсан. Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль”-ийн төсөлд дунд ангиас математик, байгалийн ухаан, техник-технологи, хэл, урлаг, спортын чиглэлээр суралцагчийн авьяас, чадварыг хөгжүүлэх төрөлжүүлсэн сургалт зохион байгуулж болох заалтыг тусгаад байна.	70%	

		санхүүгийн боломж нөхцөлийг бий болгох;			
96		1.9/. Боловсролын салбарт бодит хөрөнгө оруулалт хийж байгаа төрийн бус өмчийн сургуулиудыг дэмжих бодлого боловсруулах, багш, ажилтнуудад олгох тэтгэвэр, тэтгэмж олгох эрх зүйн орчин бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх;	- Төрийн албаны шинэтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэх ажлын хүрээнд БШУ-ны Сайдын 2021 оны А/125 дугаар тушаалаар Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийг боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, 6 чиглэлээр 25 ажлын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Салбарын цалин хөлсний асуудал хариуцсан хороог байгуулан “Боловсрол, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах аргачлал боловсруулах, холбогдох дүрэм журмыг шинэчлэх чиглэлээр ажиллах юм.	30%	
97		1.10/. Боловсролын үнэлгээний төвийн бие даасан хараат бус байдлыг хангах, шалгалтын даалгаврын санг байгуулах замаар шалгалтын даалгаврын нууцлалтай холбоотой олон нийтийн хардлагыг арилгах, шалгалтын бүртгэл, зохион байгуулалт, материал засах, дүн, оноог мэдээлэх, мэдээллийн сангийн баталгаатай, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийг нийлүүлж, их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтын баталгаатай ил, тод нээлттэй шуурхай, байдлыг хангах;	- Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулдаг элсэлтийн ерөнхий шалгалтад шууд засалтын технологийг 2018 оноос нэвтрүүлсэн. Энэ ажлын хүрээнд аймаг, дүүрэг дэх шалгалтын төвүүдэд шууд засалтын scantron засагч машинуудыг ажиллуулах мэргэжилтнүүдийг бэлтгэж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж байна. - Шалгалтад олон нийтийн хардлагыг арилгах, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор хяналтын дуран, металл илрүүлэгч, гар утасны сүлжээ сарниулагч, зөөврийн болон суурин чанга яригч зэрэг тоног төхөөрөмжийг суурилуулан, техникийн аюулгүй байдал, доголдолгүй бүрэн ажиллагааг ханган ажиллаж байна. - Байгууллагын хараат бус байдлыг хангахтай холбогдуулан шалгалтын сэдэв, даалгавар бэлтгэх, сэдэв боловсруулагч, эксперт хийх багш, туслах ажилтан, хэвлэлийн ажилтан, брайл үсгийн багш, хамгаалалтын цагдаа, үйлчилгээний ажилтан, албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр гар утас, интернэтийн сүлжээгүй, бүрэн камержуулсан орчинд нэг сарын хугацаанд ажиллуулж хэвшсэн. Ерөнхий боловсролын сургуулийн 16 хөтөлбөрийн агуулгаар 27000 даалгавар бүхий даалгаврын нэгдсэн санг үүсгэн, жил бүр даалгаврын тоог нэмж, чанаржуулан, программын хөгжүүлэлт хийснээр сургууль, багшийн түвшинд үнэлгээний даалгавар боловсруулахад бодит дэмжлэг болж байна. Программ хангамжийг хөгжүүлж, жил бүрийн чанарын үнэлгээ болон элсэлтийн ерөнхий шалгалтын даалгаврын шинжилгээг байршуулснаар багш, сургуулийн удирдлага, Боловсролын газрын мэргэжилтнүүд сургалтын үр дүнгээ үндэсний болон орон нутаг, сургуулийн түвшинд харьцуулан, багшийн хөгжлийг дэмжих хэрэгцээг тодорхойлох боломж бүрдэж байна.	100%	
98		1.11/. Ерөнхий боловсролын сургууль сэтгэл зүйчтэй байх, дотуур байрны багшийн ээлжийн амралтын хоногийг бусад багш нартай адил байхаар эрх зүйн орчинг бий болгох;	- Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан Боловсролын ерөнхий хуулийн төслийн 13.3.3-т дотуур байрын багш, нийгмийн ажилтан, арга зүйч, сургалтын менежерийн ээлжийн амралт бусад багштай адил байхаар тусгасан. Мөн Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулийн төсөлд ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллах, сэтгэл зүйчийн чиг үүргийг тус тус тусгасан. 2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 124 сэтгэл зүйч ажиллаж байна. Тэдний	100%	

			50.0 хувь буюу 62 сэтгэл зүйч нийслэлд, 50.0 хувь буюу 62 сэтгэл зүйч орон нутагт ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас “Боловсролын сэтгэл зүйч”-ийн мэргэшүүлэх сургалтыг 2021 онд зохион байгуулсан бөгөөд сургалтаар 62 сэтгэл зүйчийг бэлтгэсэн.		
99		1.12/. Багш өөрийгөө хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, тэдэнд хувь хүний хөгжлийн, байгууллагын, манлайллын болон бусад сургалтуудыг үе шаттай явуулж, багаараа болон бие даан хөгжих сонирхлыг дэмжих бодлого хэрэгжүүлэх, боловсролын салбарын багш, ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, багшийн цалинг ажлын үр дүнтэй уялдуулан олгох, ажлын үр дүнг үнэлэх үнэлгээний системийг индексжүүлэх, багшийн мэргэжил нь үр дүнтэй, тогтвортой, төрийн албанд шат ахин ажиллах, амьдралаа дээшлүүлэх нөхцөл болдог үнэ цэнийг бий болгох, багшийн нийгмийн баталгаа, хөгжлийн талаар бие даасан эрх зүйн орчин бий болгох, ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч нарт мэргэжлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл олгох талаар Боловсролын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхэд тусгах;	- УИХ-д өргөн барьсан Боловсролын ерөнхий хуулийн төсөлд багш, ажилтны нийгмийн баталгаа, мэргэжлийн тасралтгүй хөгжил, төрийн албанд тогтвортой шат ахин ажиллах талаар тодорхой заалтуудыг тусгасан. Тухайлбал: Хуулийн төслийн 13 дугаар бүлэгт багшийн эрх, үүрэг, нийгмийн баталгаатай холбоотой 35 заалт тусгагдсан. Мөн УИХ-д өргөн барьсан сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн 16 дугаар бүлэгт Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн чиглэлээр 8 заалтыг тусган, хэлэлцүүлэх шатандаа байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.8 дахь заалтын хүрээнд “Чадварлаг багш” арга хэмжээний төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, тэмдэглэл гаргасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн “Хөтөлбөр, төлөвлөгөө, баталж, хэрэгжилтийг хангах тухай” А/07 тушаалаар “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж байна. - Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Салбарын цалин хөлсний асуудал хариуцсан хороо байгуулах тухай” А/198 дугаар тушаалаар баталсан хороо нь боловсролын салбарын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшуулалтай уялдуулсан гүйцэтгэлд суурилсан цалин хөлс олгох аргачлал боловсруулахаар ажиллаж байна. - Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 2 дугаар сарын 01-ны өдрийн “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” А/35, А/10, А/9 хамтарсан тушаалаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг баталсан. - Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 812 дугаар тогтоол, БСШУС-ын сайдын 2018 оны “Журам батлах тухай” А/812 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн багш, менежер, захирлуудад мэргэжлийн зэрэг олгож байна. - Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн үнэлгээний журмын төслийг Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нийцүүлэн боловсруулаад байна.	100%	
100		1.13/. Багшийг төрийн тэргүүлэх үйлчилгээний албан хаагч болгох, төрийн албан хаагчийн зарим баталгаагаар хангах асуудлыг судлан шийдвэрлэх;	- УИХ-д өргөн барьсан Боловсролын ерөнхий хуулийн төсөлд Боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн онцгой ивээлд байлгах зарчмыг баримтлахаар тусгасан. Мөн хуулийн төсөлд багш, ажилтны нийгмийн баталгаа хангах чиглэлээр тодорхой заалтуудыг тусгасан. Тухайлбал:	70%	

			- Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ; -Тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан багшид нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг үзүүлнэ зэрэг 8 заалтыг тусгасан болно. Хуулийн төслийг УИХ-ын түвшинд хэлэлцүүлж байна. - Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 02 дугаар тэмдэглэлээр “Чадварлаг багш” хөтөлбөрийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Багш нарын нийгмийн баталгааг хангах чиглэлээр багш нарын орон сууцны нөхцөл байдлын судалгааг хийсэн. Ажлын хэсэг байгуулж багш нарт зориулсан ипотекийн зээлийн нөхцөлийг судалж, Монгол банк, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн 42830 багш ажилтнуудын амьдралын орчинд: хашаа байшинд 30.5%, орон сууцанд 43.2%, монгол гэрт 16.5%, бие даасан тохилог сууцанд 2.4%, нийтийн байранд 3%, ажиллагсдын нийтийн байранд 1.4%, айлд амьдардаг 2.6%, оюутны байранд 0.5%, зориулалтын бус байранд 0,2% амьдарч байгаа бөгөөд багш нарын 77,2% цалингийн зээлтэй, 58,6% ипотекийн зээлтэй, 61,9% хэрэглээний зээлтэй байна.		
101		1.14/. Боловсролын салбарын удирдах ажилтнууд болон багш нарын ажлын хариуцлага, ёс зүйг сайжруулахад онцгойлон анхаарч, хуулийн хүрээнд хариуцлага тооцон ажиллах;	- Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/32 тоот тушаалаар “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулан ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна, Боловсролын бүх шатны байгууллагын дэргэд ёс зүйн зөвлөлийг байгуулан тусгай төлөвлөгөө гарган сургалт, сурталчилгаа явуулан ажиллаж байна. БСШУС-ын сайдын 2018 оны А/243 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллаж байна.	100%	
102		1.15/. Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрт хүүхдэд мэдлэг, боловсрол олгохоос гадна тэдний хүмүүжил, бие бялдар төлөвшил, бие хүнийг хөгжүүлэх, нийгэмшүүлэх талаар хийгдсэн холбогдох судалгаануудад үндэслэн хүүхдийн хандлага төлөвшлийн шалгуур үзүүлэлтийг бий болгох, сургалтын стандарт, ном сурах бичгийн агуулга, арга зүйг шинэчлэн боловсруулж, батлан хэрэгжүүлэх талаар судалж, шийдвэрлэх.	БСШУС-ын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн суралцагчдын судлах “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталсан. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр нь “Бага ангийн сурагч монгол хүн болж төлөвших суурь мэдлэг, чадвар, дадал эзэмших, дунд ангийн сурагч монгол иргэн болж хүмүүжих, ахлах ангийн сурагч эх орныхоо эзэн монгол хүн болж төлөвших” ерөнхий зарчим, шалгууртай бөгөөд зорилго нь хүнлэг энэрэнгүй, цэвэр ариун сэтгэлтэй, билиг оюун төгөлдөр, монгол үндэстнийхээ хэл, соёлыг эзэмшсэн, бахархаж хэрэглэдэг, хүндэлж хамгаалдаг, эх орноо эрхэмлэн дээдлэх үүрэг, хариуцлагаа ухамсарласан, хүмүүнлэг нийгмийг цогцлоон байгуулах ирээдүйн монгол иргэнийг өсгөх, хүмүүжүүлэх, бэлтгэхэд оршиж байгаа юм. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр нь сурагчид ёс зүйн боловсрол буюу ёс суртахууны хэм хэмжээг өөртөө хэвшүүлж хүмүүжил төлөвшилтэй, зөв хандлагатай болох шалгуурыг агуулсан юм. Мөн 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 200 дугаар тогтоолоор “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Батлан	100%	

				хамгаалах яамтай хамтран баталлаа. Үндэсний хөтөлбөрийн зорилго нь хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулж, эх орноороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах бахархлыг тээгч байх, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлж, түүх, соёл, шинжлэх ухааны давтагдашгүй үнэт өвийг үе дамжуулан үлдээх, байгалийн унаган төрхийг хадгалж, экосистемийн тэнцвэрт байдал болон тогтвортой хөгжлийг хангахад оршино. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Батлан хамгаалахын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 2019 оны А/567/А227/А268 дугаар хамтарсан тушаалаар “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна.		
	103		2.. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс хийх ажлын төлөвлөгөө гаргаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгахыг БСШУС-ын сайд, Сангийн сайд нарт даалгасугай.	- Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдсанаар эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг таван жилээр төлөвлөн боловсруулж батлуулахад салбарт хэрэгжүүлэх бодлогын зорилго, зорилт, хүрэх үр дүн, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан, үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг гаргасан. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлагдахад салбарын санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг жил бүрээр тусгуулсан.	100%	
	104		3.. Тогтоолын хэрэгжилтийн талаар НББСШУБХ-ны хуралдаанд 2017 оны намрын чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг МУ-ын Засгийн газарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг НББСШУБХ-ны даргад тус тус үүрэг болгосугай.	- Боловсролын багц хуулийн төсөлд 2020 оны 11-12 сард олон нийтээс санал авч, хэлэлцүүлгийг 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, 88 их дээд сургууль болон УИХ, Засгийн газрын төлөөлөл оролцсон өргөн бүрэлдэхүүнтэйгээр үндэсний хэмжээнд зохион байгуулав. 2/ Багц хуулийн төсөлд: Боловсролын ерөнхий хуулийн төсөл Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулийн төсөл Дээд боловсролын тухай хуулийн төсөл Судалгааны их сургуулийн тухай хуулийн төслийг боловсруулсан. 3/ Төслийг 2021-06-23 өдрийн ЗГ-ын хурлаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барьсан.	100%	Хяналтаас хасах
36	105	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017-07-05 Дугаар 2017 №25 НББСШУБХ	1.1/. Нийслэлийн цэцэрлэггүй 25 хороонд цэцэрлэг барих асуудлыг 2017-2019 онд үе шаттай шийдвэрлэх;	- Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлд эрх шилжүүлсэн нийт 149 төсөл арга хэмжээнээс сургууль 44, цэцэрлэг 81, спорт заал 6, дотуур байр 1, шинжлэх ухааны барилга 1, их засвар 9ш, тоног төхөөрөмж 6 төсөл арга хэмжээ хэрэгжүүлснээс 10,560 хүчин чадалтай 20 сургуулийн барилга, спорт заал 2, 4675 ортой 26 цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулсан байна. Их засвар 7, тоног төхөөрөмжийг 4 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан.	100%	Хяналтаас хасах
	106		1.2/. Нийслэлийн 75 цэцэрлэг, хөдөө орон нутгийн нэн шаардлагатай цэцэрлэгт өргөтгөл хийх;	- Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлд эрх шилжүүлсэн нийт 149 төсөл арга хэмжээнээс сургууль 44ш, цэцэрлэг 81 ш, спорт заал 6ш, дотуур байр 1ш, шинжлэх ухааны барилга 1ш, их засвар 9ш, тоног төхөөрөмж 6 ш төсөл арга хэмжээ хэрэгжүүлснээс 10,560 хүчин чадалтай 20 сургуулийн барилга, спорт заал 2, 4675 ортой 26 цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулсан байна. Их засвар 7, тоног төхөөрөмжийг 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан. 2021 оны жилийн эцсийн байдлаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга угсралтын	100%	

			төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2020-2021 онд нийт төсөвт өртөг 204.8 тэрбум төгрөгийн 156.4 тэрбум төгрөгөөр санхүүжиж 56 төсөл арга хэмжээ ашиглалтад орсон байна. Үүнд: Ерөнхий боловсролын 16 сургууль хүчин чадал 5160 суудал, сургуулийн өмнөх боловсролын 27 байгууллага хүчин чадал 4735 ор, дотуур байр 9 хүчин чадал 715 ор, ерөнхий боловсролын спорт заал 3, боловсролын байгууллага 3 байна. Мөн АНУ-ын буцалтгүй тусламжаар Цэцэрлэгийн барилга /Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум/ 50 ор, Цэцэрлэгийн барилга /Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум/ 50 ор, Цэцэрлэгийн барилга /Увс аймаг, Баруунтуруун сум/ 50 ор, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Сургуулийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүргэ, 26 дугаар хороо/ 920 хүүхдийн суудал, Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 19 дүгээр хороо/ 640 хүүхдийн суудал, Сургуулийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо/ 640 хүүхдийн суудал, Сургуулийн барилга /Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо/ 920 хүүхдийн суудал, Япон улсын буцалтгүй тусламжаар Сургуулийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, 75 дугаар сургууль/ 960 хүүхдийн суудал, Азийн хөгжлийн банкны зээлээр Сургуулийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 122 дугаар сургууль/ 640 хүүхдийн суудал, Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 164 дүгээр цэцэрлэг/ 150 ор, Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 65 дугаар цэцэрлэг/ 120 ор, Цэцэрлэгийн барилга /Говьсүмбэр аймаг Сүмбэр сум, 5 дугаар цэцэрлэг/ 150 ор, нийт ерөнхий боловсролын 6 сургууль 4720 хүүхдийн, сургуулийн өмнөх боловсролын 6 байгууллага 570 орны хүчин чадалтайгаар ашиглалтад хүлээн авсан байна.		
107	1.4/. Улсын хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй болсон цэцэрлэгийг буулгаж, газрын байршил, зориулалтыг өөрчлөхгүйгээр шинээр барих;	- Монгол Улсын 2019-2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтын шаардлага хангахгүй болсон цэцэрлэгийг буулгаж, газрын байршил, зориулалтыг өөрчлөхгүй шинээр 2460 хүүхдийн хүчин чадал бүхий 11 цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулж, хэрэгжилтийг хангасан байна.	100%		
108	1.5/. Хувилбарт сургалт буюу хөдөө, орон нутагт сургуулийн өмнөх боловсрол олгох явуулын сургалтыг хамрах хүрээг өргөжүүлэх;	- Монгол Улсад сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй нийт хүүхдийн 7-8 хувь (17.1-20.7 мянган хүүхэд) нь хувилбарт сургалтад хамрагдаж байгаагийн 90 гаруй хувь нь малчин болон алслагдсан бүс нутагт оршин амьдарч буй өрхийн хүүхэд байна. Цэцэрлэгийн үндсэн бүлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулах журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйлчилгээний хүртээмж, чанар, орчин нөхцөл, аюулгүй байдал, багшлах хүний нөөц, санхүүжилт, эцэг эх, асран хамгаалагчид, орон нутгийн захиргааны байгууллагын оролцоо дэмжлэгийн өнөөгийн нөхцөл байдлыг судлан тайлан дүгнэлтийг гаргалаа. Дээрх судалгааны тайлан, дүгнэлтэд үндэслэн "Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт зохион байгуулах журам"-ыг шинэчлэн i) сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтын төлөвлөлт, зохион байгуулалт, хүүхдийн хөгжлийн үнэлгээ, ii) сургалтын орчин, аюулгүй байдал, iii) багш ажилтны ажиллах нөхцөл, iv) эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо, хамтын ажиллагаа, v) санхүүжилт, vi) элсэлт бүртгэл зэрэг	100%		

			асуудлын хүрээнд төслийг боловсрууллаа. Журам батлагдсанаар хөдөөгийн сум бүрд хувилбарт сургалтын багш ажиллуулах боломж нөхцөл бүрдсэнээр хувилбарт сургалтын хүртээмж нэмэгдэнэ. Журмыг Сангийн сайдтай хамтран батлуулах тул тус яамнаас санал авах, хэлэлцүүлэн батлуулах асуудлыг 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.		
109		1.6/. Шинээр барих цэцэрлэгийн хүчин чадлыг тухайн орон нутгийн хүн амын тоо, өсөлтийг харгалзан тогтоох, газрын асуудлыг шийдвэрлэх;	- Газар зүйн мэдээллийн системд суурилж боловсрол, шинжлэх ухаан, инновацын салбарын хөрөнгө оруулалтыг төлөвлөн цэцэрлэг, сургуулийн байршлыг оновчтой тогтоож, тухайн орон нутгийн хүн амын тоо, өсөлтийг харгалзан тооцож 2020 онд улсын төсвөөр 63 цэцэрлэг ашиглалтад орсон ба 2021 онд Боловсролын салбарын хөрөнгө оруулалтаар 87 цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтад оруулахаар төлөвлөн ажилласан.	100%	
110		1.7/. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны стандартыг мөрдүүлж, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллах;	- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.2.2-т заасан стандартын хамрах хүрээг өргөжүүлэн "Сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага" болгож стандартын төслийг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлж байна. Мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, хүүхдэд зориулсан хоол, шим тэжээлийн боловсрол олгох сургалтын 4 багц гарын авлагыг боловсруулж, хэвлэлтэд шилжүүлээд байна. Уг багц гарын авлагаар хүүхдэд эрүүл мэнд, хоол шим тэжээл, хоол, хүнсний мэдрэхүйн үзүүлэлтүүд, хүнсний бүлэг гэж юу вэ, хүнсний чанар аюулгүй байдлыг хэрхэн хангах, амьдралын зөв хэвшил дадал зуршлыг бий болгох чиглэлээр мэдлэг, ойлголт өгнө.	100%	
111		1.8/. Цэцэрлэгийн багш, ажилтны орон тоог хүүхдийн тоотой уялдуулах, туслах багшид цагийн хөлс олгох эрх зүйн орчинг бий болгох;	- Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн Боловсрол, шинжлэх ухааны салбарт цэцэрлэгийн орон тооны нормативыг шинээр боловсруулсан нормативаар тооцож хүргүүлсэн. Цэцэрлэг, сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэн Засгийн газрын хурлаар 2021 оны 12 дугаар сарын 29-ний өдөр оруулахаар ажиллаж байна. Хувьсах зардлыг шинэчлэн тогтоож батлуулах гэж байгаатай холбоотойгоор орон тооны нормативыг батлуулахаар ажиллаж байна. Засгийн газрын 2016 оны "ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ, САНХҮҮЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ" 242 дугаар тогтоолд багш, ажилтны хувьсах зардлын нормативыг шинэчлэн боловсруулж БШУ-ны сайдын 2022 оны 1а/546 тоот албан бичгээр яамдаас санал авахаар явуулсан.	70%	
112		1.9/. Цэцэрлэгийн туслах багшийг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд бэлтгэх;	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны "Сургалтын жишиг хөтөлбөр батлах тухай" А/278 дугаар тушаалаар "Цэцэрлэгийн туслах багш бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр", "Гэрчилгээ"-ний загварыг тус тус баталсан. Тус тушаалаар сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэдэг магадлан итгэмжлэгдсэн зарим их, дээд сургуульд 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн цэцэрлэгийн туслах багш бэлтгэх сургалт эрхлэх зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Цэцэрлэгийн туслах багш бэлтгэх зарим арга хэмжээний тухай" А/132 тушаалыг батлан мөрдөж байна. Цэцэрлэгийн туслах багш бэлтгэх зөвшөөрлийг 2021-2022 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх	100%	Хяналтаас хасах

			боловсролын багш бэлтгэдэг 7 сургуульд олгон туслах багшийг бэлтгэж байна - Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/05 дугаар тушаалаар Цэцэрлэгийн туслах багшийг бэлтгэх их дээд сургуулиудад зөвшөөрөл олгох ажлын хэсэг байгуулж, тус тушаалын ажлын хүрээнд Цэцэрлэгийн туслах багш бэлтгэх сургуулиудын судалгаа хийж, 6 их, дээд сургуульд цэцэрлэгийн туслах багш бэлтгэх зөвшөөрөл олгох БШУСайдын 2021 оны А/132 дугаар тушаал гарсан. Үүнд: /Монгол Улсын Боловсролын их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Гурван-Эрдэнэ дээд сургууль, Дорнод их сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Ховд их сургууль/		
113		1.10/. 0-3 насны хүүхдийг асран харгалзах, сургаж хүмүүжүүлэх өнөөгийн бодит боломж, нөхцөл, эрх зүйн орчныг судалж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж тус Байнгын хороонд танилцуулах;	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/142 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр”- баримт бичгийн төслийг боловсруулсан. Энэхүү хөтөлбөрийн баримт бичгийн төслийн зорилт, үйл ажиллагаа нь 0-3 хүртэлх настай хүүхдийг гэр бүлд түшиглэсэн олон хувилбартай үйлчилгээнд хамруулах замаар нийгмийн суурь үйлчилгээг үзүүлж, тэдний цогц хөгжлийг дэмжих боломж бүрдүүлэхэд чиглэж байна. Шинэчлэн боловсруулсан хөтөлбөрийн төслийг Боловсролын багц хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхтэй холбогдуулан хойшлуулсан бөгөөд МУЗГ-ын хуралдаанд оруулж танилцуулах бэлтгэл хангаад байна. Хөтөлбөрийн төслийг Сангийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны хүрээнд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, батлуулахад бэлтгэж байна.	70%	
114		1.11/. Цэцэрлэгт хамруулах насыг 3-5 нас болгож өөрчлөх талаар судлан, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах.	- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2 дугаар бүлгийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны хүүхэд хамрагдана.", 4.3-т "Сургуулийн өмнөх боловсролыг 5 настай хүүхдэд заавал эзэмшүүлэх бөгөөд 200-аас доошгүй цагийн сургалтад хамруулсан байна." гэж насыг өөрчлөн тусгасан. Шинэчилсэн хуулийн төслийг 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн бөгөөд УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан. Энэхүү зохицуулалтын үндэслэл нь дэлхийн 225 улсын 156 буюу 69,3 хувь нь хүүхдийг 3-5 насанд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж байгаа чиг хандлагад нийцүүлж, НҮБ-ын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилго 4.2-т "Сургуулийн өмнөх чанартай боловсролыг хамгийн багадаа 1-ээс доошгүй жил үнэ төлбөргүй заавал эзэмшүүлж, бага боловсрол эзэмшихэд бэлтгэгдсэн байх" зорилт, НҮБ-аас бага насны хүүхдийн хөгжил боловсролын талаар дэлхийн улс орнуудад өгч буй зөвлөмжид үндэслэсэн. Монгол Улсад 3-5 насны 231,2 мянган хүүхэд байгаа бөгөөд хууль батлагдсанаар эдгээр хүүхдийг 100% цэцэрлэгийн үндсэн сургалтаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх боломж бүрдэх юм.	100%	
115		2.. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс хийх ажлын төлөвлөгөө гаргаж, жил	- Тухайн онд шинээр ашиглалтад орох сургууль, цэцэрлэгийн хүчин чадлаас хамаарч, шинэ орон тоо, хүчин чадлын тооцооллыг хийж, жил бүрийн төсвийн төсөлд тусган Сангийн яаманд хүргүүлж байна. Жишээ нь: 2020 оны	100%	

37			бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд /Г.Чулуунбаатар/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Н.Номтойбаяр/, Эрүүл мэндийн сайд /А.Цогцэцэг/, Сангийн сайд /Б.Чойжилсүрэн/ нарт даалгасугай.	төсвийн төсөлд шинээр ашиглалтад орох сургуулийн өмнөх байгууллагын 9925 хүүхдийн хүчин чадалтай 61 барилга нэмэгдэж, багш, багш бус албан хаагч 1228 орон тоогоор өсөж, төгрөгийн цалин НДШ, тогтмол зардал бусад урсгал зардалд 13,5 тэрбум төгрөгийн санал хүргүүлсэн. Харин ерөнхий боловсролын сургуулийн шинээр ашиглалтад орох 46306 хүүхдийн хүчин чадалтай 122 ЕБС-ийн барилга, өргөтгөлийн барилга 95, дотуур байр 13, спорт заал 14 нэмэгдэж, багш, багш бус албан хаагч 1763 орон тоогоор өмч, цалин, НДШ, тогтмол зардал бусад урсгал зардалд 21.7 тэрбум төгрөгийн санал хүргүүлсэн.		
	116		3.. Тогтоолын хэрэгжилтийн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанд 2017 оны намрын чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг НБСШУБХ-ны дарга /Л.Энх-Амгалан/-д тус тус үүрэг болгосугай.	- Боловсролын багц хуулийн төсөлд 2020 оны 11-12 сард олон нийтээс санал авч, хэлэлцүүлгийг 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, 88 их дээд сургууль болон УИХ, Засгийн газрын төлөөлөл оролцсон өргөн бүрэлдэхүүнтэйгээр үндэсний хэмжээнд зохион байгуулав. - Багц хуулийн төсөлд: Боловсролын ерөнхий хуулийн төсөл Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулийн төсөл Дээд боловсролын тухай хуулийн төсөл Судалгааны их сургуулийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Төслийг 2021-06-23 өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барилаа.	100%	Хяналтаас хасах
	117	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017-07-25 Дугаар 2017 №26 НБСШУБХ	1.а.1/. а.Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр: Их сургуулиудыг судалгаанд суурилсан хэлбэрээр хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, санхүү, хөрөнгө оруулалтын зохих дэмжлэг үзүүлдэг болох;	Судалгааны их сургуулийг байгуулах, удирдлага, чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий “Дээд боловсролын тухай” болон “Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай” 2 хуулийн төсөл боловсруулагдсан. Эдгээр хуулийн төслийн хэлэлцүүлгүүд зохион байгуулагдаж байна. Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар дараах ач холбогдолтой байна. Үүнд: • Эрдмийн эрх чөлөөг баталгаажуулж, эрдэм шинжилгээ, судалгааны чадамжийг сайжруулж, мэдлэгт суурилсан эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангана. • Шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэхэд ахиц гарч, шинэ бүтээл, үр ашигтай шинэ технологийг нэвтрүүлэх, ашиглах хөгжүүлэх ажлыг төрийн ивээлд зохион байгуулна. • Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн, судлаачдын хүний нөөцийг бэлтгэж, судалгааны их сургуулийг хөгжүүлэхэд өндөр хөгжилтэй орнуудын их сургуулиудтай хамтран ажиллаж, инновацийн соёлыг нэвтрүүлнэ. • Судалгааны их сургуулийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, санхүүжүүлэх, үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах эрх зүйн орчныг баталгаажуулна.	100%	
	118		1.а.2/. Өмчийн бүх хэлбэрийн шинжлэх ухааны байгууллага, Их сургуульд шинжлэх ухаан,	- 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д инновацийн	100%	Хяналтаас хасах

		үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох, ажил, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлэх;	бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын аж ахуй нэгжид давуу эрх олгохоор тусгасан. Уг заалт бүрэн хэрэгжиж байна.		
119		1.а.3/. Сургалтын үйл ажиллагааны чанарын шинэчлэлийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан сургалтын агуулга, арга зүйг сайжруулах, үнэлгээний аргачлалыг шинэчлэх “Үр дүнд суурилсан боловсрол”-ын тогтолцоог хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх;	БСШУСЯ CDIO стандарт аргачлалд үндэслэн дээд боловсрол дахь Үр дүнд суурилсан боловсрол (ҮДСБ)-ын бодлогыг 2018 онд боловсруулан баталсан. Энэ хүрээнд хүрээнд дэлхийн боловсролын стандартыг өөрийн орны боловсролын салбарт нэвтрүүлэхээр Инженерийн боловсролын CDIO стандарт, арга зүйг нэвтрүүлэх ажлыг хийж байна. Энэ арга зүйг нэвтрүүлэх хамтын ажиллагааны байгууллага нь дэлхий даяар бүс нутгийн 7 төв ажиллаж, 140 гаруй их дээд сургууль, коллеж хамтран ажиллаж, харилцан туршлага солилцдог. CDIO стандарт, арга зүйг нэвтрүүлэх эхний үе шат нь БСШУСЯ, ДБШТ, АХБ-ны санхүүжилтээр амжилттай хэрэгжиж их, дээд сургуулийн багшийг чадавхжуулах сургалт 2000 гаруй багшид мөн CDIO Азийн бүсийн төвтэй хамтарч хөтөлбөрт үнэлгээ хийх арга зүйд 10 багшийг сургах, “Үр дүнд суурилсан боловсрол” сэдэвт эрдэм шинжилгээний улсын болон олон улсын хэмжээний хурлыг нийт 3 удаа, гадаад туршлага судлах бүсийн болон олон улсын нийт 7 хурал, сургалт семинарт 70-80 орчим багш төлөөлөл оролцуулж, ШУТИС-ийн 3 хөтөлбөрийн нийт 8 урланг ашиглалтад оруулж, түүнд хэрэглэх тавилга, тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг зохион байгуулах, төслийн хүрээнд туршилтын гурван хөтөлбөр болох “Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи”, “Үйлдвэрлэлийн автоматжуулалт”, “Цахилгаан холбоо”-ны 95 хичээлийн хөтөлбөр, үнэлгээний арга зүйг CDIO стандарт, арга зүйн дагуу шинэчлэн боловсруулах, арга зүйн зөвлөмжийн 6 багц гарын авлагыг боловсруулан, нийт 12000 ширхгийг хэвлүүлж түгээн дэлгэрүүлэх, орчуулгын болон цахим сургалтын материал бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Ахисан түвшний CDIO арга зүйг хэрэгжүүлэх төслийг 2018-2019 онд ШУТИС, МУИС, ХААИС, МУБИС, СУИС, ҮБХИС-ийн 6 хөтөлбөрт хэрэгжүүлэхээр өргөжүүлсэн. Энэхүү 2 шатны төслөөр CDIO стандарт, арга зүйг эзэмшин цаашид түгээн дэлгэрүүлэх чадвар бүхий 46 мастер багшийг бэлтгэн, сургалтын хөтөлбөрүүддээ хэрэгжүүлж байна Ахисан түвшний CDIO-ийн стандарт, арга зүйг нэвтрүүлэх ажиллагааг тогтворжуулах, сайжруулах, багшийн хөгжлийн орчныг дэмжих, хөтөлбөр болон багшийг чадавхжуулах, хэрэгжилтийн ажлын үр дүнгээ хэлэлцүүлэх, CDIO2020 Азийн бүсийн хурлыг Монгол улсад амжилттай зохион байгуулсан. “ҮР ДҮНД СУУРИЛСАН БОЛОВСРОЛ 2021” сэдэвт эрдэм шинжилгээний 7-р хурлыг 2021 оны 12 дугаар сард амжилттай зохион байгууллаа. Хуралд Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын хүрээлэн, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Үндэсний	100%	

			батлан хамгаалахын их сургууль, Техник технологийн их сургууль, Этүгэн их сургууль, Ховд их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуулийн төлөөлөл оролцлоо.		
120		1.а.4/. Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчдийн хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан тогтоох талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;	- Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг баталсан бөгөөд тус журмын 1.4. дэх заалтад “Тухайн жил батлагдсан төсөв болон зээлийн санхүүжилтэд багтаан зээл авах оюутан, суралцагчийн хяналтын тоог боловсролын шатлал, хөтөлбөр, сургууль тус бүрээр төрийн захиргааны төв байгууллагуудын саналыг харгалзан боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар жил бүрийн 2 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө тогтооно” гэж зааж өгсөн.	100%	Хяналтаас хасах
121		1.а.5/. Байгууллага дэмжих санг дээд боловсролын сургалтын байгууллагын дэргэд байгуулах, сангийн зарцуулалт, хяналт тавих тогтолцоо, эрх зүйн орчин бий болгох;	- Засгийн газрын 2018 оны 233 дугаар тогтоолоор “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан. Тус бодлогын 4 дүгээр зорилтын 4.1.2-т “инновацийн үйл ажиллагааг дэмжих, гарааны бизнест хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн тусгай зориулалтын хөрөнгө оруулалтын сан (Венч, Эндаумент сан гэх мэт)206т)-г байгуулах, ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэсэн заалт орсон. Улсын Их Хуралд өргөн барьсан Дээд боловсролын тухай хуулийн төслийн 4 болон 30 дугаар зүйлд эндаумент сантай холбоотой заалтыг тус тус тусгасан. Их сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн тусгай зориулалтын хөрөнгө оруулалтын сан (Венч, Эндаумент сан investment+fundament гэх мэт)-г байгуулж, ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.”-ээр тусгасан.	70%	
122		1.б.2/. Төрийн ивээлд байх, төсвийн санхүүжилтээр хэрэгжих шинжлэх ухааны салбар, судалгааны чиглэлийг тодорхой болгох, төсвийн санхүүжилтээр хийгдэх судалгааны сонгон шалгаруулалт, ажлын үр дүнг эрдэмтэд, хэрэглэгч, олон нийтэд ил тод, нээлттэй болгох;	- Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-аар төслийн сонгон шалгаруулалтад эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуй нэгж, судлаачдын баг, иргэн оролцож болно. Уг журамд Засгийн газрын 2018 оны 99, 343 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон.	100%	Хуулийн зохицуулалт бүрэн бүрдсэн хэрэгжиж байгаа тул хяналтаас хасах
123		1.б.4/. Багш, судлаач, эрдэмтдийн бүтээлийн мэдээллийн сан, номын сангийн нэгдсэн сүлжээг бий болгох /БУМС/;	- Шинжлэх ухааны салбарын мэдээллийн нэгдсэн санг бий болгох ажлын хүрээнд салбарын үйл ажиллагаанд өнөөгийн болон суурь судалгааг хийж шинжлэх ухаан технологийн мэдээллийн нэгдсэн системийн шийдэл боловсруулах, хөгжүүлэлтийн тойм төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээг 2021 оны 6-11 дүгээр сард мэргэжлийн багаас авсан. Тус зөвлөх үйлчилгээнээс гарсан зөвлөмжийн дагуу салбарын хэмжээнд байгаа мэдээллийн сангуудыг нэгтгэх ажлыг зохион байгуулж байна.	70%	
124		1.б.5/. Багш, судлаач, магистр, докторын сургалтад суралцагчдын судалгааны ёс зүйг сайжруулах, бүтээлийн хуулбарлалтыг илрүүлэх системийг бүрдүүлэх;	- Судлаачийн ёс зүйн дүрмийн төсөл болон дүрмийн төслийг батлах тухай БШУ-ны сайдын тушаалын төслийг боловсруулан холбогдох нэгж, байгууллагаас санал авах хүсэлтийг 2021.10.14-ны өдрүүдэд холбогдох газруудад илгээсэн. Дүрмийн төсөлд 2021.10.20-22-ны өдрүүдэд 2 газраас санал ирүүлсэн. Тухайлбал, Хуулийн хэлтсээс тушаалын төсөлд дурдсан	70%	

			хуулийн заалтууд Судлаачийн ёс зүйн ерөнхий дүрмийг БШУ-ны сайд батлах эрх зүйн үндэслэл болохгүй гэж дүгнэж, ёс зүйн дүрмийг ШУТИБХЗГ-тай хамтран боловсруулах, батлуулах санал өгсөн. Мөн Боловсролын хүрээлэнгээс Боловсролын багц хуулиуд батлагдсаны дараа судлаачийн ёс зүйн дүрмийг авч үзэх, дүрмийн концепц, зорилгыг тодорхой болгох. Тухайлбал, “судлаач” гэж хэнийг нэрлэх, дүрмийг ямар хүрээнд ашиглах гэх мэт саналыг өгсөн. - Төрийн өмчийн их сургуулиуд бүтээлийн хуулбарлалт плагаризм шалгадаг программыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд бүтээлийн хуулбарлалт шалгах програм хангамжийг худалдан авах гэрээг байгуулж, программ хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхлээд байна. Тухайлбал, ШУТИС, МУИС гэх мэт их сургуулиуд. - ШУТИБХЗГ-аас мөн л дүрмийн төслийг боловсруулан яамны цахим хуудсаар дамжуулан дүрмийн төсөлд санал авч байгаа болно.		
125	1.б.6/. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны сэтгүүлд бүтээлээ нийтлүүлж, бүтээл нь дэлхийн хэмжээнд шинжлэх ухааны эргэлтэд орж байгаа эрдэмтдэд дараагийн судалгааны ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг болох;	- Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтыг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/141 дүгээр тушаалаар “Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл сонгон шалгаруулж, урамшуулах журам”-ыг батлуулсан. 2021 онд журмын дагуу эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн шагналыг “ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ ӨГҮҮЛЭЛ” ангилалд 6 шилдэг өгүүлэл нийтлүүлсэн судлаачдад 60 сая төгрөгийн, “ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ НОМ” ангилалд 3 шилдэг бүтээлд 30 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг анх удаа олголоо. Шинжлэх ухааны түүхт 100 жилийн ойг угтан 2021 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр инженерчлэл, технологи, инновац, анагаах ухаан, байгалийн ухаан, биологи-хөдөө аж ахуй, газарзүй геологи, нийгэм хүмүүнлэгийн ухаан, эдийн засаг, менежмент гэсэн 7 салбар чиглэлээр онлайнаар зохион байгуулж, дараах 14 залуу судлаачдад Боловсрол, шинжлэх ухааны сайдын нэрэмжит “Хүрэлтогоот-2021” залуу судлаачдын грантыг олгож, тус бүр 10 сая төгрөг, нийт 140 сая төгрөгийн судалгааны тэтгэлэг олгосон.	100%		
126	1.б.7/. Төрийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн талаар баримтлах бодлогыг тодорхой болгох;	- 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолоор Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл”-ийг хүчингүй болгосон. Ингэснээр их, дээд сургууль, коллеж нь зөвхөн сургалтын төлбөрөөс санхүүжихээр болсон.	100%		
127	1.б.8/. Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, ангилал, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад дүгнэлт өгч, холбогдох арга хэмжээ авах.	- Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Улаанбаатар их сургууль, Монгол улсын боловсролын их сургууль, Соёл урлагийн их сургуулиудын үйл ажиллагаанд Боловсролын тухай хууль, Дээд боловсролын хууль тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталж гаргасан эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг,	100%		

			Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг үндэс болгосон. Хяналт-шинжилгээ, үнэлгээг БУМС дээр байгаа мэдээлэл болон холбогдох баримт бичиг, тайлан мэдээ, статистик мэдээлэл судалгаанд дүн шинжилгээ хийх, үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх, хууль эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах чиглэлээр хийсэн. Мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/144 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, ангилал, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад хяналт-шинжилгээ хийж ажиллаж санал, дүгнэлт гаргасан. Уг санал, дүгнэлтийг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Мэргэжил /хөтөлбөр/-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” А/12 дугаар тушаалаар 17 дээд боловсролын сургалтын байгууллагын 68 мэргэжил /хөтөлбөр/-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.		
128		1.в.1/. в.Боловсролын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны чиглэлээр: Боловсролын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны талаарх холбогдох хуулийн зохицуулалтын сайжруулах;	- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 08 тоот тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”, “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”, “Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг тус тус баталсан. Дээд боловсролын тухай хуулийн төсөлд “Чанарын баталгаажуулалт” гэсэн зүйлээр магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны талаар холбогдох хуулийн заалтыг тусгасан. • Дотоод чанарын баталгаажуулалт, • Хөндлийн магадлан итгэмжлэл, • Байгууллагын магадлан итгэмжлэл гэсэн 3 төрөлтэй байхаар тусгасан. Дотоод чанарын баталгаажуулалт нь байгууллагын өөрийн үйл ажиллагааны чанарыг сайжруулахад чиглэсэн бөгөөд дээрх 3 төрлийн магадлан итгэмжлэлийг захирлын үр дүнгийн гэрээг үнэлэх нэг үзүүлэлт болгох заалтыг тусгасан.	100%	
129		1.в.2/. Магадлан итгэмжлэх байгууллага, хөтөлбөр магадлан итгэмжлэх байгууллага, Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн эрх үүргийг холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулан тодорхой болгох;	- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 08 тоот тогтоолоор “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Дээд боловсролын тухай хуулийн төсөлд “Чанарын баталгаажуулалт” гэсэн зүйл оруулсан. Хуулийн төслийн 12.2.3, 12.7, 12.8, 12.9, 12.11, 12.12-д-д магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны талаар холбогдох хуулийн заалтуудыг тусгасан. Дээд боловсролын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг их, дээд сургуулиудын дунд зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлгээр Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу хараат бус болгох, ингэхийн тулд удирдлагын томилгоог Боловсролын	100%	

			асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилдог байдлыг хуулиар өөрчлөх саналыг гаргасан. Саналыг УИХ-ын байнгын хороо, хуулийн ажлын хэсэгт танилцуулаад байна.		
130		1.в.3/. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;	- Европын холбооны “Ерасмус плюс” хөтөлбөрийн хүрээнд Армени, Казакстан, Монгол, Украин улсууд хамтран хэрэгжүүлсэн “3 дугаар түвшний хөтөлбөрийг Европын улсуудын жишигт нийцүүлэн, үйл ажиллагааг сайжруулах замаар судалгааны интернационалчлалыг дэмжих нь” (СЗQA) төслийг хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд “Дээд боловсролын 3-р түвшин (доктор)-ий чанарын баталгаажуулалтын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ыг боловсруулсан бөгөөд БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан. Ингэснээр докторын түвшний чанарын баталгаажуулалтын шалгуур шаардлага нь олон улсын түвшинд нийцэх нөхцөл бүрдсэн болно. Мөн тухайн төслийн хүрээнд МУИС-ийн докторын түвшний биологийн сургалтын хөтөлбөр, Отгонтэнгэр их сургуулийн Боловсрол судлалын хөтөлбөр тус тус магадлан итгэмжлэгдсэн.	100%	
131		1.в.4/. Боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагыг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх ажилд дэмжлэг үзүүлэх;	- АХБ-ны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл ба Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын олон улсын сүлжээ (INQAAHE) хамтран “Чанарын дотоод баталгаажуулалт” сэдэвт цахим сургалтыг 2020 оны 5 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад төрийн өмчийн 11 их сургууль (МУИС, АШУУИС, МУБИС, ШУТИС, МГАМТИС, СУИС, ХААИС, Дорнод их сургууль, Ховд их сургууль, ДХИС, ҮБХИС), хувийн өмчийн 14 их, дээд сургуулиас (Хүмүүнлэгийн их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Технологи, технологийн дээд сургууль, Их засаг олон улсын их сургууль, Олон улсын Улаанбаатарын их сургууль, Сан их сургууль, Шихихутуг их сургууль, Эм Ай Ю дээд сургууль, Билиг дээд сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Сэрүүлэг дээд сургууль, Шинэ иргэншил дээд сургууль, Энэрэл дээд сургууль, Маргад дээд сургууль)-ийн 300 багшийг онлайн оролцуулан зохион байгуулсан. Сургалтаар “Сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаанд чанарын дотоод баталгаажуулалтыг хангах нь” сэдэвт лекц, Тайван, Оросын Холбооны Улс болон Монгол Улсын МУИС болон Хүмүүнлэгийн ухаан их сургуулийн дотоод баталгаажуулалтын арга зүй, туршлагатай тус тус танилцсан. АНУ-ын/ACBSP/ байгууллагын 2021 оны олон улсын хурал нь 2021 оны 6 дугаар сарын 25-28-нд АНУ-ын Флорида мужийн Майми хотод зохион байгуулагдсан. Тус зөвлөлд Монголын 13 их дээд сургуулиуд гишүүнчлэлтэй байдаг. ба энэхүү хуралд Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөс төлөөлөл оролцож, магадлан итгэмжлэл хийх шинжээчийн сургалт, шалгалтыг амжилттай өгч олон улсын шинжээчийн эрхийг 2 хүн авсан. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл ХБНГУ-ын магадлан итгэмжлэлийн ACQUIN байгууллагатай хамтарсан магадлан итгэмжлэлийг	100%	

			МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн "Багш, гадаад хэлний боловсрол" /Англи хэл/, "Багш гадаад хэлний боловсрол /Герман хэл/" хөтөлбөрүүд дээр 2021.05.19-21-ний өдрүүдэд Монгол, Германы хамтарсан шинжээчийн баг ажилласан. Энэхүү 2 хөтөлбөрийг магадлан итгэмжлэх 2022 оноос хэрэгжүүлэх Судалгааны их сургуулийн хөгжүүлэх төслийн 2 дахь багц ажилд судалгаанд-суурилсан ахисан түвшний сургалтын чанарыг нэмэгдүүлэх, тогтолцоог үнэлэх, чанарын баталгаажуулалтыг хүрээг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа. Төслийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх бөгөөд одоогийн байдлаар төслийн бэлтгэл ажил хийгдэж байна.		
132		1.в.5/. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагад олгох санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх.	- 2020 оны Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн төсөв 150.8 сая төгрөгөөр батлагдсан. 2021 оны Төсвийн төсөлд санхүүжилтийг нэмэгдүүлэх санал боловсруулж 2021 онд 273.7 сая төгрөг болгож батлуулсан. 2022 оны улсын төсөвт өмнөх оны түвшинг бууруулалгүй батлуулсан.	100%	
133		1.г.1/. г.Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны чиглэлээр: оюутны хөгжлийн зээлийг барьцаа хөрөнгөгүйгээр олгоход үүсэх эргэн төлөлтийн эрсдэлийг шийдвэрлэх банк, санхүүгийн механизмыг бий болгох, эргэн төлөлт, хуримтлалын хөрөнгөөр төсөвт ачаалалгүй, бие даан хөгжих оюутны хөгжлийн зээлийн сангийн тогтолцоог бий болгох;	- Төрөөс дээд боловсролын санхүүжилтэд эрэлтийг дэмжсэн буюу суралцагчийн сургалтын төлбөрийг санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Боловсролын зээлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 264 дүгээр тогтоолыг батлууллаа. Тогтоолоор дараах асуудлыг шийдвэрлүүлээ. 1. Төрөөс олгох сургалтын төлбөрийн тэтгэлэг, буцалтгүй тусламжийг зорилтот бүлэгт болон төрөөс бодлогоор дэмжих нэн шаардлагатай, дутагдалтай мэргэжлээр амжилттай суралцагчдад олгох бодлогыг үргэлжлүүлэх; 2. Төсвийн санхүүжилтээр шинээр олгох оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлийг зөвхөн тэргүүлэх мэргэжлээр амжилттай суралцагчдад олгох; 3. Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийг шинэчлэн батлах, өмнө нь хэрэгжиж байсан зарим гадаадын их дээд сургуульд суралцагчийн сургалтын төлбөрийн санхүүгийн дэмжлэгийг уялдуулж, өөрчлөх байдлаар боловсролын зээлийн санд нэмэлт санхүүжилт болгох; 4. Эрэлт ихтэй мэргэжил болон тэргүүлэх чиглэлд хамаарахгүй бусад нэн шаардлагатай мэргэжлээр амжилттай суралцагчдын хэрэгцээнд нийцсэн сургалтын төлбөрийн зориулалтаар олгох зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн байгууллагаас олгох нөхцөл бүрдүүлэхэд төрөөс хүүгийн татаас олгох, зээлийн баталгаа гаргах, хямд эх үүсвэрээр хангах зэрэг санхүүгийн бусад арга хэрэгслийг ашиглан бодлогоор дэмжих; 5. Цаашид их, дээд сургуулийн судалгааны ажлын санхүүжилтийг төрийн захиалгат судалгааны ажил болон ахисан түвшин(магистр, доктор)-ий сургалтад судлаач оюутнаар суралцагчдад олгох өрсөлдөөнт тэтгэлэг хэлбэрээр санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх; 6. Дээд боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог хөгжүүлж, төсвөөс сургалтын төлбөр, санхүүгийн дэмжлэгийг олгох гол нөхцөлд сургалтын	100%	

			байгууллага, мэргэжлийн хөтөлбөр, суралцагчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг оновчтой зөв тогтоон хэрэгжүүлэх замаар сургалтын чанар, үр дүнг сайжруулах.		
134		1.г.2/. Оюутны хөгжлийн зээлд хамрагдалтыг нэмэгдүүлэх, иргэд, оюутан, суралцагчид тус зээлийн талаар мэдээлэл, сурталчилгаа хийх.	- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоол гаргуулсан. Тус тогтоолын 5 дугаар заалтаар “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4 дэх хэсэгт “4.1.8. цаатан өрхийн бакалаврын хөтөлбөрт суралцагч.”, “4.1.9. төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр дээд боловсролын дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтын 501-ээс дээш оноо авсан бол хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь; суралцагч 2.5-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувийг, 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд 100 хувь” гэсэн хэсгүүдийг нэмж оруулсан.	100%	Хяналтаас хасах
133		3.. Тогтоолын хэрэгжилтийн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанд 2017 оны намрын чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Л.Энх-Амгалан/-нд тус тус үүрэг болгосугай.	- Боловсрол, шинжлэх ухааны яамны эрлэх асуудалд хамаарахгүй тул хяналтаас хасах Бүрэн танилцуулагдсан.	100%	Хяналтаас хасах
136		1.б.1/. Б.Засгийн газраас дүрэм, журам, тогтоол гарган хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: дээд сургуулийн судалгааны чадавх, үр өгөөжийг сайжруулах, үр дүнг нь хөдөлмөрийн зах зээлийн эргэлтэд оруулж инновацийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, өндөр технологийн лабораторийг нийлүүлэх, хамтран ашиглах, судалгаа, шинжилгээний дэд бүтэц, лабораторийн нөхцөл байдлыг үнэлж, хүний нөөц, байгууллагын чадавх, хөрөнгө	- Судалгааны их сургуулийг байгуулах, удирдлага, чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий “Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөл боловсруулагдсан. Хуулийн төслийн хэлэлцүүлгүүд зохион байгуулагдаж байна. Хууль батлагдсанаар дараах ач холбогдолтой байна. Үүнд: 1. Эрдмийн эрх чөлөөг баталгаажуулж, эрдэм шинжилгээ, судалгааны чадамжийг сайжруулж, мэдлэгт суурилсан эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангана. 2. Шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэхэд ахиц гарч, шинэ бүтээл, үр ашигтай шинэ технологийг нэвтрүүлэх, ашиглах хөгжүүлэх ажлыг төрийн ивээлд зохион байгуулна. 3. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн, судлаачдын хүний нөөцийг бэлтгэж, судалгааны их сургуулийг хөгжүүлэхэд өндөр хөгжилтэй	100%	

			оруулалтыг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээлд гаргаж улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;	орнуудын их сургуулиудтай хамтран ажиллаж, инновацийн соёлыг нэвтрүүлнэ. 4. Судалгааны их сургуулийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, санхүүжүүлэх, үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах эрх зүйн орчныг баталгаажуулна.		
38	137	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	2.1.4.. Баян-Өлгий аймаг дахь хэлний цөөнх хүүхдийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг төрийн албан ёсны хэл дээр явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны ажлын хэсэг тус аймагт ажиллаж, Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжил, арга зүйн ажлын үр дүн, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтан, багшийн мэргэжлийн бэлтгэл, хичээл, сургалтын үйл ажиллагааг монгол хэлээр зохион байгуулах чадварыг тандан судалж дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтэд үндэслэн Багшийн арга зүйг хос хэлний сургалтын онцлог, заах арга зүйг эзэмших, багш бүр сургалтын идэвхтэй арга барил эзэмших, хөгжүүлэх, Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн, сургалтын менежерүүдээс багшид үзүүлэх онол арга, зүйн дэмжлэгийг нэмэгдүүлэх, бүх судлагдахууны мэргэжилтэн нар өөрийн чиглэлийн багш нарынхаа монгол хэлний мэдлэг, чадвар хэрэглээнд анхаарах, Увс, Ховд аймгуудтай багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж багшаа хөгжүүлэх, Их дээд сургуульд элссэн оюутнуудаа монгол хэлний чадварын түвшнээр хэлний бэлтгэл хөтөлбөрт хамруулах зэрэг зөвлөмжийг өгч хэрэгжилтийг хянан, зөвлөн тусалж ажиллаж байна.	70%	
	138		2.1.5.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох эрхийг хангах үүднээс Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг дэх Сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолборын барилга байгууламжийг шинэчлэн ашиглалтад оруулах, төсөв, хөрөнгийг шийдвэрлэх.	- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ үзүүлэх олон улсын стандартад нийцсэн орчин нөхцөлтэй ясли, цэцэрлэгийн 10 дугаар цогцолбор 2020-2021 оны хичээлийн жилд ашиглалтад орсон. Тус цэцэрлэг нь сургалтын болон дасгал хөдөлмөрийн танхим, спорт заал, усан бассейн, эмчилгээний хэсэг, тосон бариа, ахуй болон хэл засал, тархины саажилт болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийг сэргээн засах эмчилгээний хэсэгтэй бөгөөд хүүхдийн хөгжлийн онцлогт үйлчилгээг үзүүлж байна.	100%	Хяналтаас хасах
	139		2.1.6.. Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах үүднээс Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн холбогдох заалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нийцүүлэх.	- Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тэгш хамруулан сургах талаар тусган боловсруулсан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны "Журам батлах тухай" А/177 дугаар тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам"-ыг баталсан. Тус журам 2021-2022 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхлэх бөгөөд цэцэрлэгийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах эрх зүйн орчин бүрдсэн.	100%	Хяналтаас хасах
	140		3.13.. Хүний эрх, хүүхдийн эрхийн боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэх.	- Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн Нийгэмшихүйн сургалтын чиглэлийн агуулгад “хүүхдийн ялгаатай байдлыг мэдэх, хүндэтгэлтэй хандах, өөрөөсөө дүү хүүхдэд болон найздаа туслах, тусламж хүсэх” зэрэг чадварыг эзэмшүүлэх ажлыг тоглоомын үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлж байна.	100%	Хяналтаас хасах

				- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хүний эрх, хүүхдийн эрхийн чиглэлээр тодорхой агуулгыг тусган сурагчдад ойлголт мэдлэгийг олгож байна. Тухайлбал, бага ангийн сургалтын хөтөлбөрт хүүхдийн анги танхим болон сургууль орчиндоо мөрдөх дэг журам, өөрийн болон бусдын болгоомжгүй үйлдлээс үүсдэг осол гэмтлээс сэргийлэх, тээврийн хэрэгслээр аюулгүй зорчиход мөрдөх журам, зорчигчийн үүрэг зэрэг ойлголт мэдлэгийг суралцагчдад өгөх, дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт эрхээ хамгаалах, зөрчил үүсэх шалтгаан, зөрчлийн эерэг, сөрөг тал, үл ойлголцол, зөрчлөөс сэргийлэх арга зам, эрх зүйн харилцаанд оролцоход эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг агуулга судлагдахаар тусгагдсан		
39	141	Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ	1.4/. Монгол Улсын боловсролын салбарт статистикийн үйл ажиллагааг дэмжсэн бодлого хэрэгжүүлж, статистикийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг сургах, давтан сургаж мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох.	- Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/139/А/38 дугаар хамтарсан тушаалаар хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. - Дээд боловсролын салбарт Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем /ДБУМС/-ийг 2020 онд албан ёсоор нэвтрүүлсэн мөн статистик мэдээний албан ёсны маягт шинэчлэгдсэнтэй холбоотойгоор 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын төгсөлт болон жилийн эцсийн голч дүнгийн мэдээллийн санг баяжуулах, суралцагчийн бүртгэл, тайланг гаргахад тулгамдаж буй асуудлаар дээд боловсролын сургалтын байгууллагын давхардсан тоогоор 704 мэргэжилтнийг хамруулсан 8 удаагийн цахим сургалт зохион байгуулсан. - Шинжлэх ухааны салбарын статистик мэдээний албан ёсны маягт 2020 онд шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Шинжлэх ухаан, технологийн салбарын төрийн болон хувийн өмчийн байгууллагууд, их дээд сургуулийн дэргэдэх шинжлэх ухааны хүрээлэн зэрэг 68 байгууллагын статистикийн мэдээ хариуцсан 78 мэргэжилтэнд шинэчлэгдэн батлагдсан аргачлал, захиргааны болон албан ёсны статистикийн маягт, нөхөх зааврын талаар илтгэл танилцуулж, мэдээлэл хийж, асуулт, хариулт хэлбэрээр цахим сургалт зохион байгуулсан. /Нийт сургалтад хамрагдсан хүний тоо: 782/	100%	Хяналтаас хасах
	142		2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах;	- Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/139/А/38 дугаар хамтарсан тушаалаар хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 6 дахь хэсэгт “Салбарын албан ёсны статистик мэдээллийг агуулсан нугалбарыг боловсруулж, нийтийн хүртээл болгох” ажил тусгагдсаны дагуу Боловсрол, Шинжлэх ухаан, технологийн статистикийн мэдээллийн нугалбарын үзүүлэлтийн хүрээг гаргаж, яамны холбогдох газар, хэлтсээс санал авч боловсруулан, нугалбарыг хэвлүүлэн нийтэд түгээсэн. Нугалбарын дараагийн хувилбарт боловсролын салбарын чанарын үзүүлэлтүүдийг төрийн мэдээллийн нэгдмэл сангуудын мэдээллийн санд үндэслэн тооцож, нийтэд түгээхээр төлөвлөн ажиллаж байна.	100%	

				Мөн ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 4 дэх хэсэгт “Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хүний нөөц, хөрөнгө оруулалт, зардлын хэмжээ, эх үүсвэр, нэн ялангуяа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, зардлыг тодорхойлох, үр дүнг боловсруулан тайлан бичиж, нийтэд танилцуулах” ажил тусгагдсан. Төлөвлөгөөний дагуу Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулах “Аж ахуйн нэгжийн тооллого”-д Шинжлэх ухаан, инноваци, технологийн чиглэлээр 30 үзүүлэлт бүхий 2 бүлэг асуулгыг Шинжлэх ухааны газар, Инноваци технологийн газартай хамтран боловсруулж 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр 1а/1180 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлж, арга зүйн байнгын зөвлөл, даргын зөвлөлийн хурлуудаар хэлэлцүүлэн батлуулсан. 2021 оны 11 сарын 01 -аас 12 сарын 01-ний хооронд улс орон даяар ААНБ-ын улсын үзлэг тооллого зохион байгуулагдаж батлагдсан маягтын дагуу мэдээллийг цуглуулсан. Тооллогын явцад БШУЯ-ны харьяа байгууллагуудын жагсаалтыг гарган ҮСХ-д хүргүүлэн байгууллагуудын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд хамтран ажилласан.		
40	143	Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлд үүрэг өгсөн хуралдааны тэмдэглэл 2018-05-01 Дугаар 2018 №07 ТББХ	5.. Олон удаагийн шүүхийн шийдвэртэй яамдууд хүний нөөцийн бодлого алдагдсан асуудлыг засаж, сайжруулах арга хэмжээг нэн даруй авах;	- Боловсрол, шинжлэх ухааны яамны эрхлэх асуудалд хамаарахгүй байх тул хяналтаас хасах	Үнэлэх боломжгүй	Хяналтаас хасах
41	144	Монгол Улсын консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-05-15	1.1/. Консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийг бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол олгодог шаталсан сургалттай, сургалт-эрдэм шинжилгээний хэв шинжтэй их сургууль болгох, консерваторийн боловсрол эзэмшүүлэх зардлыг төр хариуцдаг байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	- Консерваторийн дээд боловсрол эзэмшүүлэх зардлыг цэрэг, цагдаагийн сургуулийн адил төрөөс хариуцдаг болохоор Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хуулиудын үзэл баримтлалын төсөлд тусгаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд явуулсан боловч, “хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн төсөл биш шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах нь зүйтэй” гэсэн хариу ирүүлсэн. Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг батлуулсан. Хууль шинээр батлагдсаны дараа “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын дагуу тус сургуулийг их сургуулийн ангилалд оруулах асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар шийдвэрлэнэ.	70%	
	145	тухай 2018-05-15	1.2/. Сургалтын тоног төхөөрөмж, сургалтын орчны материаллаг	- Боловсролын салбарын сургалтын орчны материаллаг баазыг сайжруулах зорилтыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар авч		

	Дугаар 2018 №13 НББСШУБХ	бааз /хөгжмийн зэмсэг, номын сан, лингафоны кабинет зэрэг/-ыг бэхжүүлэх, сургуулийн хичээлийн зориулалтын барилга, байгууламжийн засвар үйлчилгээ, циркийн сургуулийн болон оюутны дотуур байр барих хөрөнгө оруулалтыг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц болон гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс жил бүр үе шаттай төсвийн төсөлд тусган хэрэгжүүлэх;	хэрэгжүүлж байна. Үүнд 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сургуулийн хөгжмийн зэмсэг, хөгжмийн кабинетад тоног төхөөрөмж, спорт зааланд шаардлагатай тоног төхөөрөмжийн 1,5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. 2021 оны улсын төсвөөр Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад “Морин хуур” хөгжмийн зэмсэг худалдан авах, ерөнхий боловсролын байгууллагад “Морин хуур” хөгжим худалдан авах төсөв өртөг 1.8 тэрбум төгрөг, спорт зааланд техник хэрэгсэл, мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмж 1.3 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн хуваарилж байна. 2022 оны төсвийн хязгаарт хуучин циркийн байрыг сургуулийн спорт заалны барилга болгох 1.9 тэр бум төгрөгийн саналыг тусгаад байна.		
146		1.3/. Консерваторийн бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг сургалтын хөтөлбөр, онцлогтой уялдуулан ялгавартай тогтоож, жил бүр Засгийн гарзын тогтоолд тусган шийдвэрлэж байх;	- Консерваторийн бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг бодит ажиллагчдын тоо, зардлын тооцоололд үндэслэн шинэчлэн хийж 2022 оны төсвийн төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсний дагуу УИХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганаар 2022 оны төсөв батлагдсан. 2022 онд Монгол улсын консерваторит 4.7 тэрбум төгрөгийн төсөв батлагдан хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив батлуулах Засгийн газрын тогтоолын төсөлд Консерваторийн суралцагчдад итгэлцүүрээр нэмэгдүүлэн тооцох саналыг тусган 2022 оны 1 дүгээр сард уг тогтоолыг батлуулахаар Сангийн яамтай нэгдсэн байр сууринд хүрээд байна.	70%	
147		1.4/. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.4 дэх заалтыг хэрэгжүүлэхэд Консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-д дэмжлэг, тусалцаа үзүүлэх;	- Улсын төсөвт жил бүр санхүүжилтийг тусган батлуулдаг бөгөөд Консерваторийн сургалтын онцлогт тулгуурлан санхүүжилтийг төсөвлөн тусгай статусаар үйл ажиллагааг явуулж байна. 2020 онд 1000 гаруй суралцагчтай үйл ажиллагаа явуулж, 4797,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. 2021 онд 1077 суралцагчидтай үйл ажиллагаа явуулах бөгөөд сургуулийн төсөв 5.1 тэрбум төгрөгөөр батлагдаад байна.	100%	
148		1.5/. Консерваторийн залуу багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх, магистр, докторын сургалтад Боловсролын зээлийн сан, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд тэтгэлэгт хамруулах болон багш, оюутныг олон улсын ижил түвшний консерваторид туршлага судлах, солилцоонд хамрагдах, гадаадаас багш, мэргэжилтэн урьж ажиллуулах талаар тусгайлсан	<u>2019-2020 оны хичээлийн жилд:</u> - Улаан-Үд хотын Чайковскийн нэрэмжит коллежид Хөгжмийн ухааны тэнхимийн 6 багш 10 хоног мэргэжил дээшлүүлсэн. - ОХУ-ын Чайковскийн нэрэмжит Москвагийн Консерваторитай хамтын ажиллагааны гэрээний дагуу тус сургуульд 1 багш, 4 оюутан суралцаж байна. <u>2020-2021 оны хичээлийн жилд:</u> - Монгол Улсын Консерваторийн багш нараас докторын сургалтад 5 багш, магистрын сургалтад 5 багш Боловсролын зээлийн сангийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан.	70%	

			хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх;	- Германы Мюнхений Театр урлагийн их сургуульд ISAP хөтөлбөрөөр жааз хөгжмийн 4 оюутан суралцаж байна. Мюнхений сургуультай хамтын ажиллагааны хүрээнд 3 оюутан, 3 багш солилцоогоор явах байсан ч Ковид-19 хол хорионы нөхцөлөөс шалтгаалан хүлээгдэж байна. - ОХУ-ын Буриадын их сургуулийн “Хөгжим ба гоо зүйн сургалт өнөө үед” олон улсын сургалтанд 2021 оны 6 сарын 23-нд нийт 4 багш, 2 магистрант оролцов. <u>2021-2022 оны хичээлийн жилд:</u> - Германы Мюнхений Театр урлагийн их сургуулийн 5 оюутан Монгол Улсын Консерватрид суралцана. Манай сургуулийн 3 оюутан, 3 багш солилцоогоор Мюнхений сургуульд сурч, туршлага судална.		
	149		2.. Энэ тогтоолын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т, жил бүр биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Ё.Баатарбилэг/-нд тус тус даалгасугай.	УИХ-ын НББСШУБ-ын хороонд 2018 онд танилцуулагдсан.	100%	Хяналтаас хасах
42	150	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-12-20 Дугаар 2018 №24 НББСШУБХ	1.4/. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хэрэгжүүлэх хүрээнд хүүхдийн сургууль, цэцэрлэг, дотуур байр, нийтийн эзэмшлийн зам, талбай, орон сууц болон гэр хороолол дахь гадаад, дотоод орчны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, орчны нэгдсэн стандартыг баталж мөрдүүлэх;	- Монгол Улсын стандарт MNS 6782:2019 “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”, Монгол Улсын стандарт MNS 6781:2019 “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага”, Монгол Улсын стандарт “Сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага”-ыг батлуулсан. Стандарт нь сургалтын байгууллагын гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг багш, ажилчид, сурагч, эцэг эхийн оролцоотой үнэлж, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг амжилттай сурч хөгжих орчин нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн.	100%	Хяналтаас хасах
	151		1.11/. Архи, тамхи, согтууруулах ундаагаар үйлчилдэг болон худалдан борлуулдаг цэгүүдийг сургуулийн ойр орчинд ажиллуулахгүй байх хуулийн хэрэгжилтийг хангуулж, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний хангамжийн эрүүл ахуй,	- Боловсрол, шинжлэх ухааны сайдаар ахлуулсан тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Шадар Сайдын ажлын алба, МХЕГ, ОБЕГ, СЯ, ЭМЯ, ХНХЯ, ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн төлөөллүүд орж ажилласан юм. Ажлын хэсгээс, Монгол Улсын Шадар Сайдын 02 тоот “Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” албан даалгавар, БШУС-ын А/17 тоот “Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” тушаал, Шадар сайд болон Сангийн яам, ХНХЯ, БШУЯ, ЭМЯ-ны сайдуудын “Хичээл, сургалтын үйл ажиллагааг	100%	Хяналтаас хасах

			аюулгүй байдлыг хангах талаар холбогдох байгууллагын хяналтыг сайжруулах;	эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” хамтарсан тушаал, МХЕГ-ын даргын “Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх чиглэл өгөх тухай” албан даалгавар гарсан. Энэ хүрээнд Мэргэжлийн хяналтын байгууллагаас төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж дүгнэлт гаргасан.		
43	152	Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019 №04 ЭЗБХ	1.4/. Олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, мэдлэг, инноваци шингэсэн хөдөө аж ахуй, мэдээллийн технологи, аялал жуулчлал болон бусад салбарыг хувийн хэвшилд тулгуурлан хөгжүүлэх бодлого, стратегийг танилцуулах;	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДАЛД ХАМААРАХГҮЙ БАЙХ ТУЛ ХЯНАЛТААС ХАСУУЛАХ	Үнэлэх боломжгүй	Хяналтаас хасах
44	153	Чиглэл өгөх тухай 2019-06-05 Дугаар 2019_05 "Цахим бодлогын түр хороо"	1.9/. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 25/16 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг Цахим бодлогын түр хороонд 2019 оны 6 дугаар сарын 15-ны дотор танилцуулах;	- Инноваци цахим бодлогын байнгын хорооноос 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдөр “Боловсролын салбар дахь цахим шилжилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Уг хэлэлцүүлэгт Боловсролын салбарт хэрэгжиж буй мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний биелэлтийг танилцуулж, дунд хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлыг танилцуулсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан гарсан.	100%	Хяналтаас хасах
	154		1.10/. Үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхолд харшлах цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээний сөрөг мэдээллээс иргэдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээний зөв зохистой хэрэглээг сурталчлах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бүх нийтийн тоон бичиг үсгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх тодорхой төсөл, арга хэмжээг төлөвлөн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020-2022 онуудад хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, хэрэгжилтийг эрчимжүүлэх;	- БСШУС-ын сайдын 2018 оны 09 дүгээр сарын 28-ний өдрийн “Журам батлах тухай”А/608 дугаар тушаалаар “Цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх журам”-ыг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Журмыг хэрэгжүүлэх зөвлөмж гарын авлагыг боловсруулж, 1000 ширхэг хэвлүүлэн ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлсэн. Цахим орчинд өөрийгөө болон бусдыг хүндэтгэх, зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх, зүй бус харилцаанаас урьдчилан сэргийлэх,бусдыг гадуурхаж, дарамтлахгүй, бусдын гадуурхлаас ангид байх талаарх мэдээ, мэдээллийг хүүхдүүд бие биедээ хүргэх, таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах боломжийг олгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дунд “Цахим орчны зөв зохистой хэрэглээ” сэдвээр уралдааныг Харилцаа холбооны зохицуулах хороотой олон нийтийн арга хэмжээ, хамтран зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд “Бяцхан ном бүтээх уралдаан”, 10-12 дугаар ангийн сурагчдын Өөрөө удирдлагын байгууллага, клубын дунд “Цахим орчны зохистой хэрэглээ төслийн уралдаан”-ыг зохион байгуулж, дүгнэсэн. Сурагчдын хийсэн бяцхан ном, төслөөр олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан үзэсгэлэн гаргасан. Өргөн нэвтрүүлэгт хүүхдийн аюулгүй байдлыг хангахад холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор “Хүүхэд хэрэглэгч” аяны хүрээнд ХЗДХЯ, ХНХЯ, ХХЗХ, ХХМТГ, Телевизүүдийн холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран Санамж бичиг байгуулсан.	100%	Хяналтаас хасах

Ерөнхийлөгчийн зарлиг

45	155	Хадны зураг, бичээсийг хамгаалах, судлах ажлыг дэмжих тухай 2017-07-09 Дугаар 2017_181	1.. Өвөг дээдсийн хаданд мөнхөлсөн хосгүй гайхамшигт чулуун судар, түүх, соёл, урлагийн нандин өв: хадны зураг, бичээсийг хадгалан хамгаалах, судлан шинжлэх талаар эрдэмтэн судлаачид, иргэд, байгууллагаас гаргаж буй санал, санаачилгыг дэмжих ЗОРИЛГООР, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь: 1.Хил дамнасан соёлын өв, түүний дотор хадны зураг, бичээсийг судлах зорилгоор олон улсын хамтарсан судалгааны баг байгуулж ажиллах; Хадны зураг, бичээсийн олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн-“Хадны зураг, бичээсийн чуулган”-ыг хоёр жил тутамд нэг удаа Дэлхийн өвийн өдрийг тохиолдуулан зохион байгуулж байхыг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх Ухааны Академид даалгасугай.	- Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөр”-т хадны зургийн бүртгэн баримтжуулах, судлах, сэргээн засварлах, хамгаалах, сурталчлах чиглэлээр 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн зарим ажлуудыг эхлүүлсэн. Тухайлбал, Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын хадны зураг, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Жаргалантын ширээний хадны зургийн хэв хуулбар, дардсыг авч хадгалах ажлыг хэрэгжүүлээд байна. Монгол-Оросын хамтарсан “Хадны зургийг судлах анги” Баян-Өлгий аймгийн Улаанхус, Буянт сумдын нутагт ажиллаж, Цагаан салаа, Бага Ойгор, Хөшөөтийн хадны зургаас хуучин чулуун зэвсгийн үед холбогдох хадны зургийг дагнан судалж байна. Мөн ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн шинжилгээний анги Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт орших хадны зургийг бүртгэн баримтжуулах суурь судалгааны ажлыг хэрэгжүүлсэн. Түүх, археологийн болон Палеонтологийн мэргэжлийн зөвлөлийг 5 дугаар сарын 13-ний өдөр цахим хэлбэрээр хуралдуулж 2020 онд судалгааны ажил, хайгуул, малтлага хийх хүсэлт гаргасан байгууллагуудын хүсэлтийг хэлэлцэн, нийт 4 байгууллагын 11 судалгааны багт зөвшөөрөл олгосон.	100%	
46	156	Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай 2017-07-10 Дугаар 2017_186	1.. Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь: 1. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт” дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Хөтөлбөр батлах тухай” 2019 оны А/492 дугаар тушаалаар бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн агуулга, арга зүйг сайжруулан боловсруулж, баталлаа. 1-12 дугаар ангийн сайжруулсан сургалтын хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулиудад хэрэгжүүлж байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын сайжруулсан хөтөлбөрт Газарзүйн хичээлээр өөрийн орон нутаг, газар зүйн байрлал, нэр, нэрийн гарал үүсэлтэй танилцах мэдлэгийг өгч эх нутаг, газар шороогоо хайрлах үзэл санааг төлөвшүүлж байна. Бага ангийн хүн-байгаль, хүн-нийгэм, хүн-орчин, дунд ангийн газар зүй, нийгмийн ухаан, иргэний ёс зүйн боловсрол, ахлах ангийн нийгмийн ухааны	70%	

			мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, тухайн орон нутагтаа ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэх, цаашид хууль бусаар газар орны нэр өөрчлөх гэмт явдалтай хууль тогтоомжийн дагуу тууштай тэмцэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. 2. Уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг Монгол Улсын нийт иргэд, байгууллагад уриалсугай.	сургалтын хөтөлбөрөөр сурагчид Уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх зэрэг мэдлэг чадвар эзэмшиж байна.		
47	157	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	1.. Монгол бичгийн цахим кодыг хэрэглэх үндэсний стандартыг холбогдох мэргэжилтнүүдийн саналыг тусган шуурхай боловсруулж, хуульд заасны дагуу батлуулах, цаашид хөгжүүлэн тогтвортой байдлыг хангаж, цахим орчинд үндэсний хэрэглээг нэмэгдүүлэх талаар бодлого, төлөвлөгөө гарган ажиллахыг Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол хэлний тухай хуулиар үүрэг хүлээсэн эрх бүхий судалгааны байгууллагад; Үндэсний стандартыг боловсруулах ажилд хяналт тавьж, боловсруулсан стандартыг судалж батлах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, монгол бичгийн цахим кодчиллыг олон улсын стандартад үндэсний стандартыг хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх тухай” 2018 оны 46 дугаар зарлиг, Ерөнхий сайдын 2018 оны 95 дугаар захирамжаар өгсөн чиглэл, үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Олон улсын компьютерын кодчиллын стандартын байгууллага Юникод Консорциумаас 2019 оны 4 дүгээр сарын 3-5-ны өдрүүдэд зохион байгуулсан “Монгол бичгийн юникодын ажлын хэсгийн гуравдугаар хурал”-ыг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн хамтран зохион байгуулагчаар оролцсон. Энэхүү хурлаар: - Монгол бичгийн үсэг бүтээх дүрмийг боловсронгуй болгох замаар авиазүйн загварыг хялбаршуулах, боловсронгуй болгох; - Монгол бичгийн цэг, таслал, форматын удирдлагыг авч хэлэлцэх; - Хэрэглэгчид хялбар дөхөм байх, харагдац сайтай, тогтвортой, бүрэн нийцэлтэй монгол бичгийн кодчиллын дүрэм боловсруулах асуудлыг хэлэлцэв. Хурлаас дараах ерөнхий дүгнэлт гарсан болно. Үүнд: Нөхцөл, дагаврыг удирдах таслахгүй нарийн зайг удирдах тэмдэг (NNBSP) талаар: Монгол улс, ӨМӨЗО-ны талууд таслахгүй нарийн зайн удирдах тэмдэг буюу NNBSP-ийн хэрэглээ ихээхэн асуудал дагуулж байгаа талаар байр сууриа илэрхийлж, түүнийг хэрэглэхгүй байх талаар ижил байр суурьтай байлаа. - Эгшиг тусгаарлалтын удирдах тэмдэг MVS талаар: Хуралд оролцогчдын зүгээс MVS удирдах тэмдэгтийн дүрмийг илүү нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэсэн байр суурийг дэмжсэн.	70%	

		байгууллага болон Монгол Улсын Шадар сайдад чиглэл болгосугай.			
158		2.. Монгол бичгийн дунд болон урт хугацааны үнэдсний хөтөлбөрийг боловсруулан баталж, 2018 багтаан хэрэгжүүлж эхлэх; бүх шатны боловсролын сургалтын байгууллагын суралцагч хичээлийн хөтөлбөрөөр монгол хэл, бичгийн хичээлийг судлахдаа цахим орчинд монгол бичгийг ашиглах, бичвэр боловсруулах бүрэн чадамжтай болж төгсдөг байх; монгол бичгийн хичээлээр улсын төрөлжсөн олимпиадыг зохион байгуулж хэвших; элсэлтийн ерөнхий шалгалт өгөх иргэнээс заавал авах монгол хэл, бичгийн шалгалтанд босго оноо тогтоох; монгол хэл, бичгийн хичээлийг үр бүтээлтэй заан сургаж, амжилт гаргаж буй багш нарыг урамшуулж ажиллахыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүрэг болгосугай.	2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор “Монгол бичгийн хөтөлбөр-III”-ийг баталсан. Хөтөлбөрт 4 зорилт дэвшүүлж, 46 арга хэмжээг 2020-2024 онд хэрэгжүүлэхээр заасан. ЕБС-ийн 6-12-р ангийн суралцагчид үндэсний бичгийн хичээлийг 7 хоногт 2 цагаар судалж байна. “Монгол хэл бичгийн боловсролын сайжруулах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоол”-ын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан монгол хүний ургийн болон нэрийн цахим санг үүсгэж толь бичиг хэвлүүлсэн. БСШУС-ын Сайдын 2018 оны А/194 дүгээр тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгч нь монгол хэл бичгийн шалгалтыг заавал өгсөн байна. Монгол хэл, бичгийн шалгалтыг жилд 2 удаа зохион байгуулах ба эхний шалгалтад бага оноо авсан шалгуулагч оноогоо ахиулах зорилгоор, хүндэтгэн үзэх шалтгаанаар эхний шалгалтад хамрагдаж чадаагүй бол иргэн дараагийн шалгалтад орж болно” гэсэн зохицуулалтыг баталж, мөрдүүлж байна. 2020, 2021 онд ковид цар тахлын хорио цээрийн дэглэмээс шалтгаалан ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд зохион байгуулах, их, дээд сургуульд элсэгчдээс авах монгол хэлбичгийн шалгалтыг энэ онд цуцлах санал, Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулгыг тус тус боловсруулж, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар дээр дурдсан асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын 2021 оны 141 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Монгол хэл бичгийн сургалтын чанарыг сайжруулах, эх хэлээ хамгаалах, хөгжүүлэх нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн БСШУС-ын Сайдын 2020 оны А/144 дүгээр тушаалаар “Монгол хэлний талаар баримтлах сургалтын бодлого” баримт бичгийг батлан мөрдүүлж байна. 2021 онд онд монгол хэл бичгийн мэргэжлийн 2000 багшийг “Оюун билгийн соёрхол-монгол бичиг” цахим сургалтад хамруулж, хэл шинжлэл, онол аргазүйн шинэчлэлийн сэдвүүдээр МУИС, МУБИС, ШУА-ийн ХЗ Хүрээлэнгийн эрдэмтэн багш нар хичээл заалаа.	100%	Хяналтаас хасах
159		3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны	- Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2020 оны 96 дугаар тогтоолоор батдагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III” түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосон.	70%	

			Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.			
	160		4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.	- Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг 2020-2024 онд хэрэгжүүлэх баталсан. Хөтөлбөрийг монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх, монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх, албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах, монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлж байна. Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дэргэд хүний нэрийг үндэсний бичгээр зөв бичих зарчим боловсруулах ажлын хэсэгт ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн хамтран ажилласан. Мөн “Монгол хэлний тухай хууль”, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр - III”-ын хүрээнд 2019-2020 оны хичээлийн жилд ЕБС төгсөх ангийн сурагчдын 15000 гаруй нэрийг, нийт 24000 хүний нэрийг үндэсний бичгээр бичих, засан жигдлэх ажлыг гүйцэтгэсэн.	100%	Хяналтаас хасах
48	161	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019_60	1.. Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон талт ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай. 2. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, харилцан уялдаатай хэрэгжүүлэх. 3. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр болон Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих, урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг хангаж ажиллах. 4. Хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдлээс сэргийлэх, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай	ХНХЯ нь Хүүхэд хамгааллын тухай хуульд оруулах шаардлагатай өөрчлөлт, хүүхэд хамгааллын тогтолцоотой холбоотой бодлого, хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд сайн туршлага, сургамжийг тодорхойлох зорилгоор Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд үнэлгээ хийсэн. Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрт тусгагдсан 30 үйл ажиллагааг хэрэгжүүлэх 49 арга хэмжээ, Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрт тус боловсролын салбартай холбоотой 16 үйл ажиллагааны 36 арга хэмжээ тусгагдсан, хэрэгжиж байна. ЗГ-ын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”, төлөвлөгөөг баталсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Батлан хамгаалахын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/371-А/782 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс Зэвсэгт хүчний Жанжин штаб, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб болон Боловсрол, соёл урлагийн газартай хамтран үндэсний хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудын дунд, ахлах ангийн сурагчдад сургалт, үйл ажиллагааг 2019 оны 12 дугаар сарын 16-27-ны өдрүүдэд зохион байгууллаа. <i>Сургалтын нэгдүгээр үе шатанд</i> нийслэлийн 6 дүүргийн 124 дунд сургуулийн 25764 сурагч хамрагдсан бол <i>хоёрдугаар шатанд</i> орон нутгийн 167 дунд сургуулийн 24793 сурагч тус тус хамрагдаж нийт үндэсний хэмжээнд 291 сургуулийн 50557 сурагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг сургалтад хамрууллаа. БСШУСС-ын А/608 дугаар тушаалаар “Цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх журам” баталж, цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, түүнтэй адилтгах тоног төхөөрөмж ашиглахыг хязгаарлан, гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх үйл ажиллагааг зохицууллаа. Монгол Улсад Гэмт хэргээс	100%	

		зохион байгуулах, эцэг, эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх. 5. Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхэд, гэр бүл хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг дэмжих. 6. Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, аймаг, дүүргийн өсвөр үеийн кабиинетаар үйлчлүүлж байгаа хүүхдүүдэд сэтгэл зүйн болон бусад шаардлагатай зөвлөгөө, туслалцаан үзүүлж хэвших. 7. Хүүхдийг цахим орчны халдлагаас хамгаалах тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлж, хэрэгжилтийг сайжруулах, энэ чиглэлээр хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх. 8. Хар тамхи, мансууруулах бодисоор өсвөр, залуу үеийг хордуулж байгаа нөхцөл байдлыг судлан, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. 9. Хүүхдийн хүмүүжил, ёс суртахууныг гэр бүлд нь төлөвшүүлэх, гэр бүлийн боловсрол олгох, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах, үндэсний хэмжээнд гарч байгаа хүүхдийн хөгжил, хамгааллын бүх төрлийн хөтөлбөр /контент/-ийн агуулга, чанарыг сайжруулах. 10. Нийгмийн ажилтны /гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах байгууллага зэрэг бүх салбарт ажиллаж байгаа/ албан тушаалын тодорхойлолтыг хүүхэд хамгааллын чиглэлээр хүлээх үүрэгтэй нь уялдуулан шинэчилж, нэгдсэн арга зүй, хариуцлагын	урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн зүгээс нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчдын дунд социологийн суурь судалгааг Боловсрол, шинжлэх ухааны яам болон Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран Максима Консалтинг судалгааны байгууллагаар хийлгэж байна. Хүүхдийн хүмүүжил, ёс суртахууныг гэр бүлд нь төлөвшүүлэх, эцэг эхэд энэ чиглэлийн боловсролыг олгох зорилгоор “Анги удирдсан багшаар дамжуулан эцэг эхийн боловсролыг дэмжих арга зүйн зөвлөмж” гарын авлагыг боловсруулж, хэвлүүллээ. Уг гарын авлагыг (i) анги удирдсан багш, эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй (ii) хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн оролцоо (iii) хүүхэд хамгаалал-эцэг эхийн хамтын ажиллагаа (iv) хүүхдийн нас, сэтгэцийн онцлог, хүүхдээ ойлгохуй зэрэг агуулгын хүрээнд боловсруулав. Энэхүү гарын авлага нь анги удирдсан багш эцэг эхэд зориулсан төрөл бүрийн сургалт, уулзалт, лекц зохион байгуулахад чиглүүлэг арга зүйн санаа авах төдийгүй сургууль, багш, эцэг эхийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг болох юм.	
--	--	--	--	--

			зарчмаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх. 11. Хүүхдэд зориулсан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэгжлэх соёлыг дэмжих, импортын хүнсний бүтээгдэхүүн, хүүхдийн тоглоом, хэрэгсэлд тавих хяналтыг сайжруулах.			
49	162	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нөхцөл байдалд үнэлгээ хийх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, дүгнэлт боловсруулж танилцуулах үүргийг БСШУС-ын Байнгын хорооны 2021 оны 05 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөн. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын хуралдаанаас гаргасан тэмдэглэлд Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тусгайлан үүрэг өгсөн байна.	100%	Хяналтаас хасуулах
50	163	"ЭРДЭНИЙН СУДАР"-ЫГ ДЭЭДЛЭН ЗАЛАХ ТУХАЙ 2020-12-22 Дугаар 2020_149	2. "Эрдэнийн судар"-т тэмдэглэн үлдээсэн "монгол хүн", "гэр бүл", "төрт ёс", "эх нутаг", "монгол хэл", "эрдэм боловсрол", "ёс суртахуун", "өв соёл", "нүүдэлчин ухаан"-ыг хүүхдэд бага балчраас нь ойлгуулж, улмаар бүх шатны боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусган сурагч, оюутан залуучуудад танхимын болон танхимын бус сургалтаар бататган хөгжүүлэхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийт багш, сурган хүмүүжүүлэгч нарт даалгасугай.	- Бага, дунд боловсролын сургалтын бүх хөтөлбөрийг сайжруулан боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд 2019 оны А/492 дугаар "Хөтөлбөр батлах тухай" тушаалаар баталлаа. Сайжруулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг ерөнхий боловсролын нийт сургуулийн суралцагчид 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн судалж эхэлсэн. Бага, дунд боловсролын сургалтын бүх хөтөлбөрийг 2024 онд бэлтгэл ханган сайжруулан боловсруулах бөгөөд "Эрдэнийн судар"-т тэмдэглэн үлдээсэн арга ухааныг сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгах саналд багтаалаа. Мөн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын судлах сургалтын хөтөлбөрт тусгахаар ажиллаж байна. Улмаар бүх шатны боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусгана. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр, түүний үзэл баримтлалд сургуулийн өмнөх насны хүүхдэд монголын түүх, эх хэл, соёл, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлалаа дээдлэх хүмүүжлийг төлөвшүүлэх тухай зорилт болгон дэвшүүлсэн. Энэхүү үзэл баримтлалд үндэслэн сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг тусган хэрэгжүүлж байна.	70%	
	164		3. Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлийг улс орны түүхэн цаг үеийн онцлог, үйл явдалтай уялдуулан төрөл зүйлээр нь бүртгэн товчоолох, хувьсал өөрчлөлтийн зүй тогтлыг нь судалж тодорхойлох ажлыг Шинжлэх ухааны Академи, их,	- Монгол Улсад Орчин цагийн шинжлэх ухааны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн түүхт ойг тохиолдуулан ШУА-ийн эрдэмтэн судлаачид "Монгол Улсын шинжлэх ухааны түүх" таван боть бүтээлийг туурвилаа. Монгол Улсад 1921-1930 онд шинжлэх ухааны ажлыг эрхлэн зохион байгуулах анхны төв байгууллага Судар бичгийн хүрээлэнгийн үүсэл хөгжлөөс эхлүүлэн тус салбарын хөгжлийн түүхийг харуулсан гэрэл зураг, бодит баримт болон салбарын томоохон зүтгэлтэн, нэрт эрдэмтдийн тухай түүхэн мэдээллийг багтаасан.	70%	

			дээд сургуулийн эрдэмтэн судлаачдад хариуцуулсугай.			
	165		4. Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг сурталчлан таниулах, хүртээн дэлгэрүүлэх, хүн бүрийн үндэсний ухамсарт суулгаж, сэтгэлийн чинадад хүргэн дархлаажуулахад бодитой хувь нэмэр оруулж, олон талт ажлыг зохион байгуулж байгаа иргэд, байгууллага, багш сурган хүмүүжүүлэгчид, эрдэмтэн судлаачдын үүсгэл санаачилгыг хөхиүлэн дэмжиж ажиллахыг бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн болон чөлөөт радио, телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай.	1. “Монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйлс”-ийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: - СУИС-аас Театрын урлагийн сургуулийн профессор багш, үе үеийн төгсөгчид, оюутнууд зэрэг нийт 36 хүн оролцсон “Монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйлс”-цуврал 4 шторк хийж, СУИС-ийн цахим хуудас болон youtube сувгаар онлайнаар түгээв. - Контент хаус Монголиа” ХХК-тай хамтран “Эрүүл монгол хүн оршвой” видео контент бүтээв. - Театрын урлагийн сургуулийн захирал Д.Даваасүрэн, “Дүрслэх урлагийн академи” дээд сургуулийн Баримлын урлагийн тэнхимийн эрхлэгч Н.Дуйнхар нар МҮОНРТ-ийн “Монгол өв соёл” нэвтрүүлгийн 2021 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дугаарт оролцон “Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс”-ийн талаар ярилцлага хийсэн. - “Монголчуудыг эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйлс”-ийг кирилл болон уйгаржин монгол бичгээр 133,5x74,5 хэмжээтэй хэвлүүлж байршуулав. - СУИС-ийн оюутан залуусын соёлын үнэт зүйлсийн талаарх ойлголт, хандлагыг судлах, нийгмийн оюун санааны чиг баримжаа болж буй нийтлэг үнэт зүйлсийн эрэмбийг тодруулж тэдэнд чиглэсэн ажлыг үр дүнтэй болгоход чиглэсэн “Оюутны соёлын үнэт зүйлийн судалгаа”-г боловсруулж, нийт 1125 оюутнаас цахимаар авч, үр дүнг СУИС-ийн захиргааны зөвлөлийн хуралд танилцуулав. - “Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс”-ийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор Аз хур” ХХК-тай Эрдэнийн судар 9 боть ном хэвлүүлэх “Харилцан дэмжлэг үзүүлэх гэрээ”-г 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдөр байгуулав. - СУИС-ийн захирал Э.Сонинтогос 2021 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр СУИС-ийн “Эрдэмтдийн их семинар”-т, 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр БШУЯ, Соёлын яам, СУИС-ийн хамтран зохион байгуулсан “Монголын инновацын 7 хоног - 2021”-ийн Соёлын инновац, бүтээлч үйлдвэрлэл цахим хуралд “Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс” сэдвээр илтгэл, мөн дээх сэдвээр 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр тус сургуулийн захиргааны ажилтнуудад, 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр 2021-2022 оны хичээлийн жилд шинээр элсэж буй оюутнуудад зориулан “СУИС-д тавтай морил” цахим уулзалтад, 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр аймаг, орон нутгийн театрын дарга нартай хийх уулзах уулзалтад тус тус танилцуулга хийв.	100%	
51	166	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-08-27 Дугаар 2021_22	1.1. 2021 оноос эхлэн Олон улсын олимпиадад амжилт үзүүлж, медальт байрт шалгарсан сурагчдад тухай бүр нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит нэг удаагийн урамшууллыг олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх.	- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн математик, хими, биологи, газар зүй, физик, мэдээлэл зүй, Менделеевийн олон улсын химийн олимпиад, Азийн физикийн олимпиад, Ази, Номхон далайн орнуудын мэдээлэл зүйн олимпиадуудад амжилт үзүүлсэн хүүхдүүдэд урамшуулал олгох асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д тусгуулан оруулсан.	100%	

			2021 онд олон улсад зохион байгуулагдсан математик, хими, биологи, физик, мэдээлэл зүйн олимпиадад оролцон амжилт үзүүлсэн 15 сурагчид энэхүү сангаас 25.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Мөн эдгээр сурагчдад ерөнхийлөгчийн нэрэмжит нэг удаагийн тэтгэлэг олгох хүрээнд 100.2 сая төгрөгийн урамшуулал олгоод байна.		
167	1.2. Монгол Улсад зохион байгуулагдаж байгаа улсын олимпиадуудын шатлал, цар хүрээг нэмэгдүүлж олон улсын олимпиадын ангилалтай уялдуулж, зохион байгуулах хуваарийг шинэчлэн батлах.	“Улсын олимпиад зохион байгуулах нийтлэг журам”-ыг боловсруулахаар ажиллаж байна. Журмын төсөлд Боловсролын хүрээлэн, олимпиад зохион байгуулах хороо, аймаг дүүргүүдийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулиудаас нийт 2 удаагийн санал авсан. Журмын төсөлд 96 санал ирсэн нэгтгэн харьцуулалт хийсэн. Журмын төсөлд ирсэн саналуудыг эрэмбэлэн авч үзвэл: 1.Олимпиадын зорилго нь авьяастай хүүхдийг илрүүлэх, тэднийг хөгжүүлэх, бүтээлчээр сэтгэх, шинжлэх ухаанд шимтэн суралцахад чиглэсэн байх; 2. Олимпиадын төрлийн нэмэгдүүлэхээс гадна багш нарын хөгжлийг дэмжин багш нарын олимпиадыг жил бүр зохион байгуулдаг байхаар тусган оруулах; 3. Олимпиадын даалгаврыг онолын болон практик ур чадвар, сэтгэлгээ шаардсан байхаас гадна даалгаврын түвшин, шалгуурыг ахиулж, олон улсын олимпиадын түвшинд ойртуулах зарчим баримтлан боловсруулах; 4. Олимпиадын 1, 2, 3 дугаар шатны сэдвийг БҮТ-өөс нэгдсэн байдлаар боловсруулдаг болох, ерөнхий бюлпринт удирдамжийг гарган, хугацааг нарийн зааж өгөх; 5. Аймаг /нийслэлд/ жилд нэг удаа судлагдахуун бүрээр нэрэмжит олимпиад зохион байгуулах эрх олгох; 6. Суралцагч тухайн төрөлд анги дэвшиж оролцож болох эсэхийг тусгахаас гадна 1-2 олимпиадад зэрэг оролцох боломжийг олгох; 7. Оролцож буй суралцагчдын тооноос хамаарч шагналт байрын тоог нэмэгдүүлэх; 8.Цахимаар зохион байгуулах шаардлагатай тул орон нутгийн интернэтийн хүчин чадал, орчин нөхцөлд анхаарах; 9. Олимпиадын нэгдсэн платформыг бий болгох, хөрөнгө санхүүжилтийг шийдэх; 10. Олимпиадын санхүүжилтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүрэн шийдвэрлэдэг байх гэсэн саналуудыг ирүүлсэн байна. Мөн Оросын Холбооны улс болон Солонгос улсын олон улсын олимпиадын журмыг судалж, шинжилгээ хийсэн.	70%		
168	1.3. Хүүхэд бүрт улсын хэмжээний олимдиадад оролцох тэгш боломжийг бүрдүүлэх үүднээс улсын хэмжээгээр бүх сурагчдыг бие даан суралцаж өөрийгөө хөгжүүлэх, олимпиадад бэлтгэх, шинжлэх ухааны чиглэлээр тогтмол сургалт, хэлэлцүүлэг, цахимаар сорил, олимпиадад хамрагдах боломжоор хангасан нэгдсэн цахим дэд бүтцийг	“Улсын олимпиад зохион байгуулах нийтлэг журам”-ыг боловсруулахаар ажиллаж байна. Хүүхэд бүрт улсын хэмжээний олимпиадад оролцох тэгш боломжийг бүрдүүлэх үүднээс улсын хэмжээгээр бүх сурагчдыг бие даан суралцаж өөрийгөө хөгжүүлэх, олимпиадад бэлтгэх, шинжлэх ухааны чиглэлээр тогтмол сургалт, хэлэлцүүлэг, цахимаар сорил, олимпиадад хамрагдах боломжоор хангасан нэгдсэн цахим дэд бүтцийг хөгжүүлэх асуудалд анхаарахыг олимпиадын хороодоос ирүүлсэн. Нэгдсэн цахим дэд бүтцийг хөгжүүлэх, уг цахим дэд бүтцийн үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн судалгааг химийн олимпиадын хороо, мэдээлэл зүйн олимпиадын хороодтой хамтран санал боловсруулсан. Саналын төслийн эхний хэлэлцүүлгийг олон улсад	70%		

52			хөгжүүлэх, уг цахим дэд бүтцийн үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангахад онцгойлон анхаарах.	зохион байгуулагддаг олимпиадын хороодын дарга нарын дунд хийсэн. Хэлэлцүүлгээс гарсан саналын дагуу ахин сайжруулалт хийхээр ажиллаж байна.		
	169		1.4. Олон улсын олимпиадад сурагчдыг бэлтгэн оролцуулж байгаа багш нар болон олимпиадыг зохион байгуулах хорооны тогтвортой үйл ажиллагааг хангах, шаардлагатай техник хэрэгсэл, холбогдох санхүүжилт болон зохион байгуулалтаар дэмжин ажиллах.	- Олон улсын олимпиадад сурагчдыг бэлтгэн оролцуулж байгаа багш нар болон олимпиадыг зохион байгуулах хорооны тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор энэ хичээлийн жилд олон улсын олимпиадад баг, сурагчдыг амжилттай бэлтгэн оролцуулсан математик, мэдээлэл зүй, физик, хими, биологийн олимпиадын хороодыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/350 дугаар тушаалаар тус бүр 10.0 сая төгрөгөөр урамшуулсан.	70%	
	170		2. Энэхүү зарлигийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгах, зарлигийн биелэлтийн талаар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулж, олон нийтэд мэдээлж байхыг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.	- Улсын төрөлжсөн олимпиад зохион байгуулах болон олон улсын олимпиадад оролцох сурагчдын оролцох зардлыг жил бүр Боловсрол, шинжлэх ухааны сайдын хөтөлбөр арга хэмжээний зардалд тусган ажиллаж байна.	100%	
	171	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-08-27 Дугаар 2021_23	1.1. Монгол Улсын сум, нийслэлийн хороо бүрийн төлөөллийг жигд хангаж, тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад харьяалах сум, хороондоо хамгийн өндөр оноо авсан тус бүр 1 иргэнийг дотоодын төрийн өмчийн их сургуулийн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад бэлтгэх, тэтгэлэгийн бэлтгэл хөтөлбөрт элсүүлэх.	- Засгийн газрын 2021 оны 275 дугаар “Журам батлах тухай” тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай”, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай” журмыг тус тус баталлаа. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр зөвхөн бакалаврын түвшинд дэлхийд эхний 100-д эрэмбэлэгддэг шилдэг сургууль болон Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн хүрээнд гадаадын сургуулийн бакалаврын түвшинд суралцуулна. зарлигийн дагуу элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор сум, хороондоо эхний байр эзэлж, тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт хамрагдах 421 суралцагчийн нэрсийг олон нийтэд зарлаж, энэ талаар Ерөнхийлөгчийн асуудлыг хариуцсан зөвлөхөд танилцууллаа.	100%	
	172		1.2. Тэтгэлэгийн бэлтгэл хөтөлбөрийг амжилттай төгсөж, дэлхийн шилдэг их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах эрх авсан иргэнд сургалтын тэтгэлэг олгох.	Бэлтгэл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулж байна. 2022 оны 1 дүгээр улиралд биелэлт гарна	Хугацаа болоогүй. Үнэлэх боломжгүй	
	173		1.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүлээн зөвшөөрсөн олон улсын олимпиадад медальт	- Засгийн газрын “Журам батлах тухай”, Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай”, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай” журмыг тус тус баталлаа. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр	100%	

		байрт шалгарч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын тогтоосон зэрэглэлээр дэлхийн шилдэг 100-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах эрх авсан иргэнд сургалтын тэтгэлэг олгох.	зөвхөн бакалаврын түвшинд дэлхийд эхний 100-д эрэмбэлэгддэг шилдэг сургууль болон Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн хүрээнд гадаадын сургуулийн бакалаврын түвшинд суралцуулна. Энэхүү журмын 3.7-д Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын олимпиадад медальт байрт шалгарсан иргэн тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад орохгүйгээр тэтгэлэгт хамрагдахаар заасан.		
174		1.4. Монгол Улсын иргэдийг Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгээр дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад шаардагдах зардлыг улсын төсөвт жил бүр тусгаж байх.	- Засгийн газрын “Журам батлах тухай”, Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай”, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай” журмыг тус тус баталлаа. Энэхүү журмын санхүүжилтэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгахыг БШУ-ы болон Сангийн сайдад даалгасан. 2021-2022 оны хичээлийн жилд тэтгэлэгт хамрагдах сурагчдын зардалд шаардагдах 2,2 тэрбум төгрөгийг Боловсролын зээлийн сангийн төсөвт тусган батлуулсан.	100%	
175		1.5. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан дэлхийн шилдэг их, дээд сургуульд амжилттай суралцаж төгссөн иргэнийг Монгол Улсдаа ирж ажиллах, ажлын байраар хангах зэрэгтэй холбоотой асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах асуудлыг судалж, зохион байгуулах	- Засгийн газрын “Журам батлах тухай”, Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай”, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай” журмыг тус тус баталлаа. Журамд тэтгэлгээр суралцагч нь төгсөж ирээд тухайн сум орон нутагтаа 5-аас доошгүй жил ажиллахаар, зээлийн сангийн ажлын албан болон орон нутагтай гурвалсан гэрээ байгуулахаар тусгаснаас гадна эрүүл мэндийн шалтгаанаас бусад тохиолдолд сургалтын төлбөрийг бүрэн эргүүлэн төлөхөөр тус тус заасан. Мөн суралцагчтай байгуулах гэрээний төсөлд давхар тусгалаа.	100%	
176		1.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгийн журмыг хууль тогтоомжид заасны дагуу батлан гаргах.	- Засгийн газрын “Журам батлах тухай”, Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай”, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай” журмыг тус тус баталлаа. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр зөвхөн бакалаврын түвшинд дэлхийд эхний 100-д эрэмбэлэгддэг шилдэг сургууль болон Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн хүрээнд гадаадын сургуулийн бакалаврын түвшинд суралцуулна. Харин ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгээр магистр, докторын түвшинд гадаадын шилдэг сургуульд суралцуулахаар тус тус журамласан.	100%	
177		2. Зарлигийн хэрэгжилтийн талаар жил бүрийн гуравдугаар улиралд багтаан Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулж, олон нийтэд мэдээлж байхыг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэд/-т даалгасугай.	- Засгийн газрын “Журам батлах тухай”, Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай”, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай” журмыг тус тус баталлаа. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр зөвхөн бакалаврын түвшинд дэлхийд эхний 100-д эрэмбэлэгддэг шилдэг сургууль болон Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн хүрээнд гадаадын сургуулийн бакалаврын түвшинд суралцуулна. зарлигийн дагуу элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор сум, хороондоо эхний байр эзэлж, тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт хамрагдах 421 суралцагчийн нэрсийг олон нийтэд зарлаж, энэ талаар Ерөнхийлөгчийн асуудлыг хариуцсан зөвлөхөд танилцууллаа.	100%	

53	178	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.9. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээнд байгаль орчноо хайрлан хамгаалах монгол зан заншлыг дээдлэх, экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллагын онцлогт тохирсон хэлбэрээр сургалт, соён гэгээрүүлэх хөтөлбөрөөр хэрэгжүүлэх	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай" 2019 оны А/390 дүгээр тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын судлах "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Иргэний ёс зүйн боловсрол хичээлийг судалснаар бага, дунд, ахлах ангийн сурагчид байгаль орчноо хайрлан хамгаалах монгол зан заншлыг эзэмшсэн, эх орныхоо эзэн монгол хүн болж төлөвшинө. Мөн монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын хөтөлбөр, сурах бичигт байгаль орчноо хайрлан хамгаалах монгол зан заншлыг дээдлэх, экологийн боловсролын талаар тусган хэрэгжүүлж байна. Сургалтын энэ агуулгаар "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжин суралцагч бүр идэвхтэй оролцох ажлыг боловсролын байгууллагууд шат шатандаа зохион байгуулан ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ХААИС-ийн Агроэкологийн сургуулиас дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: 1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний шинжлэх ухааны үндэслэл, тооцоог хийхэд оролцсон бөгөөд модыг шууд эдийн засгийн үр ашигтай байдлыг харгалзан тариалах буюу агро-ойжуулалтыг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэл боловсруулсан. 2. Тэрбум мод тариалах үндсэн концепц, арга замыг боловсруулан Ерөнхийлөгчийн Тамгын газар, ХХААХҮЯ, БОАЖЯ, БХЯ болон бусад холбогдох газруудад хүргүүлж, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. 3. МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор ойн салбарын үндэсний чуулган зохион байгуулсан. 4. БХЯ, Эрдэнэс Тавантолгой ХК, ХААИС, Агроэкологийн сургууль, Монголын тариаланчид, Гурил үйлдвэрлэгчдийн холбоо тэрбумаар тоологдох мод тарих үндэсний хөдөлгөөнд хамтран ажиллах гэрээг байгуулсан. 5. Дээрх гэрээний хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-ийн амласан 180 сая модыг тарих ТЭЗҮ бэлтгэж байна. 6. Мөн дээрх гэрээний хүрээнд БХЯ-ны 3200 бие бүрэлдэхүүнийг хамруулсан 188 цагийн сургалтыг зохион байгуулж байна. 7. 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр БХЯ, Эрдэнэс Таван толгой ХК, ХААИС, Агроэкологийн сургууль, Монголын тариаланчид, Гурил үйлдвэрлэгчдийн холбооны төлөөлөгчид оролцсон хэлэлцүүлгийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна. ШУТИС-н харьяанд Ой модны сургалт, судалгааны хүрээлэнг байгуулсан. Тус хүрээлэн нь 1. Ойн экологийн төлөв байдлыг сайжруулах шинжлэх ухааны үндэслэл, технологи инноваци хөгжүүлэлт, 2. Ойн био нөөц, модлог судлал, 3. Ойн модны тогтвортой үйлдвэрлэл, бүтээгдэхүүн хөгжүүлэлт чиглэлээр судалгаа шинжилгээ хийнэ.	70%	
ҮАБЗ-ийн зөвлөмж						
54	179	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18	2. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн эрсдэлийн бодит байдлыг нийтэд таниулах, нийслэлийн орчмын бүс нутагт өндөр хурдны зам, эрчим хүчний шугам тавих замаар үйлдвэр,	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Их, дээд сургуулийг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 321 дүгээр тогтоолын дагуу БШУ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/391 тоот тушаалаар орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн	100%	

		Дугаар 2010_10/09	үйлчилгээ, хүн амын суурьшлын шинэ төвүүдийг бий болгох, их, дээд сургуулийн хотхон байгуулах зэргээр төвлөрлийг задлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх,	цогцолбор” болгон хөгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр төрөлжүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургуулийг шинээр байгуулах ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг уул уурхай, технологийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсан. Дээрх ажлын хэсгүүд үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан 2022 оны эхний улиралд багтаан батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 5 яамнаас оролцох гишүүдийн судалгааг албан тоот хүргүүлэн авч, дэд ажлын хэсгүүдийн хурал хийх бэлтгэл хангаж, ажлын төлөвлөгөө хийж байна.		
55	180	Биоаюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2011-07-07 Дугаар 2011_25/24	6. Молекул биологи, биоанагаах, биотехнологи, нано технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, тэдгээрт ажлын байрыг бодлогоор бий болгох	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн "Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/308 дугаар тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх дипломын, бакалавр, магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индексд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны "Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/52 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индексийн нэмэлт өөрчлөлт"-д 0788 инженерчлэл чиглэлийн хүрээнд 07880210 Биотехнологийн үйлдвэрлэлийн удирдлага мэргэжлийн хөтөлбөрийн индексийг, мөн "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх дипломын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр, индекс"-ийн нэмэлт өөрчлөлтөөр 0914 Анагаах ухааны оношилгоо ба эмчилгээний технологи чиглэлийн хүрээнд 091401 "Лабораторийн техникч"-ийн индексийг тус тус шинээр батлуулсан.	70%	
56	181	Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай 2017-07-19 Дугаар 2017_19/5	1.. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа	- Боловсрол, шинжлэх ухааны яам нь Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг дагалдан Монгол улсын Засгийн газар, Сангийн яам, холбогдох бусад байгууллагуудаас гаргасан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Дээрх хууль тогтоомж, дүрэм журам нь Монгол улсын хувьд Мөнгө угаахтай тэмцэх олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэгт нийцсэн байдаг. Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх үндэсний хөтөлбөр, холбогдох бусад эрх зүйн хүрээнд боловсрол, шинжлэх ухааны салбарын байгууллагуудын бүх шатанд санхүүгийн ажилтнуудын хараат бус байдлыг хангах зарчмыг	100%	

			мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах	баримтлан ажиллаж байна. Үүнд шинээр томилогдох нягтлан бодогч нарыг Төсвийн ерөнхий болон ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлагыг хангасан мэргэжилтнээр, төсөв санхүүгийн бусад ажилтныг Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан мэргэшсэн мэргэжилтнийг сонгон шалгаруулж ажиллуулж байна. Мөн салбарын төсөв санхүүгийн ажилтан, нягтлан бодогч нарын хууль эрх зүйн мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлэх, чадавхжуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Дотоод аудитын нэгж нь харьяа байгууллагад санхүүгийн болон холбогдох дотоод аудит хийхдээ Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хэрэгжилттэй хамтатган мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж ажилладаг болно. Салбарын харьяа байгууллагууд болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн нэгжүүдийн бүх мөнгөн гүйлгээ Монгол улсын сангийн яамны Төрийн сан дахь дансаар дамжин, хянагдаж байдаг.		
57	182	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.10. Ерөнхий боловсролын ахлах ангийн сургалтын хөтөлбөрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг ойлгуулан таниулах арга бүхий хичээлийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн тусган хэрэгжүүлэх.	- БСШУС-ын сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар 6-12 дугаар ангийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг батлан ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлж эхэлсэн. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр нь суралцагчид насан туршийн эрүүл амьдралын хэв маягийн талаарх хувь хүний хариуцлагыг ухамсарлан, өөрийн болон бусдын, цаашлаад хүрээлэн буй орчныхоо эрүүл байдлыг хүндэтгэх хандлагыг хөгжүүлэхэд тусална. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр дараах 6 үндсэн агуулгаас бүрдэж байна. Үүнд: 1. Хувийн ариун цэвэр, орчны эрүүл ахуй 2. Хооллолт, хөдөлгөөн 3. Сэтгэцийн эрүүл мэнд 4. Хорт зуршил 5. Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд 6. Осол гэмтэл зэрэг болно. Эрүүл мэндийн хичээл заах багш нарыг давтан бэлтгэж, тэдэнд сургалтын хөтөлбөр, зөвлөмжийг 7000 ширхэг хэвлэж түгээсэн. - 2021 онд суралцагчдад зориулсан “Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж байгаарай”, “Шаардлага гарвал бусдад хандаарай”, “Шийтгэлийг бус шийдлийг”, “Эцэг эх томчуудад”, “Хүн болгон адилгүй” зэрэг ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмж, шторкийг бэлтгэн олон нийтийн хүртээл болгосон.	100%	Хяналтаас хасах
ҮАБЗ-ийн суралдааны тэмдэглэл						
58	183	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03	1. 1. Орон нутагт ажиллаж буй газар хөдлөлт бүртгэх станц, боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, үйл ажиллагааг нь олон улсын түвшинд хүргэхэд гадаадын мэргэжлийн тэргүүлэх байгууллагуудтай хамтарч ажиллах, газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох, төв	- Орон нутагт ажиллаж буй газар хөдлөлтийг бүртгэх 10 станцыг орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглож, ООГХ болон орон нутгийн станцууд (ОНС) - ыг тусгайлсан шилэн кабелиар холбож газар хөдлөлтийн мэдээллийг шууд горимоор, богино хугацаанд хүлээж авах нөхцөлийг бүрдүүлсэн. Тус ажлын хүрээнд газар хөдлөлтийг бүртгэх 3 станцыг шинээр Сэлэнгэ, Дундговь, Баянхонгор (Богд сум) аймгуудад байгуулсан. ОНС-уудын ажилтнуудыг ООГХ дээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулснаар, газар хөдлөлтийн анхан шатны мэдээлэл боловсруулалтын ажлыг ОНС-ын ажилтнууд хийж байна.	70%	

		суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлтэй нутаг дэвсгэрт барилгажуулах боломжтой газрыг тодорхойлох арга хэмжээ авах, (Аймаг, нийслэлийн Засаг дарга, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв)	Урьд өмнө нь газар хөдлөлтийн бичил мужлалын судалгааны ажил хийгдээгүй байсан 12 аймгийн төвүүдийн нутаг дэвсгэрийн 1:10000 масштабтай газар хөдлөлийн аюулын үнэлгээний бичил мужлалын зураг зохиох ажлыг 2012-2017 онд хийж дуусгасан. Монгол орны газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураглал хийх ажлыг 2018 онд хийж дуусган БХБЯ-д хүлээлгэн өгсөн.		
184		2. Нийслэл, хот орчмын газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд геофизикийн иж бүрэн судалгаа явуулах, хүчтэй газар хөдлөлтийн голомтууд дээр урьдчилан таамаглах геофизикийн ажиглалтын байнгын цэг байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, (Сангийн яам, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв)	- Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 сарын 3-ны өдрийн 282 дугаар тогтоолоор энэхүү ажлын хөрөнгийн эх үүсвэр шийдэгдсэн. Энэхүү ажлын хүрээнд Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхжилтийн бүсэд нарийвчилсан судалгаа явуулсан. Судалгааны ажлын үр дүнд Улаанбаатар хот орчимд 6 газар хөдлөлтийн идэвхтэй хагарлыг илрүүлж, эдгээр хагарлууд дээр М6,5-7,5 хүчтэй газар хөдлөлт болох магадлалтайг тогтоосон. Энэ судалгааны үр дүнд үндэслэн Улаанбаатар хотын бичил мужлалын зураглалыг шинэчлэн боловсруулсан. Хүчтэй газар хөдлөлтийн голомтууд дээр газар хөдлөлт бүртгэх 21 станц, GPS-ийн 7 станц, газрын хэвгийлт бүртгэх 5 станц, соронзон орны 2 станцыг байгуулан хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Үүний зэрэгцээ гравиметрийн ажиглалтын цэгүүдийг байгуулан, жил бүр хэмжилтийн мэдээлэлд боловсруулалт хийж байна. Мөн Франц улсын эрдэмтэдтэй хамтран газрын гүнээс ялгарах радоны хийг бүртгэх 7 станц, 2 гүний цооног байгуулан хөрсний усны түвшин болон найрлагыг хянаж байна. Эдгээр геофизикийн станцуудыг ашиглан тухайн орчны физик орны өөрчлөлтийг хянах үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.	100%	Хяналтаас хасуулах
185		7.. Гамшгийн үед онцгой горимоор ажиллах шаардлагатай дулааны цахилгаан станц, цахилгаан, дулааны эрчим хүч дамжуулах, түгээх байгууламж, тээвэр, ачаа, зорчигчийн терминал, харилцаа холбоо, телевиз, радио зэрэг дэд бүтцийн объектууд, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, химийн болон бусад хорт бодис, нян өсгөвөр бүхий газруудын аюулгүй ажиллагааны журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга)	- “Ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, тэдгээрт тавигдах шаардлага” боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/88 дугаар тушаалаар байгуулан үйл ажиллагаанд шаардагдах зардлыг батлан ажиллуулж байна. Энэ жагсаалт, шаардлагад ерөнхий боловсролын сургуулийн химийн болон технологийн хичээлийн хэрэглэгдэхүүн урвалж бодис, түүний ашиглалт, хамгаалалт, аюулгүй ажиллагааны санал боловсруулагдах юм. Ерөнхий боловсролын сургуулийн химийн хичээлд хэрэглэгддэг, хугацаа дууссан, устгах шаардлагатай химийн хорт болон аюултай бодисын талаар авах арга хэмжээний зөвлөмж, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/277 дугаар тушаалаар байгуулан химийн хорт болон аюултай бодисын тооллого хийж тайланг боловсруулан сайдад танилцуулахад бэлтгээд байна.	70%	

	186		8. Газар хөдлөлтийн голомтоос аюулын мэдээллийг хотын хэмжээнд шуурхай мэдээлэх дуут болон бусад дохиоллын систем, "амжиж анхааруулах тогтолцоо"-г байгуулж, сургалтын дохиогоор авран хамгаалах, хор уршгийг арилгах, нүүлгэн шилжүүлэх ажиллагааны сургуулилтыг жидд нэгээс доошгүй удаа зохион байгуулж хэвших, (Сангийн яам, ОБЕГ, нийслэлийн Засаг дарга, Одон орон, геофизикийн судалгааны төв)	- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах зарим арга хэмжээний тухай 2011 оны 6 дугаар сарын 29-ны ЗГ-ын 196 дугаар тогтоол гарч "амжиж анхааруулах систем"-байгуулах хөрөнгийн эх үүсвэр шийдэгдсэн. Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо Мэдээлэл технологийн газраас хариуцан тендер зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулсан. ААС-ийг байгуулах ажлын гүйцэтгэгчээр БНСУ-ын КТ компанийг шалгаруулж уг ажлыг хийлгэсэн. ААС-ийг байгуулах ажлын хүрээнд Булган, Сэлэнгэ, Дундговь аймгуудад 12 станцыг 2013 онд байгуулж, энэхүү систем нь бүрэн хэмжээгээрээ 2014 оноос эхлэн ажиллаж байна. ООГХ нь хүчтэй газар хөдлөлтийн голомтууд дээр байгуулсан ААС-ийн 12 станцын хэвийн үйл ажиллагааг хангах, болзошгүй хүчтэй газар хөдлөлтийн үед мэдээллийг ОБЕГ -т дамжуулах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. ОБЕГ нь дохиоллыг нийтэд зарлан мэдээлэх, амжиж анхааруулах үйл ажиллагааг хариуцан ажиллан байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх Лхагва гарагийг улс орон даяар "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр" болгосонтой холбогдуулан, тухайн өдөр ААС-ийн дуут дохиог ажиллуулан дадлага сургуулилт хийгдэж байна. ОБЕГ болон ООГХ хоорондын хамтын ажиллагааны хүрээнд энэхүү системийн хэвийн үйл ажиллагааг шалгах, туршилтын ажлыг жил тутам гүйцэтгэж байна.	100%	Хяналтаас хасах
ЗГ-ын тогтоол						
59	187	Аргачлал шинэчлэн батлах тухай "Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал" 2018-01-24 Дугаар 2018_20	4.. Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тухайн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох хөрөнгийг хөгжлийн индекс ашиглан тодорхойлсон итгэлцүүрийг үндэслэн тооцож байхыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус даалгасугай.	- Монгол Улсын Засгийн газрын "хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай" 2016 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 242 дугаар тогтоолыг үндэслэн баг, сум, аймгийн төв, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьсах зардлыг байршлаас хамааруулан өөр байхаар тогтоож байгаа болно. Хувьсах зардлын тогтоолын төслийг боловсруулан 2022 оны төсвийн тооцооллыг хийж, 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн УИХ-ын чуулганаар 2022 оны төсөв батлагдсан. Төсөв батлагдсаны дагуу шинэчилсэн хувьсах зардлын тогтоолыг Засгийн газрын 2021-12-29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахад бэлтгээд байна.	70%	
60	188	Цаатан иргэдийн талаар авах арга хэмжээний тухай 2018-07-04	3.. Үндэсний цөөнхийн түүх, ёс заншил, өв соёлыг хадгалж үлдэх, эх хэлээрээ суралцах эрхийг хангах зорилгоор тува хэлний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тува хэлний багш нар бэлтгэх, мэргэжил	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн "Цаатан хүүхдийн боловсролыг дээшлүүлэх тухай" 42 тоот зарилгыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУ-ны сайдын 2013 оны тушаалаар "Цаатан хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г баталж, үндэстний цөөнх болох Баян-Өлгий аймагт амьдарч буй тува, Хөвсгөл аймагт амьдарч буй цаатан иргэдийн хэл, соёл, боловсролын асуудалд онцгой анхаарч, орон нутгийн бодит байдал, чадамж	100%	

		Дугаар 2018_213	дээшлүүлэх сургалтад хамруулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд С.Цогзолмаад даалгасугай.	болон сургалтын орчныг тооцоолж бага боловсролыг үндэстний хэлээр зохион байгуулах бүхий л боломжийг дэмжсэн арга хэмжээг авч байна. Тайгад амьдардаг 18 хүртэл насны цаатан хүүхдэд тухайн бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшний 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж сар бүр олгодог. Их, дээд сургуульд цаатан иргэдээс элсүүлэх зорилгоор Хөвсгөл аймагт цаатан иргэдэд зориулсан тусгай квот бий болгосон. 2021 оны элсэлтээр Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын сургуулийг төгссөн цаатан иргэдийн 13 хүүхэд их дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт хамрагдаж, тэдэнд 17.0 сая төгрөгийг сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж төрийн сангаас олгосон байна. Үндэсний цөөнхийн түүх, ёс заншил, өв соёлыг хадгалж үлдэх эх хэлээрээ суралцах эрхийг хангах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Сургалтын жишиг хөтөлбөр батлах тухай” А/339 дүгээр тушаалаар Хөвсгөл аймгийн Тува иргэдийн хүүхдэд зориулсан “Тува хэлний сургалтын жишиг хөтөлбөр”-ийг баталсан. 2021 онд хос хэлний боловсролыг дэмжих ажлын хүрээнд сургалтын толь бичиг боловсруулах ажил хийгдэж, хэвлэгдэн, туршигдаж байна. Математик, биологи, байгалийн шинжлэл, дүрслэх урлаг, биеийн тамирын хичээлийн сургалтын монгол-тува, тува-монгол хэл дээр толь бичиг боловсруулсан болно. Математик, байгалийн шинжлэл, дүрслэх урлаг, биеийн тамирын хичээлийн 1-6 дугаар ангийн, биологийн хичээлийн 6-7 дугаар ангийн үндэсний хэмжээний сурах бичигт орсон нэр томъёонуудыг казах, тува хэл дээр орчуулсан бөгөөд эдгээр сургалтын толь бичигт монгол-тува хэлний сургалтын толь бичигт нийт 3400 гаруй үг (4 хичээл) орсон байна.		
61	189	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-08-22 Дугаар 2018_267	8.. Малын генетик нөөцийн тухай хуульд нийцүүлэн мал зүйч мэргэжилд хамаарах мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн батлахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг нарт үүрэг болгосугай.	- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай” А/370 дугаар тушаалаар “08110402-малын генетик” индексийг баталж магистр болон докторын хөтөлбөрт сургалт явуулж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны Ажлын хэсэг байгуулах тухай А/242 дугаар тушаалаар Монгол Улсын Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөгдөж буй мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индексийг шинэчлэн, өөрчлөх ажил хийгдэж байна. Энэхүү ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн эрдэмтэд, мэргэжлийн багш нарын судалгаа, саналыг хүлээн авч хамтран ажиллаж байна. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүн 1005 мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ийн нэр, хөтөлбөрийн индексийг шинэчлэн батлахаар судалгаа хийж, 2022 эцэслэн шийдвэрлэхээр ажиллаж байна.	70%	
62	190	Багшийн хөгжлийг дэмжих талаар авах зарим арга	4.. Дээд боловсролын болон Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвийг тус тус төсөвтөө багтаан энэ оны 2 дугаар улиралд	1.БМДИ-ийн захирлын 2021 оны 02 сарын 10-ны өдрийн А/04 дугаар тушаалаар “Дээд боловсролын багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих журам”-ыг боловсруулан батлуулсан.	100%	

		хэмжээний тухай 2019-04-12 Дугаар 2019_145	байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай.	2.БМДИ-ээс дээд боловсролын багшийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх богино, дунд хугацааны төлөвлөгөө, 6 багц, 30 модуль цахим сургалтын танилцуулга болон 2021 оны эхний хагас жилд зохион байгуулах хэлэлцүүлгийн хуваарь зэргийг хамтран ажиллах тухай албан бичгийн хамт төрийн болон хувийн өмчийн 74 их, дээд сургуулийн удирдлага, багшийн хөгжлийн төвүүдэд хүргүүлсэн. 3.Дээд боловсролын багшийн хөгжлийн албанаас “Багшлахуйгаас суралцахуйд шилжих шилжилтийг хурдасгах нь” , “21-р зууны дижитал технологи ба их сургуулийн багш” сэдэвт 2 модуль цахим сургалтуудад хамрагдсан 25 их, дээд сургуулийн 74 багш хамрагдан сургагч багшаар бэлтгэгдсэн бөгөөд цаашид өөрсдийн сургуулийн багш нарт “Дамжуулах сургалт”-ыг 01-03 дугаар сарын хооронд зохион байгуулсан бөгөөд нийт 10 их, дээд сургуулийн 420 багш хамрагдсан.		
63	191	Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2020-03-25 Дугаар 2020_106	1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	- Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтөд улсын үзлэгийн мөрөөр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 8 дугаар сарын 24-ний “Улсын үзлэгийн мөрөөр арга хэмжээ авч ажиллах тухай” А/10 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллаж байна. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөнд албан хэрэг хөтлөлтийн талаар зохион байгуулах 7 ажил, архивын ажлын талаар зохион байгуулах 5 ажил, Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж байгаа талаар зохион байгуулах 4 ажил болон удирдлага зохион байгуулалтын талаар зохион байгуулах 5 ажлыг төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	100%	Хяналтаас хасах
	192		2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.	- Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын архивын баримт бүрдүүлэх, хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд 2020 онд 14'251'700 төгрөгийн хангамжийн материал авч, шаардлагатай мэргэжилтнүүдэд өгч ажилласан.	70%	
	193		5. Удирдлагын академийн сургалтын хөтөлбөрт албан хэрэг хөтлөлтийн хичээлийг тусгаж хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, их, дээд сургуулиудын төгсөх ангийн оюутнуудад 2020-2021 оны	- Удирдлагын академи нь төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг урт болон богино хугацаагаар зохион байгуулж байна. Төрийн албан хаагчдад зориулсан богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийг Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан сургалтын хөтөлбөрийн “Хоёр. Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтын хөтөлбөр” гэсэн хэсэгт “Төрийн албан хэргийн баримт бичиг	70%	

			хичээлийн жилээс эхлэн албан хэрэг хөтлөлтийн хичээл оруулах асуудлыг судлан шийдвэрлэж, албан хэрэг хөтлөлтийн сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг боловсруулж, мөрдүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт тус тус даалгасугай.	боловсруулах” гэсэн нэртэй 1 багц цаг (кредит)-ийн багтаамжтай хичээл тусгагдсан болно. 2020-2021 оны хичээлийн жилд буюу 2020 оны 9 дүгээр сараас хойш уг хичээлд нийт 236 албан хаагч хамрагдсан байна. Түүнчлэн 2021 оны төлөвлөгөөнд “Албан хэрэг хөтлөлт” хичээлийг 24 цагийн багтаамжтайгаар зайнаас цахим хэлбэрээр төрийн албан хаагчдад зориулан явуулахаар төлөвлөсөн болно.		
64	194	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай 2020-04-22 Дугаар 2020_144	1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай.	- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 144 дүгээр тогтоолын дагуу Төрийн болон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай ажлын хүрээнд Эрчим хүчний яамнаас дараах ажлыг зохион байгуулж байна. Улсын хэмжээнд 4200 ш тоолуур суурилуулах шаардлагатай гэсэн тооцоо гарсан. Үүний дагуу 33 Төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон аймаг нийслэлийн засаг дарга нарт мэдээлэл хүргүүлсэн байна. Тухайн тогтоолоор тоолууржуулах зардлыг цахилгааны хэмнэлтийн зардлаас санхүүжүүлэхийг зөвшөөрсөн байна. Байгууллага болгон тоолуур худалдан авахад тендер зарлах тул энэ асуудлыг хялбаршуулах үүднээс Сангийн яамтай ярилцан Төрийн худалдан авах ажиллагаанаас ерөнхий гэрээ байгуулах тендер зарлана. Энэ ажлын дагуу үнэлгээний хороо байгуулагдаад 2020 оны 11 дүгээр сард ерөнхий гэрээ байгуулах 5 компани шалгарч Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулаад байна. Судалгаагаар 21 аймгийн хэмжээнд тоолууртай байгууллага байхгүй гэсэн үзүүлэлт гарсан. Одоо Коронавируст халдварт цар тахлаас шалтгаалж ажил удаашралтай байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчилсан. Тус хуулийн дагуу Орон нутаг дахь нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал, засвар үйлчилгээг орон нутаг хариуцахаар 2022 оны орон нутгийн төсөвт тусгагдсан.	100%	Хяналтаас хасах
65	195	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний	19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг	- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан Боловсрол, шинжлэх ухааны салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө эдийн засгийн хүндрэлийг давах туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор бараа, ажил үйлчилгээ худалдан авахад Тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх тооцохоор тусгаж зохион байгуулж байна. Салбарын хэмжээнд гал, тогооны тоног төхөөрөмж, сургууль, цэцэрлэгийн сандал ширээ, цэцэрлэг, дотуур байрын зөөлөн эдлэл, сурах бичиг зэрэг бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлүүдээс худалдан авч Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	100%	

		тухай 2020-11-18 Дугаар 2020_183	төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.			
66	196	Яслийн үйлчилгээний тухай 2020-12-16 Дугаар 2020_226	2.1. Энэ тогтоолын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дараахь зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай: 2.1. яслийн үйлчилгээнд 1-2 насны хүүхдийг хамруулахад шаардлагатай холбогдох эрх зүйн орчныг тодорхой болгох, хүүхэд хөгжүүлэх болон хүний нөөц бэлтгэх хөтөлбөрийг баталж, сургалт зохион байгуулах, яслийн насны хүүхдийн онцлогт нийцсэн орчин бүрдүүлэх талаар батлагдсан төсөвтөө багтаан зохицуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэнд;	- Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.02.23-ны өдрийн А/4 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар “Яслийн үйлчилгээг зохион байгуулахад мөрдөх журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хэсэг дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. “Яслийн үйлчилгээг зохион байгуулахад мөрдөх журам” нь i) Нийтлэг үндэслэл, ii) Хамрах хүрээ, iii) Удирдлага, зохион байгуулалт, iv) Хүүхдийн хөгжлийг дэмжих, аюулгүй орчин бүрдүүлэх, v) Багш, туслах багш, эмч, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг, оролцоо, vi) Санхүүжилт, vi) Бусад гэсэн 6 бүтэцтэй. Журмын төслийн танилцуулга, хэлэлцүүлгийг хоёр үе шаттай цахимаар зохион байгууллаа. Үүнд: Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн, цэцэрлэгийн эрхлэгч, яслийн эрхлэгч, багш, эмч нар Яамны Хуулийн хэлтэс, Хөрөнгө оруулалтын газар, Санхүү, эдийн газрын сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, харьяа байгууллагын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан, арга зүйч нар оролцлоо. Оролцогчдоос гарсан санал, зөвлөмжийг судлан, “Яслийн үйлчилгээг зохион байгуулахад мөрдөх журам”-ын төслийг сайжруулан, боловсруулж дууссан. - Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн шууд арга хэмжээний 2021 оны төсөвт нийт 4.0 тэрбум төгрөг батлагдсан. Цаашид тус арга хэмжээний хэрэгжилтийг эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан зохион байгуулахаар судлан ажиллаж байна. Тухайн заалт Боловсролын багц хуулийн төслийг УИХ-аар батлахтай холбогдуулан хүлээгдэж байна.	70%	
	197		2.2. яслийн нэг бүлэгт 15-аас ихгүй хүүхэд хүлээн авах, нэг багш, 2 туслах багш ажиллахаар тооцон орон тооны норматив, яслийн үйлчилгээний нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг хүүхдийн цэцэрлэгийн зардлаас 1,5 дахин их байхаар тооцон, хүүхдийн нас, хөгжлийн онцлогтой уялдуулан нэг өдөрт ногдох хоолны зардлын хэмжээг Сангийн яамтай хамтран тус тус боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэнд;	- Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн шууд арга хэмжээний 2021 оны төсөвт нийт 4.0 тэрбум төгрөг батлагдсан. Засгийн газрын 2016 оны “Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай” 242 дугаар тогтоолыг шинэчлэхтэй холбоотойгоор яслийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг шинээр тооцоолж, нормативыг байршлаар хийгээд байна. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газраас цэцэрлэгийн танхимын сургалт, үйл ажиллагааг үе шаттай эхлүүлж байгаатай холбогдуулан яслийн ангийг нээх асуудал түр хойшлоод байна.	70%	
	198		2.3. яслийн бүлгийн хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх	Засгийн газрын “Яслийн үйлчилгээг эхлүүлэх тухай” 223 дугаар тогтоолын 2.2, 2.3 дугаар заалтын хэрэгжилтийн ажлын хүрээнд	70%	

			зорилгоор тоглоом, наадгай болон бусад тавилга, тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн нарт;	Яслийн орчинд тавигдах шаардлагын дагуу хүүхэд хүлээн авах анги танхимыг бэлтгэх ажлын тооцоо, санхүүжилт, тендер зарлахад шаардагдах техникийн тодорхойлолт зэргийг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн, улсын төсвөөс 4,8 тэрбум төгрөгийг батлуулан бэлтгэл ажлыг хангасан. Гэсэн хэдий ч Боловсролын багц хууль боловсруулах явцад хийсэн судалгаагаар Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах насыг өөрчлөхөөр Засгийн газраас УИХ-д өргөн барьсан хуулийн төсөлд тусгасан, нөгөө талаас Ковид цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газраас цэцэрлэгийн танхимын сургалт, үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэх, 4 болон 5 настай хүүхдийн эхний ээлжид хүлээн авахаар БШУ, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан тушаал батлагдсан зэргээс шалтгаалан 2021-2022 оны хичээлийн жилээс эхлүүлэх боломжгүйд хүрсэн. Дээрх нөхцөл байдал, шалтгааны улмаас боловсруулж батлуулахаар ажиллаж байсан үйл ажиллагааг түр зогсоож, журмыг эцэслэн батлуулаагүй болно. Хууль батлагдах явцтай уялдуулан яслид хамрагдах хүүхдийн насыг эргэж харах шаардлага үүсээд байна.		
67	199	Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-12-23 Дугаар 2020_235	1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын суралцах эрхийг тэгш хангах чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэнд даалгасугай: 1.1. хүүхдийг хөгжлийн бэрхшээлийн онцлогоос үл хамааран цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах, эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад хамрагдах боломжгүй хүүхдэд тохирсон боловсролын хувилбарт болон явуулын багшийн үйлчилгээг бий болгох талаар холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах; 1.2. их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд элсэлтийн хяналтын тоонд багтаан жил бүр хөгжлийн бэрхшээлтэй суралцагч элсүүлэх тооны доод хязгаарыг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчлэх ажилтан ажиллуулах арга хэмжээг авч, хэрэгжилтийг хянах; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй эзэмшүүлэх	1.1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Журам батлах тухай" А/177 дугаар тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам"-ыг баталсан. Тус журам 2021-2022 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхлэх бөгөөд цэцэрлэгийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах эрх зүйн орчин бүрдлээ. "Танхимын сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд гэрээр боловсрол олгох чиглэл"-ийн төслийг боловсруулаад байна. Чиглэлд хүүхдийн бэрхшээлийн онцлогоос хамааран сургалтыг гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой зохион байгуулах, багш хичээлийн цагийг хүүхдийн бодит чадварт тохируулан "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө"-ний үлгэрчилсэн загварын дагуу сургалтын хөтөлбөр, хичээлийн хуваарийг эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой боловсруулж, гэр бүлийн орчинд үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар тусгасан. Явуулын багшийн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор шинээр батлагдах хуулийн төсөлд холбогдох заалтыг тусгасан болно. 1.2. Дээд боловсролын сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэний суралцах боломж, эрхийг бүрэн хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, тэднийг хөгжүүлэх, ажилд зуучлах чиг үүрэг бүхий албан хаагчийг ажиллуулах талаар БСШУС-ын сайдын 2018 оны "Дээд боловсролын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох нөхцөлийг хангах тухай" А/261 дүгээр тушаал батлагдсан. 1.3. Засгийн газрын 2020 оны 235 дугаар тогтоолын дагуу 2020-2021 оны хичээлийн жилд "Тусгай хэрэгцээт боловсрол" хичээлийг МУБИС-д бусад	100%	

		хичээлийг багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад заавал судлуулах зохицуулалт хийх, Монгол Улсын боловсролын их сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн үйл ажиллагааг бусад их, дээд сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр өргөжүүлэх; 1.4. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр багш, албан хаагчдыг тусгайлан бэлтгэх, Засгийн газар хоорондын гэрээгээр болон гадаад улс орны Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах хяналтын тоог жил бүр тогтоон мөрдөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтыг тавигдаж буй нөхцөл, шаардлага хангасан мэргэжлийн сургалтын төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах; 1.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулж байгаа тусгай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчин нөхцөлийг сайжруулж, багш, мэргэжилтнийг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, багш, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийг зөвлөгөө, мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг чадавхжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.	мэргэжлээр сурч байгаа 281 оюутан сонгон судалсан. Цаашид дээрх хичээлийг заавал судлах хичээлийн жагсаалтад оруулах талаар МУБИС-ийн Боловсрол судлалын сургуульд болон багш мэргэжил олгож буй их дээд сургуулиудад чиглэл өгч хамтран ажиллалаа. 2021-2022 оны хичээлийн жилээс “Тусгай хэрэгцээт боловсролын үндэс” хичээлийг “Тэгш хамран сургах боловсрол” хичээл болгон өөрчилж, заавал судлах хичээлийн жагсаалтад оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн МУБИС, АШУУИС хамтран хэл засалч багшийн анхан шатны сургалтыг энэ оны 8-р сард зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаад байна. 1.4. 2021 онд Орос Монголын засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу богино хугацааны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч цар тахлын улмаас хэрэгжээгүй. Нөхцөл байдалтай уялдуулан гадаадын мэргэжлийн байгууллагын багш, эрдэмтэн нарыг оролцуулан дараах сургалтуудыг цахимаар зохион байгуулсан. - ОХУ-ын Москва хотын Багшийн Их сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн эрхлэгч профессор Елена Владимировна, Япон улсын Хюго Боловсролын Их сургуулийн профессор Торигое Такаши нарыг урьж оролцуулан багш нарт хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтыг 2021 онд зохион байгуулсан. Сургалтад ерөнхий боловсролын 29, 116 дугаар сургуулийн багш нарыг хамруулсан. - Юнескогоос зохион байгуулсан “Тэгш хамруулан сургах боловсролын үнэлгээ, төлөвлөлт” сэдэвт 2021 оны 3 дугаар сарын 01, 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд явагдсан 2 сарын сургалтад БШУЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын 6 мэргэжилтэн хамрагдлаа. 14 орны тэгш хамруулан сургах боловсрол хариуцсан мэргэжилтэн оролцсон тус сургалтаар эзэмшсэн тэгш хамран сургах боловсролын төлөвлөлт, бодлого зохицуулалтын тухай мэдлэг ойлголтыг орон нутгийн удирдлагуудад түгээх сургалтыг Хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулахаар бэлтгэж байна. 1.5. Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий, Төв, Завхан аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын тэгш хамран сургах боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн, Ерөнхий боловсролын сургуулийн “Дэмжлэгийн баг”-ийн гишүүд /захирал, сургалтын менежер, багш/ нарт ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах боловсролын бодлого, эрх зүйн баримт бичиг, үзэл санаа, чиг хандлага, хөгжлийн бэрхшээлийн тухай үндсэн ойлголт, тэгш хамран сургах боловсролын онол, арга зүйн мэдлэг, ойлголтыг эзэмшүүлэх сургалтыг 2021 оны 1 дүгээр сард цахимаар зохион байгуулсан. Сургалтад 100 багш, ажилтан хамрагдсан.		
--	--	---	--	--	--

			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй бага ангийн багш нарыг чадавхжуулах цахим сургалтыг 2021 оны 5 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй аймаг, нийслэлийн нийт 400 багш оролцсон. Аймгуудын Биеийн тамир спортын хороо, БСУГ-ын биеийн тамирын боловсрол. хариуцсан мэргэжилтнийг чадавхжуулах цахим сургалтыг Боловсролын хүрээлэн, Биеийн тамир спортын улсын хороотой хамтран 2021 оны 3 дугаар сард зохион байгуулж, 100 оролцогч хамрагдлаа. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурах бичгээр хангах хүрээнд тусгай хэрэгцээт боловсролын 1-5 дугаар ангийн Монгол хэл, математик, Дүрслэх урлаг, технологийн нийт 11 нэрийн сурах бичгийг тус бүр 500 ширхгийг нөхөн хангалтаар хэвлэн нийлүүлэх зардлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Зардал батлах, эрх шилжүүлэх тухай” А/61 дүгээр тушаалаар батлуулж, худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээгээр зохион байгуулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Сурах бичгийг хэвлэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдаад байна. - 2021 онд шинээр баригдахаар төлөвлөгдсөн тусгай цэцэрлэг, сургуульд хэрэгцээтэй тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, саажилттай, тулгуур эрхтний бэрхшээлтэй зэрэг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих, боловсролд тэгш хамруулахад шаардлагатай зарим тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүний жагсаалтыг гаргалаа. - Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах орчин бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих, ганцаарчилсан сургалт зохион байгуулах, эцэг эх багш нар харилцан туршлага солилцох үйл ажиллагаа явуулахад зориулсан “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-ыг Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий гэсэн аймгийн нийт 8 сургуульд байгууллаа. Танхим байгуулах ажлыг Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслөөс санхүүжүүлсэн. Бусад 13 аймагт “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Ингэснээр аймаг бүрд хүүхдийн хөгжлийг дэмжих загвар танхимтай болно.		
200	2. Сургалтын цахим технологийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид хүртээмжтэй хэлбэрээр хөгжүүлэх, цахим контент боловсруулан сургалтад нэвтрүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Харилцаа, холбоо,	- НҮБ-ын хүүхдийн сантай хамтран тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд зориулсан 27 интерактив хичээлийг жишиг байдлаар боловсруулан econtent.edu.mn сайтад байршууллаа. - Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын теле хичээлийн үр дүнг сайжруулах, багш, сургалтын үйл ажиллагааны эргэх холбоог дэмжих зорилгоор тусгай цэцэрлэг, сургуулийн багш нарт zoom программ ашиглан цахим хичээл зохион байгуулах арга зүйн удирдлагаар ханган, байгууллага тус бүрд тус программыг ашиглах 14 эрх олгож үйл ажиллагааг нь дэмжлээ. Ингэснээр тус сургуулиуд 2 дугаар улирлаас эхлэн хүүхдийн онцлог хэрэгцээнд	100%		

		мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.	нийцсэн нийт 32 цахим хичээл зохион байгуулж, хичээлд хүүхэд эцэг эхчүүд хамтран оролцох, сургууль харгалзахгүй хэд хэдэн сургуулийн суралцагч оролцох, багш нар оролцож туршлага судлах боломж олгосон нь үр дүнтэй ажил боллоо. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 186 дугаар цэцэрлэгт түшиглэн хөдөлгөөний болон хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллах хичээлийн бичлэгийг нийт багш нарт цахим хэрэгслээр дамжуулан хүргэлээ.		
201		4. Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, анги танхимыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ашиглах боломжтой стандарттай байхаар тоноглож, тохижуулах цогц арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх зайлшгүй шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүний зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан шийдвэрлэж байхыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	- Ерөнхий боловсролын тусгай сургалттай 70 дугаар сургуульд хүртээмжтэй орчин бүрдүүлэн эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад хамрагдах боломжгүй тархины саажилттай хүүхдийн 2 бүлгийг нээн ажиллуулахаар бэлтгэж байна. - Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах орчин бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих, ганцаарчилсан сургалт зохион байгуулах, эцэг эх багш нар харилцан туршлага солилцох үйл ажиллагаа явуулахад зориулсан “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-ыг Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий гэсэн аймгийн нийт 8 сургуульд байгууллаа. Танхим байгуулах ажлыг Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслөөс санхүүжүүлсэн. Бусад 13 аймагт “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурах бичгээр хангах хүрээнд тусгай хэрэгцээт боловсролын 1-5 дугаар ангийн Монгол хэл, математик, Дүрслэх урлаг, технологийн нийт 11 нэрийн сурах бичгийг тус бүр 500 ширхгийг нөхөн хангалтаар хэвлэн нийлүүлэх зардлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Зардал батлах, эрх шилжүүлэх тухай” А/61 дүгээр тушаалаар батлуулж, худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээгээр зохион байгуулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Сурах бичгийг хэвлэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдаад байна. -2021 онд шинээр баригдахаар төлөвлөгдсөн тусгай цэцэрлэг, сургуульд хэрэгцээтэй тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, саажилттай, тулгуур эрхтний бэрхшээлтэй зэрэг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих, боловсролд тэгш хамруулахад шаардлагатай зарим тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүний жагсаалтыг гаргасан.	70%	
202		6. Бүх шатны сургалтын байгууллагын орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан зохих стандартад нийцүүлсэн зам, талбайтай болгох арга хэмжээг	- Сургалтын байгууллагын барилга байгууламжийг хүртээмжтэй болгох ажлыг үе шаттай шийдвэрлэх талаар аймаг, нийслэлийн Засаг даргатай сайдын байгуулсан гэрээнд холбогдох заалт оруулж, хэрэгжилтийг хангах талаар хамтран ажиллах чиглэлийг Боловсролын газарт өгч ажиллаж байна.	70%	

			2021-2023 онд авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн суралцах орчин нөхцөлийг сайжруулах, хүртээмжтэй болгох зэрэг тэдний эрхийг хангах чиглэлээр батлагдсан эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах талаар их, дээд сургуулиудад хүргүүлж, хэрэгжилтийг хангах чиглэл өгч ажиллалаа. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 150 ортой цэцэрлэгийн барилгыг газар хөдлөлтийн балл, цаг уурын бүсчлэлээс нь хамааруулан нэг маягийн зургийг “MSL” ХХК-иар хийлгүүлсэн. Үүнд: ➢ Газар хөдлөлийн чичирхийллийн зэрэг: 5-6,7,8,9 балл ➢ Цаг уурийн бүсчлэлээр: Ширмэн радиатортой, Панелин радиатортой ➢ Төсөв өртөг: 6,147.2-6,175.2 сая төгрөг Мөн хөгжлийн бэрхшээлтэй ерөнхий боловсролын сургуулийн хүүхдэд зориулсан 320 суудалтай сургуулийн барилгыг газар хөдлөлтийн балл, цаг уурын бүсчлэлээс нь хамааруулан нэг маягийн зургийг “MSL” ХХК-иар хийлгүүлсэн. Үүнд: - Газар хөдлөлийн чичирхийллийн зэрэг: 5-6,7,8,9 балл - Цаг уурийн бүсчлэлээр: Ширмэн радиатортой, Панелин радиатортой - Төсөв өртөг: 10,622.0-11,090.1 сая төгрөг -Барилга, хот байгуулалтын сайдын багцад 2022 онд батлагдсан зураг, төслийн санхүүжилтийн задаргаанд ерөнхий боловсролын сургуулийн нэг маягийн зураг, төслийг Япон Улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдсан 4 барилгын зургийг жишиг болгон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шийдлийг сонгон авч, шийдвэрлүүлэх хүсэлтийг Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 2/6429 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргад уламжлаад байна.		
68	203	Төлөвлөгөө батлах тухай 2021-01-20 Дугаар 2021_18	2. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутгийн жил бүрийн холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	- 2021 онд улсын төсөв болон орон нутгийн төсөв, гадаадын буцалтгүй зээл тусламжаар 35 сургуулийн хоолны газрын засвар үйлчилгээ, 161 сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шийдвэрлэсэн. 2022-2024 онд хэрэгжих олон улсын байгууллагын төслийн хүрээнд 55 сургуулийг иж бүрэн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангана.	100%	
69	204	Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга	1. Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараахь арга	- Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн байгууллагуудын сар улирлын санхүүжилтийн хуваарийг тус тогтоолтой уялдуулан 2021 оны 3 сараас эхлэн бууруулсан хувь хэмжээгээр санхүүжүүлэхгүй байхаар 12 дугаар сард татсан. Мөн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахдаа тогтоолд	100%	

		хэмжээний тухай 2021-02-17 Дугаар 2021_43	хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай: 1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах; 1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх; 1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг	дурдсан зардлуудыг өөрчлөхгүй байх зарчим баримтлан ажиллаж байна. 2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын хүрээнд тус тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд тогтоолыг яам болон тус яамны харьяа байгууллагуудад хүргүүлсэн. 3. Салбарын төсөв, түүний дотор цалин орон тооны бүтцийг боловсронгуй болгох зорилгоор салбар бүрд цалин хүний нөөцийн судалгаа хийж байгаа бөгөөд нэн тэргүүнд ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн орон тооны жишиг норматив батлуулан баримталж, чиг үүргийн давхардал, нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгохдоо эрх зүйн баримт бичгийг ялгаатай байдлаар мөрдөж байгаа зэрэг алдаа дутагдлыг арилгахаар судлан ажиллаж байна. Мөн тус ажлын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2021 оны А/38/15 тоот ажлын хэсэг ажиллаж байна. 4. Боловсрол, шинжлэх ухааны Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хүсэлтийг www.tender.gov.mn батлахад тавилга тоног төхөөрөмж, автомашины худалдан авах арга хэмжээг батлахгүй цуцалж ажиллаж байна. 5. Салбарын хэмжээнд бүх төрлийн хурал, сургалт, хэлэлцүүлгийг цахимаар хийж байгаа бөгөөд цаашид төсвийн төсөл боловсруулах, түүний мэргэжил арга зүйн сургалтыг боловсролын мэдээллийн системд тулгуурлан цахимаар зохион байгуулахаар ажиллаж байна. Үүний үр дүнд улсын хэмжээнд 2400 орчим нягтлан бодогч нарын томилолтын зардал хэмнэгдэх боломж бүрдэх юм. 6. Салбарын хэмжээнд Засгийн газрын шийдвэр гарснаар бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалгыг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй төсвийн хуваарь хийгдсэн. 7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсвөөс зөвхөн сургалтын контентыг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй.		
--	--	--	---	--	--	--

		жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх; 1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх; 1.5. салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх; 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх; 1.7. хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх; 1.8.		
--	--	--	--	--

			байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; 1.9. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах.			
70	205	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-02-24 Дугаар 2021_47	1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын “ногоон түвшин” (халдвар илрээгүй)-д байгаа аймаг, сум, тосгон, багт байршилтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг ариутгал халдваргүйжүүлэлт хийсний үндсэн дээр халдвар, хамгааллын дэглэмийг баримтлан 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс үе шаттай эхлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/58 дугаар тушаалаар аймаг, сум, тосгон багийн цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг 03 дугаар сарын 01-ний өдрөөс танхимаар зохион байгуулахаар шийдвэрлэн “Цэцэрлэгийн хичээл, сургалт, үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам”-ыг тус батлан аймаг орон нутгуудад хүргүүлж, аймаг, нийслэл, сум, баг, хорооны цэцэрлэгүүд тушаалын хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Засгийн газрын тогтоолын 1 дэх заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн А/58 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам”-ыг батлан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Энэ тушаалаар (i) хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс танхимаар зохион байгуулах, (ii) зайн сургалтаар эзэмшсэн агуулга бататгах, агуулгын хоцрогдлыг арилгах, сурах үйлийг дэмжихэд танхимын сургалтыг чиглүүлэх, сургалтын зохион байгуулалт, (iii) сургуулийн орчинд халдварын эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээ болон халдвар хамгааллын дэглэм баримтлах, (iv) сургалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагаа, оролцоо, үүрэг хариуцлага зэрэг асуудлыг тус тус нарийвчлан зохицууллаа. Халдварын тархалтын нөхцөл байдалтай холбогдуулан танхимын сургалт 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл үргэлжилж, 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс улирлын амралтыг эхлүүлэх зохицуулалт хийсэн болно.	100%	Хяналтаас хасах
	206		2. Теле болон цахим хичээлээр олгож буй мэдлэг, чадварын түвшинг тогтоосны үндсэн дээр сурлагын хоцрогдлыг арилгах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.	- Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө”-ний төслийг хэлэлцэн дэмжиж 32 дугаар тэмдэглэл гаргаж уг төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасан. . Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх тухай” 2021 оны А/190 дүгээр тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө /2021-2023/-г баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд цар тахлын үеийн хөл хорионы улмаас бий болсон сурагчдын сурлагын хоцрогдлыг бүрэн арилгаж, нийгэм, сэтгэл зүйн	100%	

			зохистой орчин бүрдүүлж, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг тусгасан. Цар тахлын хорио цээрээс үүдсэн хичээл, сургалтын хоцрогдлын нөхцөл байдал (хичээл бүрээр)-ыг тодруулах зорилгоор оношлох үнэлгээг II-XII ангийн суралцагчдын 10 хувийг хамруулан үндэсний хэмжээнд 2021 оны 9 дүгээр сард, сургуульд суурилсан үнэлгээг 2021 оны 10 дугаар сард тус тус зохион байгууллаа. Үндэсний хэмжээнд 2021 оны 9 дүгээр сард зохион байгуулсан үнэлгээнд II-XII ангийн 62,8 мянган сурагч хамрагдаж давхардсан тоогоор 64 хичээлийн агуулгаар 296,282 нэгж үнэлгээ судалгаа хийгдсэн. Энэхүү үнэлгээгээр сурагчдын гүйцэтгэл үндэсний хэмжээнд 2019 онд зохион байгуулсан чанарын үнэлгээний гүйцэтгэлтэй харьцуулахад хичээл бүрд буурсан урьдчилсан үр дүн гараад байна. Тухайлбал, бидний хамгийн их анхаарал хандуулдаг математикийн хичээлийн оношлох үнэлгээний дүн 2019 оны чанарын үнэлгээний дүнгээс бага ангид 15.1 хувь, дунд ангид 1.6 хувиар тус тус буурсан байна. Мөн 2 дугаар ангийн суралцагчдын унших, бичих чадвар 70.1 хувьтай үнэлэгдэж байгаа нь тэдний 30 хувьд унших, бичих чадварыг нөхөн олгох хэрэгцээ үүссэн, энэ хэмжээгээр багшид ачаалал нэмэгдэж буйг харуулж байна. Иймд багшийн ачааллыг оновчтой зохицуулах, хоцрогдол нөхөх, арилгах чиглэлээр ахмад багш нартай хамтран ажиллах зэрэг сайн туршлагууд зарим аймагт хэрэгжиж байна. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ боловсрол, сургалтад анхаарал хандуулж, сургууль, багш нартай хамтран ажиллах хэрэгцээ нэн чухал байгаа бөгөөд энэ нь хоцрогдлыг нөхөхөд ихээхэн дэмжлэг болно.		
207	3. Эрсдэлгүй ногоон бүсэд танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг зохих журам, зааврын дагуу ариутгаж халдваргүйжүүлэхэд нэн шаардлагатай ариутгалын бодис, багаж, хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд Ковид-19 болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн сан, "Wash action" ТББ хамтран улсын хэмжээнд бүх цэцэрлэг, сургуулийн нийт 5549 эрхлэгч, захирал, эмч, дотоод хяналтын асуудал хариуцсан ажилтныг оролцуулсан цахим сургалтыг 2021 оны 2 дугаар сарын 26 өдрөөс эхлэн 3 дугаар сарын 07-ны өдрийг дуустал амжилттай зохион байгууллаа. "ЖАЙКА" Олон улсын байгууллага нь буцалтгүй тусламжийн хүрээнд нийт 2089 ширхэг автомас, 20,000 ширхэг 5 литрийн савлагаатай ариутгалын бодис хандивласан. Тус ариутгалын бодис, багаж хэрэгслийг аймаг, нийслэлийн боловсролын газраар дамжуулан улсын хэмжээний 662 ерөнхий боловсролын сургууль, 522 дотуур байр, 905 цэцэрлэгт тараах үйл ажиллагааг зохион байгуулсан. - Онцгой Байдлын Ерөнхий Газар, Гамшиг судлалын хүрээлэн, НҮБ-ын Хүүхдийн Сан, ШУА-ийн, Одон орон, геофизикийн хүрээлэн, Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагатай хамтран 2021 оны 3 дугаар сарын 23-нд "Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний арга зүй" сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа. - Тус сургалт нь мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн менежментийн чиглэлээр боловсролын байгууллагын ажилтнуудын чадавхыг сайжруулах,	100%		

				сургагч багш нарыг бэлтгэн, нийт аймаг, сумдын цэцэрлэг, сургуулийн 6000 гаруй захирал эрхлэгч, нийгмийн ажилтан, арга зүйч нар оролцсон. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын багш, ажилтнуудад “Хүүхдийн хөгжлийн болон харилцааны онцлог, хүүхэдтэй ажиллах арга зүй, суралцагчдын нийгэм, сэтгэл зүйн асуудал, шийдвэрлэх арга зам дотуур байрны ариутгал халдваргүйтгэл” сургалтыг 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдөр цахимаар зохион байгууллаа. Сургалтад аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын багш, ажилтан 439 хүн хамрагдсан		
	208		4. Энэ тогтоолын 2, 3-т заасан арга хэмжээнд шаардагдах зардлыг тооцож, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны батлагдсан төсвийн багцын хүрээнд зохицуулалт хийж, санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	- Халдварын өндөр эрсдэлтэй төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг мэргэжлийн байгууллагатай хамтран ариутгаж халдваргүйжүүлэлт хийлгэхээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Ариутгалын зардал батлах тухай” А/81 дүгээр тушаал гарч хэрэгжүүлэн ажилласан. - 2021-2022 оны хичээлийн жилийн хичээл сургалтын ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан төрийн өмчийн төв орон нутгийн сургууль, дотуур байрны ариутгалд шаардлагатай хөрөнгийг засгийн газрын нөөц хөрөнгөөс зарцуулахаар шийдсэнийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Зардал батлах тухай” А/279 дүгээр тушаалаар хуваарилан аймаг дүүргийн Боловсролын газруудад хуваарилсан. Тус 512,3 сая төгрөгийн хөрөнгөөр төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг мэргэжлийн байгууллагатай хамтран ариутгаж халдваргүйжүүлэлт хийлгэж хичээл эхлэх бэлтгэлийг бүрэн хангаж ажилласан.	100%	
71	209	“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58	2. “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын 1-д заасан төслийг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай: 2.1. төслийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, төслийг хэрэгжүүлж, зохион байгуулахад хамтран ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын сайд Ч.Номин нарт;	БШУЯ нь Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “ОРОЛЦОО” төсөлд сургагч багш бэлтгэхэд хамтран ажиллаж 9 их дээд сургуулийн багш нарыг оролцуулах, сургалтын дараах Менторшип хөтөлбөрийг зохион байгуулсан. Үндсэн сургагч багшаар 9 их дээд сургуулийн багш нар, менторшип хөтөлбөрт их дээд сургуулийн 38 багш, ажилчид оролцсон. Менторшип хөтөлбөр дараах зорилтын хүрээнд хийгдэж дуусгавар болсон. 1. Менторшип хөтөлбөрийн цахим хуудасны дизайн болон техникийн тодорхойлолтыг боловсруулсан. 2. Менторшип хөтөлбөрийн цахим хуудсыг хөгжүүлж, туршилтийн үйл ажиллагааг хийж дуусгаж хүлээлгэн өгсөн. 3. Менторшип хөтөлбөрийн 89 цахим контент боловсруулан, цахим хуудсанд байршуулснаас гадна 3 хэвлүүлэх материалыг бэлтгэн хэвлүүлсэн. 5. Цахим хуудсыг интернетийн орчинд турших, хайлтын системүүдэд нийцүүлэх, цахим хуудсыг хэрхэн удирдах талаар сургалт зохион байгуулсан. 6. 16 багшийг ментор болгож, 600 орчим ментий болох хүсэлтэй залуучуудыг бүртгэн цахим хуудсыг идэвхжүүлж, хүлээлгэн өгсөн. Төслийн хэрэгжилтийн явцад ҮБХИС-ийн харьяа шар хадны хээрийн сургалтын төв, Зэвсэгт хүчний жанжин сургалтын нэгдсэн төв дээр очиж 300	100%	

				орчим оролцогчдод, Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор, Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн сургалтын төв дээр 400 орчим оролцогчдод Менторшип хөтөлбөрийн танилцуулах сургалт зохион байгуулсан. 16 их дээд сургуулийн багш нар ментороор сонгогдож, нийт 5 удаагийн менторуудад зориулсан сургалтыг зохион байгуулсан. БШУЯ-ны дээд боловсролын газар, Дээд боловсролын багшийн хөгжлийн алба, АШУҮИС, ШУТИС, МУИС, ДХИС-ийн багш, албан хаагчид нийт 38 хүмүүс энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцсон. Цахим хуудасны хаяг: www.mentorship.gov.mn		
	210		3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай.	- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.1.5- д заасны дагуу ажиллах хүчин санал болгосон тохиолдолд мөн хуулийн 10.2-т заасны дагуу ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7.5 хувиар хийсвэрээр бууруулж тооцон бусад оролцогчийн тендерийн үнэтэй харьцуулж үнэлж байна. Мөн гүйцэтгэгч компанийг орон нутгийн Хөдөлмөр, халамжийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй залуучуудыг барилгын ажилд оролцуулах шаардлагыг тавьж ажиллаж байна.	100%	
72	211	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-03-24 Дугаар 2021_70	1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай: 1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбогдуулан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах; 1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд	- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шилжин хэрэгжиж байгаа цэцэрлэгийн төсөвт өртөг 46,654.5 сая төгрөг, санхүүжих дүн 28,452.4 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. 2021 оны 3 дугаар улиралд 3 цэцэрлэгийн барилгыг байнгын ашиглалтад хүлээн авсан. 3 барилга угсралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулахаар ажиллаж байна. 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр чөлөөлсөн. Тогтоолын хүрээнд 6 сургуулийн барилга угсралтын ажлын 2,151.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлүүлэхээр аж ахуйн нэгжид мэдэгдэж 2 аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийг барилга хөгжлийн төвөөр хянуулан олгохоор ажиллаж байна. 2. 2021 онд хэрэгжүүлэх 22 төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр 17,266.3 мянган төгрөгийг шуурхай, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан баталгаажуулж санхүүжилтийг олгуулсан. 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх цэцэрлэгийн төсөл арга хэмжээний нийт 34 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц 19 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулж барилгын ажил эхлүүлээд байна. 4. Аймаг, нийслэлд баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас олгодог зөвшөөрлийг зохих журмын дагуу шуурхай олгоход дэмжлэг үзүүлж ажилласан. Шинээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний барилга эхлүүлэх зөвшөөрөл болон гэрээ сунгах ажлыг 21 аймагтай цахимаар хуралдаж тухай бүр чиглэл зөвлөгөөг өгсөн. 5. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, нийт 148 барилга 226,642.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж, орон нутгийн дансанд бүртгүүлсэн. 6. Төсөл, арга	100%	

			хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүжилтийн шуурхай, нээлттэй, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан хангах, төсвийн тухайн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой анхаарах; 1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулж, гэрээ байгуулсан байхаар тооцож ажиллах; 1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлд баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас олгодог зөвшөөрлийг зохих журмын дагуу шуурхай олгоход дэмжлэг үзүүлж ажиллах; 1.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, хөрөнгийг бүртгэж, баталгаажуулахад онцгой анхаарч ажиллах; 1.6. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжид холбогдох гэрээ, хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах.	хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, өмнө оноос хэрэгжиж зогсонги байгаа төсөл арга хэмжээ гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжид холбогдох гэрээ, хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажилласан. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа нийт хөрөнгө оруулалтаар 274 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд шилжин хэрэгжиж байгаа 210 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 691,225.7 сая төгрөг, шинээр 64 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 145,078.1 сая төгрөгөөр хэрэгжихээр батлагдсан.		
73	212	Олон улсын чуулга уулзалт зохион байгуулах тухай 2021-03-24 Дугаар 2021_73	3. Монгол Улсад орчин цагийн боловсролын болон шинжлэх ухааны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “Олон улсын боловсролын сайд нарын чуулга уулзалт”-ыг 2021 оны 10 дугаар	- Дэлхий нийтэд тархаад байгаа Ковид 19 цар тахалтай холбоотой нөхцөл байдлын улмаас тус арга хэмжээг 2022 оны 2-3 дугаар улиралд багтаан зохион байгуулахаар хойшлуулав.(Хаалгах саналтай байна)	Үнэлэх боломжгүй, хугацаа болоогүй	

			сард зохион байгуулсугай. 2. “Олон улсын боловсролын сайд нарын чуулга уулзалт”-ыг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай. 3. Энэ тогтоолын 1-д заасан чуулга уулзалтыг 2021 оны батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.			
74	213	Боловсролын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээний тухай 2021-05-05 Дугаар 2021_127	1. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, зураг төсөл, ажлын даалгавар болон шаардлагатай бусад баримт бичгийг холбогдох яамдтай хамтран боловсруулж, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Гадна нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтыг хэрэгжүүлэхээр БШУ-ны сайд, БХБ-ын сайд, БОАЖ-ын сайдын хамтарсан тушаалаар Ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг улсын хэмжээнд гадна нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байр болон сумдын инженерийн шугам сүлжээний судалгааг хийж гүйцэтгэн ариун цэврийн байгууламжийн технологийн шийдлийг судлан шийдэж нэг маягийн зураг төсөл, загвар зураг, техникийн тодорхойлолтыг боловсрууллаа. Төсөл, арга хэмжээг зохион байгуулах ЗГ-ын 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 125 дугаар тогтоол батлуулсан. ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж БШУ-ны сайдын 2021.05.21-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” А/188 дугаар тушаалаар нэгдүгээр ээлжид хэрэгжүүлэх 16 аймгийн 54 сумын 195 сургууль, цэцэрлэг, дотуур байрны төсөвт өртгийг баталсан. ЗГ-ын 2021 оны 125 дугаар тогтоол, БШУ-ны сайдын 2021 оны А/188 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог тус яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулан төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov цахим системээр худалдан авах ажиллагааг зарлаж, төлөвлөгөөний дагуу ажлыг эхлүүлж, төсөл арга хэмжээний 2021 оны 1 дүгээр ээлжийн /Архангай, Баян-Өлгий, Баян-Хонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Төв, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий, Увс, Ховд, Хөвсгөл аймгуудын 54 суманд 12 багц төсөл арга хэмжээний шалгарсан аж, ахуй нэгжүүдтэй барилга, угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ариун цэврийн байгууламжийн угсралтын ажлыг эхлүүлсэн. - Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих төсөл арга хэмжээ /Архангай, Батцэнгэл, Өндөр-Улаан, Чулуут, Хашаат, Хотонт сум/ болон /Завхан, Түдэвтэй, Цагаанхайрхан, Дөрвөлжин сум/-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулаад байна. Мөн/ Сүхбаатар, Баяндэлгэр, Түвшин-ширээ сум,-ын Хэнтий, Баянхутаг, Дэлгэрхаан сум/-ний тендерийг дахин зарлахаар ажиллаж байна.- Ариун цэврийн байгууламжийн 2 дугаар ээлжийн 49 суманд	70%	

			хэрэгжих 16 багц төсөл: үүнээс Архангай, Баян-Өлгий, Булган, Сэлэнгэ, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Төв, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, , Увс, Ховд, төсөл арга хэмжээний гэрээ байгуулагдсан. Хөвсгөл, Хэнтий, Баян-Хонгор, арга хэмжээний тендер зарлагдаж, сонгон шалгаруулалт хийгдэж байна. 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэлийн мэдээллийг нэгтгэн 2021 онд багтаан санхүүжүүлэх санхүүжилтийн судалгааг гаргаж Эрдэнэт ТӨҮГ-т 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлэн ажилласан.		
214		3. Сонгон шалгарсан гүйцэтгэгчтэй холбогдох гэрээг байгуулан, гүйцэтгэлд нь захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар (Х.Бадамсүрэн) нарт, захиалагчийн хяналт тавихад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт тус тус даалгасугай.	- Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл, арга хэмжээний 2021 оны 1 дүгээр ээлжийн 12 багц төсөл, арга хэмжээний тендерт шалгарсан дараах аж ахуй нэгжүүдтэй Мурап ХХК, Модернхас ХХК, Бэсүб ХХК, Динатос ХХК, Ажнай шарга ХХК, Винтергарден ХХК, Жавхлантур ХХК, Номунзаяа ХХК, Нью-Эрхэм ХХК, В Софт ХХК, Грэйт майнинг ХХК, Тэмээн ХХК-тай барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. - Ариун цэврийн байгууламжийн угсралтын ажилд хяналт тавих ажлыг Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв гэрээгээр гүйцэтгэнэ. Боловсрол, шинжлэх ухааны яамны удирдлагууд орон нутагт ажиллахдаа уг төсөл арга хэмжээний гүйцэтгэлтэй газар дээр нь танилцан, хяналт тавьж ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны яам болон ажлын дэд хэсгээс аймгийн Засаг дарга нарт болон барилга угсралтын гүйцэтгэгч компаниудад 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр 2/5800, 2/5801 албан тоотоор зураг төслийг яаралтай хийлгэж, магадлалаар хянуулах, ажлыг эрчимжүүлэх мэдэгдэл хүргүүлсэн. Мөн зураг төсөл боловсруулж буй аж ахуйн нэгжүүд нь тухайн орон нутгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газарт зураг төслийг баталгаажуулах явцыг хугацаа алдалгүй зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах чиглэлийг 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 1а/6135 албан тоотыг МХЕГ болон ОБЕГ хүргүүлж, ажлын уялдааг хангах, тулгамдаж буй асуудлаг шийдвэрлэх чиглэлээр холбогдох яамд, төрийн байгууллагууд, гүйцэтгэгч компаниудын хооронд зөвлөлдөх, чиглэл өгөх уулзалт, хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулж хамтарч ажилласнаар дараах үр дүнгүүд гарч байна. Үүнд: -Нэгдүгээр ээлжийн барилга угсралтын ажлын явц 47 %, зураг төслийн ажлын явц 61.1 %, санхүүжилт 13.1% бөгөөд нийт 3.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээлгэхээр Сангийн яаманд хүргүүлсэн. - Хоёрдугаар ээлжийн барилга угсралтын ажлыг түр зогсоож, геологи болон байгаль орчны дүгнэлт гаргуулж, холболтын зураг, төсөл батлуулах ажлыг эхлүүлсэн. - Хоёрдугаар ээлжийн барилга угсралтын ажлын явц 17%, зураг төслийн ажлын явц 15,6 %, одоогоор санхүүжилтийн хүсэлт ирээгүй байна. (1, 2-р ээлжийн ажлын явц 2022.01.15-ны өдрийн байдлаар)	70%	

				БШУЯ, БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нар болон 3 яамны хамтарсан Ажлын дэд хэсэг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хуралдаж, АЦБ-ийн төслийн хэрэгжилтийн явц болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэн, 2022 оны төлөвлөгөөг баталлаа. Цаашид барилга угсралтын ажлыг эхлэхээс өмнө дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд: 1. Нэг, хоёрдугаар ээлжийн сонгогдсон байршлуудын ажлын явцтай газар дээр нь танилцан /Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, орон нутгийн удирдлагуудыг байлцуулах/ гүйцэтгэсэн ажил норм стандартын дагуу хийгдсэн эсэхэд захиалагчийн техник хяналтыг хийх. Ингэснээр бодит байдлыг үнэлэн ажлыг цаашид хэрхэн үргэлжлүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, ажлыг чанартай хийж гүйцэтгүүлэх. 2. Орон нутаг дахь нөхцөл байдлын судалгааг чанартай гүйцэтгэж, зургийн ажлын даалгаврыг боловсруулж, зураг төсөл зохиогчийг сонгон шалгаруулан зургийг магадлалаар оруулж батлуулсны дараа 3, 4 дүгээр ээлжийн ажлын худалдан авах ажиллагааг зарлах. 3. Батлагдсан зураг төслийн дагуу барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах. 4. Зураг, төсөв магадлалаар баталгаажсаны дараа төсөвт өртөгт зохицуулалт, өөрчлөлтийг хийх. Ингэснээр 2022-2023 оны хичээлийн жилд судалгаанд хамрагдсан сургууль, цэцэрлэг, дотуур байранд орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болох нөхцөл бүрдэх юм.		
75	215	Боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021-05-12 Дугаар 2021_141	1. Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ариутгал халдваргүйжүүлэлт, халдвар, хамгааллын горим, дэглэмийг чанд баримтлан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай: 1.1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд 2021 оны 5 дугаар сарын	- Улсын Онцгой комиссын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 17 дугаар хуралдаанаас өгсөн чиглэл, багш, эцэг эх, асран хамгаалагчдаас авсан судалгааны үр дүнд үндэслэн “Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/165 дугаар тушаалын төслийг боловсруулж, батлууллаа. Уг тушаалаар (i) цэцэрлэг, сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг ангиас хамаарч 2021 оны 5 дугаар сарын 7 (I-III анги), 5 дугаар сарын 14-ний өдөр (бусад анги)-өөр тус тус дуусгавар болгох, (ii) анги дэвших болон улсын шалгалтыг цуцалж, суралцагчийг анги дэвшүүлэх, төгсгөх, (iii) жилийн эцсийн үнэлгээ гаргахад суралцагч зайнаас суралцсан байдлыг харгалзан сурах үйлийг дэмжиж уян хатан хандах бөгөөд жилийн эцсийн үнэлгээ тооцох аргачлал боловсруулж хүргүүлэх, (iv) суралцагчдын зайнаас суралцсан хугацааны сургалтын агуулгыг бататгах, сурлагын хоцрогдлыг нөхөх чиглэлээр 2021-2022 оны хичээлийн жилд авч хэрэгжүүлэх үйл	100%	Хяналтаас хасах

			17-ны өдрөөс эхлэн нэг сарын хугацаанд зохион байгуулах арга хэмжээ авах; 1.2. Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг төгсөгч, 2021-2022 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэл бичгийн хичээлээр шалгалт авахгүй байх зохицуулалт хийх.	ажиллагааг тодорхойлох, багшид мэргэжил арга зүйн дэмжлэг зэрэг асуудлыг тус тус зохицууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд зохион байгуулах, их, дээд сургуульд элсэгчдээс авах монгол хэлбичгийн шалгалтыг энэ онд цуцлах эсэх асуудлыг Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, улмаар Засгийн газрын 2021 оны 141 дүгээр тогтоол гарсан.		
76	216	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-06-16 Дугаар 2021_164	2. Орон нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн салбар төвийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах ажлыг хамтран зохион байгуулж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, салбарын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг энэ тогтоолын 1-д заасан аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Орон нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн салбар төвийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр “Нийгмийн сэргээн засалтын цогц арга зүй Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг 2021 оны 11 дүгээр сард ХНХЯ-тай хамтран зохион байгуулсан. Дээрх 5 өдрийн сургалтаар 6 аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-д ажиллах багш, мэргэжилтнүүд нийгмийн загварт суурьтай хөгжлийн дэмжлэг үзүүлэх арга зүйн мэдлэг, ойлголттой болсон. Хөгжлийн төвд ажиллах тусгай хэрэгцээт боловсролын багшийг МУБИС-ийн тусгай хэрэгцээт боловсролын тэнхимд бэлтгэж 2019-2021 онд 44 мэргэжилтэн төгссөн байна. Мөн 2022 оны 4 дүгээр сард хэл засалч бэлтгэх сертификаттай сургалтыг явуулахаар сургалтын төлөвлөгөө болон удирдамжийг гаргаад байна. “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг үнэлэхэд баримтлах чиглэл”-ийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Чиглэл батлах тухай” А/325 дугаар тушаалаар баталсан. Энэ чиглэл батлагдсанаар ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй 6208 суралцагчийн ахиц, амжилтыг үнэлэх боломжтой болсон. “Харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа олгох сургалтын жишиг хөтөлбөр”, “Харааны бэрхшээлтэй хүүхдэд хөдөлгөөн орон зайн баримжаа олгох хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийг тус тус боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Сургалтын хөтөлбөр батлах тухай” А/309 дүгээр тушаалаар баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр багш нарын мэдлэг ойлголт, арга зүйг дээшлүүлэх чиглэлээр дараах сургалтыг зохион байгуулсан. -“Жайка” Олон улсын байгууллагатай хамтран “Тэгш хамран сургах боловсролын багшийн арга зүй” сэдэвт сургалт (9 дүгээр сард хамрагдсан 180 багш, ажилтан) - “Койка” Олон улсын байгууллагатай хамтран “Тэгш хамран сургах боловсрол-сургалтын орчин ” сэдэвт сургалт (10 дугаар сард хамрагдсан 186 багш) Дээрх сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллах арга зүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүн бэлтгэх талаар мэдлэг ойлголт өгсөн.	100%	

77	217	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2021-06-16 Дугаар 2021_168	2. “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 9 дүгээр тогтоолын 4 дэх заалтын “- Боловсрол, соёл, урлагийн газар” гэснийг “-Боловсролын газар; - Соёлын хэлтэс” гэж өөрчилсүгэй. 2. Энэ тогтоолын 1-д заасан Соёлын хэлтсийг байгуулахдаа Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд одоо ажиллаж байгаа “Боловсрол, соёл, урлагийн газар”-аас холбогдох чиг үүрэг, орон тоог цалингийн сан, түүнд ногдох үйл ажиллагааны зардлын хамт шилжүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, орон нутгийн төсөвтөө зохицуулалт хийж, тус хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	- Боловсрол, соёл урлагийн газарт соёлын чиглэлээр ажиллаж байгаа орон тоо, цалингийн тооцооллыг хийж Соёлын яаманд хүргүүлж хамтарч ажилласан, мөн тогтоолтой холбогдуулан Боловсролын газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллаж байна.	100%	
78	218	Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-06-23 Дугаар 2021_173	3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэгийг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, санхүүгийн зохих дэмжлэгийг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын гишүүд болон боловсролын асуудал хариуцсан гишүүнийг чадавхжуулах дараах сургалтыг зохион байгуулсан. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш болон салбар комиссын гишүүд, боловсролын газрын мэргэжилтнийг хамруулсан арга зүйн сургалтаар ICF улсын ангиллаар ХБХ-ийг үнэлэх, үнэлгээнд үндэслэн ганцаарчлан ажиллах төлөвлөгөө боловсруулах талаар мэдлэг ойлголт олгосон./ 2021 оны 5 дугаар сар 180 хүн/ -Жайка олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” -ийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх агуулга бүхий цахим сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймаг, дүүрэг, нийслэлийн Боловсролын газрын тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтэн болон Эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийн оролцоотой нийт 210 хүн хамрагдлаа. /2021 оны 11 дүгээр сар/	100%	
79	219	Ургац хураалтын	1. Ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд дуусгах,	- Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлын дэгдэлтийн улмаас онцгой дэглэм мөрдөж байгаа энэ үед хүнсний	100%	

		талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-08-11 Дугаар 2021_235	цар тахлын үед хүнсний хангамж, нөөц бүрдүүлэх зорилгоор ургац хураалтын ажилд их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан, сонсгогч, цэргийн алба хаагчид болон ажлын байр хайж байгаа иргэдийг оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, ариутгал халдваргүйжүүлэлт, халдвар хамгааллын горим, дэглэмийг чанд мөрдүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын сайд Ч.Номин, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, холбогдох аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	хангамжийн тогтвортой байдлыг хангах, ургац хураалтын ажлын технологийн хугацаанд гүйцэтгэх зорилгоор “Ургац хураалтын ажлыг зохион байгуулахтай холбоотой зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан хүргүүлсэн. Ургац хураалтын ажилд ХААИС, МУБИС, ДХИС зэрэг их, дээд сургуулийн 3000 гаруй оюутан оролцсон бөгөөд газар тариалангийн бүс болох Төв, Хэнтий зэрэг 7 аймгийн 50-аад аж ахуйн нэгж дээр ургац хураалтад ажиллав. энэ талаар БШУ-ны сайд ЗГ-ын хуралдаанд мэдээлсэн.		
80	220	Үдийн хоолны норматив тогтоох тухай 2021-08-11 Дугаар 2021_237	2. Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1800 (нэг мянга найман зуун) төгрөг байхаар тогтоож, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг 2022 оны улсын төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.	- Засгийн газрын 237 дугаар тогтоолоор 6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1800 төгрөгөөр тогтоосны дагуу 2022 оны төсвийн төсөлд дунд ангийн үдийн хоол хөтөлбөрт нийт 121.0 тэрбум төгрөгийн зардлын тооцооллыг хийж, Сангийн яаманд хүргүүлсэн. 2022 оны Төсвийн тухай хууль 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлагдахад 6-9 ангийн сурагчдын үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацааг хойшлуулан 2023 оноос хэрэгжүүлж эхлэхээр хуульчилсан тул зөвхөн бага ангийн сурагчдын үдийн хоолны зардалд 80.5 тэрбум төгрөг батлагдаад байна	100%	
	221		3. Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавих, удирдлага, арга зүйгээр хангуулах зайлшгүй шаардлагыг харгалзан Аймаг, нийслэлийн Боловсролын газар, нийслэлийн дүүргийн Боловсролын хэлтэст хоол зүйчийн орон тоо шинээр бий болгох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-	- Хариуцах ерөнхий боловсролын сургуулийн тооноос хамааруулж Хүүхдийн хоол хүнс, орчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний орон тоог Аймгийн Боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэст нэгээр, Нийслэлийн боловсролын газарт хоёроор нэмэгдүүлж, 2022 оны улсын төсөвт цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 512.9 сая төгрөгийг тусган батлуулсан.	100%	

			Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.			
81	222	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021-09-29 Дугаар 2021_299	1. Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.	БШУ-ны сайдын 2021 оны “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” А/366 дугаар тушаалыг батлуулж, ШУТҮЗ-ийг хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Мэргэжлийн гэрээт шинжээчдийг хуульд заасны дагуу авч ажиллуулах, цалинг шинжлэх ухааны салбарын сүлжээгээр цалинжуулж ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, зохицуулалтыг хангасан.	100%	
	223		2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.	- “Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын төсөл боловсруулсан.	70%	
	224		4. Дундын ашиглалттай болон сүлжээ лабораториудын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэхэд шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодис, туршилтад зориулсан бусад бараа, материал худалдан авах ажиллагааг хөнгөвчлөх асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.	- Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагаа зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор “Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн итгэмжлэлийн техникийн шаардлага болон судалгааны нээлттэй, дундын болон сүлжээ лабораторийн стандарт, эрх зүйн зөвлөх үйлчилгээ” сэдэвт судалгааны ажил гүйцэтгэсэн. Судалгаагаар Монгол улсын эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, хувийн болон үндэсний хүрээлэн төвүүдийн дэргэд судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 54 байгууллагын сургалт, судалгаа, шинжилгээ, хяналтын 311 лаборатори байна. Үүнээс олон улсад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн 24 лаборатори байна. Дундын ашиглалттай болон сүлжээ лабораториудын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Дундын ашиглалтын нээлттэй лабораторийн журам”-ын төслийг боловсруулсан.	70%	
	225		5. Шинжлэх ухааны Академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшиж байгаа 18 га газрыг зориулалтын дагуу ашиглуулах зорилгоор улсын тусгай хэрэгцээнд авах эсэх асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх	- Шинжлэх ухааны Академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшиж байгаа 18 га газрыг зориулалтын дагуу ашиглуулах зорилгоор улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг судалж, тусгай хэрэгцээнд авахтай холбоотой материал бүрдүүлбэрийг хангах чиглэлийг Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захиралд өгч бүрдүүлбэрийг хангаж байна. Шинжлэх ухааны Академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшлийн 18 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авлаа. Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь Монгол Улсад байгаа судалгааны зориулалт бүхий хамгийн том ногоон байгууламж бөгөөд манай орны нэн ховор ургамлыг	100%	Хяналтаас хасах

			ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.	тарималжуулах, үрийн фонд бий болгох, хадгалах, хамгаалах, гадаад орны зарим ургамлыг нутагшуулах чиглэлээр эрдэм шинжилгээ, сургалт, танин мэдэхүйн цогц үйл ажиллагаа явуулдаг цорын ганц байгууллага юм. Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшлийн 18 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авснаар газрыг зориулалтын дагуу ашиглаж, Монгол Улсын улаан ном, нэн ховор ургамлын лавлах, улаан дансанд бүртгэгдсэн эмийн, ашигт, хүнс, тэжээл, техникийн, гоёл чимэглэлийн ач холбогдол бүхий ургамлыг амьд хэлбэрээр хадгалж хамгаалах, тэдгээрийг тарималжуулах боломжийг судлах, урьд өмнө хийгдсэн судалгааны ажлын үр дүнг баталгаажуулах үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх чухал ач холбогдолтой.		
	226		6. Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагаанд үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, шаардагдах эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах асуудлыг судлан шийдвэрлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.	- Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагаанд тогтмол болон өрсөлдөөнт санхүүжилтийн зарчимд шилжүүлэх асуудлыг судалж, танилцууллаа. Сангийн яаманд салбарын санхүүжилтийн шинэчлэлийг хийхэд шаардлагатай эрхзүйн зохицуулалт, авах арга хэмжээний саналыг танилцуулах үндэслэл бүхий мэдээлэл, материалыг бэлтгэн судалсан.	70%	
82	227	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай 2021-10-13 Дугаар 2021_314	2. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор энэ тогтоолын хавсралтад заасан Засгийн газрын тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай. 2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан салбар, орон нутгийн түвшинд батлан хэрэгжүүлж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлэх арга хэмжээг 2021 оны 12 дугаар сард багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Боловсролын салбарт хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгийн арга хэмжээний жагсаалтыг нэгтгэн Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/13 дугаар бүхий тушаалын хавсралтаар Боловсрол, шинжлэх ухааны салбарын урт, дунд, богино, хугацааны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг гаргаж, холбогдох нэгж болон байгууллагад хүргүүлэх хугацааны хуваарь, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах аргачлалыг боловсруулж батлуулсан. Боловсролын салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн давхардал уялдаанд дүн шинжилгээ хийсэн. Мөн МУБИС дээр байгуулагдсан “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын тулгамдсан асуудал”-ын ажлын хэсэгт ажиллаж, судалгааны хүрээнд төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд шинжилгээ хийж, тайланг Боловсрол, шинжлэх ухааны сайдад танилцуулсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан хүчингүй болсон бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хуваарийн дагуу холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.	100%	
83	228	Аж ахуйн нэгжийн	3. Аж ахуйн нэгжийн улсын тооллогод өөрийн аймаг,	Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллогод дэмжлэг үзүүлэн ажиллах ажлын хүрээнд Боловсрол,	100%	хяналтаас хасах

		тооллого явуулах тухай 2021-10-13 Дугаар 2021_315	нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тооллогын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.	шинжлэх ухааны сайдаас яам болон тус яамны харьяа байгууллагуудын удирдлагуудад тооллогодоо хуулийн хугацаанд нь идэвхтэй оролцох үүрэг, чиглэлийг өгч ажилласан.		
84	229	Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авч зарим арга хэмжээний тухай 2021-10-20 Дугаар 2021_321	1. Орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай: 1.1. Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр төрөлжүүлэх; 1.2. Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургуулийг шинээр байгуулах; 1.3. Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг уул уурхай, технологийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх.	- БШУ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/391 тоот тушаалаар орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр төрөлжүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургуулийг шинээр байгуулах ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг уул уурхай, технологийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсан. Дээрх ажлын хэсгүүд үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан 2022 оны эхний улиралд багтаан батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.	100%	
	230		2. Орон нутаг дахь төрийн өмчит их, дээд сургуульд суралцах оюутнуудад сургалтын төлбөрийн	БШУ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/391 дүгээр тушаалаар орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх	70%	

		50 хувийн хөнгөлөлт үзүүлэх, зээл олгох асуудлыг холбогдох журамд тусгаж, шаардагдах эх үүсвэрийг тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэж байхыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.	ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусган судалгаа хийж байна. Судалгаагаар: - 2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчит их, дээд 14 сургууль 9 аймагт 230 хөтөлбөрөөр /дипломын, бакалавр, магистр, доктор/ сургалтын үйл ажиллагаа явуулж байна. 2022-2023 оны хичээлийн жилээс 11 сургууль үйл ажиллагаа явуулна. - Орон нутгийн төрийн өмчит их, дээд сургуульд 9690 суралцагч одоогоор суралцаж байна. /Диплом хөтөлбөрөөр 1513 суралцагч, бакалавр 6896 оюутан, магистр 1638 суралцагч, доктор 37 суралцагч/ - Суралцагчийн тоог тооцохдоо шинэ элсэлтийг өмнөх оноос 20% нэмэгдүүлж тооцсон. - 2022-2023 оны хичээлийн жилд 9,922 суралцагчид 10,863.3 сая төгрөг, 2023-2024 хичээлийн жилд 10,107 суралцагч 11,070.2 сая төгрөг, 2024-2025 хичээлийн жилд 10,298 суралцагчид 11,283.5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэхээр байна.		
231		3. Орон нутаг дахь төрийн өмчит их, дээд сургуульд ажиллаж байгаа багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан бол зохих тэтгэмж олгох, хөнгөлөлттэй зээлд хамруулдаг байх зохицуулалт бий болгох асуудлыг судлан, эрх зүйн орчныг бүрдүүлэх, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	- БШУ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/391 дүгээр тушаалаар орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг “Сургалт - эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусган судалгаа хийж байна. Судалгаагаар 2021 онд орон нутгийн төрийн өмчийн их, дээд сургуульд суралцаж байгаа суралцагчийн тоо болон ирэх онуудын суралцагчийн тооны өсөлтийг тооцож 2022-2023 оны хичээлийн жилд 327 багш, 2023-2024 оны хичээлийн жилд 384 багш, 2023-2024 оны хичээлийн жилд 415 багш ажиллана гэж тооцоход жилд дунджаар 12.5 төгрөгийн цалингийн зардал гарах тооцоо хийсэн.	70%	
232		4. “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг орон нутагт хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгах, тухайн орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны	- Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг хэрэгжүүлэхээр дараах ажлуудыг хийсэн. Үүнд: • Орон нутаг дахь Их дээд сургуулиудын одоогийн нөхцөл байдалтай биеэр танилцахаар БШУ-ны дэд сайд Г.Ганбаяраар ахлуулсан ажлын хэсэг Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ, Өмнөговь, Архангай, Завхан, Ховд, Баян-Өлгий аймгууд дахь Их, дээд сургууль, коллежид ажиллав. • БШУ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/391 дүгээр тушаалаар Орон нутаг дахь их сургуулиудыг Сургалт-эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор болгон хөгжүүлэх ажлыг	100%	

		техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, газар олголт, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	удирдах болон зохион байгуулах зорилго бүхий ажлын хэсгүүдийг байгуулав. - Боловсрол, Шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Төрийн өмчийн 6 их сургуулийн захирлууд, Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны дарга Ю.Энхбат нартай уулзалт хийн, орон нутаг дахь их сургуулиудыг цогцолбороор хөгжүүлэх, Улаанбаатар хот дахь төв сургуулиудын нэгдсэн цогцолбор барих асуудлаар уулзалт хийн ажлын чиглэл өгсөн. Тус уулзалтаар Дархан, Эрдэнэт, Өмнөговь, Хөшигтийн хөндийд бий болох цогцолборуудын төлөвлөлт болон ерөнхий төлөвлөгөөний зургууд, хийгдэх ажлын жагсаалтуудыг гаргахыг үүрэг болгосон. - Хөшигтийн хөндийд Их, дээд сургуулиудын нэгдсэн цогцолбор барих зорилгоор БШУ-ны дэд сайд Г.Ганбаяраар ахлуулсан ажлын алба, Хөшигтийн хөндийд чөлөөт бүс байгуулах ажлын албатай хамтран Хөшигтийн хөндийн газар дээр ажиллав. 2021 оны 12 сарын 01-ний өдөр А/391 дүгээр тушаалаар байгуулагдсан Удирдах ажлын хэсгийн анхны уулзалтыг хийв. уулзалтаар Дархан-уул аймаг, Өмнөговь аймаг, Орхон аймаг тус бүрд байгуулах их сургуулийн хотхоны газарт төлөвлөлт, хийгдэх ажлын төлөвлөгөө гаргах, дэд бүтэц, эрчим хүч, барилгын тооцооллыг нарийвчлан гаргаж танилцуулахаар болсон. - Төрийн өмчийн их сургуулиудтай хамтран аймаг тус бүрд байгуулагдах их сургуулийн урьдчилсан ерөнхий төлөвлөгөөний загвар, хийгдэх ажлын төлөвлөгөө нарийвчилсан төлөвлөгөө, урьдчилсан эдийн засгийн тооцооллыг хийж гүйцэтгэн 12 сарын 22-ны өдөр сайдад танилцуулав.		
233	5. Энэ тогтоолын 1.1-д заасан төрийн өмчийн их, дээд сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвийн төсөлд тусгахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, 1.2-т заасан Шинжлэх ухаан, технологийн сургуулийн харьяа сургууль байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв болон тухайн орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх арга хэмжээ	- БШУ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/391 дүгээр тушаалаар орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусган судалгаа хийж байна. Уг тогтоол 2022 төсвийн төслийн цагалбараас хойш батлагдсан тул 2022 оны төсөвт уг зардал тусгагдаагүй.	30%		

			авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт, 1.3-т заасан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Монгол Улсын Их сургуулийн бүрэлдэхүүн “Эрдэнэт” сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болон нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх зохих арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга С.Батжаргал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Х.Бадамсүрэн) нарт тус тус даалгасугай.			
85	234	Жагсаалт батлах тухай 2021-12-01 Дугаар 2021_359	2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг техникийн хяналтын зардлын тооцооны хамт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 359 дүгээр тогтоолыг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2021 оны 12 дугаар 06-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө батлах тухай” А/422 дугаар, 2021 оны 12 дугаар 08-ны өдрийн Эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай” А/430 дугаар тушаалаар тус тус батлуулж худалдан авах ажиллагааны эрхийг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр шилжүүлсэн.	100%	

	235		4. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай.	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 359 дүгээр тогтоолыг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2021 оны 12 дугаар 06-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө батлах тухай” А/422 тоот, 2021 оны 12 дугаар 08-ны өдрийн Эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай” А/430 тоот тушаалаар тус тус батлуулсан. Уг тушаалуудыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, Төрийн худалдан авах ажиллагааны газарт БШУ-ны сайдын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn-д 2022 онд шинээр батлагдсан 173 төсөл арга хэмжээг шивж оруулан, Сангийн яамаар баталгаажуулж, сайдын тушаалаар эрх шилжүүлсэн байгууллагуудад цахим системээр эрх шилжүүлсэн. Өнөөдрийн байдлаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт эрх шилжүүлсэн 71 төсөл, арга хэмжээний 31 төсөл арга хэмжээний Үнэлгээний хороо байгуулагдан зарлах ажлыг зохион байгуулж ажилласан байна.	100%	
86	236	Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг батлах тухай 2021-12-08 Дугаар 2021_372	2. Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 407 дугаар тогтоолоор Боловсролын хүрээлэнгийн бүтэц, дүрмийг батлахыг Боловсрол, шинжлэх ухааны сайдад даалгасны дагуу тус хүрээлэнгийн бүтцийг өөрчиллөө. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Боловсролын хүрээлэнг өөрчлөн байгуулах, дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” 2022 оны А/10 дугаар тушаалаар Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн бүтцэд Гадаад хэлний төв байгууллаа. Гадаад хэлний төв нь бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. Мөн 2022 оны улсын төсөвт бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээний зардлыг тусган баталлаа.	100%	
87	237	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-12-14 Дугаар 2021_397	1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. 1.1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн өмнөх онд хийсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн	Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолын дагуу Боловсрол, шинжлэх ухааны салбарт 178 төсөл арга хэмжээний 80.0 тэрбум төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд авч үлдсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж Боловсрол, шинжлэх ухааны яамтай гэрээ байгуулсан 105 төсөл, арга хэмжээний 48.3 тэрбум төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд үлдсэн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургуулийн 25 төсөл, арга хэмжээний 12.7 тэрбум төгрөг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 36 төсөл, арга хэмжээний 21.8 тэрбум төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны 8 төсөл, арга хэмжээний 3.2 тэрбум төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны 3 төсөл, арга хэмжээний 1.0 тэрбум төгрөг, их засварын 5 төсөл, арга хэмжээний 0.6 тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн 24 төсөл, арга хэмжээний 7.3 тэрбум төгрөг, шинжлэх ухааны салбарын барилгын 1 төсөл, арга	100%	

			багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж санхүүжүүлэх; 1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах; 1.3. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	хэмжээний 0.2 тэрбум төгрөг, боловсролын салбарын 3 төсөл, арга хэмжээний 1.5 тэрбум төгрөг. Мөн 73 төсөл, арга хэмжээний 31.7 тэрбум төгрөг нь орон нутагт эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ байна.		
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл						
88	238	2019 оны 8 дугаар сарын 7-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2019-08-07 Дугаар 2019_34	ХИҮ.3. 3.. Улсын төсвийн хөрөнгөөр урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах төсөл, арга хэмжээний жагсаалтад Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёл, урлагийн салбарын томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг тусган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт;	- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан урьдчилан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах төсөл, арга хэмжээг зохион байгуулаагүй бөгөөд Засгийн газрын хуралдаанаар танилцуулж шийдвэрлүүлсэн асуудал байхгүй болно.	100%	Хяналтаас хасах
89	239	2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр 40 дүгээр тэмдэглэл	ХҮҮ.8. . Хүлэмжид хүнсний ногоо тариалах шинэ стандартын технологийг нэвтрүүлэх, ногоочдыг сургаж дадлагажуулах замаар хүнсний нарийн ногооны	- ХХААХҮ-н сайд З.Мэндсайхан УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хөдөө аж ахуйн салбарт хамаарах эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг салбарын сайдын харьяанд шилжүүлэх талаарх мэдээлэл хийсэн. Мэдээлэлтэй холбогдуулан Байнгын хорооноос Мал аж ахуйн эрдэм	70%	

		2019-09-18 Дугаар 2019_40	хангамжийг сайжруулах “Хүнсний ногооны хүлэмжийн жишиг парк, сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулах” инновацийн төслийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан тус инновацийн төслийг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн их сургуулийн дэргэд төрийн өмч давамгайлсан гарааны компани байгуулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих талаар зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, төслийн хүрээнд хүлэмжийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх газрын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус даалгав.	шинжилгээний хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяалалд байгааг өөрчилж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяанд шилжүүлэх асуудлыг судалж, танилцуулах талаар Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгож “Чиглэл өгөх тухай” тогтоолын төслийг дараагийн хуралдаанаар хэлэлцэн батлахаар боллоо.		
90	240	2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2020-04-01 Дугаар 2020_22	ХҮИХ.2. . 2. Дараахь арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллах; 2.2. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах; 2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 362 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх Засгийн газрын “Жагсаалт батлах тухай” 2020 оны 21 тоот тогтоол батлагдсан. Тус тогтоол дараах арга хэмжээг зохион байгуулахаар тусгасан байна Үүнд: Орон нутагт 219 төсөл арга хэмжээ, Нийслэлийн ЗДТГ-т 37 төсөл арга хэмжээ, ТХААГ-т 93 /97/ төсөл арга хэмжээ /2019 онд зарлагдаагүй 4 төсөл/, БСШУС-ын яаманд 13 төсөл арга хэмжээ зэрэг болно. Тус тогтоол гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Шийдвэр хэрэгжүүлэх тухай” 2020 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 1А/734 тоот тушаалаар эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний жагсаалтыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлэн ажилласан байна. Үүнтэй холбогдуулан 2020 онд 297 төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны урилга, үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлж ил тод байдлыг ханган ажиллаж байна. - Төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах, хуулийн хугацаанд гүйцэтгэлийн баталгааг гаргуулах, гэрээ байгуулах зэргээр ажиллаж байна. 2020 онд 184 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй хуулийн	100%	Хяналтаас хасах

			гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх; 2.4. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах.	хугацаанд гэрээ байгуулсан ба гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгж байхгүй болно. - Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах Тендерийн бичиг баримтад бараа, ажил үйлчилгээнээс хамаарч дотоодын давуу эрх тооцох, техникийн тодорхойлолтын гаргах тухай салбарын мэргэжилтнүүд оролцсон ажлын хэсэг байгуулагдан боловсруулж ажиллаж үнэлгээний хороонд хүргүүлж ажилласан.		
91	241	2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 26 дүгээр тэмдэглэл 2020-04-22 Дугаар 2020_26	ҮИЛ. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгох; 2. Дулааны тоолуур худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийг төсөвт байгууллагын зарлагын хэмнэлт, давсан орлогоос холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэхийг Төсвийн захирагч нарт зөвшөөрөх;	- Байгууллага бүр тоолуур худалдан авахад тендер зарлах тул энэ асуудлыг хялбаршуулах үүднээс Сангийн яамтай зөвшилцөн үнэлгээний хороо байгуулсан байна. 2020 оны 11 дүгээр сард ерөнхий гэрээ байгуулах 5 компани байгуулагдаж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулаад байна. 21 аймгийн хэмжээнд тоолууртай байгууллага байхгүй гэсэн үзүүлэлт судалгаагаар гарсан. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчилсан. Тус хуулийн дагуу Орон нутаг дахь нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал, засвар үйлчилгээг орон нутаг хариуцахаар 2022 оны орон нутгийн төсөвт тусгагдсан.	100%	Тогтоол, шийдвэрийн биелэлтээс хасуулах
92	242	2020 оны 9 дүгээр сарын 16-ний өдөр 50 дүгээр тэмдэглэл	XI.1. . Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Архангай, Булган, Өвөрхангай аймгуудад ажилласан дүнгийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх	- Архангай, Өвөрхангай, Булган аймгуудын нутагт буй түүх, соёлын голлох 16 дурсгалт газрын танилцуулга, судалгааны үр дүн болон энэ бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх боломж, маршрут зэргийг тусгасан “Монгол төрийн голомт нутаг” А4 форматаар 278 тал бүхий хамтын бүтээлийг ШУА-	100%	Чиг үүрэгт хамаарахгүй тул Хяналтаас хасах

		2020-09-16 Дугаар 2020_50	газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: 1. Түүх, соёл, археологийн олдворуудад тулгуурласан бүс нутгийн аялал, жуулчлалын цогцолбор байгуулах стратегийг боловсруулж, төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Соёлын сайд С.Чулуун, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн нарт;	ийн Археологийн хүрээлэнгээс бэлтгэж, УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат зардлын асуудлыг шийдвэрлэж хэвлүүлсэн. 2021 оны 9-р сарын 23-нд "Орхон-Тамир, Хануй-Хүнүй голын сав нутаг дахь түүх соёлын дурсгалд түшиглэсэн аялал жуулчлалын цогцолбор" байгуулах ажлын эхлэл болгож "Луут хот" хэмээн таамаглаж буй Архангай аймгийн Өлзийт сумын нутагт орших Харганын дөрвөлжингийн дурсгалт газарт "Мэдээллийн төв" байгуулах шав тавих ёслолыг хийсэн. Энэхүү ажлыг Соёлын яам, БШУЯ болон УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат, Ё.Баатарбилэг, Г.Тэмүүлэн нар, мөн ШУА-ийн Археологийн хүрээлэн хамтран зохион байгуулсан. Харганын дөрвөлжингийн дурсгалт газарт хамгаалалтын хашаа барих ажлыг Соёлын яам зохион байгуулан гүйцэтгэсэн байна.		
	243		XI.1. 2. Түүх, соёл, археологийн үнэт олдворын хадгалалт, хамгаалалтад онцгой анхаарал тавьж, стандарт технологийн шаардлага хангасан сан хөмрөгийн агуулах байгуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Соёлын сайд С.Чулуун, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн нарт;	- Соёлын яам болон ЗГХА Соёл урлагийн газрын санхүүгийн дэмжлэгээр ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн археологийн олдворын сан хөмрөг болох эртний хүн, малын ясны хэрэглэгдэхүүн, булш оршуулгын олдворууд, хот суурины дурсгалаас илэрсэн олдвор, хэрэглэгдэхүүн зэрэг 100,000 орчим олдвор эд өлгийн зүйлсийг Соёлын өвийн Үндэсний төвийн Буянт-Ухаа дахь шинэ байранд шилжүүлэн байршуулсан. Энд нийт 4 сан хөмрөгийг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулснаар Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж байсан олдворуудын хадгалалтын нөхцөл сайжирсан байна.	100%	
	244		XI.1. 4. Монгол улс дахь түүх, соёл, археологийн судалгааны байгууллагуудын археологи, түүх, угсаатны зүй, антропологи, палеозоологи, сэргээн засварлалт зэрэг чиглэлээр мэргэшсэн судлаачдаар үндэсний цогц судалгааны баг бүрдүүлэн хайгуул, малтлага, судалгаа, шинжилгээ, сэргээн засварлах ажлыг зохион байгуулан, санхүүжүүлж ажиллахыг Соёлын сайд С.Чулуун, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт;	- ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс Монголын эзэнт гүрний үеийг судалгаа шинжилгээний ажил харьцангуй бага хийгдсэн, цаашид илүү анхаарал хандуулах шаардлагатай хэмээн тодорхойлж суурь судалгааны хүрээлэнгийн тэргүүлэх судалгааны чиглэл болгон ШУА-ийн Бага чуулганд танилцуулж, батлуулсан бөгөөд энэ хүрээнд Монголд археологийн судалгаа хийж буй болон сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын чиглэлээр үүрэг хүлээсэн бүх байгууллага, судлаачдын оролцоог хангаар тооцоолсон "Монголын эзэнт гүрний археологи" хэмээх цогц төслийг боловсруулж, БШУ-ны Сайд Л.Энх-Амгаланд танилцуулсан бөгөөд төслийн саналыг боловсруулаад байна.	70%	
93	245	2020 оны 9 дүгээр сарын 23-ний өдөр 51 дүгээр	XII.1. 8. Хөдөө аж ахуйн их сургууль болон түүний харьяанд байгаа Ургамал газар тариалангийн хүрээлэн, Ургамал	- Засгийн газрын 2015 оны "Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай" тогтоолд Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяанд байгаа Ургамал газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн, Мал аж ахуйн хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэнгүүд үйл	100%	Хяналтаас хасах

		тэмдэглэл 2020-09-23 Дугаар 2020_51	хамгааллын хүрээлэн, Мал аж ахуйн хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяалалд шилжүүлэх эсэх асуудлыг судалж, нэгдсэн санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн нарт;	ажиллагаагаа явуулахаар батлагдсан. 2020 оны 9 дүгээр сарын 23-ний өдөр 51 дүгээр хуралдааны тэмдэглэлийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд 2015 оны Засгийн газрын шийдвэрт өөрчлөлт оруулахгүйгээр тогтсон.		
94	246	2020 оны 10 дугаар сарын 7-ны өдөр 53 дугаар тэмдэглэл 2020-10-07 Дугаар 2020_53	ҮИИ.4. 2. . Багшийн ур чадварын үнэлэмжийг нэмэгдүүлж, нийгмийн асуудлыг нь үе шаттай шийдвэрлэх зорилгоор орон сууцны “Багш хотхон” байгуулах асуудлыг судлан үзэж, саналаа танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт;	- Боловсрол шинжлэх ухааны сайдын үүрэг чиглэлийн дагуу Боловсрол, шинжлэх ухааны яамнаас нийт багш нарын орон сууцны нөхцөлийн талаар дэлгэрэнгүй судалгааг гаргаж, Монголын ипотекийн корпорацтай уулзалт зохион байгуулж, холбогдох мэдээлэл, санал солилцсоны үндсэн дээр зээлийн урьдчилгааг Монголын ипотекийн корпорацаас гаргуулах зарчмын тохиролцоонд хүрч, санамж бичгийн төсөл боловсруулан, гарын үсэг зурагдсан. “МИК ОССК” ХХК-аас /цаашид “МИК” гэх/ тусгайлан гаргасан орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн баталгааны хөтөлбөрт хамрагдах албан хаагчдад тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлт тогтоох, тэдгээрийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, шалгарсан албан хаагчдыг “МИК”-д хүргүүлэх, урьдчилгаа төлбөрийн баталгааны харилцааг зохицуулахаар журам боловсруулж байна.	70%	
	247		ҮИИ.4. 3. Төрийн үйлчилгээний цахим шилжилтийн хүрээнд боловсролын бүх шатны байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагаанд сургалтын удирдлагын системийг нэвтрүүлэх, туршилтын үр дүнг харгалзан цаашид цахим технологийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн;	Нэгдсэн үндэстний байгууллагын нэгдсэн төслийн хүрээнд econtent.edu.mn системийг шинэчлэн цахим сургалтын нэгдсэн платформ болгон хөгжүүлж 2.0 хувилбарыг гаргасан бөгөөд тус платформ дээр тулгуурлан үндэсний сургалтын удирдлагын MEDLE.mn платформ боловсруулсан. - БШУС-ын 2021 оны “Ээлжит хичээлийн цахим контентын сан бүрдүүлэх тухай” А/237 дугаар тушаалаар ээлжит хичээлийн цахим контент, сан бүрдүүлэх ажлын удирдамж, ерөнхий боловсролын сургуулийн 16,411 ээлжит хичээлийн цахим контент сонгон шалгаруулах үнэлгээний аргачлалыг баталсан бөгөөд энэхүү удирдамж, аргачлал батлагдсанаар бүх багш, сурагчдад ерөнхий боловсролын сургуулиудад мөрдөгдөж буй хөтөлбөрийн дагуу нэгж хичээл бүрээр контент бүтээж сонгон шалгаруулалтад оролцох боломжийг бүрдүүлсэн. Ээлжит хичээлийн цахим контентыг сонгон шалгаруулах багийг зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагаа зохион байгуулж сонгосон бөгөөд 38 зөвлөхийн бүрдэхүүнтэй баг Боловсролын мэдээллийн технологийн төв дээр ажиллаж байна. Тус баг нь багшаас ирүүлсэн контентыг дээрх заавар, аргачлалын дагуу 6 чиглэл, 24 ажлын дарааллаар үнэлгээ хийж, шаардлага хангахуйц, хамгийн сайн үнэлэгдэж шалгарсан контентыг MEDLE.mn платформоор дамжуулан	100%	

				нийтийн хүртээл болгож, ерөнхий боловсролын сургалтын үйл ажиллагаанд ашиглуулах ажлыг зохион байгуулж байна. Жилийн эцсийн байдлаар ээлжит хичээлийн цахим контент бүрдүүлэх ажлын явц: - Бэлэн болж платформ дээр байршсан 145, - Боловсруулагдаж байгаа 742, - Шалгаруулалтад оролцуулах санал ирүүлсэн 1,464, - Нийт хандалт 1,308,986 байна. Нэгдсэн үндэстний байгууллагын нэгдсэн төслийн хүрээнд боловсруулсан сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан Казак, Тува, дохионы хэлний хувилбартай 104 интерактив контент, 30 аудио контент, ерөнхий боловсролын сургуульд хэрэглэгдэж буй 147 сурах бичгийн гарчиг, бүлэг, сэдэв тус бүрд хамаарах бичвэр текст болон зургийг html форматтайгаар хөрвүүлсэн цахим хувилбар зэргийг сурах бичиг, интерактив, видео хичээл, теле хичээл гэсэн ангиллаар 3,900 гаруй контентыг MEDLE.mn платформ дээр байршуулан нийтийн хүртээл болгоод байна.		
	248		ҮИИ.4. 5. 2022 онд багтаан модон жорлон бүхий сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах ажлыг үе шаттайгаар хийх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт.	-Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” гэж тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Орон нутгаас ирүүлсэн судалгааг үндэслэн, Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох 1, 2 дугаар ээлжид сонгогдсон байршилд түлхүүр гардуулах гэрээний нөхцөлөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулан, барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. 1-р ээлжийн 16 аймаг 54 сумын 195 объектын барилга угсралтын ажил эхлүүлсэн. 2-р ээлжийн 16 аймгийн 49 суманд 173 объектын барилга угсралтын гэрээ байгуулагдсан. Зураг, төсвийн ажлыг эхлүүлсэн, дулааны улиралд барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. 3-4-р ээлжид 16 аймгийн 350 объектын судалгааны ажлыг эхлүүлсэн.	100%	
95	249	2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл 2020-11-04 Дугаар 2020_58	ХҮИ.4. . Дорноговь аймагт явагдаж байгаа цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагааны талаар Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 31 дүгээр	ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/45 тушаалаар Дорноговь аймгийн Улаанбадрах суманд хүхрийн хүчил ашиглан газар доорх уусгалтын аргаар уран олборлох үйл ажиллагаа явуулсан болон явуулахаар төлөвлөж байгаа талбайн газар нутгийн байгаль орчны суурь нөхцөлийг тодорхойлох, өмнө хийгдэж байсан судалгааны ажлын үр дүнтэй харьцуулсан дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах зорилго бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажлын хэсгийн ахлагч ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал, доктор Л.Жаргалсайхан, ШУА-	100%	

			тушаалаар байгуулсан Ажлын хэсгээс гаргасан зөвлөмжийн дагуу хүхрийн хүчлээр газрын дор ураныг уусган олборлох технологийн нөлөөллийг судлах ажлыг тухайн чиглэлийн холбогдох эрдэмтэд, судлаачдыг оролцуулан зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч Д.Рэгдэл нарт даалгав.	ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Хөрсний лабораторийн эрхлэгч, доктор Х.Золжаргал, Усны лабораторийн эрхлэгч, доктор Б.Одсүрэн, эрдэм шинжилгээний ажилтан Ц.Пүрэвдорж, ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн Ургамалжлалын экологи, ургамлын нөөцийн лабораторийн эрдэм шинжилгээний ажилтан А.Алтанцоож, МУИС-ийн Цөмийн физикийн судалгааны төвийн салбарын эрхлэгч, доктор Н.Норов, инженер-гидрогеологич, Монгол Улсын зөвлөх инженер, Д.Сурмаажав нар ажиллав. Ажлын хэсэг Дорноговь аймгийн Улаанбадрах суманд байрлах Бадрах энержи ХХК-ийн лиценцийн тайлбай болон туршилтын үйлдвэрт 2021 оны 07 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд ажиллаж, ГДУО технологиор ажиллах туршилтын үйлдвэрийн технологитой танилцаж, хөрс, газрын доорх ус, ургамал, мах, сүүний дээж авч, судалгаа хийж, судалгааны үр дүн, дүгнэлт гаргасан.		
96	250	2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69	Ү.. Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав.	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Мэдээлэл солилцох арга хэмжээний тухай” А/403 дугаар тушаалаар боловсролын салбарын мэдээллийн системийн мэдээллийн бодит байдлыг хангах, нэгж байгууллагын ажлын ачааллыг бууруулах зорилгоор боловсрол, сургалтын байгууллагын өөрийн болон бусад аж ахуйн нэгж байгууллагын хөгжүүлсэн сургуулийн удирдлагын систем, сургалтын удирдлагын системийг Боловсролын салбарын мэдээллийн системтэй сервисээр холбох боломжийг бүрдүүлсэн бөгөөд БСМС-ийн мэдээллийг харьяа байгууллага болон бусад боловсрол сургалтын байгууллага, аж ахуйн нэгж байгууллагатай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж СӨБ-ийн түвшинд -1, ЕБС-ийн түвшинд -15, Дээд боловсролын түвшинд -26, Орон зайн мэдээллийн системийн түвшинд -2, Боловсролын үнэлгээний төвд зориулж -5 сервисийг бэлтгэн холбогдох баримт бичгийн дагуу боловсруулан developer.esis.edu.mn системд байршуулж ДБУМС-ийн сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөр, хичээлийн жил, улирал, суралцагч, сургалтын агуулга, багш, улирлын дүн, хөтөлбөрийн дүн, санхүүгийн дэмжлэг, суралцагчийн санхүү, эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр модулийн сервисээр мэдээлэл солилцох туршилтын ажлыг МУИС, АШУҮИС-тай хамтран зохион байгуулсан. Их, дээд сургууль төгссөн эсэх тухай лавлагааны сангийн баяжуулалтыг хийж, Үндэсний дата төвд байрлах сервисээр дамжуулан Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia цахим системээр дамжуулан лавлагааг цахим хэлбэрээр олгож эхэлсэн бөгөөд Худалдан авах ажиллагааны газар, Барилга хөгжлийн төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд лавлагааны сервис олгож байна.	100%	

				Мөн боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй тухай тодорхойлолтын сервисээр Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн системтэй холбогдож Их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа оюутан, суралцагчийн мэдээллийг солилцдог болсноор цахим хэлбэрээр тодорхойлолт олгож эхэлснээр татварыг буцаан олголтод сургалтын байгууллагаас тодорхойлолт шаардахгүй болсон.		
	251		ХҮИ.7. . Улсын төсвийн санхүүжилтээр Коронавируст халдварын оношилгоо, эмнэл зүйн чиглэлээр хийж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлын явцын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан судалгааны ажлыг эрчимжүүлж, гарсан үр дүнг оношилгоо, эмчилгээнд шуурхай нэвтрүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт тус тус даалгав.	- Салбар дундын Эрдэмтдийн зөвлөл 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Онцгой комиссын даргын 32 тоот тушаалаар байгуулагдаж, зөвлөлийг удирдан ажилласан. 2021 оны эхний хагас жилд нийтдээ 30 удаа хуралдаж, 52 асуудал хэлэлцэн, УОК-д 11 зөвлөмж хүргүүлсэн байна. Эрдэмтдийн зөвлөлийн дарга, гишүүд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цаг үеийн асуудал, шинжлэх ухааны тайлбар мэдээллийг хүргэн ажиллаж байна.Үүнд: Эрдэмтдийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, баримт, судалгаагаар хангах, ард иргэдэд болон эмч мэргэжилтнүүдэд мэдээлэл зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах чиглэлээр Био анагаах ухаан, Эмнэлзүй, Нийгмийн эрүүл мэнд гэсэн гурван чиглэлээр ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Эдгээр ажлын хэсгүүд иргэдэд зориулсан зөвлөмж мэдээлэл, видео материал, эрдэм шинжилгээ судалгааны тойм мэдээлэл, эмч мэргэжилтнүүдэд зориулсан мэдээлэл, арга зүйн заавар зэргийг бэлтгэн ажиллаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байна. Иргэдэд зориулсан зөвлөмж мэдээлэл 121 удаа хийсэн байна. Эмч мэргэжилтнүүдэд зориулсан мэдээлэл, арга зүйн зааварчилгааг 18 удаа хийсэн байна. "SARS-CoV2-ийг илрүүлэх шинэлэг оношлуур бүтээх" төсөл шүлсэнд коронавирусыг илрүүлэх оношлуур бүтээх судалгаа хийсэн байна. "Коронавируст халдварын тархалтыг хүн амд суурилан, насны бүлэг тус бүрээр судлах тархвар зүйн судалгаа" хийсэн байна. "Монгол улсад бүртгэгдсэн шинэ коронавирүст (COVID-19) халдварын эмнэлзүйн судалгаа" хийсэн байна. "Монгол улсад SARS-CoV-2-ын голомтолсон халдварын геномын судалгаа" хийсэн байна. - АШУҮИС-ийн эрдэмтэд шүлсэнд SARS-CoV2 вирусийг илрүүлэх оношлуурыг бодит хугацааны мультиплекс ПГУ технологи ашиглан боловсруулж, эмнэл зүйн сорьцонд баталгаажуулаад байна. Энэхүү оношлуур нь хамар залгиураас арчдас авч шинжилж буй аргатай харьцуулахад зовиургүй, шинжилгээ авахад хялбар, богино хугацаанд хямд өртгөөр өндөр мэдрэг шинжилгээ хийх боломжтой. - АШУҮИС-ийн төв байранд Био-Анагаахын хүрээлэнгийн дэргэдэх Био-Аюулгүй байдлын 2-р зэргийн Молекул биологийн оношилгооны лаборатори байгуулан вирусийн халдварын оношилгооны лабораториудын ачааллыг хуваалцах, бэлэн байдлыг хангах, коронавируст халдварын оношилгооны дэвшилтэт арга технологийг нутагшуулахаар ажиллаж байна.	100%	
97	252	2021 оны 1 дүгээр сарын	IX.2. . "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр,	- БШУС-ын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2020.01.14-ний өдрийн А/07 дугаар тушаалаар "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр,	100%	

		6-ны өдөр 2 дугаар тэмдэглэл 2021-01-06 Дугаар 2021_2	төлөвлөгөөний төслийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан уг баримт бичгийг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох зорилттой уялдуулан батлах арга хэмжээ авч шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг зохих журмын дагуу жил бүрийн төсвийн төсөлд тусгуулж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэнд даалгав.	төлөвлөгөөг баталсан. Энэхүү хөтөлбөр нь сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багшид мэргэжлээрээ бие дааж, тасралтгүй хөгжих тэгш боломж олгох, шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг 2022 оны улсын төсөвт тусгасан. Английн Глобал грөүф их сургуулийн манлайллын “Дэлхийн хэмжээний менежер бэлтгэх 1000 багшийн сургалтыг эхлүүлж, 6 сарын онлайн эрхийг нээж, 3 дугаар сарын 23-ны өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд 21 аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын мэргэжилтэн нийт 1000 багшийг 100 хүнтэй 10 бүлэг болгон 7 хоногийн давтамжтай 12 бүлэг сэдвийг цахимаар судлуулж, давхар английн их сургуулийн онлайн хөтөлбөрийг судалсан. Энэ сургалтын манлайллын хөтөлбөрөөр цаашид ерөнхий боловсролын сургуулийн багш нар болон үлдсэн сургалтын менежерүүдээ сургахаар төлөвлөж байна. Шилдэг багш нарын арга туршлага, манлайллыг олон нийтэд таниулж багш мэргэжлийн нэр хүндийг өргөх, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх зорилготой “Би багш” зорилтот шоу нэвтрүүлгийг Боловсрол ТВ-тэй хамтран 2 дахь удаагаа зохион байгууллаа. Би багш уралдаант нэвтрүүлэг нь төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулийн бүх мэргэжлийн багш нарыг хамруулснаараа онцлогтой. Уралдаант шоу нэвтрүүлгийн эхний шатанд 21 аймаг, нийслэлийн сургуулиудаас 140 гаруй багш оролцсон. БШУЯ, БМДИ, Боловсрол ТВ хамтарсан комисс багш нарын эсээ, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, нийгэм, хүмүүнлэгийн үйлсэд оруулсан хувь нэмэр зэрэг шалгуураар үнэлж, 2 дугаар шатанд 20 багш шалгаруулсан. 20 багш оролцсон 16 цуврал дугаарыг 7 хоногийн 3 өдөр нэвтрүүлж байна. Мэргэжлийн 20 багшийг багш хүний ерөнхий мэдлэг, бүтээлч сэтгэлгээ, менежментийн ур чадвар, ёс зүй, мэдээллийн технологи ашиглах чадвар, багаар ажиллах, зөөлөн ур чадвараар өрсөлдүүлэн, шилдэг 4 багшийг тодруулсан. 12 дугаар сарын 20-ны өдөр шилдгийн шилдэг багшаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн газарзүйн багш Д.Мөнхбаатар шалгарлаа. Багшийн мэргэжил дээшлүүлэх зардалд 2021 онд 1.3 тэрбум төгрөгийг төсөвт тусган, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Чадварлаг багш арга хэмжээний 2021 онд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь урьдчилсан байдлаар 95% байна.		
98	253	2021 оны 2 дугаар сарын 3-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2021-02-08 Дугаар 2021_8	1.3. . “Цахим үндэстэн” арга хэмжээний талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. “Цахим үндэстэн” арга хэмжээний хүрээнд иргэдийн мэдээллийн технологийн хэрэглээний ур чадварыг	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/54 дүгээр тушаалаар Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн цахим үндэстэн болох 6 зорилтын хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Цахим үндэстэн” арга хэмжээний хүрээнд иргэдийн мэдээллийн технологийн хэрэглээний ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Тоон бичиг үсэгтэн” арга хэмжээний дагуу бүх нийтийн хэрэглээнд бэлтгэсэн цахим контентыг	100%	

		дээшлүүлэх зорилгоор “Тоон бичиг үсэгтэн” арга хэмжээг зохих журмын дагуу хамтран зохион байгуулж хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ) нарт даалгав.	үндэсний сургалтын удирдлагын MEDLE.mn платформ дээр байршуулан иргэн бүр орон зай цаг хугацаанаас үл хамааран үзэж, суралцах боломжийг бүрдүүлэв.		
254		1.4. . Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 2 дугаар сарын 2-ны өдөр барилгын салбарын зарим төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын дүнгийн талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэдийг орон сууцжуулах замаар хүн амын хөгжлийг хангах, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэхэд чиглэгдсэн зорилтыг хуримтлалын нэгдсэн сан байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан нэгдсэн цогц, уялдаатай байдлаар хэрэгжүүлэх чиглэлээр дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: 1. иргэдийг орон сууцжуулах асуудлаар санал солилцох, уулзалт зохион байгуулах болон орон сууцны хороолол барих байршлыг газар дээр нь судалж, нэг маягийн зураг төслөөр барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-	- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтаар нийт 274 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд төсөвт өртөг нэмэгдэж батлагдсан цэцэрлэгийн 29 барилгын төсөвт өртгийн нэмэгдэл зөрүү 15,739.8 сая төгрөг, сургууль, дотуур байр, спорт заалны нийт 24 төсөл арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл 30,854.8 сая төгрөгт Барилга угсралтын ажлын нэмэлт санхүүжилтийн гэрээг МУ-ын 2021 оны төсвийн тухай хууль, Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.4, 34.1.5 заалт, МУ-ын ЗГ-ын 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл, Барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлт, БШУЯ-ны ТНБД-ын 2021 оны А/08 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийн тэмдэглэл шийдвэр, БШУЯ-тай байгуулсан гэрээний 19 дүгээр зүйлийг үндэслэн байгуулж барилга угсралтын ажлыг эрчимжүүлсэн.	100%	

99	255		Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт; I.4. 2. иргэдийг орон сууцжуулах, түүний санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх механизмыг боловсронгуй болгох, шинэчлэх чиглэлээр санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт;	- Багш нарыг орон сууцжуулахад зээлийн хүү болон урьдчилгаа төлбөрийн асуудал нэн чухал байна. Энэ асуудлыг судалж, урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр СЯ, Монголын ипотекийн корпораци, Монгол банкны төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан. Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын ...-нд өргөн барьсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийг дагалдуулж Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд ... нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан. УИХ-аас 2021-11-12-ны өдөр баталсан Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, уг хуулийн 9.1.3. дахь заалтад "төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах." Эрх зүйн зохицуулалтыг бий болгосон. Ингэснээр Засгийн газраас хэрэгжүүлэх зорилтот хөтөлбөрийн хүрээнд урьдчилгаа төлбөрийн төлбөрийн чадваргүй бол Зээлийн батлан даалтаас урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаж, түүний хүрээнд УИХ, Монгол банкнаас хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн хөтөлбөрт хамрагдах боломж бүрдэж байна.	100%	
	256		I.4. 3. иргэдийг орон сууцжуулах асуудлыг амжилттай хэрэгжүүлсэн гадаадын зарим орны туршлагыг судлах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтын ажиллагаа өрнүүлж, холбогдох тооцоо, судалгааг хийсний үндсэн дээр хуримтлалын нэгдсэн сан байгуулах талаар санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт;	- Боловсрол, шинжлэх ухааны сайд ипотекийн санхүүжилтийг шийдвэрлэх УИХ-ын дэд ажлын хэсгийн хүрээнд энэ чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд холбогдох ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Тухайлбал Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд БШУ-ны сайдын 2021 оны 12 дугаар сарын 09-ний 16/6397 тоот албан бичгээр Боловсролын салбарт тулгамдаж буй хичээл сургалтын үйл ажиллагааг явуулахад анги танхимаас гадна байгалийн ухааны лаборатори, тоног төхөөрөмж, компьютер болон интернэтийн хангамж дутагдалтай, орон нутагт мэргэжлийн болон бага ангийн багшийн хэрэгцээ шаардлага өндөр боловч залуу багш нар очиж ажиллахад орон байр, нийгмийн баталгааны асуудал шийдэгддэггүй зэрэг олон асуудлыг тусгуулан шийдвэрлэх саналыг хүргүүлээ.	70%	
	257	2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл	XII.2. . Монгол Улсын Ерөнхий сайд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын дүнгийн талаар Монгол Улсын	- Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2016-2020 онуудад Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экзим банкнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр багц тус бүр дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2-р багц дээр Lovely International Trust компанитай 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдөр 7,989,525 ам.долларын, 1-р багц дээр 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр	70%	

		2021-02-10 Дугаар 2021_9	сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. “Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв”-ийг байгуулах, цаашид удирдан зохион байгуулах, Инновацийн тухай хуулийн дагуу мэдээллийн технологийн гарааны компанид татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлах, дээд боловсролын салбарт мэдээллийн технологийн өндөр түвшний мэргэжилтэн бэлтгэх, Шинжлэх ухаан технологийн сангаар дамжуулан мэдээллийн технологийн компанийг дэмжих, “Боловсролын цахим шилжилт” арга хэмжээг хэрэгжүүлэх, Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологийн чиглэлийн сургалтын агуулгыг нэмэгдүүлэх асуудлыг авч үзэж, зохих арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ) нарт даалгав.	P.K. Saxena Contractor компанитай 10,159,015 ам.долларын гэрээ байгуулсан. Төслийн явц: 1-р багцын гүйцэтгэгч P.K. Saxena Contractor компани барилгын зураг төсвийн ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд 04 дүгээр сарын 20-нд Монгол хэл дээр боловсруулж дуусган холбогдох байгууллагуудаар батлуулах ажлыг эхлүүлнэ. Дулаан, цахилгаан, ус суваг, сүлжээний техникийн нөхцөлийг сунгах хүсэлтийг холбогдох байгууллагууд руу хүргүүлээд байна. 2-р багцын гүйцэтгэгч ovely International Trust компани Монгол Улсад шаардлагатай сургалтын судалгаа /TNA/-г ШУТИС-ын МХТС-ын мэргэжлийн багш нар, Боловсролын мэдээллийн технологийн төвтэй хамтран хийж, сургалтын хөтөлбөрийн жагсаалтыг 2020 оны 12 дугаар сард МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан шинэчлэн боловсруулж ирүүлсэн. Тус сургалтын хөтөлбөрийн жагсаалтыг төслийн удирдах хороонд 2021 оны 03 дугаар сарын 05 өдөр танилцуулж, батлуулсан бөгөөд хөтөлбөрийг эцэслэн боловсруулах ажлаа хийж байна. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчид мэдээллийн технологийн хичээлийг судалдаг. БШУЯ бага, дунд боловсролын нийт сургалтын хөтөлбөрт 2021-2024 онд үнэлгээ хийж, сайжруулахаар төлөвлөн ажиллаж байна. Мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг нэмэгдүүлэх асуудлыг тухай бүр үнэлж судлан зохих арга хэмжээ авна.		
100	258	2021 оны 2 дугаар сарын 14-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2021-02-14 Дугаар 2021_10	I.2. 2. “10 их наядын цогц төлөвлөгөө”-ний эдийн засгийн ажлын хэсгийг Сангийн сайд Б.Жавхлан, эрүүл мэндийн ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, нийгмийн бодлогын ажлын хэсгийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариуцаж ажиллахаар холбогдох Ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-д Боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах дараах 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ туссан. Үүнд: 1. Монгол эрдэмтдийн бүтээсэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношлуур, эмчилгээний аргачлалыг эмнэл зүйд нэвтрүүлэх үйл ажиллагаанд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх. 2. Сургуулийн өмнөх боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах. 3. Ерөнхий боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах. 4. Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах. 5. Орон нутагт байгуулагдсан “Зайн сургалтын төв”-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дүүрэг, хороонд цахим сургалтын төвүүдийг ажиллуулж, цахим	100%	

		Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид;	сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, залуучуудад үйлчилдэг цэгүүдийг бий болгох. 6. Шинжлэх ухаан, инновацын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, шинэ санаа, санаачилгыг дэмжин нийгмийн үйлчилгээнд нэвтрүүлж, бүх талын хамтын ажиллагааг дэмжих зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг гаргаж хүргүүлсэн. Сангийн яамнаас ирүүлсэн хуваарийн дагуу 2021 оны 08 дугаар сарын 17-д ЗГ-т “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулсан. Дэлхийн банкны санхүүжилттэйгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газартай хамтран хэрэгжүүлж байгаа "Ухаалаг засаг" төслийн "Инновацийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд гүйцэтгэх 16 инновацийн дэд төслийг "Инновацийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх заавар"-ын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. Төслийн сонгон шалгаруулалтад нийт 120 гаруй төслийн санал ирүүлснээс шалгарсан 16 төсөлд нийт 1,274,294,989 төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэж, дэмжлэг үзүүлээ.		
259		I.2. 10. Залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд сар тутамд 5000 залуучуудыг тодорхой хэмжээний тэтгэлэгтэйгээр ур чадвар, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж, гэрчилгээ олгох, ажлын байранд зуучлах арга хэмжээний санал боловсруулж, Засгийн газрын 2 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр нарт;	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-д Боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах дараах 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ туссан. Үүнд: 1.Монгол эрдэмтдийн бүтээсэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношлуур, эмчилгээний аргачлалыг эмнэл зүйд нэвтрүүлэх үйл ажиллагаанд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх; 2.Сургуулийн өмнөх боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах; 3.Ерөнхий боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах; 4.Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах; 5.Орон нутагт байгуулагдсан “Зайн сургалтын төв”-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дүүрэг, хороонд цахим сургалтын төвүүдийг ажиллуулж, цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, залуучуудад үйлчилдэг цэгүүдийг бий болгох; 6.Шинжлэх ухаан, инновацын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, шинэ санаа, санаачилгыг дэмжин нийгмийн үйлчилгээнд нэвтрүүлж, бүх талын хамтын ажиллагааг дэмжих гэсэн арга хэмжээнүүд туссаныг бүрэн хэрэгжүүлж ажилласан. Сангийн яаманд явцын мэдээг 7 хоног тутам тогтмол өгч ажилласан ба хэрэгжилтийн эцсийн тайланг нэгтгэн гаргаж хүргүүлсэн. Сангийн яамнаас ирүүлсэн хуваарийн дагуу 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Засгийн газарт “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөөнд туссан Боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг танилцуулах ажлыг хийсэн.	100%	
260		I.2. 21. Хариуцсан салбартаа тулгамдаж байгаа асуудалтай газар дээр нь биечлэн танилцаж	- Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургаж байгаа 2 цэцэрлэг, 6 сургуулийн удирдлага, багш, ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, санал сэтгэгдлийг сонссон.	100%	

			ажиллахыг Засгийн газрын гишүүдэд.	Уулзалтын мөрөөр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/124 дүгээр тушаалаар байгуулагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулан сургаж буй цэцэрлэг, сургуулийн орчин нөхцөлтэй танилцаж цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилго бүхий ажлын хэсэг 2021 оны 03 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд Нийслэлийн 10, 186 дугаар цэцэрлэг /тусгай/, ерөнхий боловсролын 29, 116, 25, 55, 70, 63 дугаар сургуулиуд /тусгай/, хамран сургах тойргийнхоо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг амжилттай сургаж буй Хан-Уул дүүргийн 34 дүгээр сургуулиуд дээр ажиллаж, удирдлагуудын мэдээлэл сонсох, орчин нөхцөлтэй танилцаж, зарим холбогдох асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэлээ. Мөн Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очир нар Багануур дүүрэгт ажилласан. Мөн Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй танилцаж, тулгамдаж буй асуудлуудын хүрээнд санал солилцлоо. Зөвлөн туслах ажлыг Булган, Баян-Өлгий, Ховд аймагт зохион байгуулж, цар тахлын үед хичээл, сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулахад тулгарч байгаа асуудлаар хэлэлцүүлэг, сайн туршлага солилцох, цахим сургалт удирдах арга зүй, практик, шийдлийг тус тус танилцуулж ажиллалаа. Мөн Архангай, Өвөрхангай аймгуудад ажиллаж салбарын тулгамдсан асуудалтай газар дээр нь биечлэн танилцлаа.		
101	261	2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2021-02-17 Дугаар 2021_11	XII.7. . “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд туссан залууст зөв хандлагыг төлөвшүүлэх, ур чадвар, мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлд сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан уг арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтот хөтөлбөрийг хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган, хамтран боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Удирдлагын	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 58 дугаар тогтоолоор “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” -ийг батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.6 дахь заалт болон 2021 оны 58 дугаар тогтоолын хүрээнд батлагдсан залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “ОРОЛЦОО” төслийн хүрээнд нийт 5000 гаруй залуусыг хувь хүний цогц сургалтад 12 ээлжээр хамруулан хөдөлмөрт бэлтгэх юм. Энэ хөтөлбөрт 18-34 насны, сүүлийн 3 жил ажил хөдөлмөр эрхлээгүй, их, дээд сургууль болон мэргэжлийн боловсролын байгууллага болон сургуульд суралцаагүй, ажилтай орлоготой болж ирээдүйгээ өөрчлөх зорилго, хүсэлтэй залуучууд оролцох боломжтой юм.	100%	

			академи (Д.Сүрэнчимэг) нарт даалгав.			
	262		XII.13. . Сургуулийн барилга угсралтын ажлыг 2021 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд;	- Тус сургуулийн барилгын зураг төсвийн гүйцэтгэлээр ТГТ ХХК шалгарч зургийн ажлын даалгаврын дагуу зураг төслийг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар БШУЯ-ны ТНБД-ын албан бичгээр хянуулахаар хүргүүлээд байна. Барилга угсралтын ажил явагдах Хан-Уул дүүргийн 11-р хороонд байрших газрын гэрээ гэрчилгээ албажин гарсан байна.	70%	
	263		XII.13. 3. Сургуулийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхэд 2021 онд Монголын талаас олгох санхүүжилтийн асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт.	Монгол-Энэтхэгийн найрамдалт дунд сургууль байгуулах төслийг хэрэгжүүлэх Монгол талын хариуцах гадна инженерийн шугам сүлжээ, гадна холбоо, дохиоллын ажлын зардал төсвийг 2022 оны Сангийн сайдын багцад батлагдсан гадаадын зээл тусламжаар хэрэгжих Монгол талын хөрөнгө оруулалт /улсын хэмжээнд төслийн хүрээнд шийдвэрлүүлэх хүсэлтийг хүргүүлэхээр бэлтгэж байна.	70%	
102	264	2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл 2021-02-24 Дугаар 2021_13	XI.3.6. Эрхлэх асуудлын хүрээнд хугацаа хоцорч, хэрэгжилт нь удаашралтай байгаа төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож ажиллахыг холбогдох сайд нарт.”	-Боловсрол, шинжлэх ухааны салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шилжих шинээр хэрэгжиж байгаа барилга угсралтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэн 2021 оны 4 сард бүх гүйцэтгэгч нарын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Салбарын хэмжээнд 2021 оны жилийн эцэст удаашралтай барилга угсралтын ажил, гүйцэтгэл ахисан дүн гарч байна.	70%	
103	265	2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14	XII.4. 5. А.Б.Важпайн нэрэмжит Аутсорсингийн төвийн барилгын ажил дуустал тус төвийн сургалтын үйл ажиллагааг явуулах түр байрыг Буянт-Ухаа нисэх онгоцны буудалд гаргаж өгөх, сургалтыг эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт;	- Төслийн 2-р багц дээр шалгарсан Lovely International Trust компанитай байгуулсан гэрээний үнийн дүнгийн 5,677,400 ам.доллар нь сургалтын зардал бөгөөд Монгол Улсад зохион байгуулах сургалтын үнийн дүн 204,000 ам.доллар. Гэрээнд тусгагдсан сургалтын хөтөлбөрийн хувьд тендерийн баримт бичиг боловсруулж байх үеийн буюу 2016 онд боловсруулж байсан хөтөлбөр тул шинэчлэх шаардлагатай болсон. Хөтөлбөр шинэчлэх асуудлыг БШУЯ-аас гүйцэтгэгч компанид тавьсны үндсэн дээр гүйцэтгэгч компани, ШУТИС-ын МХТС-ын мэргэжлийн багш нар, Боловсролын мэдээллийн технологийн төвтэй хамтран 2020 оны 12 дугаар сард сургалтын жагсаалтыг МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан шинэчилж ирүүлсэн. Тус сургалтын хөтөлбөрийн жагсаалтыг төслийн удирдах хороогоор 2021 оны 03 дугаар сарын 01 өдөр хэлэлцүүлсэн бөгөөд нэмэлт тайлбар бэлтгэж 03 дугаар сарын 05 өдөр танилцуулж, батлуулсан. Сургалтыг эхлүүлэх байрыг ШУТИС-ын МХТС-ын байранд байрлах Монгол Энэтхэгийн хамтарсан МХХТ-ийн сургалтын төвийн байранд эхлүүлэх бэлтгэл ажил хангав.	70%	
	266		XII.2.2. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл	- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй	100%	

		боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д тусгагдсан хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталж, үндсэн чиглэлд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	болгох үндсэн чиглэл"-ийн 1.11 дэх хэсэгт Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд 6 хууль багтсан. Үүнээс Боловсролын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Дээд боловсролын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд УИХ-д өргөн баригдаж, 2021 оны намрын чуулганаар хэлэлцэгдээд байна.		
267		XII.8. . “Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластер”-ын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластер”-ын техник, эдийн засгийн үндэслэлийн асуудлыг судлан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан даалгав.” гэжээ.	Нийслэлийн Баянзүрх дүүргийн 12-р хороонд баригдаж буй Шинжлэх ухаан, инновацийн кластерын барилгын ажлыг “Нутгийн буян групп” ХХК гүйцэтгэж байна. Тус бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Барилга угсралтын ажил санхүүжилт, ажлын графикийн дагуу хэвийн үргэлжилж байна. Барилга угсралтын ажил 28,15%-тай явагдаж байна. Кластерын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвөөр магадлуулан 147,5 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоосон. 2022 оны улсын төсөвт барилга угсралттай холбоотой зардлыг тусган санал хүргүүлсэн. Засгийн газрын 2017 оны 19 дугаар тогтоолоор инноваци, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэйгээр байгуулагдсан “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн чиг үүргийг шинэчлэн тогтоож “Шинжлэх ухаан, инновацийн кластер”-ын ашиглалтын өмнө захиргааны чиг үүргийг шилжүүлэхээр ажиллаж байна. Үүний зэрэгцээ ХААИС-ийг түшиглэн эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах асуудлыг судалж, зөвлөлдөх уулзалтыг 2 удаа зохион байгуулж, нөхцөл байдал, боломж, гарц шийдлийн талаар тодорхой санал шийдэлд хүрлээ. 2021 оны 11 дүгээр сард зохион байгуулсан Донор байгууллагын олон улсын хурал зохион байгуулж, тус хуралд “Шинжлэх ухаан, технологийн парк байгуулах”-д шаардлагатай ТЭЗҮ-ийг боловсруулах төсөл, арга хэмжээг танилцуулсан.	100%	
268		XII.6. . Хуримтлалын нэгдсэн сан байгуулах зорилтыг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажил, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хуримтлалын нэгдсэн сан байгуулах асуудлаар нэгдсэн ойлголтод хүрч, шаардлагатай эрх зүйн орчин,	- Боловсролын салбарын багш, ажилтнууд, оюутан сурагчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор Боловсрол шинжлэх ухааны яамны зүгээс дараах судалгааг боловсруулан, холбогдох төрийн болон хувийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг судлан ажиллаж байна. Үүнд: 1. Багш нарын орон сууц, амьдрах нөхцөлийн талаар судалгаа хийж, цаашид үе шаттайгаар орон сууцжуулах боломжийг бүрдүүлэх олон талт эх үүсвэр бүхий хуримтлалыг бий болгох 2. Оюутан суралцагчдад олон талт тэтгэлэг, зээлийг бий болгох боломж 3. Боловсролын салбарын багш, ажилтнуудад олгох тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг хуримтлуулах, цаашид санхүүгийн эргэлтэд оруулах боломж 4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг эрүүл мэндийн үзлэгт үе шаттайгаар хамруулах боломж Эдгээр асуудлын	70%	

			санхүүжилтийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлэх, цаашид хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулан иргэдийг орон сууцжуулах, тэтгэвэр, тэтгэмж, сургалтын тэтгэлэг олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг иргэдийн нийгэм, эдийн засгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хамтран судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав.”	талаарх судалгаа тооцоог хийж, салбарын 2022 оны төсөвт тусгаж, батлуулах, төрийн болон хувийн байгууллагуудыг хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэхээр ажиллаж байна. Ажлын хэсэг хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж, батлуулахаар яамдаас санал авахаар хүргүүлсэн. Хуримтлалын нэгдсэн сангийн орлогыг байгалийн баялаг, хувьцааны зэрэг орлогоос бүрдүүлэхээр, зардлыг эрүүл мэнд, боловсрол, тэтгэвэр, ипотекийн зээлд зарцуулахаар төлөвлөж төсвийг боловсруулж байна. Хуримтлалын нэгдсэн санг байгуулсан тохиолдолд дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг зэргийг олгох асуудлаар судалж байна.		
104	269	2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2021-03-10 Дугаар 2021_17	XII.3.. Сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох төсөл, арга хэмжээний талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9.4-т заасан нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд оновчтой шийдлийн хувилбар, тооцоо судалгааг хамтран гаргаж, ажлын даалгавар, зураг төслийг батлуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан нарт даалгав.”	- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” гэж тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. БШУ-ны сайд, БХБ-ын сайд, БОАЖ-ын сайдын хамтарсан тушаалаар Ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг улсын хэмжээнд гадна нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байр болон сумдын инженерийн шугам сүлжээний судалгааг хийж гүйцэтгэн ариун цэврийн байгууламжийн технологийн шийдлийг судлан шийдэж нэг маягийн зураг төсөл, загвар зураг, техникийн тодорхойлолтыг боловсрууллаа. Орон нутгаас ирүүлсэн судалгааг үндэслэн, Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох 1, 2 дугаар ээлжид сонгогдсон байршилд түлхүүр гардуулах гэрээний нөхцөлөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулан, барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. 1-р ээлжийн 16 аймаг 54 сумын 195 объектын барилга угсралтын ажил эхлүүлсэн. 2-р ээлжийн 16 аймгийн 49 суманд 173 объектын барилга угсралтын гэрээ байгуулагдсан. Зураг, төсвийн ажлыг эхлүүлсэн, дулааны улиралд барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. 3-4-р ээлжид 16 аймгийн 350 объектын судалгааны ажлыг эхлүүлсэн.	100%	

105	270	2021 оны 3 дугаар сарын 17-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2021-03-17 Дугаар 2021_18	ХҮ.6.1. Эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой 100 төсөл, арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжийг харгалзан 100 төсөл, арга хэмжээг сонгож улсын төсөв, Засгийн газарт өрийн дарамтгүйгээр, хувийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн арга хэлбэрүүдийг ашиглан 2021 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх, хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд;	- Эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой 100 төсөл, арга хэмжээний жагсаалтад Боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжих төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэн ТЭЗҮ боловсруулах, хэрэгжүүлэх саналыг Үндэсний хөгжлийн газар, Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.	30%	
	271	2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19	ХҮ.5.2. Концессын гэрээ байгуулсан төслийн гүйцэтгэлд байнгын хяналт тавих талаар Концессын тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгов.	- Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор Улаанбаатар хотод 72 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барихаар шийдвэрлэж, энэхүү гүйцэтгэгчээр “Рич голден буллс эдукэшн” ХХК-ийг шалгаруулж концессын гэрээ байгуулсан. Тус компани нь 2013 оноос нийслэлийн 32 байршилд бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барих төслийг хэрэгжүүлж, байршил тус бүрд 0-60 хувийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн. ЗГ-ын 2018 оны 5-р сарын 2-ны өдрийн 115 дугаар тогтоолоор дээрх баригдаж эхэлсэн 32 байршлаас 23 байршилд эхэлсэн бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх, концессын гэрээгээр шинээр байгуулах эрхийг “Рич голден буллс эдукэшн” ХХК-д олгосон. Төсөл хэрэгжүүлэгч компани нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй гэж үзэж ЗГ-ын 2019.06.19 өдрийн 240 дүгээр тогтоолоор концессын гэрээг хүчингүй болгосон. Дээрх 32 байршилд хэрэгжиж байсан бага сургууль, цэцэрлэгийн барилгыг үргэлжлүүлэхээр МУ-ын 2020 оны улсын төсөвт 5 төсөл арга хэмжээ, нийслэлийн төсвөөр 23 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан. 2020 оны улсын төсвөөр хэрэгжүүлэх 5 төсөл арга хэмжээний гэрээг ЗГ-ын 2020.10.28 өдрийн 56 дугаар тэмдэглэлийг үндэслэн гэрээг байгуулж барилга угсралтын ажлын явц 40-80 хувийн гүйцэтгэлтэй байна. Концессын гэрээгээр хэрэгжиж байсан 16 байршлын төсөл арга хэмжээний 7 төсөл арга хэмжээг 2022 оны улсын төсөвт санал хүргүүлж батлуулаад байна. Үлдсэн 9 төсөл арга хэмжээний санхүүжилтийг 2022 оны нийслэлийн төсөвт тусгуулах ажиллаж байна	100%	
106	272		II.. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” асуудлыг	- Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны тайланг холбогдох хууль, тогтоомжийн хугацаанд Сангийн яам хүргүүлсэн. Төсвийн ерөнхийлөн	100%	

107			хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнг хэлэлцэн дэмжээд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, хууль, тогтоолд заасны дагуу эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгав.	захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны үнэлгээ дүнгээр хангалттай үнэлэгдсэн. 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Эрх шилжүүлэх тухай” холбогдох тушаалуудаар аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Эрх шилжүүлсэн аймаг, нийслэл, төрийн худалдан авах ажиллагааны газрын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2021 оны 3,4,5 сард хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолтыг түргэн шуурхай гаргаж худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шилжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлж хяналт тавьж ажиллах талаар цахим хурлыг зохион байгуулсан.		
	273		II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	- Он дамжин хэрэгжиж байгаа нийт 79 төсөл арга хэмжээний судалгааг хийж үүний 54 төсөл арга хэмжээг дуусгаж ашиглалтад оруулахаар 2022 оны улсын төсвийн саналд илгээж батлуулан ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхэлсэн ХААИС-ын хичээлийн 2-р байрны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/-ын ажлыг эрчимжүүлэн 2022 оны 1 дүгээр сарын 20 ны өдөр байнгын ашиглалтад хүлээн авахаар хяналт хийж ажиллаж байна. Одоогоор барилга угсралтын ажил 95 хувьтай явагдаж байна.	100%	
	274	2021 оны 3 дугаар сарын 31-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2021-03-31 Дугаар 2021_21	Х.2.2. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх, үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлж байхыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов.	- 2021 оны 3 дугаар сарын 31-ны өдөр 21 дүгээр тэмдэглэлийн дагуу Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх, үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлж ирүүлж байхыг яамны харьяа байгууллага болон дотоод нэгжүүдэд зөвлөмжөөр хүргүүлэн ажиллав. Монгол Улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2021 оны тайланг дээрх зөвлөмжийн дагуу зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж, үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлж, тайлагнасан.	100%	
	275		Х.7. “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их	- Боловсролын салбарын үйл ажиллагаанд цахим шилжилтийг эрчимжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг мэдээллийн технологийн тусламжтайгаар	70%	

108			Хурлын Инновац, цахим бодлогын Байнгын хорооны 2020 оны 01 тоот тогтоолын хэрэгжилт болон боловсролын салбарын цахим шилжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Сургалтын байгууллагын мэдээлэл, харилцаа холбооны гадаад, дотоод сүлжээний дэд бүтэц, цахим сургууль, ухаалаг анги, танхим байгуулахад болон багш, суралцагчийг зөөврийн компьютер, төхөөрөмжөөр хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад улсын болон олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрийн хүрээнд судлан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав;	нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим орчныг бүрдүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, багшийн үндсэн үйл ажиллагааг дэмжих, ажлын байрандаа суралцах, зайн сургалтын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор		
	276		Х.7.2. Боловсролын салбарын цахим шилжилтийн ажлыг эрчимжүүлж, дүнг танилцуулж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан даалгав.	1. Ерөнхий боловсролын сургуулийн интернэтийн гадаад, дотоод сүлжээний орчин бүрдүүлэх 10 сая долларын өртөг бүхий төслийг боловсруулан БНХАУ-н буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, асуудал дэмжигдсэн. “Боловсролын цахим шилжилтийг дэмжих” 100 сая ам долларын төсөвт өртөг бүхий Онлайн шалгалтын танхим, Хичээлийн цахим контентын студи, Боловсролын дата төвийн тоног төхөөрөмж, Багш нарын зөөврийн компьютер, Цэцэрлэгийн интернэтийн сүлжээ гэсэн 5 дэд хэсгээс бүрдсэн төслийг 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайд донор байгууллагуудтай хийсэн уулзалтын үеэр танилцуулсан.		
	277	2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2021-04-07 Дугаар 2021_22	IX.3.2. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан цахим систем бүхий аргачлалын дагуу боловсруулах, холбогдох бэлтгэл ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	- Боловсролын салбарын цахим шилжилтийн үйл ажиллагааны талаарх танилцуулгыг Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн хуралдаанд, УИХ-ын БСШУС-ын байнгын хорооны 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанд, УИХ-ын Инноваци, цахим бодлогын байнгын хорооны 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулж холбогдох чиглэлийг авч ажиллаж байна. - Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд Боловсрол, шинжлэх ухааны төсвийн Ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэл, харьяа байгууллагуудаас авч нэгтгэн боловсруулж хуулийн хугацаанд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Сангийн яаманд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 8 дугаар сарын 13-ны 1/4041 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.	100%	Хяналтаас хасах
					100%	Хяналтаас хасах

	278		IX.6. Монгол Улсын 2021 төсвийн тухай хуулиар төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан соёлын салбарын зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар Соёлын сайд Ч.Номин Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар нэмэлт ажлын эх үүсвэр нь батлагдсан, магадлалын нэгдсэн дүгнэлттэй, барилга, угсралтын ажил нь он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гэрээний үнэд тохируулга хийх асуудлыг Барилгын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Соёлын сайд Ч.Номин, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Биеийн тамир, спортын улсын хороо (Ц.Шаравжамц)-нд даалгав.”	- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар нэмэлт ажлын эх үүсвэр нь батлагдсан, магадлалын нэгдсэн дүгнэлттэй, барилга, угсралтын ажил нь он дамжин хэрэгжиж байгаа 47 төсөл, арга хэмжээний нийт 15,739 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гэрээний үнэд тохируулга хийж нэмэлт санхүүжилтийн гэрээг Барилгын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу байгуулж ажилласан. - Монгол Улсын 2021 төсвийн тухай хуулиар төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан соёлын салбарын зарим хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагуудтай нэмэлт гэрээ байгуулан барилга угсралтын ажлын гэрээг сунган ажилласан.	100%	
109	279	2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2021-04-21 Дугаар 2021_25	ХҮ.2. . “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар тус бүрийн арга хэмжээний хэрэгжилтийн явцыг Сангийн яамны “нэгдсэн мэдээллийг хянах цахим самбар”-т мэдээлж, танилцуулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын 7 дахь заалтыг үндэслэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан (1.19/Сургуулийн өмнөх боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах/, 1.20/Ерөнхий боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах/, 1.21 / Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах/, 1.22 / Орон нутагт байгуулагдсан “Зайн сургалтын төв”-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дүүрэг, хороонд цахим сургалтын төвүүдийг ажиллуулж, цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, залуучуудад үйлчилдэг цэгүүдийг бий болгох/) зорилт арга хэмжээний хэрэгжилтийн үзүүлэлтийг 7 хоног бүр гаргаж, мэдээллийг Сангийн яаманд хүргүүлэн ажилласан. 1. Орон нутагт байгуулагдсан “Зайн сургалтын төв”-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дүүрэг, хороонд цахим сургалтын төвүүдийг ажиллуулж, цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, залуучуудад үйлчилдэг цэгүүдийг бий болгох- Улсын хэмжээнд 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар ерөнхий боловсролын 63 сургуулийн танхимын сургалтад	100%	

				5462 суралцагч, 743 сургуулийн цахим сургалтад 369,716 суралцагч, насан туршийн боловсролын танхимын сургалтад 14 суралцагч, насан туршийн 355 төвөөр дамжуулан зайнаас 5792 суралцагч, цахим сургалтаар 10095 суралцагчийг тус тус хамруулж байсан. 2. Шинжлэх ухаан, инновацын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, шинэ санаа, санаачилгыг дэмжин нийгмийн үйлчилгээнд нэвтрүүлж, бүх талын хамтын ажиллагааг дэмжих; - 2021 оны байдлаар статистик мэдээнд тулгуурлан дүгнэхэд инновац, технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд шинэ технологи 64, шинэ биет бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний загвар 87, шинэ бүтээлийн патент 130, оюуны өмчийн гэрчилгээ 30, лицензийн гэрээ 2 нийт 313 үр дүнг баталгаажуулсан гэсэн арга хэмжээний хэрэгжилтийг гаргаж хүргүүлсэн.		
110	280	2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 27 дугаар тэмдэглэл 2021-04-28 Дугаар 2021_27	XI.5. 3. Хүүхдийг зөвхөн хамран сургах тойрогт байгаа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт суралцуулах, сургууль, цэцэрлэгийг шаардлагатай хороодод шинээр барьж байгуулах ажлыг судалж шийдвэрлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгав.	- Суралцагчдын хамран сургах тойрог тогтоох, сургалтын байгууллагад хуваарилан сургах асуудлыг Боловсролын хуулийн дагуу аймаг дүүргийн Боловсролын газрууд эрх хэмжээний хүрээндээ шийдвэрлэн ажиллаж байна. 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид элсэгчдийг цахимаар, зөвхөн өөрийн хамран сургах тойрогтоо бүртгэгдэх ажлыг амжилттай зохион байгуулан ажилласан.	70%	
111	281	2021 оны 5 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2021-05-05 Дугаар 2021_28	ХХIII.2. . Нийслэлийн Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барих асуудлын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, дарга нарт даалгав: 1. Тус эмнэлгийг барих зориулалтаар олгох газрын асуудлыг хамтран судалж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт;	- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн чиг үүрэгт хамаарах тул хасуулах.	Үнэлэх боломжгүй	Хяналтаас хасах
	282		ХХIII.5. . “Нэрэмжит тэтгэлгийн журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 4 дүгээр	- Засгийн газрын “Журам батлах тухай”, Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох тухай”, “Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын	100%	

			сарын 4-ний өдрийн 111 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж байгаа талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дээрх журмыг хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган шинэчлэн боловсруулж, батлуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгав.	тэтгэлэг олгох тухай” журмыг тус тус баталлаа. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр зөвхөн бакалаврын түвшинд дэлхийд эхний 100-д эрэмбэлэгддэг шилдэг сургууль болон Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн хүрээнд гадаадын сургуулийн бакалаврын түвшинд суралцуулна. Харин ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгээр магистр, докторын түвшинд гадаадын шилдэг сургуульд суралцуулахаар тус тус журамласан.		
112	283	2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 30 дугаар тэмдэглэл 2021-05-12 Дугаар 2021_30	XIX.2. . “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр тухайн салбарын хэмжээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцыг долоо хоног бүрийн Баасан гаригт Сангийн яаманд хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад 7 хоног тутам үнэлгээ хийж, “нэгдсэн мэдээллийг хянах цахим самбар”-т мэдээлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид тус тус даалгав.	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын 7 дахь заалтыг үндэслэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан (1.19 / Сургуулийн өмнөх боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах/, 1.20 / Ерөнхий боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах/, 1.21 / Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах/, 1.22 / Орон нутагт байгуулагдсан “Зайн сургалтын төв”-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дүүрэг, хороонд цахим сургалтын төвүүдийг ажиллуулж, цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, залуучуудад үйлчилдэг цэгүүдийг бий болгох/) зорилт арга хэмжээний хэрэгжилтийн үзүүлэлтийг 7 хоног бүр гаргаж, мэдээллийг Сангийн яаманд хүргүүлэн ажилласан.	100%	
113	284	2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 32 дугаар тэмдэглэл 2021-05-27 Дугаар 2021_32	XV.7. . “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө (2021-2023)”-ний төслийн талаар Соёлын сайд Ч.Номин Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Ерөнхий боловсролын сургуулийн	Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх тухай” 2021 оны А/190 дүгээр тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө /2021-2023/-г баталлаа. КОВИД-19 цар тахлын улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг зайн, цахим хэлбэрээр зохион байгуулснаас үүдсэн хичээл, сурлагын хоцрогдлын нөхцөл байдлыг тодруулах зорилгоор “Суралцагчийн сурлагын хоцрогдлыг оношлох үнэлгээ”-г үндэсний хэмжээнд нийт суралцагчийн 10 хувийг	100%	

			суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө (2021-2023)"-ний төслийг дэмжин, уг баримт бичгийг батлан хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгав.	хамруулан 2021 оны 9 дүгээр сард зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллалаа. Оношлох үнэлгээнд II-XII ангийн 62.8 мянган сурагч хамрагдаж, давхардсан тоогоор 64 хичээлийн агуулгаар 296,282 нэгж үнэлгээ хийж, сурагчдын хоцрогдож буй агуулга болон гүйцэтгэлд шинжилгээ хийж, үр дүнг холбогдол талуудад танилцуулсан. Энэхүү үнэлгээгээр сурагчдын гүйцэтгэл үндэсний хэмжээнд 2019 онд зохион байгуулсан чанарын үнэлгээний гүйцэтгэлтэй харьцуулахад хичээл бүрд буурсан үр дүн гарсан. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад чиглэсэн сургалт, зөвлөн туслах ажлыг сурагчдын улирлын амралтын үргэлжлэх хугацаанд зохион байгуулах чиглэлийг аймаг, нийслэлийн боловсролын газруудад өгөөд байна. Үнэлгээний үр дүнд үндэслэн авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулаад байна. Мөн "КОВИД-19 цар тахлын дараах боловсролын салбарын сэргэлтийг дэмжих техникийн туслалцаа" төслийн баримт бичгийн төслийг Японы Хүүхдийг ивээх сантай хамтран боловсруулж, Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл (GPE) олон улсын байгууллагад хүргүүлээд байна.		
114	285	2021 оны 6 дугаар сарын 1-ний өдөр 33 дугаар тэмдэглэл 2021-06-01 Дугаар 2021_33	ҮИ.1. . Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. ҮИ.2. "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолыг 7 дахь заалтыг үндэслэн "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө" - 1.19, 20.1, 1.21, 1.22-ийн хүрээнд: Танхимын болон цахим сургалтад хамрагдаж буй сурагчдын тоо, Зайн сургалтын төвд хамрагдсан хүүхэд, залуучуудын тооны талаарх мэдээллийг 2020-2021 оны хичээлийн жил дуустал 7 хоног тутам гаргаж, Сангийн яаманд хүргүүлж ажилласан. Мөн төлөвлөгөөнд тусгагдсан салбарт хамаарах дараах арга хэмжээний биелэлтийг гаргаж, Сангийн яамаар дамжуулан Засгийн газарт танилцуулах ажлыг хийсэн. Үүнд: 1.Орон нутагт байгуулагдсан "Зайн сургалтын төв"-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дүүрэг, хороонд цахим сургалтын төвүүдийг ажиллуулж, цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, залуучуудад үйлчилдэг цэгүүдийг бий болгох- Улсын хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар ерөнхий боловсролын 63 сургуулийн танхимын сургалтад 5462 суралцагч, 743 сургуулийн цахим сургалтад 369,716 суралцагч, насан туршийн боловсролын танхимын сургалтад 14 суралцагч, насан туршийн 355 төвөөр дамжуулан зайнаас 5792 суралцагч, цахим сургалтаар 10095 суралцагчийг тус тус хамруулж байсан. 2.Шинжлэх ухаан, инновацын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, шинэ санаа, санаачилгыг дэмжин нийгмийн үйлчилгээнд нэвтрүүлж, бүх талын хамтын ажиллагааг дэмжих;- 2021 оны байдлаар статистик мэдээнд тулгуурлан дүгнэхэд инновац, технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд шинэ технологи 64, шинэ биет бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний загвар 87, шинэ бүтээлийн патент 130, оюуны өмчийн гэрчилгээ 30, лицензийн гэрээ 2, нийт 313 үр дүнг баталгаажуулсан гэсэн арга хэмжээний хэрэгжилтийг гаргаж хүргүүлсэн.	100%	

115	286	2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2021-06-23 Дугаар 2021_36	XII.2. . “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Шаардлагатай тохиолдолд цар тахлын үед эдийн засгийг сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын 7 дахь заалтыг үндэслэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан (1.19/Сургуулийн өмнөх боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах/, 1.20/Ерөнхий боловсролын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах/, 1.21 / Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах/, 1.22 / Орон нутагт байгуулагдсан “Зайн сургалтын төв”-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дүүрэг, хороонд цахим сургалтын төвүүдийг ажиллуулж, цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, залуучуудад үйлчилдэг цэгүүдийг бий болгох/) зорилт арга хэмжээний хэрэгжилтийн үзүүлэлтийг 7 хоног бүр гаргаж, мэдээллийг Сангийн яаманд хүргүүлэн ажилласан. 1. Орон нутагт байгуулагдсан “Зайн сургалтын төв”-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дүүрэг, хороонд цахим сургалтын төвүүдийг ажиллуулж, цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, залуучуудад үйлчилдэг цэгүүдийг бий болгох- Улсын хэмжээнд 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар ерөнхий боловсролын 63 сургуулийн танхимын сургалтад 5462 суралцагч, 743 сургуулийн цахим сургалтад 369,716 суралцагч, насан туршийн боловсролын танхимын сургалтад 14 суралцагч, насан туршийн 355 төвөөр дамжуулан зайнаас 5792 суралцагч, цахим сургалтаар 10095 суралцагчийг тус тус хамруулж байсан.	100%	
	287		XII.11. . Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав: 1. Нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг шинэчлэн тогтоох, нийслэл болон орон нутгийн боловсролын асуудал хариуцсан захиргааны байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж,	- 2021 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчид үдийн цайны үйлчилгээнээс үдийн хоолны үйлчилгээнд шилжсэн бөгөөд нэг сурагчдад ноогдох үдийн хоолны зардлыг Засгийн газрын 2021 оны “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 237 дугаар тогтоолоор 1500 төгрөг байхаар баталсан. Мөн аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтэст хоолзүйч ажиллуулах орон тоо, цалингийн зардлыг шийдвэрлэсэн.	100%	

			удирдлага арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий хоолзүйч ажиллуулах асуудлыг төсвийн шинэчлэлтэй уялдуулан хамтран судалж, саналаа Засгийн газарт танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт;			
	288		XII.11. . Сургуулийн хоол үйлдвэрлэлийн ажилчдын ажлын онцлог нөхцөл, ачаалалд тохируулан албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн шатлалтыг тогтоох асуудлыг судлан танилцуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт;	- Хоолзүйч, тогооч зэрэг мэргэжлийн хүний нөөцийн хэрэгцээ шаардлага, цалин хөлсний тооцоо судалгааг хийж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Цалингийн ангилал, зэрэглэлийг өөрчлөх Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж байна.	100%	
	289		XII.11.4. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, шаардлага хангасан зориулалтын байргүй сургуульд шинээр зориулалтын байр барих ажлын зураг төслийг 2021 онд багтаан боловсруулж, 2022 оноос улсын төсөвт тусгуулах, төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн хоол үйлдвэрлэлийн зориулалт бүхий талбайг бусдад ашиглуулсны төлбөрөөс төвлөрүүлэх орлогыг 100 хувь тухайн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрны засвар, тоног төхөөрөмжид зарцуулах боломжийг судлан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	2021 онд улсын төсөв болон орон нутгийн төсөв, гадаадын буцалтгүй зээл тусламжаар 35 сургуулийн хоолны газрын засвар үйлчилгээ, 62 сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шийдвэрлэсэн бөгөөд 2022-2024 онд хэрэгжих олон улсын байгууллагын төслийн хүрээнд 55 сургуулийг иж бүрэн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах юм. Салбарын хөрөнгө оруулалтын зардлаас хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нэн шаардлагатай байгаа 99 сургуульд нийт 3.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрхийг шилжүүлсэн. Цаашид хөрөнгө оруулалт шаардлагатай улсын хэмжээнд хоолны газаргүй бөгөөд хоолны газрын өргөтгөл барихаар зураг төсөл боловсруулсан 6 сургууль, зориулалтын бус хоолны газартай 235 сургууль /аймаг, орон нутагт 166, нийслэлд 69/, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж шаардлагатай 272 /аймаг, орон нутагт 238, нийслэлд 34/ сургууль байгаа бөгөөд холбогдох судалгаа мэдээллийг танилцуулж ажилласан.	100%	
116	290	2021 оны 7 дугаар сарын 20-ны өдөр 43 дугаар тэмдэглэл	XIII.1.1. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс авах элсэлтийн ерөнхий шалгалтыг коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга	- Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолоор “Ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэлбичгийн хичээлээр шалгалт авч байх”-аар заасан. Гэвч дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас суралцагч сүүлийн 2 хичээлийн жилд танхимд хичээллээгүйгээс сурлагын амжилтын ялгаатай байдал үүссэнтэй	100%	Хяналтаас хасах

		2021-07-20 Дугаар 2021_43	хэмжээ авах журам, вакцинжуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлт, халдвар, хамгааллын горим, дэглэм, шаардлагыг чанд мөрдүүлэн 2021 оны 8 дугаар сарын 19-өөс 24- ний хооронд орон даяар зохион байгуулах арга хэмжээ авах, шаардагдах санхүүжилтийг батлагдсан төсвийн багцдаа багтаан зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх- Амгалан даалгав;	холбогдуулан Засгийн газрын 2020 оны 139, 2021 оны 141 дүгээр тогтоолоор их, дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэл бичгийн хичээлээр шалгалт авахгүй байхаар зохицуулалт хийсэн. Засгийн газрын хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу элсэлтийн ерөнхий шалгалтыг улсын хэмжээнд 2021 оны 8 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэ удаагийн элсэлтийн ерөнхий шалгалтыг нэг танхимд 12-15 хүртэл шалгуулагч буюу "нэг ширээ-нэг шалгуулагч" байхаар тооцож, шалгалтын 82 (үүнээс орон нутагт 42) байранд мэргэжлийн байгууллагаас өгсөн халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулсан бөгөөд нийт 37.2 мянган иргэн шалгалт өгсөн байна. 2021 оны ЭЕШ-ыг тогтоосон хугацаанд улс орон даяар амжилттай зохион байгуулж 40420 шалгуулагч элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлсэн бөгөөд тэдний 78.6 хувь (31.7 мянга)-ийг энэ онд ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчид бүрдүүлж шалгалт өглөө. Ковид-19 цар тахлын улмаас шалгалт өгч чадаагүй 2 мянган хүүхдийг 9 дүгээр сарын 5-6-ны өдрүүдэд дахин шалгалтад хамрууллаа. Шалгалтууд халдвар хамгааллын дэглэм баримталж амжилттай зохион байгуулагдлаа.		
117	291	2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 45 дугаар тэмдэглэл 2021-08-04 Дугаар 2021_45	ХИ.2. . Бүх шатны сургалтын байгууллагын 2021-2022 оны хичээлийн жилийг эхлүүлэх талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс үе шаттайгаар эхлүүлэх бэлтгэл хангах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2021 оны А/294, А/508 дугаар тушаалаар "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2021- 2022 оны хичээлийн жилийг эхлүүлэх, бэлтгэл хангах, эрүүл, аюулгүй орчинд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг нээх зөвлөмж, заавар боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажилласан. Ажлын хэсгээс боловсруулсан 2021-2022 оны хичээлийн жилийг эхлүүлэх, бэлтгэл хангах, эрүүл, аюулгүй орчинд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг нээх Түр журмыг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/292, А/525 хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна. ЕБС-ийн хичээлийг 5/9-ийн зарчмаар буюу ковид-19 цар тахлын халдвар илрэх, өвчлөлийн эмчлэгдэх хугацаа зэргийг харгалзан танхимаар болон цахимаар зохион байгуулахаар түр журамд тусгасан. Нэг ангийн сурагчдыг 20-25 хүүхэдтэйгээр 7 хоногийн 5 өдөр танхимаар 1 дүгээр хэсэг нь хичээллэж байхад үлдсэн хэсэг нь 7 хоногийн Бямба гарагаас дараагийн 7 хоногийн Даваа гараг хүртэл 9 хоногийн хугацаанд цахимаар хичээллэхээр зохицуулалт хийсэн. Боловсролын үйлчилгээ ямар ч нөхцөлд тасрахгүй байх юм. "2021-2022 оны хичээлийн жилийн бэлтгэл" сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг 2021 оны 08 дугаар сарын 04-06-ны өдөр дараах 5 чиглэлээр зохион байгууллаа. Үүнд: 1. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж 2. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах түр сургалтын төлөвлөгөө 3. Ногоон гэрэл үйл ажиллагааны удирдамж	100%	Хяналтаас хасах

				4. Бие даан суралцах ажлын дэвтэр боловсруулах арга зүй 5. Сургууль завсардаж болзошгүй хүүхдийг илрүүлэх судалгааны арга зүй Хэлэлцүүлэгт нийслэл болон 5 бүсийн Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн хамрагдвал зохих ажилтнуудын 96% нь хамрагдлаа. Хэлэлцүүлэгт оролцогчдын өгсөн саналыг 2021-2022 оны хичээлийн жилийн бэлтгэл хангах ажилд тусган ажиллаж байна.		
118	292	2021 оны 8 дугаар сарын 11-ний өдөр 46 дугаар тэмдэглэл 2021-08-11 Дугаар 2021_46	ХҮИ.2.4. Төрийн өмчит их сургуулиудыг нэгтгэх асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд;	Төрийн өмчит их сургуулиудын /МУБИС, МУИС, ШУТИС, ХААИС, СУИС, АШУУИС/ хамтын ажиллагааны Санамж бичгийг 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдөр байгуулж, дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Засгийн газраас баримталж буй бодлого, хөгжлийн тэргүүлэх чиглэлд нийцүүлж их сургуулийн хөгжлийн бодлого, үзэл баримтлалыг тодорхойлж, төрийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллагын нэгдсэн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, Их сургуулийн үлгэрчилсэн дүрэм, эрх зүйн баримт бичгүүдийн бүтэц, агуулгыг нэг жишигт оруулж, боловсронгуй болгох, Чанартай элсэгчдийг оновчтой сонгон шалгаруулах, сургалтын чанарыг сайжруулах, Их сургуулийн засаглалыг оновчтой болгох, хараат бус бие даасан байдлыг хөгжүүлэх, Их сургуулийн багшийн хөгжлийн бодлого, багшийн загвар, багшийн нэгдсэн хөтөлбөрийг боловсруулах, нийгмийн баталгааг хангах, Сургалт, судалгааны чадавхыг дээшлүүлэх, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх, Их сургуулийн жишиг эрэмбэ, чансааг тогтоох, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх Төрийн өмчийн их сургуулиудын сургалт, судалгааны чадавхыг нэмэгдүүлэхэд зориулсан төсвийн багцыг улсын төсөвт тусгах, Их сургуулийн статус, засаглалын тогтолцоо, академик эрх чөлөөг баталгаажуулах талаар холбогдох шийдвэрийг гаргах, Олон улсад өрсөлдөх чадавх, боловсролын чанарыг дээшлүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын тэргүүлэх чиглэлийн 12 хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлэх зардлыг шийдвэрлэх, Төрийн өмчийн сургуулийн удирдлага, мэдээллийн нэгдсэн систем буюу дижитал их сургуулийн систем хөгжүүлэх дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх тус тус болно. Хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийн талаар ЗГ-ын 9 дүгээр сарын -ны өдрийн хуралдаанаар танилцуулав.	100%	
119	293	2021 оны 8 дугаар сарын 18-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2021-08-18 Дугаар 2021_47	ХИҮ.7. . Боловсролын зээлийн сангийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг зохицуулах холбогдох журмын төслийг хууль тогтоомжид	- Боловсролын зээлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолыг батлуулж, энэ хүрээнд Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг ЗГ-ын 2021 оны 347 дугаар тогтоол, Нэрэмжит тэтгэлэг олгох тухай журмыг 2021 оны 275 дугаар тогтоолоор, дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг олгох журмыг 2021 оны 264 дүгээр тогтоолоор тус тус батлууллаа.	100%	

			нийцүүлэн боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгав.			
120	294	2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2021-08-25 Дугаар 2021_48	ХҮІ.5. . Улсын Их Хурлын 2021 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал болон Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолд заасан хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, 2021 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	- “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 2021 оны 75 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлын жагсаалтад Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж багтаагүй. Уг тогтоолын 2 дах хэсэгт заасан хэлэлцэх шатанд байгаа, үргэлжлүүлэн хэлэлцүүлэх хуулийн төслийн дотор Боловсролын багц хуулийн төслүүд багтаж байгаа. Боловсролын багц хууль болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 58 дугаар захирамжаар баталсан.	70%	
	295		ХҮІ.6. . Шинжлэх ухаан, технологийн салбарын шинэчлэлийн зарим асуудлын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгав: 1. Шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх;	- Монгол Улсын Засгийн газрын 2019 он “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 379 дугаар тогтоол батлагдсан. - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/104 дүгээр тушаалаар Засгийн газрын 2019 оны 379 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. Үүний зэрэгцээ Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоолоор ШУТС-г ажлын алба болгон 24 орон тоотой ажиллахаар, ШУТУЗ-ийг хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой өргөжүүлсэн, зарим хүрээлэн төвийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, ШУА-ийн харьяанд Тархи судлалын хүрээлэнг байгуулахаар шийдвэр гарсантай холбогдуулан дараах зохицуулалтыг хийлээ: ШУТС-ийн бүтэц, дүрмийн өөрчлөлтийн төслийг боловсруулсан.	100%	Хяналтаас хасах

			2. Эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны лабораторийн тогтвортой үйл ажиллагааг хангах, судалгааны орчин, нөхцөлийг сайжруулах, дундын ашиглалттай болон сүлжээ лабораториудын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; 3. Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгах.	ШУТУЗ-ийг гэрээт шинжээч авч ажиллуулах, цалин хөлсийг тооцож олгохтой холбоотой шийдвэр бүхий БШУ-ны сайдын 2021 оны А/366 дугаар тушаалыг баталж, хэрэгжилтийг бүрэн хангалаа. ШУА-ийн харьяанд Тархи судлалын хүрээлэнг байгуулж, төсвийг 2022 оны төсөвт тусган батлуулсан. Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн, Ой мод судлалын хүрээлэнг ШУТИС-ийн харьяанд улсын төсвөөс санхүүжүүлэхээр зохицуулалтын арга хэмжээ авч, төсвийг 2022 оны улсын төсөвт тусган батлуулсан.		
121	296	2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр 50 дугаар тэмдэглэл 2021-09-08 Дугаар 2021_50	ХI.3. . Нийслэл Улаанбаатар хотын дэд төвүүдэд хөрөнгө оруулж, бүтээн байгуулалт хийх сонирхолтой хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн уулзалтын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Нийслэлд шинээр байгуулах дэд төвүүд байгуулах ажлыг гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл болон сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга, байгууламжийн барилгын ажилтай нэгдсэн цогц байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх, холбогдох санхүүжилтийг улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хүрээнд шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;	- Нийслэлийн хэмжээнд гэр хороололд судалгаа явуулж сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг судлан сургууль, цэцэрлэггүй хороодыг судалгаанд хамруулж “Өргөө” цэцэрлэг, “Хүрээ” бага сургуулийн төслийг хэрэгжүүлж Барилга хот байгуулалтын яаманд 50 хүүхдийн хүчин чадалтай бүхий нэг маягийн зураг төсөв, 160 хүүхдийн суудалтай бага сургуулийн нэг маягийн зураг төсвийг тус тус хийлгэн бэлэн болгож 2022 оны төсвийн тухай хуульд 50 ортой цэцэрлэгийн барилтын төсвийг суулгасан.	100%	
	297		ХI.5.1. Мэргэжлийн боловсролын бодлого, зохицуулалтын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд	- Улсын Их Хурлаар Монгол Улсын Төсвийн тухай хууль 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдаж, түүнийг дагалдан гарсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан, Мэргэжлийн	100%	Хяналтаас хасах

		Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав: 1. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагатай холбоотой харилцааг боловсролын салбарын эрх зүйн шинэчлэлийн бодлого, хууль тогтоомжид нийцүүлэх асуудлыг судлан, санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт;	боловсролыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд оруулсан		
298		XI.5.2. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон политехник коллежийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хүний нөөц, элсэгч, суралцагч болон мэдээллийн сан, бусад холбогдох асуудлыг шилжүүлэн авч, суралцагчдыг элссэн мэргэжлийн чиглэлийн дагуу үргэлжлүүлэн суралцуулж, төгсгөх талаар хууль тогтоомжийн хүрээнд судлан, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт;	- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон политехник коллеж, коллежийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх бэлтгэл хангах Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан ажлын хэсэг байгуулах тушаалын төсөл боловсруулагдсан. Тушаалын төслийг 2 сайд баталгаажуулсан. /2021.12.14-ны байдлаар/ Улмаар БШУЯ-аас ажлын хэсэгт ажиллуулах ажилтнуудыг дэд сайдын удирдлагаар хуралдуулж, хариуцах ажлын хуваарийг боловсруулан ажиллаж байна.	100%	
299		XI.5.3. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон политехник коллежийн тогтолцоог хөгжүүлэх асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэхтэй	- 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаар баталсан Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон политехник коллежийн санхүүжилтийн асуудал 2022 оны Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсөвт туссан.	100%	

			холбогдуулан 2022 оны улсын төсөвт тусгах саналыг судлан, танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт;	2022 оны төсөвт Мэргэжлийн боловсролын салбарт 92,3 тэрбум төгрөг, үүнээс суралцагчдын тэтгэлэгт 18,6 тэрбум, хөрөнгө оруулалт их засварт 5,4 тэрбум төгрөг, урсгал зардалд 66, 89 тэрбум төгрөгийг батлуулав.		
	300		XI.5.4. Төвлөрлийг бууруулах зорилгоор зарим их, дээд сургуулийг сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор хэлбэрээр төрөлжүүлэн хөгжүүлэх тухай асуудлаар санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан.	- “Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай асуудлыг 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоолын төсөл, танилцуулга, тэмдэглэлийн төслийг 2021 оны 10 дугаар сарын 14-ны 1а/5307 тоот албан бичгээр хүргүүлсэн. “Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай асуудал Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар 20-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэгдэж, 321 дүгээр тогтоолоор баталсан.	100%	
122	301	2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2021-09-15 Дугаар 2021_51	X.3. . Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон санхүүжилтийн төрийн сан дахь гүйлгээний явц байдлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт болон санхүүжилтийн гүйлгээг гүйцэтгэгч нарт олгох явцыг үндэслэлгүйгээр удаашруулж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид учруулж буй хүнд суртлыг таслан зогсоохыг захиалагч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллага, бүх шатны төсвийн захирагч нарт; 2. Гүйцэтгэлийг хянан баталгаажуулдаг захиалагч, захиалагчийн хяналтын байгууллага болон аймаг, нийслэл, яамдын төрийн сангийн гүйлгээний	- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу хянан, захиалагчийн албан бичгээр баталгаажуулан Сангийн яаманд уламжлан, төсвийн хуваарь, төсвийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн, Төрийн сангийн төлбөр тооцооны дагуу ажлын 3-5 хоногийн дотор гүйцэтгэгчид санхүүжилтийг олгож ажилласан.	100%	

		үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, гарсан зөрчил дутагдлыг арилгах, буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийг Авлигатай тэмцэх газарт мэдээлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт болон санхүүжилт олгохтой холбоотой хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг “Иргэд, олон нийттэй харилцах-1111” төв, “e-mongolia” системээр хүлээн авч, дүн шинжилгээ хийж, танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж нарт; 4. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан хатуу баримтлан улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйлгээг шилжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч нарт; 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс санхүүжилтийн гүйцэтгэлийг захиалагч байгууллага хянан баталгаажуулсны үндсэн дээр Сангийн яамнаас гүйцэтгэгч нарт шууд шилжүүлэх цахим системийг нэвтрүүлж, санхүүжилтийн явцыг ил тод нээлттэй болгохыг Сангийн сайд Б.Жавхланд; 6. Улсын		
--	--	---	--	--

		төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажилт, санхүүжилтийн хугацаа болон зөрчил, хариуцлагын асуудлыг холбогдох хуульд тусгах талаар судлахыг Сангийн сайд Б.Жавхланд.			
302		Х.7. . Их, дээд сургуулийг орон нутагт “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, үе шаттай хэрэгжүүлэх асуудлыг судалж, шаардагдах эх үүсвэрийн хамт санал боловсруулан зохих журмын дагуу хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан даалгав: 1. Орхон аймаг дахь технологийн сургуулийг инженер, технологийн чиглэлээр, Дархан-Уул аймаг дахь төрийн өмчийн их сургуулийг Сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн чиглэлээр цогцолбор болгон хөгжүүлэх; 2. Өмнөговь аймагт геологи, уул уурхайн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа салбар сургууль шинээр байгуулах; 3. Дээр дурдсан арга хэмжээний ажлын төлөвлөгөөг орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, МУИС, ХААИС, ШУТИС, АШУУИС-тай хамтран боловсруулах; 4. Холбогдох байгууллагуудтай хамтран тухайн орон нутагт ажиллах багш,	- БШУ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/391 тоот тушаалаар орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр төрөлжүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургуулийг шинээр байгуулах ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг уул уурхай, технологийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсан. Дээрх ажлын хэсгүүд үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан 2022 оны эхний улиралд багтаан батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.	100%	

			ажилтны нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй зээлд хамруулах, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр судалж танилцуулах.		
123	303	2021 оны 10 дугаар сарын 6-ны өдөр 54 дүгээр тэмдэглэл 2021-10-06 Дугаар 2021_54	XII.2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргыг шинээр томилох хүртэлх хугацаанд түүний албан үүргийг Төрийн албаны тухай хуулийн 43.3.2-т заасны дагуу чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар нь түр орлон гүйцэтгүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгав.	- - Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг тус яамны ерөнхий боловсролын газрын дарга Т.Ням-очир түр орлон гүйцэтгэсэн. - Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “ажилд томилох тухай” 330 дугаар тогтоолоор Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргаар Л.Цэдэвсүрэнг томилсон болно.	100%
124	304	2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55	II.. Энэ тогтоолоор хүчингүй болсонд тооцсон болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан дараахь бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр, салбарын бусад баримт бичигт уялдуулан тусгах замаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээг 2022 оны 3 дугаар сард багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов. Үүнд: Нэг. Төрөөс баримтлах бодлого: 1.“Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай” Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 333 дугаар тогтоол; 2.“Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого батлах тухай” Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 70 дугаар тогтоол; 3.“Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар	Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс инновацын талаар баримтлах бодлого”, “Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл”, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Боловсрол Үндэсний хөтөлбөр, “Нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөр, Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр, салбарын бусад баримт бичигт уялдуулан тусгах ажлыг зохион байгуулж байна. Үүнд: 1.Боловсрол, шинжлэх ухааны яам болон Боловсролын ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн бодлогын баримт бичгийн ойрын хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааг Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулан тусгах ажлыг хийсэн. 2. Тухайн бодлогын баримт бичгүүдийн үргэлжлэн хэрэгжиж буй арга хэмжээнүүдийг хариуцсан газар хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулах ажлыг тус тус зохион байгуулсан.	100%

		баримтлах бодлого батлах тухай” Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 169 дүгээр тогтоол; Хоёр. Стратеги, зорилт, чиглэл: 4. “Стратеги батлах тухай” Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 127 дугаар тогтоол; 5. “Зорилт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 407 дугаар тогтоол; 6. “Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай” Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 95 дугаар тогтоол; Гурав. Үндэсний хөтөлбөр, хөтөлбөр: 7. “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоол; 8. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 418 дугаар тогтоол; 9. “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2015 оны 8 дугаар 4-ний өдрийн 324 дүгээр тогтоол; 10. “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 325 дугаар тогтоол; 11. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоол; 12. “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 346 дугаар тогтоол; 13. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 156 дугаар тогтоол; 14. “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 223 дугаар тогтоол; 15. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн			
--	--	--	--	--	--

		газрын 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 77 дугаар тогтоол; 16. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоол; 17. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 34 дүгээр тогтоол; 18. “Хөтөлбөр шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 278 дугаар тогтоол; 19. “Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 44 дүгээр тогтоол; 20. “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2011 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 277 дугаар тогтоол; 21. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 1999 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 129 дүгээр тогтоол; 22. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 282 дугаар тогтоол; 23. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн 207 дугаар тогтоол; 24. “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 209 дүгээр тогтоол; 25. “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 341 дүгээр тогтоол; 26. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 177 дугаар тогтоол; 27. “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 298 дугаар тогтоол; 28. “Үндэсний хөтөлбөр		
--	--	---	--	--

		батлах тухай” Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 362 дугаар тогтоол; 29.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 318 дугаар тогтоол; 30.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 148 дугаар тогтоол; 31.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 214 дүгээр тогтоол; 32.“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 278 дугаар тогтоол; 33.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 200 дугаар тогтоол; 34.“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоол; 35.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 400 дугаар тогтоол; 36.“Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 202 дугаар тогтоол.” гэжээ.			
305		ХҮ.9.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулж	- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 359 дүгээр тогтоолыг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2021 оны 12 дугаар 06-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө батлах тухай” А/422 тоот, 2021 оны 12 дугаар 08-ны өдрийн Эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай” А/430 тоот тушаалаар тус тус батлуулсан. Уг тушаалуудыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, Төрийн худалдан авах ажиллагааны газарт БШУ-ны сайдын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn-д 2022 онд шинээр батлагдсан 173 төсөл арга хэмжээг шивж оруулан, Сангийн ямаар баталгаажуулж, сайдын тушаалаар эрх шилжүүлсэн байгууллагуудад цахим системээр эрх шилжүүлсэн. Өнөөдрийн байдлаар Төрийн худалдан авах ажиллагааны	100%	

			дууссан байхаар тооцож, бэлтгэл хангахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгав;	газарт эрх шилжүүлсэн 71 төсөл, арга хэмжээний 31 төсөл арга хэмжээний Үнэлгээний хороо байгуулагдан зарлах ажлыг зохион байгуулж ажилласан байна.		
	306		ХҮ.13.2. Сонгон шалгаруулалтад оролцогчийн инженер, техникийн ажилтны мэргэжлийн боловсролын талаарх мэдээллийг “ХҮР” системээс шалгах боломжийг бүрдүүлэх, уг системээс авах мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, бүрдлийг сайжруулах ажлыг зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд;	- Их, дээд сургууль төгссөн эсэх тухай лавлагааны сангийн баяжуулалтыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/265 дугаар тушаалаар Боловсролын салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмын дагуу яам болон сургалтын байгууллагын архивын мэдээлэлд үндэслэн хийж, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 220 тогтоолоор батлагдсан Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмын дагуу төрийн мэдээлэл солилцооны ХҮР системээр Худалдан авах ажиллагааны газар, Барилга хөгжлийн төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд лавлагааны сервис олгож байна.	70%	
	307		ХҮ.13.6. “Худалдан авах ажиллагааны цахим систем”-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад;	- “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-д Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад батлагдсан шинэ төсөл арга хэмжээг шивж оруулан, эрх шилжүүлсэн аймаг, нийслэлийн Засаг дарга нарт төсөл арга хэмжээг шилжүүлэх, худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тайлагнах ажлыг тухай бүрд нь зохион байгуулж ажилласан.	100%	
125	308	2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр 57 дугаар тэмдэглэл 2021-10-27 Дугаар 2021_57	ҮҮ.. Монгол төрийн түүхийн музейн үйл ажиллагааг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн зогсоож, “Чингис хаан” музейд нэгтгэх тухай асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов. 2. Шинжлэх ухааны академийн харьяа зарим хүрээлэн, их дээд сургууль, музейд хадгалагдаж байгаа палеонтологи, археологийн олдвор, судалгааны дээж болон баримтат өвийн хадгалалт, хамгаалалтын байдалд холбогдох байгууллагатай хамтран шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Соёлын сайд Ч.Номин, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт даалгав.	Соёлын яам, Чингис хаан музей, Боловсрол, шинжлэх ухааны яамны төлөөлөл уг тогтоолын дагуу холбогдох ажлууд төлөвлөн хамтран ажиллаж байна.	Үнэлэх боломжгүй	Үндсэн чиг үүргийн яам хэрэгжилт гаргах тул хяналтаас хасах
126	309	2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58	ХII.6. . Газар хөдлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын	Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгыг тэргүүн ээлжид буулгах, шинээр барих ажлыг судлан танилцуулсан. 2019-2024 онд 52 цэцэрлэг, 66 сургуулийн нийт 118	70%	

		дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58	Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох сайд, дарга нарт даалгав: 1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 17/12 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2018 оны н/206 дугаар тогтоолын хавсралтад заасан газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгыг тэргүүн ээлжид буулгах, шинээр барих ажлыг судлан танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	барилгыг буулгаж, шинэчлэн барих шаардлагатай дүгнэлт гарсан байна. Үүнээс: 2021 оны байдлаар ашиглалтад орсон буюу хэрэгжиж байгаа 27 цэцэрлэг 51.9 хувьтай, 29 сургуулийн барилга 43.9 хувь буюу нийт 47.4 хувийн биелэлттэй байна. 2023, 2024 оны төсвийн төсөлд 25 цэцэрлэг, 37 сургуулийн барилгыг буулгаж, шинэчлэн барих төсөл арга хэмжээг үе шаттай тусгаж шийдвэрлэхээр төлөвлөж байна.		
310		ХII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран 21 аймгийн боловсролын байгууллагын барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг үнэлэхэд 330 барилга, байгууламжийг ашиглалтын шаардлага хангахгүй гэж дүгнэсэн талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн референт, Байнгын ажиллагаатай зөвлөлийн нарийн бичгийн дарга Я.Баасанбат 2021 оны 08 дугаар сард танилцуулсан байна. Мөн Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй сургууль, цэцэрлэгийн барилгыг тэргүүн ээлжид буулгах, шинээр барих ажлыг судлан 2019-2024 онд 52 цэцэрлэг, 66 сургуулийн нийт 118 барилгыг буулгаж, шинэчлэн барих шаардлагатай дүгнэлт гарсан байна. Үүнээс: 2021 оны байдлаар ашиглалтад орсон буюу хэрэгжиж байгаа 27 цэцэрлэг 51.9 хувьтай, 29 сургуулийн барилга 43.9 хувь буюу нийт 47.4 хувийн биелэлттэй байгаа бөгөөд 2023, 2024 оны төсвийн төсөлд 25 цэцэрлэг, 37 сургуулийн барилгыг буулгаж, шинэчлэн барих төсөл арга хэмжээг тусгаж, үе шаттай шийдвэрлэхээр төлөвлөж байна. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 2.3-т “Сургууль, цэцэрлэгийг гамшиг ослын үед хэрэглэх тоног төхөөрөмжөөр хангах, эрсдэлийн үнэлгээ хийх” гэж заасны дагуу 2022 онд Төсвийн ерөнхийлөн захирагч аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгаж оруулахаар төлөвлөж байна.	70%		

				Мөн дэд ажлын хэсгийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан ажил үүргийн хуваарьт “Шинээр баригдах барилга, байгууламжийн нэгдсэн судалгааг гаргаж тухайн газар болон талбайн хэмжээнд геологийн гадаргуугийн гүний тогтоц нөхцөл байдлыг газар хөдлөлтийн эрсдэлтэй уялдуулан судалж дүгнэлт гаргах, эрсдэлийг харгалзан олгогдсон тусгай зөвшөөрөл, барилга, байгууламж, талбайг цаашид хэрхэх талаар санал боловсруулах” асуудал тусгагдсан. Энэ асуудлын хүрээнд боловсролын салбарт баригдах цэцэрлэг, сургууль, сургуулийн дотуур байр, спорт заалны барилгын нэг маягийн зураг төслийг газар хөдлөлтийн баллыг нэмэгдүүлж, 7-9 баллаар тооцон боловсруулж баталсан зураг төслийн дагуу 2022 оны улсын төсөвт шинээр тусгагдсан төсөл арга хэмжээнд ашиглахаар төлөвлөсөн. Засгийн газрын 2021 оны “Жагсаалт батлах тухай” 359 дүгээр тогтоолын төслийн хэрэгжилтийг хангаж, Сайдын тушаалаар орон нутаг, нийслэл, Төрийн худалдан авах ажиллагааны газарт худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрх шилжсэн төсөл арга хэмжээг тухайн байршлын газар хөдлөлтийн баллаас шалтгаалан нэг маягийн батлагдсан зураг төслийг ашиглан зохион байгуулах юм.		
127	311	2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2021-11-17 Дугаар 2021_60	XIII.1. . Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгаварт тусгагдсаны дагуу Нийслэл Улаанбаатар хотод хог, хаягдал боловсруулах үйлдвэр барих төслийн судалгааны талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Нийслэл Улаанбаатар хотод хог шатааж эрчим хүч гаргах үйлдвэр байгуулах төслийн урьдчилсан судалгаа, шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, хэрэгжүүлэх боломжит бүтцийг тодорхойлох үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсэг байгуулах, ажлын дүнг 2021 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт, дээрх үйл ажиллагаанд холбогдох чиг үүргийн дагуу дэмжлэг үзүүлж,	ШУТИБХЗГ ШУТИБХЗГ-үндсэн чиг үүргийн хүрээнд хамаарахгүй тул үндсэн хэрэгжүүлэгч яам хэрэгжилтийг гаргана.	Үнэлэх боломжгүй	Үндсэн чиг үүргийн яам хэрэгжилт гаргах тул хяналтаас хасах

			хамтран ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт тус тус даалгав.			
128	312	2021 оны 12 дугаар сарын 1-ний өдөр 62 дугаар тэмдэглэл 2021-12-01 Дугаар 2021_62	XI.1.2. Коронавируст халдварын нөхцөл байдал болон томуу, томуу төст өвчлөл ихсэж байгаатай холбогдуулан бүх шатны боловсролын байгууллагын оюутан, суралцагчдын улирлын амралтын хугацаанд зохицуулалт хийхийг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав.	Коронавируст халдварын нөхцөл байдал болон томуу, томуу төст өвчлөл ихсэж байгаатай холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн төрийн болон төрийн бус өмчийн Ерөнхий боловсролын сургуулиудын хичээл сургалтын ажлыг цар тахлаас сэргийлэн цахимаар хичээллүүлэх тухай Шадар сайд, БШУ, ЭМ, ХНХ-ын сайд нарын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 128, А/433, 7531, 196 хамтарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан. Хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу ерөнхий боловсролын сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийн 1 дүгээр улирлын амралт эхэлж байгаатай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2021 оны 5/6364 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг аймаг, нийслэлийн Боловсролын газруудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл өглөө. Үүнд :Суралцагчдын улирлын амралтын хичээл, даалгаврын зохицуулалт, халдвар хамгааллын дэглэмийн асуудлаар тодорхой үүрэг чиглэл өглөө.	100%	
129	313	2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 64 дүгээр тэмдэглэл 2021-12-14 Дугаар 2021_64	XIY.5.3. Бүх шатны төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд хийх хяналт шалгалтыг хэвээр үргэлжлүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын дэргэдэх дотоод аудитын нэгжийн 2021 оны төлөвлөгөөнд туссан, 4-р улиралд хэрэгжүүлэх төлөвлөгөөт шалгалтын ажлын хүрээнд 2021 оны 11-12 дугаар сард Шинжлэх ухаан технологийн сан, Монгол Улсын их сургууль, Соёл урлагийн их сургууль, Ховд их сургууль, Өвөрхангай аймгийн Боловсролын газрын санхүүгийн болон үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийгдэж, нэгдсэн тайлан дүгнэлт гарч, удирдлагад танилцуулагдсан.	100%	
ЗГ-ын албан даалгавар						
130	314	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2	1. Дор дурьдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1. Салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж	- КОВИД-19 цар тахлын хүрээнд боловсролын салбарын суурь үйлчилгээг дэмжих Нэгдсэн үндэстний байгууллагын нэгдсэн төслийн хүрээнд ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр Боловсролын салбар дахь Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн бодлогын тойм шинжилгээний судалгааг амжилттай зохион байгуулж, тайланг эцсийн байдлаар боловсруулж, хэвлүүлсэн бөгөөд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/84 дүгээр тушаалаар Монгол Улсын боловсролын салбар дахь мэдээлэл, харилцаа холбооны технологийн дунд хугацааны бодлогын	70%	

		Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;	баримт бичиг боловсруулах Боловсрол, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. - Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2020 оны “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 1 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан салбарын хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний дагуу Монгол Улсын боловсролын салбар дахь мэдээлэл, харилцаа холбооны технологийн дунд хугацааны бодлогын баримт бичгийн бүтцийн хүрээг 6 бүлэгтэй байхаар боловсруулж бодлогын баримт бичгийн эхний төсөл бэлэн болсон.		
315		1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх;	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/54 дүгээр тушаалаар Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн цахим үндэстэн болох 6 зорилтын хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Тус ажлын хэсгийн хуралд цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг хэлэлцэн, цаашид үйлчилгээний тоог нэмэгдүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөө, үйлчилгээний жагсаалтыг боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.	100%	
316		1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх;	- БШУСын 2018 оны “Журам батлах тухай” А/286 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын сургалтын байгууллагын тодорхойлолтыг ТҮЦ машинаас олгох журам, загварыг баталж Боловсролын салбарт суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дээд боловсролын сургалтын байгууллага төгссөн тухай дипломын лавлагаа болон ерөнхий боловсролын сургуулийн Улсын шалгалтын нэгдсэн дүнгийн хуулбар гэсэн 4 төрлийн лавлагааг ТҮЦ машин болон Төрийн үйлчилгээний нэгдсэн системт буюу E-Mongolia цахим системээр дамжуулан олгож байна. - Ерөнхий боловсролын элсэлт, төгсөлт, журнал хөтлөлт, боловсролын баримт бичиг олголт, элсэлтийн ерөнхий шалгалтын материал түгээлт, засалт, түүний чанарын үнэлгээний судалгаа, багшийн эрхийн бүртгэл, салбарын шагнал урамшууллын хүсэлт, үнэмлэх тэмдгийн нөхөн олголтын хүсэлт зэрэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. - БШУС-ын 2019 оны “Журам, заавар батлах тухай” А/156 дугаар тушаалаар Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйлцүүлэх журмыг баталсан бөгөөд 2019 оны 06 дугаар сараас эхлэн ерөнхий боловсролын сургуулийн боловсролын баримт бичгийг боловсролын салбарын мэдээллийн системээс хэвлэж олгодог болсон.	100%	

			- БШУС-ын 2021 оны “Журам, заавар батлах тухай” А/09 дугаар тушаалаар Боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа эсэх тухай тодорхойлолтыг дээрх системээр дамжуулан цахимаар олгох журам, загвар батлагдсан бөгөөд Үндэсний дата төвтэй гэрээ байгуулан, систем хооронд мэдээлэл солилцох сервис хөгжүүлэлтийг хийж, тодорхойлолтыг сервисээр аж ахуйн нэгж байгууллагад, иргэнд ТҮЦ машин болон Төрийн үйлчилгээний нэгдсэн системт буюу E-Mongolia цахим системээр дамжуулан олгож байна. - Боловсролын салбарын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг гүйцэтгэж, Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тусгай зөвшөөрөл олгох, сунгах хүсэлтийг журмын дагуу иргэн, аж ахуйн нэгжээс 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 12-ны хооронд Боловсролын мэдээллийн технологийн төвийн www.license.edu.mn системээр дамжуулан цахимаар хүлээн авсан. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia.mn системд тусгай зөвшөөрлийн системийн тухай мэдээллийг байршуулж иргэн, аж ахуйн нэгжүүд цахим үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэв.		
317		1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх;	- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/265 дугаар тушаалаар Боловсролын салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам батлагдаж, төрийн болон төрийн бус өмчийн боловсрол сургалтын бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа бөгөөд Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтын мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдлыг хангахтай холбоотой зохицуулалт тус журмаар хийгдэж байна.	100%	Хяналтаас хасах
318		1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах;	- Боловсролын удирдлага мэдээллийн систем ашиглахад тоон гарын үсэг ашиглах, талаар эрх зүйн судалгааны ажил гүйцэтгэж байна. Аймаг, нийслэлийн боловсролын асуудал хариуцсан нэгж нь БШУ-ны яамны харьяа байгууллага биш тул тоон гарын үсэг ашиглах токен төхөөрөмж худалдан авч олгох боломжгүй байдал үүссэн. - Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нөрийн бичгийн даргаас аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт 2021 оны 11 дүгээр сарны 01-нд 2/5587 тоот албан бичгээр боловсролын салбарын цахим шилжилтийн хүрээнд салбарын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, хүний оролцоог багасгах, авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Боловсролын салбарын мэдээллийн системд тоон гарын үсэг ашиглах боломжийг шийдвэрлэх нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж байгаа тул Монгол Улсын “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн дагуу шаардлагад нийцсэн өөрийн тоон гарын үсгийн шифр, токен төхөөрөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол хэрэглэж хэвшиж, бэлтгэл ажлыг хангах тухай албан бичгийг хүргүүлсэн.	70%	
319		1.6. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах;	- Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн 2020 оны “Тушаал хүчингүй болгох тухай” А/33 дугаар тушаалаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, тариф батлах тухай” А/528 дугаар тушаалыг	100%	

			хүчингүй болгосон. Хүчингүй болгосон А/528 дугаар тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны яамны мөнгөн кассын орлогоор авч байсан гүйлгээг хүчингүй болгосон. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээг шинэчлэн батлах тухай” А/43 дугаар тушаал батлагдсан. Тушаалаар Их сургууль, дээд сургууль байгуулах тусгай зөвшөөрлийг 1 000 000 төгрөг, Магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг, Дээд боловсролын байгууллага шинэ мэргэжлээр бакалаврын сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгоход 300 000 мянган төгрөгийн тус тус улсын тэмдэгтийн хураамжийг авахаар заасан. Мөн энэ тушаалаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/321 дүгээр тушаалыг хүчингүй болгосон байна. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны Тариф батлах тухай А/44 дүгээр тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны яамнаас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифыг баталсан. Үүнд Боловсролын тэргүүний ажилтны тэмдэг нөхөн олгосны 10 000 төгрөг, Шинжлэх ухааны тэргүүний ажилтны тэмдэг нөхөн олгосны 10 000 төгрөгийг тус тус авахаар болов.		
	320	1.7. ХҮР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах;	- Боловсролын салбарын мэдээллийн систем агуулагдаж буй Боловсролын дата төвийн тоног төхөөрөмжийг Үндэсний дата төв руу 2021 оны 05 дугаар сард шилжүүлж сүлжээ, тэжээлийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангасан бөгөөд Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 220 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу бусад байгууллага, аж, ахуйн нэгж байгууллагатай сервисээр мэдээлэл солилцохдоо ХҮР систем ашиглаж байна. Мөн боловсролын баримт бичгийн лавлагаа тодорхойлолтыг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машин болон E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан олгож байна.	100%	
	321	1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах;	- Боловсролын салбарын баримт бичгийг ТҮЦ машин болон E-mongolia.mn ашиглан цахимаар хүлээн авах боломжтой тухай мэдээллийг яамны веб сайт, лавлах утас болон боловсролын салбарын бүхий л байгууллага, фэйсбүүк хуудас, цахим сүлжээгээр дамжуулан мэдээллийг хүргэж байна.	100%	
	322	1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох.	- Албан хэрэг хөтлөлтийн intranet.gov.mn программ хангамжийг БШУЯ нэвтрүүлэн ашиглаж байна. Мөн иргэдээс ирж байгаа өргөдөл, гомдол саналыг Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвийн системийг бичиг хэргийн системтэй хоршуулан нэвтрүүлж ашиглаж байна.	100%	
131	323	Бүтээн байгуулалтын	9.1. 9.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол,	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”	100%

		төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2021-09-15 Дугаар 2021_01	шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд: 9.1.Их, дээд сургуулиудыг нэгтгэн зохион байгуулж, Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймагт МУИС-ийн төрөлжсөн салбар сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” хэлбэрээр байгуулан хөгжүүлэх асуудлыг судлан танилцуулах;	болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 321 дүгээр тогтоол батлуулан хэрэгжүүлж байна.		
324			9.2. 9.2.Англи хэлийг албан ёсны 2 дахь хэл болгох асуудлыг судлан танилцуулах;	- “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээний тухай” тогтоолын төслийг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанд танилцуулж дэмжигдсэн.	100%	
325			9.3. 9.3.Монгол үндэсний бичгээр төрийн албан хэргийг хөтлөх асуудлыг судлан танилцуулах.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн хөтөлбөр-III”-т үндэсний бичгийн бүх нийтийн хэрэглээний орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох стандарт, дүрэм журмыг батлах, инновац, технологийн дэвшлийг ашиглах, төрийн байгууллагууд манлайлан ажиллах тодорхой зохицуулалтыг тусгасан. Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороо хамтран 2021 онд “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-г 149 000 албан хаагч буюу нийт төрийн албан хаагчдын 70 хувийг хамруулан зохион байгуулсан. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 47.1 хувь нь монгол бичгийн дундаас дээш түвшний мэдлэгтэй байгаа бол 52.6 хувь нь мэдлэг хангалтгүй байна. Нийт төрийн албан хаагчдын 46.4 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн биш, 85.0 хувь нь сургалт хэрэгтэй гэсэн дүн гарсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн гишүүд болон Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Соёлын сайд Ч.Номин тэргүүтэй албан тушаалтнуудыг хүлээн авч уулзаж, Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн албан хэргийг 2025 оноос хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах, үндэстний цөөнхийн хэлний асуудал болон хос хэлний сургалт, Монгол Улсын Боловсролын их сургуульд Монгол-Тува, Монгол-Казах хэлний ангийг нээх, монгол угсаатны аман аялгууг судлах, хамгаалах, хөгжүүлэх, гадаад оронд суугаа монгол үндэстнүүд, олон улсын хэмжээнд монгол хэл, бичиг үсгийн хэрэглээ, сургалт судалгааг өргөжүүлэх үүрэг даалгаврыг өгсөн. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 144 дүгээр захирамжаар Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд нэгдсэн бодлого зохицуулалтаар хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг	100%	

				Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангаар ахлуулан байгуулаад байна. “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн.		
132	326	Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2021-09-15 Дугаар 2021_01	17. 17.Албан даалгаварт тусгагдсан төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд онцгой анхаарч ажиллахыг Засгийн газрын нийт гишүүдэд тус тус үүрэг болгосугай.	Эрхлэх асуудлын хүрээнд зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үүрэг даалгаврын биелэлтийг ухай бүр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, хэрэгжилтийг хангаж ажилласан.	100%	
	327	2013.03.07. Боловсролын тухай	42.3. Цэцэрлэг, сургуулийн барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хоол хүнсний зүйл болон суралцагчийн эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсрол, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж мөрдүүлнэ.	- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 40 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 6781:209:2019, “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” 6782:2019 стандартыг батлуулан мөрдүүлж байна. - Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/166, А/559, 222 дугаар хамтарсан “Норматив батлах тухай” тушаалаар “Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт”, “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”, “Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г тус тус батлан хэрэгжүүлж байна.	100%	

Боловсрол, шинжлэх ухааны яамны 2021 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланд нийт 327 заалтын хэрэгжилтэд Засгийн газрын 206 дугаар тогтоолоо батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд: Бүрэн хэрэгжсэн буюу 100%-ийн биелэлттэй 246, Хэрэгжих шатанд байгаа буюу 70%-ийн биелэлттэй 68, Хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн биелэлттэй 3, Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй Үнэлэх боломжгүй 10 заалт байна. Хэрэгжээгүй буюу 0 хувийн биелэлттэй заалт байхгүй болно. 2021 оны жилийн эцсийн байдлаар хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 92,9% хувийн биелэлттэй дүгнэгдлээ.